ЕВРЕЙ ХҮМҮҮСИЙН БОЛОВСРОЛ БОЛОН АМЖИЛТЫН НУУЦ

Эгэл жирийн нэгнийг гайхалтай чадвартай нэгэн болгож буй Еврейчүүдийн боловсролын нууц

Улаанбаатар хот
2013 он

Еврей хүмүүсийн боловсрол болон амжилтын нууц
Зохиолч: Марвин Токаер
Орчуулсан: Бат-Эрдэнэ

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Еврей хүмүүсийн боловсрол болон амжилтын нууц

Эгэл жирийн нэгнийг гайхалтай чадвартай нэгэн болгож буй

Еврейчүүдийн боловсролын нууц

“Асуулт хариултын хэлбэрээр хоорондоо харилцан ярилцах”

Энэ бол 5000 жилийн түүхтэй Еврейчүүдийн боловсролын гол нууц юм

Өмнөх үг

Бүх хүнд адилхан өгөгдсөн нэг зүйл бол гэр бүл байдаг. Хүн бүр төрсөн цагаасаа эхлэн өөрийн гэсэн орон зайг бий болгож эхэлдэг бөгөөд энэ нийгэмд ямар хүн болж өсөж торних нь гэр бүлийн орчин, эцэг эхийн анхаарал халамж гэх мэт олон зүйлээс шалтгаалдаг. Эдгээрийн нэг чухал зүйл бол яах аргагүй боловсрол юм.

Сүүлийн үед дэлхий ертөнц маш хурдацтай хөгжиж байна. Үүнээс шалтгаалан хүмүүс маш олон талын мэдлэг мэргэжилтэй болохын тулд бүгд л хичээж байгаа нь бодит үнэн юм. Иймээс эцэг эхчүүд хүүхдээ өнөөгийн нийгмийн шаардлагад нийцэхүйц мэдлэг мэргэжил, ур чадвартай, улс орондоо хэрэгтэй хүн болгохын тулд хүүхдийнхээ боловсролд маш ихээр анхаарах болсон. Эцэг эхчүүд хүүхдээ мэдлэг боловсролтой болгохын тулд үнэтэй сургууль дамжаанд сургаж, ямар ч зүйлээр дутаахгүй сайн орчин нөхцөлд амьдруулахын тулд хичээж байгаа юм. Үүнийгээ хүүхдийнхээ төлөө хийж байгаа хамгийн том хөрөнгө оруулалт гэж эцэг эхчүүд үзэж байгаа боловч хүүхэддээ хэрэгтэй хамгийн чухал зүйлсийг орхигдуулж байгаа нь харамсалтай юм.

Иймд бид улс орны ирээдүй хойч үе болсон үр хүүхдүүддээ зөв арга барилаар боловсролыг олгох нь маш чухал байгаа юм. Энэхүү номонд гарч байгаа зүйлс маш энгийн аар саар зүйл юм шиг боловч бидний амьдралд төдийгүй гэр бүл, үр хүүхдийн маань боловсролд хамгийн чухал зүйлс юм.

Та энэхүү номыг уншсанаар хүүхдийнхээ боловсрол болон гэр бүлийнхээ төлөө хамгийн том хөрөнгө оруулалтыг хийж чадна гэдэгт гүнээ итгэж байна.

Оршил

Юу Еврей хүмүүсийг хамгийн шилдэг нь болгон

энэ их амжилтанд хүргэж байгаа юм бол?

Нэг өдөр диваажинд Мосе(Moses), Есүс(Jesus), Маркс(Karl Heinrich Marx), Фрүд(Sisigmund Schlomo Freud), Эйнштэн(Albert Einstein) зэрэг 5 Еврей хүн цугларан нэг зүйлийн талаар хоорондоо ярилцсан байна. Тэдний ярилцах зүйлийн сэдэв "Хүн төрөлхтнийг тодорхойлж буй зүйл юу вэ?" гэсэн сэдэв байв. Эхлээд Мосе(Moses) их л нухацтай царайлан "Хүн төрөлхтнийг хүн төрөлхтөн болгож байгаа зүйл бол оюун ухаан" гэж хэлэв. Гэтэл Есүс(Jesus) "Үгүй ээ биш, тэр зүйл бол хайр" гэж хэлэв. Энэ хоёрын яриаг сонсож байсан Маркс(Karl Heinrich Marx) гараа өргөн "Бүх зүйл бол амьралын төлөөх тэмцэл, тухайлбал эдийн засаг шийддэг" гэж хэлэв. Энэ үед Фрүд(Sisigmund Schlomo Freud) тэдний яриаг таслан "Хүн төрөлхтөнийг тодорхойлдог зүйл бол хүний мөн чанар" гэж хэлсэн байна. Ингээд нилээн маргалдаж эхлэх үед чимээгүй сууж байсан Эйнштэн(Albert Einstein) "Бүх зүйл бол харьцангуй чанар" гэж хэлснээр тэдний ярилцлага дууссан байна.

Нэг эрдэмтэн "Еврей хүмүүс байгаагүй бол орчин үеийн соёл иргэншил байхгүй байх байсан" гэж хэлсэн байдаг бөгөөд энэхүү тоглоом шоглоом маягаар хэлсэн үгэнд нэг ёсондоо дэлхий ертөнцийг бий болгосон зүйл бол Еврей хүмүүс гэсэн бардамнал шингэсэн нь ажиглагдаж байгаа юм. Америкийн нэгдсэн улсын хамгийн шилдэг цаг үеийн байдлын долоо хоног тутмын "US News & World Report" сэтгүүл "Суут ухаантнуудын нууц : 20-р зууныг бий болгосон 3 агуу хүн" гэсэн сэдвээр тусгай дугаар гаргасан байдаг. Энэхүү дугаарт орсон 3 агуу хүн бол Эйнштэн(Albert Einstein), Фрүд(Sisigmund Schlomo Freud), Маркс(Karl Heinrich Marx) нар юм.

Эйнштэн(Albert Einstein) бол орон зай, цаг хугацаа, хүндийн хүчний талаарх шинэ онол саналаараа "Ньютоний физикийн ухаан"-ыг давсан орчин үеийн шинжлэх ухааны манлайлагч юм. Маркс(Karl Heinrich Marx) бол капитализмын тогтолцоог маш нарийн объектив талаас нь задлан шинжилсэн шинжлэх ухаан социализмын үндэслэгч юм. Фрүд(Sisigmund Schlomo Freud) бол хүний оюун ухааны талаар задлан шинжилгээ, судалгаа хийдэг шинийг санаачлагч бөгөөд хүн төрөлхтний бие хүн болон оюун ухаан гэж юу болох мөн хэрхэн ажилладаг болохыг таньж мэдэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан хүн юм.

Нэг хачирхалтай зүйл гэвэл хүн төрөлхтний түүхэнд томоохон ул мөр үлдээж чадсан эдгээр хүмүүс бүгд Еврей хүмүүс байсан юм. Бас үүнээс илүү нэг гайхалтай зүйл гэвэл Еврей хүмүүсийн энэхүү гайхалтай чадвар зөвхөн өнгөрсөн үед биш өнөө үед ч гэсэн хэвээр оршсоор байгаа юм. Санхүүгийн корпорацийн эзэн Ротшильд (Rothschild), газрын тосны корпорацийн эзэн Рокфеллер (John Davison Rockefeller), хөрөнгө оруулалтын салбарын эцэг хэмээн нэрлэгддэг Жорж Сорс (George Soros), АНУ-ын эдийн засгийн ерөнхийлөгч хэмээн нэрлэгддэг Алэн Грийнспэн (Alan Greenspan), Францийн автомашины эзэн хаан хэмээн нэрлэгддэг Андре Ситроен (Andre Citroen), Английн Пример лигийн алдарт баг болох Челси (Chelsea)-г эзэмшдэг Оросын газрын тосны корпорацийн эзэн Абрамович (Roman Abramovich), Старбакс (Starbucks)-ийн үүсгэн байгуулагч Ховард Шальц (Howard Schultz),

Хэрши шоколадны (Hershey Chocolate) компанийг үүсгэн байгуулагч Милтон Хэрши (Milton Hershey), Данкин Донатс (Dunkin Donuts) компанийг үүсгэн байгуулагч Уильям Розенберг (William Rosenberg), Haagen Dazs–ийг үндэслэгч Рубин Матев (Ruben Matthew), Баскин Роббинс (Baskin Robbins)-ийн үндэслэгч Ирвайн Роббинс (Irvine Robbins), Майкрософт (Microsoft) компаний үүсгэн байгуулагчийн нэг болох Стив Балмер (Steve Ballmer), Oracle компаний үүсгэн байгуулагч Ларри Эллисон (Larry Ellison), Гүүгл (Google) компанийг хамтран үүсгэн байгуулсан Сергей Брин (Sergey Brin) болон Ларри Пэйж (Larry Page), Нобелийн эдийн засгийн шагналыг АНУ-аас хамгийн анх авсан Паул Сэмүелсон (Paul Samuelson), Нобелийн энхтайвны шагнал авсан дипломатч Хэнри Киссинжер (Henry Kissinger), “Пулитзерийн шагнал (Pulitzer Prize)”-ыг бий болгосон Жосеф Пулитзер (Joseph Pulitzer), “Бурханаас бусадтай нь ярилцана” хэмээх ярилцлагын хаан домогт сэтгүүлч Ларри Кинг (Larry King), хийлч Исаак Стерн (Isaac Stern), хөгжмийн зохиолч Жорж Гершвин (George Gershwin), удирдаач Леонард Бернстин (Leonard Bernstein), зохиолч Андрей Гайд (Andre Gide) болон Прүст (Proust), зураач Чагал (Chagall), Модеглиани (Modigliani), Пикассо (Picasso), “Гүгэнхаймийн дүрслэх урлагийн музей (Guggenheim Museum)”-г байгуулан үйл ажиллагааг нь удирдан явуулж байсан Соломон Гүгэнхайм (Solomon Guggenheim) болон Пэгги Гүгэнхайм (Peggy Guggenheim), шүлэгч Хэнрич Хайн (Heinrich Heine), “Худалдаачны үхэл” зохиолоороо алдартай жүжгийн зохиолч Артур Миллер (Arthur Miller), Холливүд (Hollywood)-ийн үндэс суурийг тавьсан жүжигчин Чаплин (Chaplin), алдарт кино найруулагч Стивен Сбилберг (Steven Sbielberg), Вүүди Аллэн (Woody Allen) ..... улс төр, эдийн засаг, хэвлэл мэдээлэл, соёл урлаг гэх мэт нийгмийн бүхий л салбарт томоохон амжилт гаргасан хүмүүсийн ихэнхи нь Еврей хүмүүс байгаа юм.

Еврей хүмүүсийн гаргаж буй энэхүү томоохон амжилтуудаас болоод ч тэр үү зарим хүмүүс Еврей хүмүүстэй адилхан амжилт гаргахыг хүсэж байхад зарим нь тэднийг үгүйсгэж шүүмжилсэн байр суурьнаас ханддаг. АНУ-д “Еврей өмгөөлөгч” гэвэл зөвхөн өөрийнхөө ашгийг боддог амиа хичээсэн хуульч гэсэн утгыг давхар агуулсан байдаг. Шекспер (William Shakespeare)-ийн “Вениційн худалдаачин(The Merchant of Venice)” хөгжимт жүжигт гардаг мөнгө хүүлэгч Шяаролд гэдэг Еврей хүнийг нулимс ч үгүй, цус ч үгүй зөвхөн мөнгөнөөс өөр зүйл мэддэггүй харгис хатуу зүрх сэтгэлгүй хүнээр дүрсэлсэн байдаг. Еврей хүмүүсийн бас нэг шүүмжлэгдэж байгаа зүйл бол өөрсдийгөө сонгогдсон үндэстэн гэсэн сэтгэхүйгээр хандан бусад үндэстнийг гадуурхан зөвхөн Еврей хүмүүс хоорондоо харилцан бусдаас хаалттай амьдарч буй байдал нь байж болох юм. Мөн АНУ-ын нөлөө бүхий улс төрчдийг өөрсдийн талдаа урвуулан дорнодын улс орнуудын энх тайванд заналхийлж буй байдал ч Еврей хүмүүст ажиглагддаг. Ийнхүү хэдийгээр зарим нэг тал дээр дутуу тал байгаа юм шиг боловч нэг баталгаатай зүйл гэвэл Еврей үндэстнээс бүх цаг үед дэлхий дахинд танигдсан чадварлаг хүмүүс олноор төрөн гарсаар байгаа юм.

Тэгвэл Еврей хүмүүсийн энэ том амжилтууд хаанаас үүсэлтэй юм бол? Эсвэл үнэхээр төрөлхийн оюун ухаан сайтай үндэстэн гэдэг үнэн юм болов уу? Үгүй энэ бол зүгээр л нэг хүмүүсийн цуу яриа. Еврей үндэстний IQ(сэтгэн бодох чадвар) бусад үндэстэнтэй харьцуулахад өндөр байдаг гэсэн нотолгоо хаана ч байдаггүй. Финлянд (Finland) улсын Хэлсинки(Helsinki) их сургууль 2002 онд дэлхийн 185 орны ард иргэдийн IQ(сэтгэн бодох чадвар)–ын түвшинг судалсан бөгөөд судалгааны үр дүнд Израйль улсын ард иргэдийн дундаж IQ 95/26-р байр/, Солонгос улс 106 /2-р байр/, АНУ 98/19-р байр/ байсан бөгөөд энэ 2

улстай харьцуулахад IQ–ний түвшин нь бага үзүүлэлттэй гарсан байна. Тэгэхээр Силикон Валли(Silicon Valley)-гийн Еврей гаралтай олон улсын өмгөөлөгч Эндрю Саттер (Andrew J.Sutter) Еврей хүмүүсийн амжилтын арга барилын талаар бичсэн “The Rule” номондоо Еврей хүмүүсийн амжилтын нууцыг ген юмуу биологийн онцлог гэж онцолсон байдаг нь хий хоосон санаа болж байгаа юм.

Тэгвэл Еврей хүмүүсийн амжилтын жинхэнэ нууц юу юм бол? Энэ нууц бол тэдний “боловсрол” юм. Еврей хүмүүс аль ч салбарт гайхалтай чадварлаг байдаг нь тэдний өвөрмөц боловсролын арга барилаас үүдэлтэй байдаг. Хэдийгээр өвөрмөц гэж байгаа боловч яг судлаад үзэх юм бол хэний ч мэдэх энгийн зүйлс байдаг. Еврей хүмүүсийн боловсролын гол цөм бол мэдлэгийн боловсрол болон хүн чанарын боловсролын тэнцвэрт байдал тухайлбал мэдлэг болон хүн чанарын боловсрол хосолсон боловсрол юм. Юуны тухай яриад байна гэж хүмүүс гайхаж болох ч хариулт нь бидний өдөр тутмын амьдралд байгаа юм. Еврей хүмүүс мэдлэгийн боловсрол болон хүн чанарын боловсролыг өдөр тутмын амьдралдаа бодитоор ашиглан дүрэм журам шиг дагаж мөрддөг. “Хүүхдийнхээ боловсролд анхаарал хандуулахыг Бурханаас тэдэнд өгсөн үүрэг” гэж ойлгон хүүхдийнхээ боловсролд хариуцлагатай ханддаг.

Боловсролын тухайд гэвэл Солонгос улсын хувьд ч гэсэн нэг их гологдоод байхааргүй улс. Солонгос хүмүүс болон Еврей хүмүүсийн боловсрол эзэмших хүсэл эрмэлзэл аль нэгийг нь урд хойно нь оруулвал харамсмаар санагдах хэмжээний өндөр түвшинд байдаг. Солонгос хүмүүсийг үр хүүхдийнхээ боловсролын төлөө амь насаа ч хайрлахгүй зүтгэдэг гэж хэлэхэд хэтрүүлсэн болохгүй. Хүүхэд нь хичээл сурлагандаа хичнээн их хичээсэн ч хамгийн сайн сургууль, дамжаануудад явуулах гэж хичээдэг бөгөөд үүнээс шалтгаалан алдартай сургалт, дамжаанууд ихээр төвлөрөн байрласан байдаг Тэчи хорооны орон сууцны үнэ тэнгэрт тулам өндөр үнэтэй байдаг. Сүүлийн үед эхнэр, хүүхдүүд нь гадны өөр улс оронд суралцахаар яван нөхөр нь ажлаа хийн ганцаараа гэртээ үлдэн амьдардаг өрх толгойлсон гэр бүлийн өсөлт ч огцом нэмэгдэж байна. Еврей хүмүүсийн тухайд ч гэсэн үүнтэй төстэй. АНУ-д Еврей хүмүүс ихээр амьдардаг бүс нутагт “сургалтын орчин” сайн бүрэлдсэн байдаг учраас тухайн бүс нутгийн орон сууцны үнэ өндөр байдаг. “Еврей ээж (Jewish Mom)” гэсэн үг “Хүүхэддээ боловсрол эзэмшүүлэх хүсэл эрмэлзэл өндөр эцэг эхийг“ дууддаг өвөрмөц хэлц болсон байна.

Гэтэл боловсролын амжилтын үзүүлэлтийг нь харвал Еврей үндэстэн хамаагүй илүү байгаа юм. Дэлхий дээр байгаа Еврей хүмүүс дэлхийн нийт хүн амын 0,25 хувиас /яг 17,000,000 хүн/ хэтрэхгүй байгаа боловч түүхэн дэх Нобелийн шагнал авсан хувь /албан байгууллагыг хасаад/ хүмүүсийн 22 хувийг Еврей хүмүүс эзэлж байгаа юм. Еврей хүмүүсийн мэдээллийн цахим хаяг болох /www.jinfo.org/ хаягаас үзвэл 1901-2009 он хүртэл Нобелийн шагнал авсан Еврей хүмүүсийн тоо 180-д хүрсэн бөгөөд үүнийг тооцоолоод үзвэл шагнал авч байсан 5 хүн тутмын 1 нь Еврей хүн байсан гэсэн үг юм. 2004-2007 оны хооронд Еврей хүмүүсийн шагнал авах хувь 33 хувь болон өссөн байдаг. Энэ бол нийт хүн амтай нь харьцуулахад бусад үндэстнээс хэдэн зуу дахин илүү түвшин юм. Мөн АНУ-ын нэр хүнд бүхий тусгай сургалттай сургуулийн сурагчдын 4/ 1, АНУ-ын тэрбумтнуудын 40 хувь нь Еврей хүмүүс байдаг.

Солонгос улсын сурагчдын тухайд гэвэл ахлах сургууль хүртлээ сурлагын үзүүлэлтээрээ дэлхийд хамгийн сайн нь байж байгаад их сургуульд ормогцоо суралцах, өрсөлдөх чадвар нь

огцом мууддаг. АНУ-д амьдардаг Солонгос улсын иргэн Ким Сын Ги докторын АНУ-ын Колумбиа их сургуульд (Columbia University) суралцаж байхдаа бичсэн докторын дипломын ажлаас (Нэр хүндтэй их сургуульд суралцаж буй Солонгос сурагчдын талаарх судалгаа) харвал АНУ-ын нэр хүндтэй их сургуульд элссэн Солонгос сурагчдын 44 орчим хувь нь сургуулиа дундаас нь орхисон байдаг. Энэ бол 1985-2007 он хүртэл Харвард (Harvard University), Иел (Yale University), Корнел (Cornell University), Колумбиа (Columbia University), Стэнфорд (Stanford), Юу Си Беркеле (UC Berkeley) гэх мэт нэр хүндтэй 14 их сургуульд элсэн суралцаж байсан Солонгос улсын 1400 сурагчийг хамруулан хийсэн судалгааны үр дүн юм. Энэ бол дундаас нь сургуулиа орхисон Еврей сурагчдаас (12,5) 4 дахин их үзүүлэлт юм. Ким доктор мөн АНУ-ын эдийн засгийн “Фортуна/Fortune/” сэтгүүлд нийтлэгдсэн 500-н томоохон компанид ажиллаж буй Солонгос гаралтай удирдах ажилтнуудын талаар судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнд Солонгос хүмүүс 0,3 хувь, Еврей хүмүүс 41,5 хувийг эзэлж байв. (Энэтхэг үндэстэн 10 хувь, Хятад үндэстэн 5 хувь). АНУ-д суралцаж буй гадаад оюутнууд дотор Солонгос улсын оюутнуудын эзлэх хувь хамгийн өндөр боловч АНУ-ын компаниудад ажилд ороход хүлээн зөвшөөрөгдөхүйц чадвар нь маш муу үзүүлэлттэй гарсан байна.

Ийм үр дүн гарах үед эцэг эхчүүд маш хүнд цохилтонд ордог. Өнөөг хүртэл бүхий л хүчээ дайчлан хүүхэддээ анхаарал халамж тавьсаар ирсэн байхад хүүхэд нь амжилт гаргаж чадахгүй үед эцэг эхчүүд хүүхдийнхээ төлөө дахиад юу хийх хэрэгтэй юм болоо гэж бодон цөхрөнгөө бардаг. Асуудлын гол нь эцэг эхчүүд хүүхдийнхээ төлөө зөвхөн шаргуу хөдөлмөрлөн хичээж зүтгэх биш хүүхдийнхээ суралцах арга барилыг өөрчлөхөд байгаа юм. Хүүхдээрээ ямар нэг зүйлийг хүчээр хийлгээд байх биш өөрийнх нь хүсэж сонирхож байгаа зүйлийг хийлгэх хэрэгтэй. Эцэг эхчүүд маань хүүхдийнхээ толгой руу зөвхөн мэдлэг мэдээлэл чихээд байх биш мэдлэг болон хүн чанарын боловсролоор хүүхдээ сурган хүмүүжүүлэх хэрэгтэй. Нэг ёсондоо Еврей хүмүүсийн боловсролын арга барилыг ашиглах хэрэгтэй гэсэн үг юм.

Еврей хүмүүс гэр бүлийн боловсролд маш их анхаарал хандуулдаг. Ер нь ихэнхи хүмүүс жаахан ажил төрөл ихтэй ч юмуу ядарсан үедээ гэр бүлдээ нэг их анхаарал хандуулахаа байдаг. Эхнэр нөхөр хоёр бие биеэ хүндэтгэх, гэр бүлээрээ хамт хооллох, өдөр бүр унтахаас нь өмнө хүүхэддээ ном уншиж өгөх, өглөөний хоол хамтдаа идэх гэх мэт зүйлсийг хүмүүс нэг их чухал биш аар саар зүйл мэт боддог. Гэтэл хүүхдийн зан чанар, зуршил, хүн чанар, бие хүн, авъяас чадвар бүрэлдэн бий болоход хамгийн их нөлөө үзүүлдэг зүйл бол эдгээр зүйлс болон гэр бүл байдаг. Тийм болохоор хүмүүсийн аар саар зүйл гэж тооцдог бидний өдөр тутмын амьдралд тохиолддог эдгээр зүйлс бидний хүүхдүүдийг чадварлаг боловсон хүчин болгож буй гол цөм элемент юм. Еврей хүмүүс хүүхдүүдийнхээ сурлагын дүнд анхаарахаасаа илүүтэйгээр асуулт хариулт хэлбэрээр хүүхэдтэйгээ харилцан ярилцахад ихээхэн анхаарал хандуулдаг. Еврей хүмүүсийн амьдралын гарын авлага хэмээн нэрлэгддэг Талмуд номонд нь “Багш ганцаараа яриад байж болохгүй. Хэрвээ сурагчид чимээгүй суун зөвхөн багшийнхаа ярихыг сонсоод байвал энэ нь тоть шувуунд юм зааж байгаатай ямар ч ялгаагүй. Багш ямар нэгэн зүйлийн талаар ярьвал сурагч түүнтэй холбогдолтой зүйлийг багшаасаа асуун хоорондоо сайн харилцан ярилцах хэрэгтэй. Багш сурагч хоёр хоорондоо харилцан ярилцсанаар сургалтын үр дүн сайжирдаг” гэж бичсэн байдаг. Сурагч зөвхөн багшийнхаа ярихыг сонсоод байх биш сонирхож мэдэхийг хүсэж байгаа зүйл байвал хэзээ ч хамаагүй багшаасаа асууж багштайгаа сайн харилцан ярилцаж байх хэрэгтэй. Еврей хүмүүс хүүхэд юм

асуух үед огтхон ч төвөгшөөсөн байдлаар хандан хэрэггүй юм битгий асуугаад бай гэж хүүхдийн ярихыг хориглодоггүй. Учир нь ямар нэгэн зүйлийн талаар зориудаар асуулт хариулт тавин хоорондоо харилцан ярилцах маягаар суралцах нь маш үр дүнтэй гэдгийг тэд сайн мэддэг.

“Хамт олон гэсэн ухамсар” ч гэсэн Еврей хүмүүсийн боловсролын бас нэгэн онцлог юм. Еврей хүмүүс Тора (Torah - Библи номын хуучин гэрээний өмнөх хэсгийн 5 ном болох Мосегийн 5 ном) болон Талмуд номыг амьдралынхаа гарын авлагаар ашигладаг. Еврей хүмүүст 5000 жилийн турш уламжлагдан ирсэн хамт олон гэсэн ухамсар ёс суртахууны зарчим байдаг учраас тэд дэлхийн янз бүрийн улс оронд тархан амьдарсан ч өөрийн үндэстнээ гэсэн чин сэтгэлтэй байдаг бөгөөд энэхүү уламжлалаа алдалгүй бие биенээ хайрлаж халамжлан туслаж дэмжин хамтдаа амжилтанд хүрсээр ирсэн.

Еврей хүмүүс дунд асар их хөрөнгө мөнгөтэй хүмүүс их байдаг учир шалтгаан нь тэдний боловсролоос шалтгаалж байгаа юм. Еврей хүмүүс бага наснаасаа эхлэн мөнгөний үнэ цэнийн талаар сайн суралцсан байдаг бөгөөд суралцаж буй зүйлээ амьдралдаа бодитоор ашиглахын тулд төсөөлөн бодох чадвар, бүтээлч чадвараа сайжруулах дасгалжуулалтыг байнга хийдэг. Хий хоосон хүсэл мөрөөдөл амархан үгүй болдог боловч бодитоор биелүүлэх боломжтой зорилго нь эсрэгээрээ хүнд гайхалтай тэсвэр тэвчээр, хүч чадлыг өгч байдаг.

“Үнэн нь шалан дээр асгарсан чулуу шиг хаа сайгүй элбэг байдаг. Харин тэрхүү чулууг авахын тулд хүн биеэ бөхийлгөх хэрэгтэй. Асуудал нь хүмүүс үнэнийг өөртөө бий болгохын тулд нуруугаа бөхийлгөхгүй байгаад байгаа юм”

Энэ бол 18-р зуунд зүүн Европт Еврейн шашны багшаар ажиллаж байсан Бэн Элизер (Ben Eliezer) гэдэг багшийн хэлсэн үг юм. Бэн Эллизер (Ben Eliezer) багшийн хэлсэнчлэн үнэнийг мэддэг хүмүүс маш их байдаг ч үүнийг амьдралдаа хэрэгжүүлдэг хүн маш цөөхөн байдаг. Еврей хүмүүсийн боловсролын арга барилыг ажиглавал маш энгийн зүйлс байдаг. Бараг хүн болгоны мэддэг энгийн зүйл шиг санагддаг. Гэвч эдгээр арга барилуудаас хэд хэдэн зүйлийг бодитоор амьдралдаа хэрэгжүүлээд үзвэл Еврей хүмүүсийн боловсролын арга барил хичнээн агуу үр дүнтэй зүйл болохыг жаахан ч гэсэн мэдэрч чадна. Тийм болохоор яг энэ цаг мөчөөс эхлэн нууц гээд байгаа тэрхүү энгийн аргуудыг хүүхдийнхээ боловсролд ашиглацгаая. Бидний өдөр тутмын амьдралд тохиолдож буй эдгээр жижигхэн зүйлс бидний хүүхдүүдийн цаашдын амьдрал, ирээдүйг өөрчлөх хамгийн чухал зүйлс гэдгийг анхаарцгаая.

“Талмуд” номын зохиолч, Марвин Токаер (Marvin Tokayer)-тай хийсэн ярилцлага

Асуулт хариулт хэлбэрээр хоорондоо харилцан ярилцах,

энэ бол Еврей хүмүүсийн боловсролын гол нууц

Рабби /Rabbis/ буюу Еврей шашны багш нь гүнзгий мэдлэг болон оюун ухаанаараа Еврейн шашны нийгэмд хүндэтгэл хүлээдэг хүн юм. Энэ хүн бол Бурхан болон хүний хооронд гүүр болж өгдгөөрөө бусад шашны алба эрхлэгчдээс ялгаатай бөгөөд уламжлал, соёлын талаар залуучуудад зааж сургадаг боловсролын ажилтны үүргийг ч давхар гүйцэтгэдэг. Марвин Токаер (Marvin Tokayer - 74 нас) нь АНУ-ын Нью-Йорк хотын Еврей хүмүүсийн шашны сургуульд “Талмуд”-ийн утга зохиолын чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан шашны зөв үзэл суртлыг баримталдаг Еврей хүн буюу шашны багш юм. Япон улсын Васеда их сургууль(Waseda University)-д Еврей хэлний багшаар ажиллаж байсан бөгөөд ихэвчлэн Япон болон АНУ-ын Нью-Йорк хотод Еврей хүмүүсийн уулзалтан дээр шашны багшаар ажиллаж байсан. 1962 оноос эхлэн 2 жилийн хугацаанд Солонгосын Кёнгиду Усангуа Тэгүгийн бүс нутагт байдаг Америкийн агаарын цэргийн ангид цэргийн офицероор ажиллаж байсан болохоор Солонгос улстай ч мөн тодорхой хэмжээгээр холбоотой хүн юм.

Япон улсад амьдарч ажиллаж байх үедээ Марвин Токаер (Marvin Tokayer) нь томоохон хэмжээний “Талмуд” номыг энгийн хүмүүс амархан сонирхолтойгоор уншиж ойлгохуйцаар “Талмудийн ухаан”, “Талмудийн амьдрах арга”, “Талмудийн инээд” гэх мэт 20 орчим ном болгон бичсэн бөгөөд одоо Солонгос улсад хэвлэгдэн гарсан ихэнхи “Талмуд”-тай холбогдолтой ном зохиолууд Япон хэлээр бичигдсэн номнуудыг орчуулсан хувилбар юм.

Марвин Токаер (Marvin Tokayer) нэгэн ярилцлаган дээр “Хүчирхэг улс орнуудаар хүрээлүүлсэн улс төрийн хувьд ашигтай байршил, ядуу дорой байдлыг даван туулахын тулд маш сайн сурч боловсрох хүсэл эрмэлзэлтэй болсон гэх мэт зүйлсээрээ Солонгос үндэстэн Еврей үндэстэнтэй төстэй тал их байдаг. Тиймээс Солонгос хүмүүс “Талмуд” хэлбэрийн боловсролд ихээхэн анхаарал хандуулах хэрэгтэй” гэж хэлсэн байна.

Асуулт : Еврей үндэстэн дэлхийн нийт хүн амын 0,25 хувийг эзэлдэгч Нобелийн шагналтнуудын 3/1-ийг Еврей хүмүүс эзэлж байна. Таны бодлоор ийм чадварлаг хүмүүсийг олноор төрүүлэн гаргаж буй нууц нь юу юм бол?

Энэ бол тэдний “Тора” болон “Талмуд” номонд үндэслэсэн боловсролынх нь ач тус юм. Еврей гэр бүлд эцэг эхчүүд бага наснаас нь эхлэн хүүхэдтэйгээ хамт энэхүү номнуудыг уншин уншсан зүйлийнхээ талаар хоорондоо харилцан ярилцаж санал бодлоо солилцдог ёс заншил байдаг бөгөөд энэ нь гайхалтай чадварлаг боловсон хүчнийг бий болгож байгаа гол нууц юм. Эцэг эхийн гол үүрэг бол энэхүү явцыг удирдан чиглүүлж өгөхөд л оршиж байгаа юм.

Асуулт : “Талмуд” номын талаар та бидэнд илүү дэлгэрэнгүй тайлбарлаж өгч болох уу?

Хүн төрөлхтний хамгийн гайхалтай оюун ухааныг мэдэхийг хүсвэл та юу хийх хэрэгтэй гэж

бодож байна? Мэдээж хүмүүс цэцэн мэргэн ухаантай хүмүүсийн үгэнд анхаарал хандуулдаг. Яагаад гэвэл тэдний үгэн дотор гэр бүл, энх тайван, дайн дажин, үхэл хагацал, найз нөхөд, шашин шүтлэг, аз жаргал, инээд хөөр гэх мэт бидний амьдралтай холбоотой бүхий л төрлийн ухаан багтаж шингэсэн байдаг учраас юм. “Талмуд” бол 5000 жилээс ч дээш хугацаанд яригдаж бичигдэж ирсэн цэцэн мэргэн хүмүүсийн яриаг цэгцэлж янзлан бичсэн ном юм. Нэг ёсондоо энэхүү номыг цэцэн мэргэн хүмүүсийн мэдээлэл болон оюун ухааны цогц тайлан гэж хэлж болно. Хүний амьдралын бүхий л салбар хүрээнд тулгардаг асуудлуудын талаар дэлгэрэнгүй өргөн цар хүрээтэйгээр тайлбарласан байдаг учраас зөвхөн нэг удаа уншиж дуусгаад хаях ном биш бүхий л амьдралынхаа турш уншиж судлах хэрэгтэй ном юм. Тийм болохоор Еврей хүмүүс хүүхэддээ 3 наснаас нь эхлэн “Талмуд” номыг зааж эхэлдэг. “Талмуд” ном хүүхдийнх нь боловсролын гол сурах бичиг төдийгүй Еврей хүмүүсийн амьдралын гол хөтөч юм.

Асуулт : Еврей хүмүүс 5000 жилийн өмнөх дүрэм журам, амьдралын хэв маяг болон оюун ухааная яаж өнөөдрийг хүртэл хадгалан үлдэж чадсан бэ?

Учир нь тэдний уншдаг “Талмуд” ном бол бүрэн дуустлаа бичигдсэн ном биш үргэлж тухайн цаг үеийнхээ нөхцөл байдлын дагуу өөрчлөгдөн хувирч байдаг ном учраас юм. “Талмуд” номны эхний хуудас болон хамгийн сүүлийн хуудас хоосон байдаг. Эхний хуудас хоосон байдаг учир шалтгаан нь “Хүн хэн ч байсан хамаагүй хэзээ ч юуг ч суралцаж болох боломжтой байдаг бөгөөд “Талмуд” номыг суралцахад ч эхлэл гэж байдаггүй” гэсэн утгыг илэрхийлдэг. Энэ нь хэн ч байсан хамаагүй өөрийн яг одоо байгаа байдлаасаа эхлэн “Талмуд” номыг суралцах боломжтой гэсэн далд утгатай юм. Номны хамгийн сүүлийн хуудас хоосон байдаг учир шалтгаан нь “Хүн амьдрах хугацаандаа өөртөө олж авч буй мэдлэг, туршлагаа цааш нь байнга баяжуулан сайжруулж байх хэрэгтэй” гэсэн утгатай юм. Хүн хичнээн гайхалтай оюун ухаантай байлаа ч өдөр бүр шинээр амьдарч буй мэтээр түүнийгээ байнга шинэчилж байхгүй бол утга учиргүй болно.

Асуулт : “Талмуд” номыг ашиглан боловсролдоо бодитоор хэрэгжүүлж болох арга юу вэ?

“Талмуд хэлбэрийн ярилцлага” гэсэн үг байдаг. Еврей хүмүүс хүүхдээ сургуульд орохоос нь өмнө хамт “Талмуд” номыг уншиж судалдаг. Номноос уншсан зүйлийнхээ талаар дүн шинжилгээ хийн хоорондоо мэтгэлцэх маягаар харилцан ярилцдаг. Харилцан ярилцаж байхад хэн нэг нь ялж ялагдах нэг их чухал биш. Ингэж харилцан ярилцаж байгаа нь нөгөө хүнийхээ дэвшүүлсэн санал бодлыг няцаахын тулд өөрөө янз бүрийн шинэ санаа дэвшүүлж байгаа бөгөөд энэ нь хүний оюун ухаан, сэтгэн бодох чадварыг сайжруулдаг хамгийн сайн арга юм.

Асуулт : Еврей хүмүүс хүүхдийнхээ боловсролд анхаарал хандуулахдаа хамгийн их чухалчилдаг зүйл юу вэ?

Энэ бол “асуулт тавих” юм. Еврей хүмүүс хүүхэддээ “зөв хариултыг нь олохын тулд дотроо сайтар тунгаан бодохуйц” асуулт тавин хүүхдийнхээ тархийг хөгжүүлдэг. Мөн хүүхэддээ мэдэхгүй зүйлийнхээ талаар бусдаас сайн асууж лавлаж байхыг заадаг. Эцэг эх нь “Өнөөдөр сургууль дээрээ юу сурсан бэ?” гэж асуулгүй “Өнөөдөр багшаасаа юу асуусан бэ?” гэх мэтээр

хүүхэддээ асуулт тавьснаар хүүхэд хэн нэгнээс юм асуухдаа айж эмээж биеэ барьдаггүй болдог бөгөөд ямар нэгэн зүйлийг суралцахдаа сонирхолтой байдаг. Хичээлийн цаг дээр багшийнхаа ярьж буй зүйлийг сонсох нь мэдээж чухал боловч мэдэхийг хүсэж байгаа зүйлээ асуун багштайгаа харилцан ярилцах бүр ч чухал зүйл юм. Үнэндээ Еврей хүмүүсийн сургуульд бусдад сайн асуулт тавьж чаддаг сурагч бол өөрийн үеийн сурагчид дотроо хамгийн шилдэгт тооцогддог. Еврей хүмүүс бүх л амьдралынхаа турш иймэрхүү асуулт хариулт маягийн боловсролоор суралцдаг. Миний бодлоор Солонгос хүмүүс ч гэсэн хүүхэддээ мэдэхгүй зүйлийнхээ талаар бусдаас сайн асууж лавлаж байхыг сайн зааж сургах хэрэгтэй.

Асуулт : Еврей хүмүүсийн сургуулийн боловсролын арга барил юу вэ?

Би үүний өмнөхөн Еврей гэр бүлд “Талмуд хэлбэрийн ярилцлага” байдаг талаар ярьсан. Сургуулийн боловсролыг үүний үргэлжлэл гэж хэлж болно. 18 настай өөрийнхөө ач хүүгээр жишээ аваад үзье л дээ. Тэр өдөр болгон “Талмуд” номноос суралцдаг. Миний ач хүү үдээс өмнө “Талмуд” номноос суралцан үдээс хойш сургуулийнхаа энгийн хичээлийг хийдэг. Сургуулийн багш нар сурагчдад хичээл заахдаа зөвхөн нэг талыг баримталсан арга барилыг ашигладаггүй бөгөөд сурагчид хамтран асуудлыг шийдвэрлэн суралцаж болохуйц арга барилыг хичээлдээ ашигладаг. Хичээлийн цаг дээр багш сурагчдад ямар нэгэн сэдэв өгвөл 2-3 сурагч хамтран тухайн сэдвийн талаар хоорондоо чөлөөтэй харилцан ярилцдаг. Хичээлийн цаг дуусахаас өмнө сурагчид өөрсдийн санал бодол болон багшийнхаа санал бодлын хооронд ямар ялгаа байгаа талаар дахин хоорондоо ярилцдаг. Еврей хүмүүс ийм арга барилаар бага наснаасаа эхлэн суралцаж эхэлдэг.

Асуулт : Еврей гэр бүлд эхнэр нөхөр хоёулаа ажил хөдөлмөр эрхлэх тохиолдол их байдаг. Ийм тохиолдолд эцэг эхчүүд бага насны хүүхдээ хэрхэн өсгөж хүмүүжүүлдэг вэ?

Бага насны хүүхэд гэдэг бол эцэг эх хоёрын хоёулангийнх нь хариуцлага. Еврей хүмүүс хүүхэдтэйгээ өнгөрүүлэх цагийг хамгийн чухал цагт тооцдог бөгөөд Еврейчүүдийн амралтын өдөр болох бямба гаригт хүүхдийнхээ боловсролд бүхий л цаг заваа зарцуулдаг. Ялангуяа Еврей эцэг хүн гэдэг бол хүүхдийнхээ хамгийн дотны найз бөгөөд багш нь юм. Хүүхэддээ гэрийн даалгавраа хийгээрэй гэж хэлчихээд өөрөө телевиз үзээд хэвтчихдэг Еврей эцэг хүн бараг байхгүй. Еврей аав нар хүүхэддээ хичээлээ хий гэж тулган шаардах биш хичээлийг нь зааж өгөнгөө хүүхэдтэйгээ хамт суралцдаг.

Асуулт : Солонгос улсын боловсролын өнөөгийн байдлын талаар та юу гэж хэлмээр байна вэ?

Солонгос, Израйль хоёр улс бол нийтлэг тал ихтэй орнууд. Хоёр орон хоёулаа нэг үндэстэн ястан бөгөөд мөн өвөрмөц соёлтой удаан хугацааны турш бусад улс оронд булаан эзлэгдэж байсан түүхтэй. Солонгос улсын хувьд Япон, Хятад, Орос гэх мэт хүчирхэг улс орнуудаас шалтгаалан багагүй зовлон бэрхшээл амсаж байсан бол Еврей хүмүүс 2000 жилийн турш тусгаар улс үндэстэн болж чадалгүй дэлхий даяар хэрэн тэнүүчилж явсаар Холокауст (Holocaust-Нацистууд Еврей хүмүүсийг олноор хомроголон устгасан газар/ хэмээх газар олнооров амь үрэгдэж байсан түүхтэй. Манай хоёр орон ийм хүнд хэцүү нөхцөл байдалд

амьдарч байсан болоод ч тэр үү эдгээр нөхцөл байдлыг хүний нөөцийн хүчээр даван туулахын тулд иргэдийнхээ боловсролд ихээхэн анхаарал хандуулахаар болсон. Үүний үр дүнд одоо манай хоёр орон хүчирхэг улс орон болж чадсан гэж бодож байна.

Гэхдээ би Солонгос хүмүүс өвөг дээдсийнхээ ухаан, уламжлалыг бага багаар мартаж байгаад маш их харамсаж явдаг. Солонгос улс мэдээлэл технологийн салбарт дэлхийн хамгийн хүчирхэг орон болон улсынхаа сул дорой байсан эдийн засгийг сайжруулан хэрэглээний бараа материалын хувьд элбэг хангалуун болж чадсан ч хүний дотоод сүнс гэсэн зүйлээ алдаж байгаа ч юмуу өвөг дээдсийнхээ өвлүүлэн үлдээсэн гайхалтай үнэт хөрөнгө болох оюун ухаан, уламжлалыг алдаж байгаа юм шиг санагддаг. Тийм болохоор Солонгос хүмүүс энэ талаар эргэн нэг бодох цаг болсон гэж бодож байна.

Израйль улсаас БНСУ-д улсад суугаа элчин сайд, Тувиа Израйль (Tuvia Israeli)-тай хийсэн ярилцлага

Номыг загас гэж үзвэл харилцан ярилцах нь загас барих арга юм

“Библийн хуучин гэрээ”-г Еврей үндэстний түүхийн ном гэж хэлж болно. Библи номонд гардаг Абрахам бол Еврей үндэстний өвөг дээдэс юм. Абрахам 5000 жилийн өмнө одоогийн Пластиний Канаан нутагт амьдарч байсан. Абрахамын ач хүү Иаковт 12 хүү байсан бөгөөд тэд тус бүрдээ өөр өөрийн овог аймгийг бий болгосон. Гэвч эдгээр овог аймгуудын 10 овог аймаг нь устаж үгүй болсон бөгөөд 2 овог аймаг /Иудэгийн овог, Бэниаминий-Benjamin овог/ үлдсэн. Одоогийн Израйль улсыг Еврей үндэстний үр сад гэж үздэг.

1948 онд Израйль улс тусгаар тогтнон 2000 жилийн турш ямар нэгэн газар нутаггүйгээр дэлхийн янз бүрийн улс орноор тэнүүчлэн амьдарч байсан Еврей хүмүүс нэг дор цугларсан байна. Амьдралын хүнд хэцүү нөхцөл байдал, байгалийн нөөцийн дутагдал гэх мэт асуудал тэдэнд маш их байсан боловч Еврей хүмүүс өөрсдийн гайхалтай боловсролын системдээ тулгуурлан 60 жилийн хугацаанд улсынхаа эдийн засгийн чадавхийг 50 дахин нэмэгдүүлэн өндөр технологийн хүчирхэг улс гүрэн болж чадсан юм.

2008 оны 08-р сард Израйль улсаас БНСУ-д элчин сайдаар томилогдон ирсэн Тувиа Израйль /Tuvia Israeli-55 нас/ нь Еврейн их сургуулийг улс төрийн ухааны чиглэлээр суралцан төгссөн дипломатч юм. Тэрээр Еврей хүмүүсийн онцлогийг товчхоноор “Суралцах чин сэтгэл” гэж хэлсэн байна.

Асуулт : Израйль улс дайсагнасан олон улс орноор хүрээлэгдэн хүнд хэцүү нөхцөл байдалд байсан ч улс төр, ардчилал, эдийн засгийн салбарт гайхалтай амжилт гаргаж чадсан. Үүнийг бараг л ид шид гэж хэлж болно. Таны бодлоор нууц нь юунд оршиж байгаа юм бол?

Солонгос, Израйль улсын одоогийн байдал маш төстэй. Хоёр орон хоёулаа маш их зовлон бэрхшээл амссаны эцэст 1948 онд тусгаар тогтносон боловч дахин дайн дажин дэгдэн олон мянган хүн амь насаа алдсан. Үүнээс хойш Солонгос улс “Шинэ тосгоны хөдөлгөөн”–өөр дамжуулан улс орноо гайхалтай удирдан хөгжингүй орон болгож чадсан бөгөөд үүнийгээ “Хан голын гайхамшиг” гэж нэрлэсэн. Харин Израйль улс Киббүц (Kibbutz-хамтран амьдрах гэсэн утгатай) хөдөлгөөнөөр дамжуулан улсынхаа эдийн засгийг сайжруулж чадсан.

Израйль улсын нэг онцлог гэвэл их сургууль байгуулахыг шинээр улс орон байгуулж байгаа юм шиг маш чухалд тооцдог. Үүний нэг тод жишээ гэвэл Израйль улс тусгаар тогтнохоосоо 30 жилийн өмнө дэлхийд алдартай их сургуулийг олноор байгуулж байжээ. 1918 онд хүн ам нь 100,000 ч хүрэхгүй автозам болон бусад үндсэн дэд бүтэц байхгүй байсан Иерусалимд Еврейн их сургууль байгуулагдсан байна. Учир нь боловсон хүчнийг бэлтгэх боловсролын байгууллагыг эхлээд бүтээн байгуулснаар аж үйлдвэр хөгжин улмаар улс орон хөгжлийн замдаа орно гэж бодсон учраас юм. Энэхүү их сургуулийн байнгын хороонд Эйнштэн, Фрүд, Визмэнн /Израйл улсын хамгийн анхны ерөнхийлөгч/ зэрэг хүмүүс орсон байна. Үүнээс хойш үргэлжлүүлэн 1925 онд Technion их сургууль, 1934 онд Визмэнний шинжлэх ухаан

судалгааны төв, 1956 онд одоогийн Израйлийн хамгийн том сургууль болох Tel Aviv их сургуулийг байгуулсан байна. Тухайн үед 2,000,000 хүн амтай байсан жижигхэн улсад /одоо 7,100,000 хүн амтай/ дэлхийн нэр хүндтэй 4 том сургууль байсан гэсэн үг юм. Шинжлэх ухааны "Science" сэтгүүлээс 2008 онд "АНУ-аас бусад орны хамгийн шилдэг судалгааны их сургуулийг шалгаруулсан бөгөөд үүнд Визмэнний шинжлэх ухааны судалгааны төв болон Еврейн их сургуулийг сонгосон байна. Еврей хүмүүсийн боловсролдоо чин сэтгэлээсээ хандан анхаардаг байдал нь 7,100,000 хүн амтай жижигхэн Израйль улсыг дэлхийн өндөр технологийн улс болгосон гол нууц юм.

Асуулт : Бараг 2000 жилийн турш тусгаар тогтнолгүй янз бүрийн улс орноор тэнүүчлэн амьдарч байсан Еврей үндэстэн үндэснийхээ уламжлал ёс заншлыг хэвээр хадгалан үлдэж чадсан. Тэд үүнийгээ "Талмуд" номынхоо хүч гэж үздэг. Тэгвэл өнөөгийн Еврейн нийгэмд "Талмуд" номыг боловсролдоо ашиглаж байгаа юу?

Еврей хүн л бол хэн ч байсан гэсэн "Тора" болон "Талмуд" номыг уншдаг. Харин Библийн хуучин гэрээнд хамаардаг "Тора" ном нь оньсого таавар шиг товч тодорхой гүн гүнзгий утга агуулгатай байдаг. Тийм болохоор үүнийг тайлбарлахын тулд олон янзын салбарын хүмүүс болон шашны удирдагч багш нар хоорондоо асуулт хариулт хэлбэрээр ярилцсаар ирсэн. Эдгээр хүмүүсийн ийнхүү хэлэлцэж ярилцаж байсан зүйл нь эмхлэгдэж цэгцлэгдэн ном болсон бөгөөд энэ нь "Талмуд" юм. Ийнхүү ямар нэгэн зүйлийн талаар хоорондоо санал бодлоо хуваалцан харилцан ярилцан тогтсон хэв маягт баригдалгүй илүү сайн нөхцөл байдлыг эрэлхийлж буй Еврей хэлбэрийн боловсролыг "Талмуд хэлбэрийн боловсрол" гэж нэрлэдэг.

"Талмуд"-ийн боловсрол нь сургуулийн сургалтын хөтөлбөрт ч ихээхэн нөлөө үзүүлдэг. Мэдээж сургууль болгон ялгаатай байдаг. Төгссөнийхөө дараа шашны багшийн эрхтэй болдог Ешива /Yeshiva- Еврей хүмүүсийн уламжлалт боловсролын байгууллага/ гэх мэт шашны сургуульд бол гол хичээлээр заан харин жирийн сургуульд энгийн хичээлүүдийн нэг болгон заадаг. Гэвч нэг тодорхой зүйл гэвэл "Талмуд" ном Еврей хүмүүст "хийх хэрэгтэй зүйл" болон "хийж болохгүй зүйл"-ийг ялгаж салган зааж өгдөг амьдралынх нь гарын авлага юм.

Асуулт : Еврей гэр бүлд эхнэр нөхөр хоёулаа ажил хөдөлмөр эрхлэх тохиолдол их байдаг. Тэгвэл Еврей хүмүүс хүүхэддээ хэр зэрэг анхаарал хандуулдаг вэ?

Израйлийн хүн ам маш олон янзын хэсгээс бүрддэг. Хэт үзэлт үзэл суртлыг баримтлагч (ultra-orthodox) Еврей хүмүүс болон Араб гаралтай Израйль хүмүүс эхнэр нөхөр хоёулаа хөдөлмөр эрхлэх тохиолдол их байдаг бөгөөд эдийн засгийн оролцоо, хүүхэд асрах зэрэг талаараа цэвэр цусны Еврей хүмүүсээс ялгаатай байдаг. Цэвэр цусны Еврей хүмүүсийн тухайд бол хүүхэд асран хүмүүжүүлэх тал дээр эцэг эх хоёулаа эрх тэгш адилхан хариуцлага хүлээдэг. Эхнэр нөхөр хоёулаа хөдөлмөр эрхэлж буй залуу гэр бүлийг төрөөс нь дэмжиж туслах тал дээр маш сайн байдаг. Амаржсан эхнэрийг нь асран халамжлуулахын тулд нөхөрт нь ажлын газраас нь 3 сарын хугацаагаар амралт олгодог бөгөөд нярай-хөхүүл хүүхэд асран хүмүүжүүлэх газруудыг олноор байгуулан эмэгтэйчүүдийг хүүхдээ өсгөнгөө ажиллаж хөдөлмөрлөх боломжоор хангаж өгдөг. Еврей эрэгтэйчүүд эхнэрүүдийнхээ нэгэн адил хүүхдийнхээ боловсролтой холбогдолтой хурал зөвлөгөөнд тасралтгүй идэвхитэйгээр

оролцдог бөгөөд хүүхдүүдтэйгээ хамт сонирхолтой хөгжилтэйгээр цаг хугацааг (quality time) өнгөрөөхөд ихээхэн анхаарал хандуулдаг.

Асуулт : Сүүлийн үед мэргэжилтнүүд хүүхдийн анхан шатны боловсролын чухал чанарыг онцолж үүнд ихээхэн анхаарал хандуулах болоод байна. Еврей хүмүүсийн анхан шатны боловсролын тухайд ямар байдаг вэ?

Энэ бол үнэн. Орчин үед хүүхдийн анхан шатны боловсролд дэлхий нийтээрээ ихээхэн анхаарал хандуулдаг болоод байна. Еврей хүмүүсийн хүүхдийн анхан шатны боловсролын тухайд гэвэл хүүхэддээ бага наснаас нь эхлэн “Тора” болон “Талмуд” номыг уншуулж эхэлдэг бөгөөд уншсан зүйлийнх нь талаар эцэг эхчүүд хүүхэдтэйгээ харилцан ярилцан хүүхдийнхээ бодол санааг цаасан дээр бичих гэх мэтээр маш эртнээс хүүхэддээ анхан шатны боловсролыг олгож эхэлдэг.

Асуулт : Еврей хүмүүсийн боловсролын хамгийн чухал 3 зүйл юу вэ?

Нэгдүгээрт ном унших. Ном уншихын чухал чанарын тухайд гэвэл хичнээн их ном уншсан ч хэтрэхгүй. Хоёрдугаарт эргэлзэж тээнэгэлзэж байгаа зүйлийнхээ талаар хэн нэгнээс асуух. Бусдаас асууж лавласнаар хүний бүтээлч чанар сайжирдаг. Гуравдугаарт бие даасан байдал, ямар нэгэн зүйлд өөрийгөө зориулах чадвар болон алдаа гаргахаас айхгүй байх юм.

Асуулт : Таны бодлоор Солонгос хүмүүс хүүхдийнхээ боловсролын талаар ямар байр суурьтай байгаа вэ?

Солонгос улс гайхмаар эдийн засгийн амжилтанд хүрэхэд боловсролын систем гол нөлөө үзүүлсэн гэдэг нь эргэлзээгүй юм. Миний бодлоор нэг анхаарч сайжруулах хэрэгтэй зүйл гэвэл Еврей хүмүүсийн боловсролдоо ашиглаж буй “асуулт хариултын хэлбэрээр хоорондоо харилцан ярилцдаг боловсрол”-ын арга барилыг боловсролын системдээ ашиглавал илүү сайн үр дүнтэй гэж бодож байна. Яагаад гэвэл мэдэхийг хүссэн зүйлийнхээ талаар айж эмээлгүй бусдаас асууж лавлах нь боловсролын хувьд хамгийн чухал зүйл юм.

Бас нэг анхаарах хэрэгтэй зүйл бол ном унших. Сүүлийн үед Солонгос хүмүүс ном унших тал дээр маш муу болж байгаа юм шиг санагддаг. Энэ бол маш муу зүйл. Сүүлийн 20 жилийн хугацаанд дэлхий ертөнц тэр чигээрээ хувьсан өөрчлөгдсөн. Бид бидний хойч залуу үеийнхэн маань түүх, соёл, урлаг гэх мэт зүйлийнхээ талаар тасралтгүй суралцаж байхаар боловсролын системийнхээ тэнцвэрт байдлыг хадгалах хэрэгтэй. Бид 3D, 4D гэх мэт өндөр техник технологийн талаар яриад л байна. Гэвч доторх агуулга нь гайхалтай сайн биш байвал ямар үнэ цэнэ байх билээ?

Гэр бүлийн боловсрол

Үндэс нь бат бөх байж үр жимс нь ч бат бөх байна

Хүүхдийн боловсролын үндэс бол гэр бүлийн боловсрол

- Мэдлэг боловсролтой хүн хамгийн баян хүн болохыг хүүхэддээ ойлгуулах -

- Зочны өрөөндөө телевизийн оронд номын тавиур байрлуулах -

- Эх хүн бол гэр бүлийн амин сүнс -

- Гэрийн эзний суух сандлыг тусад нь байрлуулах -

- Хоолны ширээний ардах боловсролыг орхигдуулахгүй байх -

- Хүүхдээ баруун гараараа шийтгэн зүүн гараараа тэврэх -

- Нөхөр нь эхнэрээ хүндэтгэн хайрлаж халамжлах -

- Эхнэр нөхөр хоёр бие биеэ хайрлаж халамжилж буй дүр төрхөө хүүхэддээ харуулах -

- Эхийн хэвлийд байх үеэс нь хүүхэддээ боловсрол олгох -

- Бэлгийн амьдралын талаар хүүхэдтэйгээ илэн далангүй байх -

Мэдлэг боловсролтой хүн хамгийн баян хүн болохыг хүүхэддээ ойлгуулах

Уулнаас мод бэлтгэн зарж түүгээрээ амь зуудаг Хиллэл гэдэг нэгэн ядуу Еврей хүн амьдардаг байв. Тэрээр ийм хүнд хэцүү амьдралтай байсан ч оройн цагаар сургуульд яван эрдэм номд хичээнгүйлэн суралцдаг байжээ. Зарим үед идэж уух юмгүй болон хүнд хэцүү байдалтай болдог байсан ч тэр сургуулиа хаяхгүйн тулд өөрт байгаа бүхнээрээ сургалтынхаа төлбөрийг төлөн суралцсаар байв. Гэтэл өвлийн нэгэн хүйтэн өдөр түлээ нь зарагдаагүй учраас тэрээр ямар ч мөнгө олж чадаагүй байна. Мөнгөгүй болохоор сургалтынхаа төлбөрийг төлж чадахгүй болов. Ингээд хичээлдээ сууж чадахгүй болохоор Хиллэл сургуулийнхаа дээвэр дээр гаран цонхонд чихээ наан хичээлээ сонсож эхэлсэн бөгөөд хэсэг хугацааны дараа ядарсандаа нам унтаж орхив. Дараа өдөр нь нэгэн сурагч Хиллэлийг цасанд дарагдсан байдалтай дээвэр дээр унтаж байхыг хараад багшдаа хэлэв. Хиллэлд ямар асуудал үүсээд байгааг мэдсэн багш нь түүнийг сургалтын төлбөр төлөхгүйгээр хичээлдээ сууж болохыг зөвшөөрсөн байна. Энэ явдлаас хойш Еврей хүмүүс бүх хүн сургалтын төлбөр төлөхгүйгээр суралцаж болох төлбөргүй боловсролын системийг хэрэгжүүлж эхэлсэн юм. Хожмын нэг өдөр Хиллэл алдартай сайн багш болсон байна. (Талмуд номны хэсгээс)

“Гэр оронд гал гаран бүх эд хөрөнгөө алдах үед аюулгүй авч үлдэж чадах хөрөнгө юу вэ? Тэр зүйл бол хэлбэргүй, өнгөгүй, үнэргүй”.

Энэ бол Еврей ээж нар хүүхдүүддээ таалгаж байгаа оньсого юм. Хүүхдүүд эхэндээ алмаз юмуу алт зэрэг эрдэнэсийн зүйл бодож байгаад хэлбэр дүрсгүй гэсэн үгийг сонсоод бүгд гүн бодолд орцгоов. Харин ээжийнх нь тэдэнд хэлсэн оньсогоны зөв хариулт бол “мэдлэг боловсрол” байсан юм. Мэдлэг боловсрол бол хэн ч булааж авч чадахгүй хүний үхэх хугацаа хүртэл хүний биед байдаг цорын ганц үнэ цэнэтэй хөрөнгө юм.

Еврей хүмүүс хүүхэддээ зүгээр л хичээлээ хий гэж хэлдэггүй. Хичээлээ хийж эхлэхээс нь өмнө хүүхэд өөрөө ухамсарлаж ойлгохуйц бага зэргийн нандин тайлбар юмуу түүх зэргийг ярьж өгдөг. Энэ нь Еврей үндэстний түүхтэй холбоотой юм. Еврей хүмүүс 2000 жилээс ч урт хугацааны турш бусад үндэстний дарамт шахалтан дор хүнд хэцүү амьдралыг туулж ирсэн. Тийм болохоор гэр орон юмуу эд хөрөнгө нь дайн дажин юмуу гэнэтийн нөхцөл байдлаас шалтгаалан хэзээ ч хамаагүй устаж үгүй болохоор байдалтай байсан. Иймээс Еврей хүмүүс оюуны өмч гэдэг зүйл бол хүн амьд байгаа цагт хэзээ ч хаана ч ашиглаж болохуйц хамгийн эрхэм зүйл гэдгийг биеэрээ ухаарч ойлгосон хүмүүс байдаг. Мэдлэг боловсрол гэдэг зүйл үнэхээр Еврей хүмүүсийн амьдралын гол зэвсэг болохыг (Дээвэр дээрх хийл) зохиолийн зохиолч Шолем Алейчим (Sholem Aleichem) ингэж тайлбарласан байдаг. Тэрээр “Еврей хүмүүс байнга малгайтай явдаг. Учир нь тэд хаашаа ч ямар ч үед явахад бэлэн бэлтгэлтэй байдаг. Тэд нэг газраас зугтан өөр газарт очин амьдаръя гэвэл толгой дотор нь бусдаас илүү гайхалтай мэдлэг байх хэрэгтэй байсан” гэж хэлсэн байна.

Еврей хүмүүсийн ямар нэгэн зүйлийг чин сэтгэлээсээ суралцах чиг хандлагад нь шашны талын үзэл баримтлал нь ч гэсэн нөлөө үзүүлдэг. Еврейн шашинд “Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүний дүр төрх”-ийг оюун ухаантай хүн гэж үздэг. Тиймээс боловсролтой оюун ухаанлаг хүнийг бий болгодог “боловсрол эзэмших” нь хүн төрөлхтний хувьд хамгийн чухал үүрэг юм. Еврей хүмүүс дэлхийд анх удаа манай эриний өмнөх 1-р зуунаас эхлэн үүрэгт

боловсролын системийг нэвтрүүлэн өнчин хүүхэд болон ядуу хүмүүст боловсролын хөнгөлөлтийг үзүүлж байсан учир шалтгаан нь үүнээс үүдэлтэй юм.

Энэхүү боловсролын чухал уламжлал нь өнөөг хүртэл уламжлагдан ирсэн бөгөөд Еврей хүмүүс Израйль улсыг байгуулан хамгийн анх бий болгосон зүйл нь үнэгүй боловсролын систем байсан юм. Израйль улсын засгийн газар тусгаар тогтносны дараа жил болох 1949 оны эхэн үеэс эхлэн санхүүгийн чадавхи, арьсны өнгө хамааралгүй 3-18 насны Израйль хүн хэн ч байсан хамаагүй бүгд үүрэгт боловсрол эзэмших хуулийн төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Тухайн үед өөр бусад оронд ч гэсэн Хятад хүн ресторан нээн, Солонгос хүн сүмийн үйл ажиллагаа эрхлэн, Еврей хүн хурал цуглааны танхим (synagogue) байгуулж байв. Синагог нь Еврей шашинтай хүмүүсийн мөргөлийн газар төдийгүй боловсролын байгууллага юм.

Мэдлэг хамгийн том хөрөнгө гэдэг нь асар их хөрөнгө мөнгө, нэр алдрыг өөртөө бодитоор бий болгож чадсан олон олон Еврей хүмүүсийн амьдралаар нотлогдсоор байна. 2000-2001 онд хийсэн нэгэн судалгаанаас харвал АНУ-ын Еврей гэр бүлийн жилийн дундаж орлого 75,000 доллар байсан бөгөөд энэ нь АНУ-ын жирийн гэр бүлийн дундаж орлогоос 2 дахин их юм. Мөн АНУ-ын докторантурын сургууль төгссөн Еврей хүмүүс нийт төгсөгчдийн 25 хувийг эзэлж байхад эсрэгээрээ Америк хүмүүсийн эзлэх хувь 6 хувиас ч хэтрэхгүй байсан юм. Ингээд тооцоолоод үзвэл докторантурын сургуулийг төгссөн Еврей хүмүүс 4 дахин их байсан гэсэн үг юм.

Зочны өрөөндөө телевизийн оронд номын тавиур байрлуулах

Манай эриний өмнөх 70 онд Иерусалим Ромын цэргүүдэд бүслэгдэн яах ч аргагүй булаан эзлэгдэхээр болсон байна. Иерусалимын удирдлагын байран дээр байсан Агиба гэдэг багш улс орон нь гадны хүмүүст булаан эзлэгдэх цаг хугацаа ойрхон байгааг мэдээд шөнийн харанхуйг үл тоомсорлон хоргодож байсан хэрмээсээ гаран Ромын цэргүүдийн байрлаж байсан газар луу явав. Замдаа хэд хэдэн удаа үхэлтэй нүүр тулгарсан тэрээр энэ бүхнийг даван туулсаар Ромын цэргүүдийн байрлаж байсан газар ирэн цэргийн командлагч Бэсбэжянтай уулзан түүнээс нэг зүйлийг гуйсан байна. Тэрээр "Танай цэргүүд манай хот руу дайрах үед гал тавих юмуу дээрэм тонуул хийх нь мэдээж. Бүх зүйлийг эвдэж сүйтгэж болох боловч зөвхөн сургуулийн барилгыг маань эвдэж сүйтгэлгүй хэвээр үлдээгээч. Хааны ордон юмуу сүм хийдээс илүү Еврей үндэстний ирээдүй болсон боловсролоо хэвээр үргэлжлүүлэх нь миний туйлын хүсэл юм" гэж хэлсэн байна. Ромын цэргийн командлагч түүний гуйлтыг сонсоод "Энэ зэргийн зүйл юм бол би чиний гуйлтыг биелүүлнэ" гэж амлав. Ийнхүү дайн болсны дараа зөвхөн нэг жижигхэн сургуулийн барилга л бүтэн үлдсэн байв. (Талмуд номны хэсгээс)

Ихэнхи Еврей гэр бүл зочны өрөөндөө телевиз тавьдаггүй. Харин оронд нь дүүрэн номтой номын тавиур, ном уншин хоорондоо ярилцаж болохуйц ширээ сандал зэргийг байрлуулдаг. Хэрвээ телевиз байвал хүүхдэд зориулсан хөтөлбөр дуусан насанд хүрсэн хүмүүсд зориулсан телевизийн хөтөлбөр гарч эхэлмэгц телевизээ унтраадаг. Еврей хүүхдүүд бага наснаасаа эхлэн телевизийн хөтөлбөрөөс зөвхөн хүүхдэд зориулсан хөтөлбөр л үзэх ёстой гэсэн ухамсраар хүмүүждэг. Гэр бүлийн гишүүд бүгд хамтдаа суун хооллонгоо хоорондоо илэн далангүй бүх зүйлээ ярилцдаг хоолны цаг дээр телевизээ асаалттай байлгана гэдэг Еврей хүмүүсийн хувьд төсөөлөхөд хэцүү зүйл. Ер нь хүүхэд эцэг эхээ харан тэдний хийж буй үйлдлийг байгаагаар нь хуулбарлан дуурайдаг учраас юуны түрүүнд эцэг эхчүүд өөрсдөдөө анхаарал хандуулан хүүхэддээ зөв үлгэр дууриал болох хэрэгтэй.

Еврей хүмүүс зочны өрөөндөө телевиз тавьдаггүй эхний учир шалтгаан нь харах мэдрэхүйгээр дамжуулан хүүхдэд нөлөөлж буй дэлхий ертөнцийн өнөөгийн соёл иргэншлийн сөрөг талыг хязгаарлахын тулд юм. Еврей хүмүүс насанд хүрээгүй байхдаа хүүхэд үзэж болохгүй зүйлийг үзэхгүй байх ёстой ингэснээр хүүхэд хичээл номондоо чин сэтгэлээсээ хандаж чаддаг гэж үздэг. Еврей эмэгтэйчүүд "Time" "News Week" зэрэг цаг үеийн байдлын талаарх сэтгүүлд хэтэрхий ил задгай хувцасласан эмэгтэй хүний зураг юмуу садар самууны холбогдолтой сурталчилгаа, мэдээлэл орсон байвал тэр хэсгийг нь салгаж авсны дараагаар номын тавиуртаа хийдэг.

Хоёр дахь учир шалтгаан нь видео бичлэгээр дамжин ирж байгаа муу нөлөөллөөс хүүхдээ хамгаалах юм. Бага наснаасаа эхлэн видео бичлэгт хэт их дассан хүүхэд цаг хугацаа өнгөрөх тусам илүү хүчтэй зүйлийг мэдрэхийг хүсэхээр болдог. Жижигхэн үсгээр шигүү бичигдсэн номыг хүүхэддээ уншуулахгүй байх нь энгийн мөртлөө маш үр дүнтэй зүйл юм. Хүүхэд анги дээшлэх тусам хүнд хэцүү агуулгатай ном унших шаардлага аяндаа бий болдог болохоор бага наснаасаа эхлэн хэтэрхий хүнд агуулгатай юмуу шигүү бичигдсэн ном уншуулвал өсөж том болоод ном унших сонирхолгүй болон хичээл сурлагандаа муудах тохиолдол их байдаг. 1996 онд Нобелийн шагнал авсан Австралийн Мэлбоурн (Melbourne) их сургуулийн Питер Дохерти багш "Намайг Нобелийн шагнал авахад хамгийн их нөлөөлсөн зүйл бол ном унших байсан.

Намайг хүүхэд байхаас эхлэн аав, эмээ хоёр маань надад маш их ном уншиж өгдөг байсан. Би 6 настайгаасаа эхлэн өөрөө бие даан ном уншиж эхэлсэн. Миний ном их уншдаг учир шалтгаан нь шинэ санаа олохын тулд юм. Телевиз бол ном уншихтай харьцуулахад бидэнд гүн гүнзгий утга санааг дамжуулж өгч чаддаггүй" (2006 он Курё их сургуулийн лекц) гэж хэлсэн байна. Видео бичлэгийн муу нөлөө сургуулийн боловсролд хүртэл нөлөөлж байгаа бөгөөд дэвшилтэт технологийн шийдлээр янз бүрийн видео бичлэгийг ашиглаж буйгаа хөгжингүй орны боловсрол хэмээн сайрхаад байгаа Солонгос улсаас нэг өөр тал нь Еврей хүмүүс сургуульд видео бичлэг ашиглан зааж буй боловсролдоо ихээхэн нухацтай ханддаг.

Хэрвээ гэрт телевиз байхгүй бол бидний амьдралд ямар өөрчлөлт гарах бол? АНУ-ын Eastern Washington их сургуулийн Барбара Брүк (Barbara Brook) доктор 385 гэр бүлийг хамруулан телевиз үзэхгүй байх үед бий болж буй гэр бүлийн өөрчлөлтийн талаар судалгаа хийсэн байна. Гэрт нь телевиз байхгүй гэр бүлийн хүүхдүүдийн 51 хувь нь бүх хичээл дээрээ А үнэлгээ авч байсан бөгөөд эцэг эхчүүдийн 83 хувь нь үүнийг гэрт нь телевиз байхгүй байгаагийн үр дүн гэж тайлбарласан байна. Гэртээ телевизгүй айлын телевиз үзэхийн оронд хийх зүйлсийн 1-рт ном унших байсан бөгөөд (тоглоом тоглох, дуртай зүйлээ хийх, биеийн тамираар хичээллэх) судалгаанд оролцогчдын 85 хувь нь гэр бүлийн гишүүдтэйгээ хамт байж тэдэнд зарцуулах цаг нэмэгдсэн гэж хэлсэн байна. (17 хувь нь өдөрт 2 цагаас дээш, 37 хувь нь өдөрт 1-2 цаг, 31 хувь нь 30 минутаас 1 цагийг гэр бүлийн гишүүддээ зарцуулсан байв)

"Бүхий л амьдралын үндэс суурь бага сургуулийн 4-р ангид тавигддаг" номын зохиолч Ким Мён Уг одоо их сургуулийн оюутан болсон том хүү нь 4 насны үедээ хүүхэлдэйн кинонд маш их сонирхолтой болон телевизийн өмнө тасралтгүй хэдэн цагийн турш сууж байгаа байдлыг хараад санаа зовон гэртээ телевизгүй болохоор шийдсэн байна. Гэвч тэрээр энэхүү шийдвэрээ бодитоор хэрэгжүүлэн гэртээ телевизгүй болох хүртэл 2 жилийн хугацаа зарцуулсан байна. Энэ хугацаанд хүүхдийнхээ телевиз үзэх цагийг нь багасган ном уншуулж эхэлсэн бөгөөд цаг хугацаа өнгөрөх тусам хүүхдийнхээ ном унших хэмжээг нэмэгдүүлсээр байсан байна. Үүний үр дүнд том хүү нь бага сургуулийн 6-р ангид орох үедээ том жижиг нийлсэн бараг 5000 дээш ном уншсан байв. Тэрээр хүүхэд нь гараа л хүргэвэл номонд хүрч байхаар хүүхэд уншихад тохиромжтой хэдэн зуун номыг гэрийнхээ энд тэндгүй байрлуулсан байна. Кимийн гэр бүл сонин, сэтгүүл, номоор дамжуулан дэлхий ертөнцийн талаарх мэдээллийг авдаг байна. Орчин үед хүмүүс телевизэд хэтэрхий дассан байдалтай байгаа бөгөөд телевиз байхгүй бол бараг л дэлхий ертөнцтэй харьцах боломжгүй болон хаагдмал байдалтайгаар амьдарч байгаа мэтээр эндүүрч байгаа юм.

Солонгос хүмүүсийн нэг өдөрт телевиз үзэхэд зарцуулж байгаа дундаж хугацаа 2 цагаас ч илүү байдаг. Хүний бүхий л амьдралын хугацаагаар тооцоод үзвэл унтах цагийг хасаад 10 жилээс ч илүү хугацааг зөвхөн телевиз үзэхэд зарцуулж байгаа гэсэн үг юм. Хэрвээ бид энэ их цаг хугацааг ном унших, хоорондоо харилцан ярилцах, дуртай зүйлээ хийх, тоглоом тоглох зэрэгт ашиглавал бидний амьдралд маш их өөрчлөлт гарна. Еврей хүмүүсийн тухайд гэвэл телевиз үзэх энэ цаг дээр хүүхэдтэйгээ "Тора" болон "Талмуд" номоо хамт уншин хоорондоо ярилцдаг. Еврей хүмүүс хүүхдээ бага наснаас нь эхлэн ном уншуулан уншсан зүйлийнх нь талаар хүүхэдтэйгээ харилцан ярилцах байдлаар дамжуулан ямар нэгэн зүйлийн талаар задлан шинжилж уялдаа холбоог нь олох чадварыг нь сайжруулдаг. Еврей хүмүүс АНУ-ын боловсрол, хууль, хэвлэл мэдээллийн салбарт байнга тэргүүлэх байр суурьтай байдаг нь

энэхүү учир шалтгаанаас болж байгаа юм. Еврей эрдэмтэн юмуу урлагийн хүн аль нь ч байсан хэл ярианы тал дээр маш сайн хүмүүс байдаг бөгөөд мөн бичиг хэрэг хөтлөхдөө ч гаргууд сайн байдаг. Тиймээс бид Еврей хүмүүс яагаад гэр, сургууль дээрээ видео бичлэгт анхаарал хандуулалгүй ном унших, хоорондоо харилцан ярилцах тал дээр түлхүү анхаарч байгаа учир шалтгааныг сайтар тунгаан бодож үзэх хэрэгтэй юм.

Бид зөвхөн телевиз гэлтгүй видео тоглоом, интернэт гэх мэт цаг хугацаа өнгөрөх тусам улам олон төрөл зүйлээр нэмэгдсээр байгаа хөгжингүй нийгэмд амьдарч байгаа бөгөөд энэхүү дүрст видео бичлэгтэй холбогдол бүхий тохиромжтой зохицуулалт бидэнд ихээхэн шаардлагатай байгаа юм. Бид янз бүрийн видео бичлэгийн муу нөлөөллийн талаар нухацтай бодож үзэхэд дараах учир шалтгаан байгаа юм.

1-рт. Видео бичлэг нь хүний анхаарал хандуулах чадвар болон мэдрэмжийг маш хүчтэй цочроон хүнд байнга гоё мэдрэмж өгөн амар тайвныг мэдрүүлдэг. Тийм болохоор хүн дахин дахин үзэх хүсэл төрдөг бөгөөд энэ нь яг л ямар нэгэн эмийн бүтээгдэхүүнд донтсон байдалтай төстэй зүйл юм. Анх төлөвлөсөн цагаасаа хэтрүүлэн телевиз үзэх юмуу тоглоом тоглох, хоол идэх юмуу гэрийн ажил хийж байхдаа ч телевизээ байнга асаалттай байлгадаг нь нэг ёсондоо донтож байгаа хэлбэр юм.

Солонгос улсын видео тоглоомын хөгжлийн хорооноос хийсэн 2006 оны судалгаанаас харвал залуучуудын 10 хүн тутмын 6 нь видео тоглоомноос болон хичээл сурлагандаа муудсан гэсэн дүгнэлт гарсан байна. Өдөрт 2 цагаас дээш хугацаагаар тоглоом тоглодог залуучуудын 29,3 хувь нь “Тоглоом тоглож эхлэхийн өмнөх үеэс сурлагын дүн муудсан” гэж хариулсан бол 28,8 хувь нь хичээл сурлагандаа чин сэтгэлээсээ хандахаа байсан гэж хариулсан байна. Мөн 69,7 хувь нь “Нэг мэдэхэд анх төлөвлөсөн хугацаанаасаа илүү удаан хугацаагаар тоглоом тоглосон байсан” гэж хариулжээ. Энэ нь эхлээд 1 цаг тоглоод болино гэж бодож байснаа эцэстээ 2 цаг, 3 цаг тоглоом тоглодог болсон гэсэн үг юм.

2-рт. Видео бичлэг нь хүүхдүүдийн сурлагын түвшинг бууруулдаг хамгийн гол буруутан юм. АНУ-ын Калифорнийн техникийн их сургуулийн нэгэн тайланд тусгаснаар бол видео бичлэг хэт их үздэг хүүхдүүдийн зүүн тархины үйл ажиллагаа ихээхэн муудсан байдаг байна. Хүний баруун тархи бүтээлч чадвар, ямар нэгэн зүйлийг шууд хүлээн авч ойлгох чадварыг харин зүүн тархи хэлний чадвар болон тооны сэтгэлгээний чадварыг хариуцсан байдаг. Хүний зүүн тархины үйл ажиллагаа муудвал тунгаан бодох чадвар, задлан шинжилж дүн шинжилгээ хийх чадвар муудан унших, бичих, тооцоолох чадвар буурдаг.

Нью-Йорк хотын хүний мэдрэлийн анагаах ухааны судалгааны төвөөс гаргасан дипломын ажилд бичсэнээр бол хүүхэд телевиз их үзсэнээр ном унших болон гэрийн даалгавраа хийх цагаасаа хумслаад зогсохгүй төвлөрөх чадвар нь муудан сургуулийн амьдралд сонирхол нь буурдаг. Телевизийн өмнө ихэнхи цагаа өнгөрөөдөг залуучуудын дунд сайн их сургуульд элсэн орж чадахгүй байх, төвлөрөх чадвар муудах, хичээл сурлагандаа муу болох, сургуулийн амьдрал хичээл номондоо сонирхолгүй идэвхигүй болох хандлага их ажиглагддаг.

3-рт. Видео бичлэгийн бас нэг хор уршигтай тал нь хүүхдийг хүчирхийлэгч болгодог. АНУ-д хүн насанд хүрэхээсээ өмнө буюу бага сургуулиа төгсөх хүртлээ 8000 удаагийн аллага, 100,000 удаагийн ямар нэгэн хүчирхийллийг видео бичлэгээр дамжуулан үзсэн байдаг гэсэн

судалгаа гарсан байна. Гэхдээ энэ тоо бол зөвхөн телевизээр дамжуулан үзсэн байдлыг судалж гаргасан дүгнэлт бөгөөд кино театрт үзсэн кино, компьютерын видео тоглоом гэх мэт бусад видео мэдээллийг оруулвал энэхүү тоо улам нэмэгдэх нь гарцаагүй юм. Мөн Ньюрк хотын хүний мэдрэлийн анагаах ухааны судалгааны төвөөс хийсэн судалгаанаас харвал бага сургуулийн сурагчдын телевиз үзэх цаг их байх тусам гэмт хэрэгтэй холбогдох хувь нь нэмэгддэг болохыг тогтоосон байна.

4-рт. Хүүхэд насанд хүрэхээсээ өмнө садар самуунтай холбогдолтой видео бичлэгийг байнга үзсээр байвал тэр хэмжээгээрээ эрт бэлгийн амьдралд хөл тавихаар болдог бөгөөд үүнээс шалтгаалан сэтгэл санаа болон бие махбодийн хохирол амсдаг. АНУ-ын 2001-2002 онд 1,792 залуучуудыг хамруулан хийсэн нэгэн судалгаанаас харвал “Sex and City” “Friends” гэх мэт садар самууны агуулга бүхий олон ангит киног тогтмол үзэж байсан 10-19 насныхан ийм төрлийн кино үздэггүй үеийнхэнтэйгээ харьцуулахад бэлгийн харьцаанд орох хувь нь 2 дахин их байсан байна.

5-рт. Видео бичлэг нь хүний сэтгэн бодох чадварыг муутгадаг. Телевиз нь үзэж байгаа хүнийхээ харах мэдрэхүйд тохирч байхын тулд дэлгэцээ 1-2 секунд тутамд байнга өөрчлөн сольж байдаг учраас хүний захын мэдрэл болон мэдрэхүйг цочроож өгдөг. Хүн бага наснаасаа эхлэн тогтмол телевиз үзсээр байвал яваандаа аливаа зүйлийг гүнзгий тунгаан бодох чадвараа алддаг. Телевиз үзнэ гэдэг нь өгөгдөж байгаа цочролыг тэр байдлаар нь хүлээн авч буй хүний идэвхигүй үйл ажиллагаа юм. Хүн аливаа зүйлд чин сэтгэлээсээ хандан санаачлагатайгаар ажиллах үед төвлөрөх чадвар сайжран бүтээлч чанар ч нэмэгддэг. Харин бага наснаасаа эхлэн видео бичлэгт хэт их дассан хүүхдүүд цаг хугацаа өнгөрөх тусам улам илүү мэдрэмж өгч чадах зүйлийг эрэлхийлэхээр болдог бөгөөд яваандаа бусад бүх зүйлийг видео бичлэгтэй харьцуулан бага мэдрэмж өгөн сонирхолгүй байвал орхидог төдийгүй ном уншиж хичээл ном хийхээс ч мөн хөндийрч эхэлдэг.

6-рт. Телевиз нь хүмүүс хоорондын харилцаа болон сэтгэл хөдлөлийн боловсролд ч сайн нөлөө үзүүлдэггүй. Видео бичлэгт дассан хүүхдүүд телевиз юмуу компьютерын өмнө суух маш дуртай байдаг. Тэдний хувьд найз нөхөдтэйгээ уулзан ярилцах, тоглож наадах, байгаль дэлхийтэйгээ харилцах тал дээр сонирхол бараг байдаггүй. Ийм байдал удаан үргэлжилвэл хүүхдийн нийгэмших байдал муудан бусад зүйлээс хол хөндий зожиг хүн болох аюултай болно гэсэн үг юм.

Эх хүн бол гэр бүлийн амин сүнс

Ромын эзэн хаан Габрэйл гэдэг шашны багшаас "Эмэгтэй хүн эрэгтэй хүний хувьд хэн бэ? Бидний мэдэж байгаагаар Библи номонд бичсэнээр бол Еврей үндэстний бурхан Адамийг унтуулан хавирганаас нь нэгийг аван эмэгтэй хүнийг бүтээсэн гэдэг. Тэгвэл Еврей үндэстний бурхан хулгайч биш гэж үү? Тэр үед хажууд нь байсан хүн цагдаа дуудах хэрэгтэй байсан юм биш үү?" гэж асуусан байна. Багш Габрэйл түүний хариуд ингэж хариулав. "Өнгөрсөн шөнө манай гэрт хулгайч ороод мөнгөн халбага савхыг маань хулгайлаад алтан архины хундагыг маань орхиод явсан байна. Энэ бол үнэхээр баярлуушитай зүйл юм. Бурхан бидэнд эмэгтэй хүнийг өгсөн нь яг үүнтэй адилхан зүйл юм" гэж хариулжээ. Энэ нь эрэгтэй хүн эмэгтэй хүнтэй цуг байвал алдах зүйл байдаг ч эмэгтэй хүн бол бүхий л амьдралынх нь турш хамт амьдрах хамгийн сайн хань нөхөр гэсэн үг юм. (Талмуд номны хэсгээс)

2008 оны 6-р сард хэвлэгдэн гармагцаа дэлхийн шилдэг борлуулалттай ном болж чадсан "Sway"-номыг Израйлд төрөн АНУ-руу нүүж ирсэн Ром Брэфмэн (Rom Brafman, 37 настай) болон Ори Брэпмэн (Ori Brafman, 35 настай) ах дүү нар зохиосон юм. Ром нь Флоридагийн их сургуулийг сэтгэл судлалын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан бөгөөд дүү Ори нь Стэнфордийн их сургуулийн бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй (MBA) юм. Ах дүү хоёр ийм залуу насандаа дэлхий дахинд танигдсан шилдэг борлуулалттай ном бичсэнийгээ "Ээжийнх нь ач тус" гэж хэлсэн байна. Эдгээр залуус "Бид тийм гайхалтай оюун ухаантай сод хүмүүс биш. Харин ээж маань биднийг хичээл номонд сонирхолгүй болгохгүйн тулд бидэнд маш их анхаарал халамж тавьдаг байсан болохоор өнөөдрийн энэхүү амжилтанд хүрч чадсан" гэж тайлбарлажээ.

Ромийн ярианд анхаарлаа хандуулцгаая. Тэрээр "Бага байхад ээж маань биднийг хичээлээ тараад ирэх үед биднээс өнөөдөр хичээлийн цаг дээрээ багшаасаа юу асуусан бэ? гэж тогтмол асуудаг байсан. Ээж маань биднээс өдөр болгон ингэж асуудаг байсан болохоор зарим үед багшаасаа асуух зүйл байхгүй байсан ч бид албаар асуулт зохион багшаасаа асуулт асуудаг байсан" гэж хэлсэн байна. Өдөр болгон багшаасаа ямар нэгэн зүйлийн талаар асууж лавласаар хүүхдүүдээ хичээлдээ сонирхолтой болтол нь удирдан чиглүүлж өгч чадсан ээжийнхээ ачаар эдгээр 2 залуу дэлхийд борлуулалтаараа тэргүүлж чадсан гайхалтай зохиолыг бичиж чадсан юм.

"Дэлхий ертөнцийг удирдан чиглүүлж байгаа улс АНУ, харин АНУ-ыг удирдан чиглүүлж байгаа хүмүүс бол Еврей хүмүүс" гэсэн үг байдаг. Еврей ээж нар ийм арга барилаар хүүхэддээ боловсрол олгодог бөгөөд үүний үр дүнд дэлхий ертөнцийг удирдан чиглүүлэх шилдэг хүмүүс олноор төрөн гарсаар байна. Хүний оюун ухааны задлан шинжлэх ухааныг үндэслэгч Фрүд нь "Би гайхалтай хүн болохоор хичээсэн нь ээж маань надад итгэсэн учраас юм" гэж хэлсэн байдаг. Хичээл сурлагандаа муу Эйнштэнийг эрдэмтэн болгосон гол зүйл бол ээжийнх нь тэвчээр, ухаалаг байдал байсан юм. Ээж нь Эйнштэнийг хичнээн их зүйл асуусан ч уурлах юмуу төвөгшөөлгүйгээр чин сэтгэлээсээ хариулдаг байсан байна. Хэрвээ мэдэхгүй зүйл гарвал хүүхэддээ үнэнээр нь мэдэхгүй гэж хариулан хамтдаа зөв хариултыг нь олдог байв. Түүний ээж хүүхэд нь заримдаа сурлагын дүн нь муудан буруу зүйл хийсэн ч хүүхдийнхээ нөөц бололцоонд итгэж найдан сайн талыг нь олж илрүүлэн сайжруулахын тулд

хамаг анхаарлаа хандуулдаг байсан байна. Эйнштэнийг бусад хүүхдээс өөр, бусдаас илүү чадвартай гэдэгт итгэсэн ээж нь байнга түүнийг урамшуулан дэмжиж байсан болохоор Эйнштэн тэрхүү өвөрмөц тооны чадвараа харуулж чадсан юм.

Нэгэн сайн эхнэр нөхөр хоёр зайлшгүй шалтгаанаас болон салсан байна. Нөхөр нь салсныхаа дараа нэг муу эмэгтэйтээ дахин гэрлэн амьдралаа эхэлсэн бөгөөд тун удалгүй тэр эмэгтэйтэйгээ адилхан муу эрэгтэй болсон байна. Эхнэр нь харин нэг муу залуутай дахин гэрлэсэн боловч хэсэг хугацааны дараа нөгөө эрэгтэй нь сайн хүн болсон байв. (Талмуд номны хэсгээс)

Гэр бүлийн боловсролд эмэгтэй хүний эзлэх байр суурь шийдвэрлэх байр суурийг эзэлдэг нь бас нэгэн учир шалтгаан нь гэр бүлд эр нөхрөө “өрхийн тэргүүн” гэдгийг хүүхдүүддээ ойлгуулдаг чухал хүн бол эмэгтэй хүн байдаг учраас юм. “Талмуд” номонд эмэгтэй хүнийг “гэр бүлийн амин сүнс” гэж илэрхийлсэн байдаг ба номны олон хэсэгт эмэгтэй хүний ухаалаг байдал болон үнэ цэнэтэй чанарын талаар онцолсон байдаг.

Чи эр нөхрөө хаан шиг хүндэтгэвэл тэр чамайг өөрийн хатан шигээ хүндлэн хайрлах болно. Харин өөрийн чинь үйл хөдлөл зарц шиг байвал тэр чамтай зарцтай харьцаж байгаа юм шиг харьцана. Эр нөхөр чинь найз нөхөдтэйгээ уулзахаар явах үед хамт явахаар болвол усанд орон гоё сайхан хувцасаа өмсөн явах хэрэгтэй. Нөхрийн чинь найз нөхөд гэрт чинь ирвэл тэдэнд чин сэтгэлээсээ хандан хүндэтгэлтэй харьцаарай. Тэгвэл эр нөхөр чинь чамайг улам их хайрлаж халамжлан улам үнэ цэнэтэй хүнд тооцно. Гэр бүлдээ сайн анхаарал хандуулан эр нөхрийнхөө хэрэглэдэг эд зүйлсийг үнэ цэнэтэйд тооцоорой. Тэгвэл тэр баяр хөөртэйгээр чиний толгойд хатны титмийг зүүж өгөх болно. (Талмуд номны хэсгээс)

Хэрвээ хэт туйлширсан байдлаар үүнийг тайлбарлавал Еврей хүн гэвэл эх нь Еврей хүн байж л Еврей хүн гэж хэлж болох юм. Эцэг нь Солонгос хүн байна уу Хятад хүн байна уу хамаагүй төрүүлсэн эх нь Еврей хүн байх ёстой гэсэн үг юм. Төрүүлсэн эх нь л Еврей хүн бол түүний үр удам ямар ч болзолгүйгээр Еврей хүн гэсэн үг юм. Эцэг нь хичнээн гайхалтай сайн Еврей хүн байсан ч төрүүлсэн эх нь Еврей хүн биш бол хүүхэд нь Еврей хүн биш юм. Зөвхөн Еврей үндэстэн л эх хүнийг өөрийн үндэстнийхээ уламжлалт чанарыг ялгаж салгаж чаддаг гэж үздэг. Учир нь тэдний хувьд эх хүн гэдэг бол хамгийн шилдэг багш төдийгүй Еврей үндэстэн болон эх орных нь ирээдүйг хариуцан авч явах хүүхдүүдийг өсгөж хүмүүжүүлж буй чухал хүн юм.

Солонгос эмэгтэйчүүд ч гэсэн Еврей хүнээс дутахааргүй гэр бүл, эр нөхөр болон үр хүүхдийнхээ төлөө зүтгэдэг. Ялангуяа хүүхдийнхээ төлөө бол юу ч хамаагүй амь биеэ хайрлалгүй зүтгэж чаддаг хүмүүс. Гэвч нэг харамсалтай зүйл гэвэл цаг хугацаа өнгөрөх тусам хүүхдийнхээ боловсролын асуудлыг хэтэрхий хөрөнгө мөнгөтэй холбон авч үздэг болж байгаа бөгөөд мөнгөтэй л байвал хүүхдийнх нь боловсролын үндэс суурь бат бөх тавигдах юм шиг андуурч байна. Солонгос улсын нийгэм бага насны хүүхдийн халамжийн тухайд хангалттай тусламж дэмжлэг үзүүлж чадахгүй байдалтай байна. Гэвч зөвхөн мөнгө байлаа гээд бүх асуудал шийдэгдэнэ гэж үү?

Хойд Солонгосын хөл бөмбөгийн багийн Жон Дэ Сэ /26 настай/ тамирчин Токиогийн их сургуулийн багууд дотроос ур чадвараараа нилээн доогуур түвшинд харъяалагдах Чусон их

сургуулиас гаралтай нэгэн юм. Чусон их сургуулийг төгссөн сурагчдаас Японы хөлбөмбөгийн мэргэжлийн лигийн шилдэг багт орсон анхны тамирчин бол Жон Дэ Сэ байсан юм. Тэрээр эхэндээ туршлага муу байсан болохоор багт орсныхоо дараа байнга нөөц тоглогчийн суудалд суудаг байв. Чусон их сургуульд сурч байх үед түүнд сайн багтай тоглож үзэх боломж огтхон ч гараагүй байна. Тухайн үед Япон улсад хүн барьцаалах гэмт хэрэг газар авч байсан бөгөөд үүнээс шалтгаалан сэтгэл зүйн хувьд ч тэрээр маш хүнд хэцүү байдалтай байв. Тиймээс эдгээр хүнд хэцүү нөхцөл байдлуудыг даван туулъя гэвэл эцэст нь дасгал сургуулилтаа хичээнгүй хийхээс өөр аргагүй байсан юм.

Түүний ээж И Жон Гым нь хүүгээ Японы хөлбөмбөгийн багт орсноос хойш 3-н жилийн турш нэг ч өдөр алгасалгүй хүүхэдтэйгээ утсаар ярьдаг байсан байна. Тэрээр утсаар ярих болгондоо хүүгээсээ “Өнөөдөр дасгал сургуулилтаа хэр зэрэг хийсэн бэ?” гэж асуудаг байв. Ингэж утсаар ярих болгонд хүү нь “Би хөлбөмбөгийн тамирчин болохоор дасгал сургуулилтаа өөрөө мэдээд сайн хийж байгаа. Таны байнга ингэж ярихыг сонсоход үнэхээр залхмаар байна” гэж заримдаа ээжийнхээ яриаг төвөгшөөдөг байсан ч ээжийнх нь асуулт сэтгэл дотор нь байнга бодогдон “Үнэхээр дасгал сургуулилтаа сайн хийж байна шүү” гэж хэлүүлэх хэмжээгээр дасгал сургуулилтаа маш шургуу хийсэн байна.

Мөн түүний ээж хүүхэд нь биеийн тамираас өөр зүйл мэдэхгүй хүн болвол байр суурь нь тийм ч бат бөх биш болно гэж бодон Жон Дэ Сэ-д бага наснаас нь эхлэн ахлах сургууль хүртэл нь төгөлдөр хуур зааж өгсөн байна. Жон Дэ Сэ тамирчин ч зураг маш сайн зурдаг. Ээжийнх нь хамгийн их хайрладаг зүйл гэвэл хүү нь ахлах сургуулиа төгсөх үед авсан 12 жилийн турш хичээл таслаагүй хичээлдээ суусан гэсэн шагнал юм. Тамирчин Жон Дэ Сэ-г амжилтанд хүргэсэн гол зүйл бол ээжийнх нь байнга өгч байсан урам зориг, хайр халамж байсан юм. Дүгнээд хэлэхэд энэ зүйл бол мөнгө биш байсан юм.

Гэрийн эзний суух сандлыг тусад нь байрлуулах

Хөдөө амьдардаг нэг Еврей хүн хүүхдээ Иерусалимын сургуульд элсүүлсэн байна. Хүүхэд нь сургуульд сурч байх хооронд тэрээр хүнд өвчин тусан үхлийн ирмэгт ирсэн бөгөөд хүүхэддээ гэрээслэл бичиж үлдээжээ. Тэрээр гэрээслэлдээ өөрийн бүх эд хөрөнгөө нэг зарцдаа өвлүүлэн харин тэр дундаас хүүхдийнхээ авахыг хүссэн зөвхөн нэг зүйлийг өөрийн хүүхэддээ өгөөрэй гэж бичсэн байв. Эцгийгээ оршуулсны дараа хүү багш дээрээ очин гомдолтойгоор ингэж хэлэв. ”Эцэг маань яагаад надад хөрөнгөнөөсөө жаахан ч гэсэн өвлүүлж үлдээгээгүй юм бол?” Багш нь түүнд ингэж хариулав. “Аав чинь чамайг чин сэтгэлээсээ хайрласан учраас ийм шийдвэр гаргасан” гэжээ. Үүнийг сонсоод хүү сайн ойлгож чадахгүй байгааг анзаарсан багш нь түүнд аавынх нь гэрээслэлийн талаар тайлбарлаж өгсөн байна. “Эцэг чинь боол нь хөрөнгийг нь аван зугтах юмуу бүгдийг урэн таран хийхгүй гэж бодоод бүх хөрөнгөө зарцдаа өвлүүлэн үлдээсэн. Эцэг чинь ингэж хандсан болохоор тэр боол маш их баярлан эцгийн чинь хөрөнгийг маш сайн харж хамгаална. Тийм болохоор эцэг чинь боолдоо хөрөнгөө өвлүүлэн үлдээсэн юм”. Үүнийг сонссон хүү бас л ойлгосонгүй “Ингэх нь надад ямар хэрэгтэй юм бэ?” гэж багшаасаа дахин асуув. Хариуд нь багш “Чи нас залуу болохоор нарийн учрыг нь сайн ойлгохгүй байх шиг байна. Боол хүний бүх хөрөнгө бүгд эзэндээ харъяалагддаг болохыг мэдэхгүй гэж үү? Эцэг чинь чамд хүссэн нэг зүйлийг чинь өгнө гэж тодорхой хэлсэн байгаа биз дээ” гэж хэлэв. (Талмуд номны хэсгээс)

К ..... бол нэгэн томоохон компаний ажилчин. Тэрээр 40 орчим настай бөгөөд компаний ажлаасаа шалтгаалан тун завгүй амьдардаг нэгэн юм. Тэрээр ажил тарсны дараа олноороо хоолонд орох юмуу янз бүрийн уулзалтанд байнга явахаар болдог байна. К ..... гайгүй нэр хүндтэй докторантурын сургуулийн удирдлагын ухааны сургалтыг дүүргэсэн бөгөөд ахлах сургуулийнхаа нэг төгсөлтийнхний даргын албан тушаалыг ч давхар хашдаг. 7 хоногийн амралтын өдрөөр тэр ажлын газрын удирдах ажилтнууд, сургуулийнхаа нэг төгсөлтийнхөн, нутгийнхаа таньдаг найз нөхөдтэйгээ хамт гольф тоглож өнгөрөөдөг. Хөдөө орон нутагт удирдлагын ухааны сургууль төгссөн ч ийм зэргийн албан тушаалд дэвшиж чадсныгаа тэрээр нийгмийн харилцаанд идэвхитэй оролцон танилын хүрээгээ нэмэгдүүлсний хүч гэж боддог. Гэр бүлийнхээ амьдралыг сайн сайхан авч явахын тулд ингэж их хичээн амь хайргүй зүтгэж байгаа болохоор эхнэр хүүхэд нь ямар ч үед өөрийг нь ойлгоно гэж тэрээр итгэдэг байна.

Харин бодит байдал дээр эхнэр хүүхэд нь үнэхээр түүнийг ойлгож чадах болов уу? Яг үнэндээ нөхөртэйгээ хамт байх цаг хугацаа ховор байхад амралтын өдрөөр хүртэл гэртээ өнжилгүй гольфын талбай руу явж байгаа нөхрийгөө удаан тэсвэрлэнэ гэдэг маш хэцүү зүйл юм. Хүүхдүүдийнхээ боловсрол, хүмүүжлийн асуудлыг ч зөвхөн өөрөө хариуцаж байгаа нь түүний эхнэрийн хувьд маш бухимдмаар зүйл юм. К ..... нь хүүхдүүддээ байсан ч байхгүй байсан ч хамаагүй тийм хүн болсон байв. Өглөө нүдээ нээхэд аав нь ажилдаа явчихсан байхгүй байж байгаад шөнө дунд халамцуухан гэртээ ирэх нь жирийн үзэгдэл болсон байв. К ..... зарим үед эрт гэртээ ирсэн ч ажилдаа маш их ядарсан байдаг болохоор зочны өрөөндөө орон телевиз үзээд хэвтчихдэг байна. Хүүхдийнхээ багштай уулзах, суралцах курс дамжааг нь сонгох, хүүхдүүддээ ном худалдан авч өгөх зэрэг бүгд ээжийнх нь үүрэг хариуцлага мэт болсон байв. К ..... –ийн гэр бүлд аав гэдэг хүн зөвхөн хэрэгцээнд зарцуулагдах мөнгийг олж өгдөг хүнээс цаашгүй байдалтай болсон байна. К ..... –ийн гэр бүлийн энэ дүр зураг бол

гашуун боловч түгээмэл болоод байгаа өнөөгийн Солонгос улсын гэр бүлийн байдал юм.

Харин хүүхдийн эмнэлэгт ажилладаг И Чон Мин-ий гэр бүл үүнээс огт өөр юм. И нь хуримаа хийснээс хойш бараг 30 орчим жил эцэг эхтэйгээ хамт амьдарсан бөгөөд одоо хадам ээжийгээ халамжлан хамт амьдарч байгаа юм. Түүнд амьдралдаа заавал дагаж мөрддөг нэг дүрэм журам байдаг байна. Энэ юу вэ гэвэл тэрээр өдөрт заавал нэг удаа гэр бүлийн бүх гишүүдтэйгээ хооллонгоо ярилцах юм. Өглөө 7 цагаас 7 цаг 10 минутын хооронд гэр бүлийн гишүүд бүгд цугларан хооллодог цаг бөгөөд энэ цаг дээр гэрт байгаа бүх хүмүүс байх ёстой. Хичнээн орой унтсан ч хамаагүй хэн ч байсан өглөө 7 цагт хоолны ширээний ард суусан байх шаардлагатай. 4 хүүхэд нь бүгд өсч том болон өөр өөрсдийн ажил төрөл гээд оройн хоолны цаг дээр тухтай ярилцаад байх цаг зав муутай болсон учраас жаахан ч гэсэн харилцан ярилцах цагийг гаргахын тулд И өглөөний хоолны цагийг сонгон ийм дүрэм журам бий болгосон байна.

Тэрээр “Үр хүүхдүүд нь том болон өөрийн гэсэн байр суурьтай болмогц гэр бүлийн амьдралынхаа баяр баясгаланг хойш тавин өөрийнхөө байдалд анхаарал хандуулан амьдардаг хүмүүс их байдаг. Тиймээс үр хүүхэд нь нас биенд хүрэн тусдаа амьдарч байгаад аав ээж дээрээ ирэх үед гэрийн эзэн болох эцэг хүний орон зай ерөнхийдөө алга болсон байдаг. Үр хүүхэд маань өсөж том боллоо гээд иймэрхүү байдлаар хайнга хандалгүй эцэг эх үр хүүхдийн харилцаагаа хэвээр хадгалж байх нь маш чухал. Тиймээс эрчүүд маань эцэг хүн болон эр нөхрийн үүргээ ямар ч үед биелүүлж байх хэрэгтэй” гэж хэлсэн байна.

Эртний Грек, Ромын үед эцгийн эрх үүрэг хязгааргүй байсан. Хүүхэдтэй болох эсэх сонголт зөвхөн эрэгтэй хүнд байсан. Тухайн үед эцэг нь хүсээгүй хүүхдийг устгаж байв. Ром улсад анх үр хөндөлтийг өв залгамжлагчийн тоог багасгах зорилготойгоор хийж байсан бөгөөд эхнэр, хүүхдийнхээ хувьд хязгааргүй эрх мэдэлтэй байсан эр нөхрийн шийдвэрийн дагуу үр хөндөх эсэхийг шийддэг байв. Тухайн үед эрэгтэйчүүд улс төр, дайн дажин гэх мэт гадаад нөхцөл байдалтай холбогдолтой ажилд оролцон эмэгтэйчүүд ерөнхийдөө гэртээ үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлдэг байв. Аж үйлдвэрийн хувьсгал болон нийгмийн хөгжил шинэчлэлтэй тулгарсан ч бараг л хэвээр оршин тогтнон үлдэж чадсан эцгийн эрхт ёс өнөө үед устаж үгүй болсон. Тэглээ гээд эцэг хүний үүрэг, эхнэр болон үр хүүхдийн аавынхаа талаарх итгэл найдвар нь алга болсон гэсэн үг биш юм.

Олон улсын сэтгэл судлалын хүрээлэнгийн захирлын албан тушаалыг хашиж байсан Итали улсаас гаралтай хүний оюун ухаан судлаач Лүижи Зояа (Luigi Zoja) өнөөгийн эцгийн эрхт ёсны талаар “Хүүхдүүд ээжээсээ илүү аавдаа итгэж найдах хувь нь өндөр байдаг” гэж хэлсэн байна. Хүүхдүүд ааваасаа энгийн хайр халамжаас илүү ихийг хүсдэг бөгөөд аавыгаа хүч чадалтай ухаалаг нэгэн байхыг хүсдэг. Гэтэл орчин үед эрчүүд маань эмэгтэйлэг тал руугаа нилээн өөрчлөгдөж байгаа болохоор өнөөгийн залуучууд аавыгаа сул дорой нэгэн гэж үзэн ааваасаа илүү хамт ажилладаг хүмүүс юмуу найз нөхөддөө итгэж найдах хандлагатай болоод байна.

Өнөөгийн нийгэмд эцэг хүн гэдэг гэр бүлийн ноён нуруу хамгийн чухал удирдагч, хүүхдийнхээ сайн багш байх ёстой ч эрэгтэйчүүд маань энэхүү байр сууриа орхин зүгээр л гэр бүлийнхээ хэрэгцээний зүйлийг хариуцдаг хүнээс цаашгүй болон өөрчлөгдөж байгаа нь өнөөгийн нийгмийн нэг харамсалтай бодит үнэн юм. Сөүлийн Каннамын бүс нутагт нэг

хэсэг ийм нэгэн инээдтэй яриа моодонд орсон байдаг. “Хүүхдээ нэр хүндтэй их сургууль (Сөүл их сургууль, Курё их сургууль, Ёнсей их сургууль)-д оруулъя гэвэл дараах 4 нөхцлийг бүрдүүлснээр боломжтой болно. Энэ 4 нөхцөл юу гэвэл өвөө нь баян хөрөнгө чинээтэй нэгэн байх, аав нь хүүхэддээ анхаарал халамж тавьдаггүй байх, ээж нь мэдээлэл сайн цуглуулсан байх, хүүхэд өөрөө биеийн хүчний тал дээр сайн байх юм”.

Дээрх 4-н нөхцөлд эцэг нь хүүхэддээ анхаарал халамж тавихгүй байснаар хүүхэд нь нэр хүндтэй их сургуульд элсэн суралцаж чадна гэж бичсэн байна. Яаж ч бодсон ийм сонин зүйл гэж хаана байхав дээ? Энэ бол өнөөгийн нийгэмд эцэг хүний үүрэг гэх зүйл байхгүй болон хүүхдийнхээ боловсролд нөлөө үзүүлж чадахаа байсан байдлыг товч тодорхой илэрхийлж буй хошин яриа юм. Харин эцэг хүний үүрэг хариуцлага бага багаар алга болж байгаа энэ цаг үед Еврей үндэстэн эцгийн эрхт ёсны уламжлалаа хатуу чанга мөрдсөөр байгаа юм.

Еврей гэр бүлд эрэгтэй эмэгтэй хүний ялгаа гэсэн зүйл байдаггүй. Тэдний хувьд бага насны хүүхэд гэдэг эцэг эхийн хэн хэнийх нь хариуцлага. Гэвч хүйсийн ялгаа оршсоор байгаа юм. Еврей хүмүүс эцгийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрөн хүндэтгэн эмээдэг учраас хүүхдүүд аавыгаа хүндэтгэн зааж зөвлөж байгаа зүйлийг нь маш сайн сурдаг. Еврей гэр бүлд зөвхөн өрхийн тэргүүн буюу аав хүний суудаг сандал тусдаа байдаг. Еврей хүмүүс ийм хэмжээгээр хүүхэд болон гэр бүлд эцэг хүний үүрэг хичнээн чухал болохыг онцолдог. Еврей эрэгтэйчүүд ажил тармагц гэртээ харин гэр бүлийн гишүүдтэйгээ хамт цагийг өнгөрөөхийг хичээдэг. Тэд хүүхдүүдтэйгээ хамт янз бүрийн тоглоом тоглон тэр өдөр юу болсон талаар ярилцан боломж гарвал ихэвчлэн ном уншдаг. Мэдээж хүүхдүүд нь ном уншиж байгаа аавыгаа хараад даган дуурайх зуршлыг өөртөө бий болгодог.

Еврей хүмүүс хүүхдээ насанд хүрсний баяр тэмдэглэх хүртэл сургуулийн боловсролоос нь гадна түүх, ёс суртахууны талаар зааж сургадаг. Үүгээр дамжуулан хүүхдийнхээ сонирхлыг олж нээн цаашид юу хийж чадах эсэхийг нь олж мэддэг. Ялангуяа долоо хоног бүрийн баасан гаригийн нар жаргах үеэс эхлэн бямба гаригийн нар жаргах үе хүртэл сахидаг амралтын өдрөөрөө телевиз үзэх, ажлаар гадагшаа явах зэрэг зүйлсийг хийлгүйгээр гэртээ амран ном уншин гэр бүлийнхэнтэйгээ янз бүрийн зүйл ярилцан цагийг зугаатай өнгөрөөдөг. Үүний гол зорилго нь гэр бүлийн хамгийн чухал хүн болох хүүхдийнхээ боловсролд анхаарч байгаа юм. Вьетнамын маргааныг шийдвэрлэсэн гавьяагаар 1973 онд Нобелийн энх тайвны шагнал авсан Еврей гаралтай АНУ-ын иргэн Хэнри Киссинжер (Henry Kissinger) “Хүүхэд наснаасаа эхлэн ааваараа дамжуулан сурсан Библи номын ухаан бүх цаг үед миний амьдралыг удирдсаар ирсэн. Библи номонд улс төрийн онол бүгд багтсан байдаг” гэж хэлсэн байдаг.

Солонгос хүмүүсийн хувьд эрэгтэйчүүд нь бага насны хүүхдийнхээ асуудлыг эхнэрийнхээ үүрэг хариуцлага мэтээр тооцон үл тоомсорлох хандлага маш их ажиглагддаг. Эрчүүд маань өөрсдийнхөө энэ байдлыг “Сэтгэл байгаа ч цаг зав олдохгүй байна” “Ажил төрлөө амжуулан хүүхэддээ анхаарал халамж тавихыг хичээж байгаа ч бодохоос хэтрэхгүй байна” гэж өөрсдийгөө өмөөрөх маягаар тайлбарладаг. Нэгэн судалгаанаас Солонгос эрэгтэйчүүд хүүхэдтэйгээ өнгөрөөдөг цаг нь өдөрт дунджээр 15-30 минут, хүүхдийнхээ царайг харах тоо нь дунджаар 2.7 удаагаас хэтэрдэггүй гэсэн үр дүн гарсан байна. Үнэхээр Солонгос улсын эрэгтэйчүүд тийм завгүй байдаг гэж үү? Ямар ч завгүй байдаг гэж хэлэх нь утгагүй юм. Шөнө орой болтол найз нөхөдтэйгээ архи уух, амралтын өдөр гольф тоглох болохоор тэд цаг

зав хангалттай их гаргадаг. Тэдний энэ байдлыг нийгмийн харилцаанд идэвхитэй оролцохын тулд хийж байгаа ажил гэж хэлэх үү? Энэ байдлыг муугаар хэлвэл нийгэмд тодорхой байр суурь эзлэн амжилтанд хүрэхийн тулд эр нөхөр, эцэг хүнийхээ үүргийг умартаж байгаа үйлдэл гэж хэлж болно. Ихэнхи хүмүүс нийгэмд тодорхой байр суурь эзлэн амжилтанд хүрэн гэр бүлдээ мөнгө олж ирж л байвал болно гэж маш буруу боддог.

Мэдээж хүн амжилт гарган хөрөнгө мөнгө, эд баялагтай болох нь сайхан зүйл боловч тодорхой анхаарах хэрэгтэй зүйл байдаг. Аавтайгаа сайн тоглодог хүүхдүүдийн бүтээлч чанар, удирдах чадвар, нийгэмтэй харьцах чадвар бусдаас хамаагүй илүү байдаг. Солонгос улсын эрэгтэйчүүд ажил алба, нийгмийн өрсөлдөөнтэй байдал зэргээс шалтгаалаад гэр бүлийн гишүүдтэйгээ хамтдаа цагийг өнгөрөөх тал дээр маш тааруухан байдаг. Учир нь өнөөгийн нийгэм маань маш хатуу ширүүн өрсөлдөөнтэй болж байгаа учраас ажил алба, мөнгө төгрөгөнд анхаарал хандуулан тэр болгон цаг зав гарган хүүхэдтэйгээ тоглож наадах боломж гардаггүй.

Гэхдээ хүмүүс бага зэрэг ухаан гарган сайн бодоод үзвэл эдийн засгийн талаасаа ямар нэгэн зардал гаргахгүйгээр гэр бүлийн гишүүдтэйгээ хамтдаа цаг хугацааг хөгжилтэй өнгөрөөх маш олон арга байдаг. Жишээ нь хүүхэдтэйгээ номын дэлгүүрээр явах, падүг болон шатар тоглох, хүүхдийнхээ сонирхсон зүйлийг хамт хийх, хамт зураг зурах, дугуй унах болон биеийн тамирын бусад төрлөөр хамтдаа хичээллэх, ямар нэгэн өнчин хүүхдийн асрамжийн газар юмуу өндөр настны асрамжийн газарт очин буяны ажил хийх гэх мэт.

Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамт цагийг өнгөрөөхдөө хүүхдийнхээ зан аашинд тохирсон хөтөлбөрөөр цагийг өнгөрөөх маш чухал юм. Жишээ нь биеийн тамирт дургүй хүүхэдтэй бол найз нөхөд юмуу эцэг эхтэйгээ хамт хийж болох ямар нэгэн урлагийн үйл ажиллагаа, падүг болон шатар тоглох зэрэгт сонирхлыг нь хандуулах ихээхэн үр дүнтэй юм. Хэрэв таны хүүхэд дотогшоо зан чанартай бол таеквондо, унадаг дугуй гэх мэт ганцаараа хичээллэж болох биеийн тамирын төрлөөр хичээллүүлэн цаашдаа бусад хүүхдүүдтэй хамт хийж болох дасгал хөдөлгөөн болон сонирхсон төрлөөр хичээллүүлэх сайн юм.

Аав нар өдөрт багаар бодоход 30 минут орчим хүүхдийнхээ ярианд анхаарал хандуулан юу ярихыг нь сонсон хамт ярилцан тоглож байх нь хүүхдийн бүтээлч чадвар, сонирхлыг хөгжүүлдэг гол хүчин зүйл болохыг бид байнга санаж байх хэрэгтэй. Тиймээс аав нар хүүхдийнхээ ирээдүй болон гэр бүлийнхээ аз жаргалын төлөө эцэг хүний үүргээ сайн биелүүлэх хэрэгтэй. Ийм учраас аавууд маань яг одооноос эхлэн хүүхэдтэйгээ илэн далангүй ярилцах цагаа нэмэгдүүлэн эцэг хүний үүргээ сайн биелүүлцгээе.

Хоолны ширээний ардах боловсролыг орхигдуулахгүй байх

Хүн хэн нэгэнтэй уулзаад салахдаа тэр хүндээ ямар нэгэн сайхан зүйлийг ерөөхийг хүсдэг. Гэтэл нөгөө хүнийгээ ухаантай хүн болохыг хүссэн ч ухаантай хүн байвал, баян чинээлэг болохыг хүссэн ч маш баян чинээлэг хүн байвал, хүмүүсийн хайр хүндэтгэлийг хүлээсэн хүн болохыг хүссэн ч тийм хүн байвал та тэр хүнд юу хүсэж ерөөж чадах вэ? Ийм үед хэлэх хамгийн гайхалтай үг бол "Таны үр хүүхдүүд тань шиг хүн болохыг хүсэж байна" юм. (Талмуд номны хэсгээс)

Лавренс Харви Зайгир (Lawrence Harvey Zeiger) Нью-Йорк хотын Брүклиний орос гаралтай ядуу Еврей цагаач гэр бүлд төрсөн нэгэн юм. Тэрээр гэр бүлийнхээ энэхүү хүнд хэцүү нөхцөл байдлаас шалтгаалан сонин хүргэх, шуудан зөөх гэх мэт ажил хийн хүүхэд насаа өнгөрөөсөн байна. Түүний эцэг эх /эцэг Зайгир нь түүнийг 9 настай байхад зүрхний өвчнөөр өөд болсон/ мөнгө төгрөг муутай байсан учраас хүүхэддээ гоё ганган хувцас хунар, тансаг сайхан амьдралыг түүнд өгч чадаагүй боловч хүүхдийнхээ боловсролыг огтхон ч орхигдуулаагүй юм. Тэд хүүхэддээ боловсрол олгохын тулд ямар ч төлбөр мөнгө ордоггүй ч хамгийн шилдэг боловсрол болох "хоолны ширээний ардах боловсрол"-ын аргыг ашигласан юм. Тэд хамтдаа хооллох болгондоо янз бүрийн зүйлийн талаар хүүхэдтэйгээ ярилцан хүүхдийнхээ сонирхлыг тасралтгүй цочроож өгч байсан бөгөөд мэдэхгүй байгаа зүйлийнхээ талаар бусдаас байнга асууж суралцаж байхыг зааж сургасан байна.

Тухайн үед хүүхдүүдэд нэр алдартай бейсболын баг болох Брүклин Дажос /одоогийн Лос Анжелесийн Дажос/ багийн тамирчдын гарын үсгийг авах нь хамгийн бахархмаар зүйл байв. Зарим үед Лавренсд аз тааран бейсболын багийн тамирчидтай уулзах боломж гардаг байсан бөгөөд тэрээр бусад хүүхдүүд шиг гарын үсгийг нь авахын оронд тамирчдаас "Та өнөөдөр тоглолтын үеэр яагаад мөргүүлээд уначихсан бэ?" гэх мэт хачин асуулт асуудаг байв. Ийнхүү асуулт асууж байсан хүү бол өнөөдрийн СИИ телевизийн од түүхэн ярилцлагыг хамгийн сайн хийдэг хүнээр цоллогдоод байгаа Ларри Кинг юм.

Израйлийн Еврейн боловсролын докторантын сургуульд хүүхдийн боловсролын чиглэлээр мэргэжил эзэмшсэн нэг эрдэмтэн "Еврей хүмүүс ихэнхи нь эхнэр нөхөр хоёулаа ажил төрөл эрхэлдэг ч хүүхдүүдээ гайхалтай сайн өсгөж хүмүүжүүлдэг нууц нь хүүхэдтэйгээ хамт өнгөрөөх цагаа маш сайн ашигладаг учраас юм" гэж хэлсэн байна. Еврей хүмүүсийн ажил ихэнхидээ үдээс хойш 4 цагийн үед тардаг бөгөөд тэр цагаас эхлэн хүүхдийнхээ унтах цаг болох оройны 9 цаг хүртэл хүүхэдтэйгээ хамт цагийг өнгөрөөдөг. Эцэг эхчүүд өөр өөрсдийн хийх ажлаа хүүхдээ унтсаны дараа хийдэг. Еврей хүмүүс хүүхэдтэйгээ хамт оройн хоол тогтмол идэхийн тулд их хичээл зүтгэл гаргадаг.

Еврей хүмүүсийн хувьд өдрийн хамгийн чухалд тооцдог цаг нь гэр бүлийн бүх гишүүд хамтдаа хооллодог оройн хоолны цаг юм. Энэ цагийг ашиглан хоорондоо ярилцан инээж хөхрөн гэр бүлийнхээ уур амьсгалыг улам сайхан халуун дулаан болгодог бөгөөд хоол идэнгээ хүүхэддээ ч боловсрол олгож байдаг. Хооллож байхдаа аав ээж хоёр нь хүүхдээсээ тухайн өдөр болсон зүйлийнх нь талаар сонсон харилцан ярилцдаг бөгөөд хүүхдээ аль болох магтаж урамшуулахыг хичээдэг. Ингэснээр хүүхэд аяндаа хүн чанарын боловсролыг суралцдаг. Кеннеди ерөнхийлөгч уран илтгэх чадвар гайхалтай сайн байсан учир шалтгаан бага насанд

нь заадаг байсан ээжийнх нь хоолны ширээний ардах боловсролын ач тус байсан юм.

Еврей хүмүүс хэн байх нь хамаагүй ахмад настай хүмүүсийг хүндэтгэж харьцахыг бага наснаасаа эхлэн сайн суралцсан байдаг. Учир нь бусдыг хайрлаж хүндэтгэж харьцах нь Бурханаас хүмүүст өгсөн үүрэг гэж тэд боддог. Библи номонд ч ертөнцийн эзэн ахмад настай хүмүүсийг ачилж хүндэтгэх хэрэгтэй гэж хэлсэн байдаг. Мөн эцэг эхээ хайрлаж хүндэтгэх, өндөр настай хүмүүсийг хайрлаж хүндэтгэх нь хоорондоо нягт холбоотой зүйлс юм. Еврей хүмүүст Бурханы үгийг заадаг шашны багш нь дотоод сэтгэлийн эцгээс ялгаагүй байдаг учраас Еврей хүмүүс шашны удирдагч багшаа бас маш их хүндэтгэдэг.

Дорнодын ёс заншилтай улс хэмээн нэрлэгдсээр ирсэн Солонгос улсад ч гэсэн хоолны ширээний ардах боловсролоор дамжуулан хүүхэддээ ёс суртахуун, үнэнч шударга байдал болон бусдыг хайрлаж хүндэтгэх чанарыг зааж сургаж байсан уламжлал байдаг. Ердөө 10-20 жилийн өмнө л гэхэд өвөө эмээ нар ач зээ нараа хажуудаа суулган сайн зүйлийг дэмжин муу зүйлийг буруушаасан эртний түүх яриаг ярьж өгөн амьдралын ухаан болон үнэнч шударга байдал, бусдыг хайрлаж хүндэтгэхийн чухал чанарын талаар зааж өгдөг байсан бодит жишээ их байдаг. Гэр бүлийн бүх гишүүд хамтдаа суун хооллодог хоолны ширээ нь зүгээр л нэг удаа хооллоод өнгөрөх газар биш гэр бүлийн насанд хүрсэн хүмүүс хойч үе болох залуу хүмүүсдээ өөрсдийн амьдралын туршлагын талаар хэлж ярин үүгээр дамжуулан залуучууд хүн чанарын боловсролыг суралцдаг газар байсан юм. Харин орчин үед ихэнхи гэр бүлд ийм хоолны ширээний ардах боловсрол алга болсон байна. Эрүүл мэнд нийгмийн хамгаалал гэр бүлийн яамнаас хийсэн нэгэн судалгаанаас харвал манай улсын дунд, ахлах сургуулийн сурагчдын бараг тал хувь нь “Эцэг эхтэйгээ хамт хооллодоггүй” гэж хариулсан байдаг. Орчин үед гэр бүлд эмэгтэй хүний эдийн засгийн оролцоо өндөр болсон бөгөөд үүнийг хоолны ширээний ардах боловсролыг үгүй болгож буй гол хүчин зүйл гэж хэлж болох юм.

Харин сүүлийн үед 2, 3 үеэрээ хамтран амьдардаг Еврей гэр бүлийн тоо ч маш их багасч байна. Еврей эмэгтэйчүүдийн гэр бүлийн эдийн засгийн оролцоо Солонгос улсын эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү их байдаг. Тэд хэдийгээр ийм цаг зав муутай байдаг ч оройн хоолны цаг дээр хүүхэддээ өөрийн үндэстнийхээ оюун ухаан, уламжлалын талаар зааж сургадаг бөгөөд энэ ажилдаа хэзээ ч залхуурч хойш суудаггүй. Солонгос улсын нийгэмд хоолны ширээний ардах боловсрол алга болсон нь хүрээлэн буй орчны өөрчлөлтөөс болсон бус хоолны ширээний ардах боловсролын чухал чанарыг мартсан учраас биш гэж үү?

“Ямар нэгэн ажлыг эхлүүлэх нь тухайн ажлын талыг хийсэн гэсэн үг” гэсэн үг байдаг. Тийм болохоор та яг одоо гэр бүлийн бүх гишүүдтэйгээ хамт хооллох цагийн хуваарийг бий болгоорой. Өглөөний хоол, оройн хоолны цаг аль нь байх хамаагүй. Гэр бүлийн гишүүд бүгд хамтдаа хооллож болох цагийг тогтоон хайртай хүмүүстэйгээ өдөрт 1 удаа заавал хамт хооллодог зуршилтай болцгооё. Хамтдаа хооллонгоо эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ санал бодол, тулгарч байгаа хүнд хэцүү асуудлын талаар сонсон өөрсдийн хийдэг өдөр тутмын ажлынхаа талаар хүүхэддээ ярьж өгөх нь гэр бүлийн гишүүдийн харилцаа, уур амьсгалыг улам сайжруулдаг бөгөөд хүүхэд хүн чанарын боловсрол эзэмшихэд ихээхэн нөлөө үзүүлдэг.

Хүүхдээ баруун гараараа шийтгэн зүүн гараараа тэврэх

“Талмуд” номонд “Хүүхдээ зодож шийтгэхдээ гутлын үдээсээр ороолгоорой” гэсэн үг гардаг. Еврей хүмүүс хүүхэд нь буруу зүйл хийвэл толгойноос бусад биеийн хэсэгт нь алганы амт үзүүлдэг. Хүүхэдтэйгээ гадуур явж байх үед хүүхэд нь буруу зүйл хийвэл хэчнээн чухал ажил байсан ч түүнийгээ хойш тавин хүүхдээ шийтгэн ямар зүйл буруу хийсэн болохыг нь тайлбарлан хэлж ойлгуулдаг. Еврей хүмүүс өөрсдийн гар, ам, нүдийг нэг төрлийн боловсролын багаж хэрэгсэл гэж үздэг. Нүд, ам, үг, гар нь бодитоор нөлөөлөн өвдөлтийг мэдрүүлдэг учраас хүүхдэд өөрийнх нь хийсэн үйлдлийн талаар эргэцүүлэн бодуулдаг үр дүнтэй. Харин шийтгэлийн гол зорилго хүүхдэд бие мах бодийн өвдөлт зовлон өгөхдөө биш юм. Шийтгэж байгаагийн гол зорилго нь хүүхдийг сэтгэл зүйн талаас нь зөв хүн болгон хүмүүжүүлэх бөгөөд ямар ч үед хүүхдийг хэрцгийгээр зодох юмуу гэмтээж бэртээх маягаар шийтгэж болохгүй. Мөн хүүхдээ шийтгэсний дараа өөрийг нь хайрласандаа ийм зүйл хийсэн болохыг заавал илэрхийлж ойлгуулах хэрэгтэй. Ийм үйлдэл дагалдуулахгүйгээр зүгээр зодож шийтгээд орхивол энэ нь хүүхдээ дарамталж байгаа хэлбэр юм. Тиймээс хүүхдээ зодож шийтгэсэн бол дараа нь заавал тайвшруулж юу буруу хийсэн болохыг нь тайлбарлаж өгөх хэрэгтэй. Хүүхдээ тэврэн тайвшруулах нь эцэг эхийн хайрыг илэрхийлж буй хамгийн чухал илэрхийлэл юм. (Марвин Токаер)

Цэцэрлэгийн насны хүүхэд өрөөнд байсан үнэтэй ваарыг санамсаргүйгээр унагаагаад хагалчихсан гэж бодоод үзье. Ийм тохиолдолд эцэг эхчүүдийн хүүхэддээ хандах хандлагыг томоор 2 хувааж болох юм. Хүүхдээ шууд загнасныхаа дараа зодож шийтгэдэг хандлагатай эцэг эхчүүд байдаг. Ийм эцэг эхчүүд “Чи ямар тэнэг хүүхэд вэ?, Энэ ваар хичнээн үнэтэй болохыг чи мэдэж байна уу?, Бүтэлгүй амьтан, болгоомжтой бай гэж чамд хичнээн их хэллээ, Чи ер нь яагаад ийм бүтэлгүй байдаг юм бэ?, Одоо энэ ваарыг яах болж байна аа?” гэх мэтээр хүүхдээ загнаж зэмлэснийхээ дараа шалан дээр өвдөглөөд гараа өргөөд 10 минут суу гэх мэтээр хүүхдээ шийтгэдэг. Хүүхэд иймэрхүү маягаар загнуулж шийтгүүлсээр байвал ихэнхдээ өрөөндөө ганцаараа байхыг хүсдэг бөгөөд аав ээжтэйгээ харилцах тал дээр муу болдог.

Харин хамгийн зөв хандлага бол шийтгэснийхээ дараа хүүхдээ тайвшруулан яагаад ийм нөхцөл байдал үүссэн талаар тайлбарлаж ойлгуулах юм. Ваар хагалсан нь яагаад буруу зүйл болох талаар хүүхэддээ тайлбарлан өөрийнх нь хийсэн буруу зүйлээс болж ямар их хэмжээний хохирол учирсан болохыг хүүхэддээ хэлж ярьж ойлгуулах нь чухал юм. Ийм тохиолдолд хүүхэдтэйгээ “Шийтгүүлэх чамд хэцүү байгаа биз дээ? Чиний хагалсан энэ ваар гэрийг маань чимэн хэчнээн гоё үзэмжтэй харагддаг байсан билээ. Аав ээж хоёр нь маш их мөнгө зарцуулан худалдаж авсан. Тийм болохоор тоглох үедээ тоглоомоор тоглож байх хэрэгтэй. Ваараар тоглож болохгүй. Чи одоо ойлгосон болохоор цаашид болгоомжтой байх хэрэгтэй” гэх мэтээр ярилцах нь маш сайн юм.

“Эцэг хүн хатуу чанга эх хүн зөөлөн байх хэрэгтэй” гэсэн үг байдаг. Энэ нь хүүхдийг өсгөж хүмүүжүүлэхдээ эцэг хүн хатуу чанга эх хүн зөөлөн байх хэрэгтэй гэсэн үг юм. Үүнийг Солонгос улсын уламжлалт хүүхдийн боловсролын арга барил ч гэж хэлж болно. Эцэг эхийнхээ хэн нэгэнд загнуулж шийтгүүлсэн хүүхдийг тэр байдалтайгаар нь орхивол боловсролын талаасаа маш муу үр дүн дагуулдаг. Учир нь өөртөө итгэх байдалдаа шарх авсан

хүүхэд сэтгэл санаагаар унан буруу зүйл хийн алдаа гаргах нь их байдаг. Мөн заавал эцэг нь хатуу эх нь зөөлөн байна гэсэн ойлголт байхгүй юм. Тухайн үеийнхээ нөхцөл байдлаас шалтгаалан хүүхэддээ эх нь хатуу эцэг нь зөөлөн ч хандаж болно. Ямар ч байсан эцэг эхийн хэн нэг нь загнуулж шийтгүүлэн сэтгэл зүрх нь шархалсан хүүхэддээ зөөлөн хандан тайтгаруулж аав ээж хоёр нь өөрийг нь хайрлан зөв хүн болгон өсгөж хүмүүжүүлэх гэсэндээ загнаж шийтгэсэн болохыг тайлбарлан ойлгуулах хэрэгтэй. Энэ талаараа Солонгос болон Еврей хүмүүсийн гэр бүлийн боловсрол төстэй байдаг.

“Эцэг нь хатуу эх нь зөөлөн ханддаг” шийтгэлийн арга барилын Еврей хэлбэрийг “Баруун гараараа шийтгэн зүүн гараараа тэврэх” гэж хэлж болно. Еврей гэр бүлд эцэг хүний эрх мэдэл томоохон байр суурийг эзэлдэг. Хүүхэд нь буруу зүйл хийсэн үед ихэвчлэн аав нь загнаж шийтгэх үүргийг хариуцдаг. Ийнхүү эцэг нь шийтгэсний дараа ээж нь хүүхдээ тэврэн тайтгаруулж яагаад шийтгүүлэх болсон талаар эелдэг зөөлөн үгээр тайлбарлан ойлгуулж хүүхдээ тайвшруулдаг ба дахин ийм алдаа гаргахгүй байх талаар зааж хэлж өгдөг. Ер нь хүүхдийг зөвхөн шийтгээд л өнгөрвөл эцэг эхийн эрх мэдлээр хүүхдээ дарамталж байгаагаас цаашгүй зүйл болох бөгөөд хүүхэд ч яваандаа бусдад өөрийн бодол санаагаа илэрхийлж чаддаггүй аймхай бүрэг ичимхий зан чанартай болох нь амархан байдаг муу талтай.

Еврей хүмүүс бага наснаасаа эхлэн өөрийнхөө хийх ёстой ажлыг өөрөө бие даан хийж суралцаж эхэлдэг. Жишээ нь өөрийнхөө амьдардаг өрөөг цэвэрлэх, угаалгын машинаар хувцасаа угаах гэх мэт. Гэрт нь гаднаас зочин ирсэн үед мэндлэх, хүмүүсийн дунд биеэ хэрхэн зөв авч явах байдал зэрэг ёс зүйн боловсролыг ч бага наснаасаа эхлэн сайтар суралцдаг. Мөн өөрийн хийх ёстой ажлаа мартах, залхуурах, хийгээгүй тохиолдолд өөрийгөө алдаа гаргасан гэж үзэн дотроо дүн шинжилгээ хийн яагаад ийм байдалд хүрсэн талаараа эргэцүүлэн тунгаан бодож байх ёстойг эцэг эх нь бага наснаас нь сайн зааж өгсөн байдаг. Эцэг эхчүүд эхлээд хүүхдийнхээ байр суурийг хүндэтгэн юу ярихыг нь сонссоны дараа юу буруу хийсэн болохыг нь хүүхэддээ сайн тайлбарлаж өгч байвал хүүхэд алдаа гаргасандаа харамсахаасаа илүүтэйгээр өөрийнхөө юу буруу хийсэн болохыг ухааран дахин алдаа гаргахгүйг хичээдэг.

Харин хичнээн тайлбарлаж ойлгуулсан ч эцэг эхийнхээ үгийг сонсохгүй байвал хүүхдээ зодож шийтгэж байх хэрэгтэй. Солонгос хүмүүс хүүхдийг зодож шийтгэхийг нэг их сайшаадаггүй бол Еврей хүмүүс хүүхдээ зөв хүмүүжилтэй зөв хүн болгон өсгөж хүмүүжүүлэхийн тулд шаардлагатай бол зодож шийтгэхийг хүлээн зөвшөөрдөг. Яагаад гэвэл эцэг эх нь шийтгэхгүй байсаар байгаад хүүхэд муу хүн болж өсөж хүмүүжсэнээс шаардлагатай үед нь зодож шийтгэж байх нь хүүхдийн цаашдын амьдралд тустай юм. Библи номын хуучин гэрээнд ч гэсэн зодож шийтгэхийн чухал чанарын талаар дурьдсан ишлэл цөөнгүй байдаг. “Саваанаас хэлтрүүлэгч нь хүүгээ үл хайрлагч юм. Харин хүмүүжүүлэхдээ хичээнгүй нэгэн хүүгээ хайрладаг хүн мөн” /Сургаалт үгс 13:24/ “Мунхаг байдал хүүхдийн зүрхэнд уяастай байдаг. Сахилгын саваа мод түүнийг мунхаглалаас холдуулна. /Сургаалт үгс 22:15/, “Саваа зэмлэл хоёулаа мэргэн ухааныг өгнө. Харин дур зоргоороо аашлагч хүүхэд эхийгээ ичгүүрт оруулна. /Сургаалт үгс 29:15/

Яг үнэндээ энгийн зүйл юм шиг боловч хүүхдийг зодож шийтгэхэд нарийн дүрэм журам шаардлагатай. Юуны түрүүнд хүүхэддээ буруу хийсэн зүйлийнх нь талаар сайн тайлбарлан

хэлж ойлгуулан үүнд тохирсон шийтгэлийнх нь талаар хэлснийхээ дараа зодож шийтгэх хэрэгтэй. Гэтэл ихэнхи хүмүүсийн тухайд хүүхдээ зэмлэж шийтгэж байгаа байдалд нь ямар ч уялдаа холбоо байдаггүй. Жишээ нь сэтгэл санаа сайхан өөдөрлөг байх үед хүүхэд нь буруу зүйл хийвэл хүүхдээ шийтгэлгүй орхин, ажил төрөлдөө ядрах юмуу сэтгэл санааны хувьд хүнд хэцүү байдалтай байвал гэнэт хүүхэд рүүгээ уурлаж уцаарлан зэмлэж шийтгэдэг. Мөн хүүхдийнхээ хийсэн буруу зүйлийн талаар эхлээд дотроо сайтар тунгаан бодохоосоо өмнө хүүхэд рүүгээ шууд сэтгэл хөдлөлөөр ханддаг. Хүүхэд өөрсдийнх нь үгийг сонсохгүй бол юу юугүй сэтгэл хөдлөлөөр хандан уурлаж уцаарладаг эцэг эхчүүд маш их байдаг. Мөн хүүхэдтэйгээ маш хэрцгий бүдүүлэг байдлаар хандан янз бүрийн байдлаар доромжилж басамжлан харааж зүхдэг эцэг эхчүүд ч байдаг. Бүр цаашилвал хүүхдийнхээ хацар ам руу алгадах, толгой тархи руу нь цохиж нүдэх гэх мэт буруу үйлдэл хийдэг хүмүүс ч цөөнгүй байгаа юм. Түрхэн зуур үүсэж буй сэтгэл хөдлөлөө барьж чадалгүй хүүхэдтэйгээ хэтэрхий хатуу ширүүн харьцдаг хүмүүс байдаг. Мөн “Ах чинь хичээлээ ийм сайн хийж байхад чи яагаад ийм муу байгаа юм бэ” гэх мэтээр хүүхдийнхээ дандаа сул талыг хайн басамжилж доромжлон хүүхдээ үг хэлээрээ хүчирхийлдэг хүмүүс байдаг.

Хүүхэдтэйгээ сайн ярилцаж ойлголцолгүй юу юугүй хүүхдийг зэмлэж шийтгэх нь хүүхдийн зөрүүд занг нэмэгдүүлэхээс өөр үр дүнгүй зүйл. Иймэрхүү буруу хандлагаар хүүхдийг зэмлэж шийтгэх нь хүүхэд амьдралын зөв хандлагатай болон өсч хүмүүжихэд огтхон ч тус нэмэр болдоггүй. Харин ч эсрэгээрээ хүүхдийн зан чанар бүрэлдэн бий болоход маш муу нөлөө үзүүлдэг. Хүүхэд гэдэг бол маш цовоо сэргэлэн амьтан. Тэд эцэг эх нь өөрийг нь үнэхээр хайрласандаа зэмлэж шийтгэж байгаа эсэх, эсвэл зүгээр л сэтгэл хөдлөлөөр зэмлэж шийтгэж байгаа эсэхийг бүгдийг нь ялгаж чаддаг. Ер нь хүүхдийг зэмлэж шийтгэж байгаа гол зорилго бол юу буруу хийсэн болохыг хүүхдэд ойлгуулж ухааруулан дахин ийм алдаа гаргуулахгүй байх юм. Зэмлэл шийтгэлийг нэг үгээр хүүхдийг зөв хүн болгон өсгөж хүмүүжүүлэх арга гэж хэлж болно.

Еврей хүмүүс хүүхдээ буруу зүйл хийсэн үед зодож шийтгэхдээ толгойноос бусад биеийн хэсгийг нь зодож шийтгэдэг. Хүүхдээ зодож шийтгэхдээ ихэнхдээ гараараа бөгсөн дээр нь алгаддаг бөгөөд буруу зүйл хийсэн үед нь хүүхдээ загнаж зэмлэх бол тэдний хувьд энгийн үзэгдэл юм. Хүүхдээ зодож шийтгэхдээ ямар нэгэн эд зүйл ашигладаггүй. Өөрсдийнхөө гараар хүүхдээ зодож шийтгэж байгаа нь хүүхдээ үзэн ядсандаа биш хайрласандаа хийж байгаа зүйл гэсэн утгатай юм. Еврей хүмүүс огтхон ч ах, эгч, дүү гэх мэт гэр бүлийн гишүүдийн авъяас чадварыг хооронд нь харьцуулдаггүй. Хүн бүрийн авъяас чадвар харилцан адилгүй байдаг учраас хүмүүсийг хүчээр хооронд нь харьцуулах нь огтхон ч сайн зүйл биш бөгөөд эсрэгээрээ хүүхдийг амархан цөхөрч гутрах хандлагатай болгон хүүхдийн өөрийнхөө давуу талыг нээж илрүүлэх боломжийг хаадаг.

Мэргэжилтнүүд хүүхдийг зэмлэж шийтгэхдээ дараах аргыг ашиглахыг зөвлөж байна.

1-рт. Эцэг эхчүүд уур уцаартай сэтгэл санааны хувьд таагүй байх үедээ хүүхдээ зэмлэж шийтгэж болохгүй. Еврей сургааль үгэнд “Хүн уур уцаартай үедээ хэнд ч юу ч зааж чаддаггүй” гэсэн үг байдаг. Хэрэв уур уцаартай сэтгэлзүйн хувьд түгшүүртэй байвал уураа гарч тайвширсны дараа хүүхдийнхээ буруу хийсэн зүйлийн талаар хүүхэдтэйгээ ярилцах хэрэгтэй.

2-рт. Хүүхэд ямар нэгэн зүйлийг буруу хийсэн бол тухай бүрт нь хэлж ярьж алдааг нь засуулж байх хэрэгтэй. Хийсэн буруу зүйлсийг нь сэтгэл дотроо хуримтлуулж байгаад нэг дор хэлэх нь огтхон ч сайн арга биш юм.

3-рт. Буруу хийсэн зүйлийнх нь зөвхөн үр дүнг харах биш учир шалтгааныг нь хүүхдээсээ сайтар сонссоны дараа хүүхдээ загнаж шийтгэх хэрэгтэй. Томчууд өөрөө алдаа гаргаж байсан зүйл дээр нь хүүхэд нь адилхан алдаа гаргах үед буруу хийсэн зүйлийг нь хүүхэддээ хэлж ойлгуулан загнаж зэмлэхээсээ илүүтэй хөхүүлэн дэмжих тохиолдол их байдаг. Эцэг эхчүүд хүүхэд нь санамсаргүйгээр буруу зүйл хийсэн эсэх эцэг эхийн анхаарал халамж дутсанаас хийсэн үйлдэл эсэхийг сайтар ажигласны дараа хүүхэдтэйгээ харьцах нь маш чухал.

4-рт. Хүүхдээ загнаж зэмлэхдээ үг хэлнийхээ сонголтонд маш сайн анхаарах хэрэгтэй. Ихэнхи эцэг эхчүүд хүүхдээ загнаж байхдаа сэтгэл хөдлөлөөр “байнга, огтхон ч, үнэхээр, заавал” гэсэн хэтрүүлсэн үг хэллэгийг маш их ашигладаг. “Чи яагаад дандаа ингэж асуудалд орж байдаг юм бэ?” “Чи үнэхээр яах гээд ч нэмэргүй хүн юмаа“ гэх мэт үгийг сонссон хүүхэд өөрийнхөө зан чанарын талаар буруу ойлголттой болон эсрэгээрээ эцэг эхээ улам эсэргүүцэх хандлагатай болох нь амархан байдаг.

Нөхөр нь эхнэрээ хүндэтгэн хайрлаж халамжлах

Сургааль ном сайн заадгаараа алдартай Миеэр (Meyer) гэдэг нэг шашны багш байсан байна. Долоо хоног бүрийн баасан гаригийн орой заадаг түүний хичээлд олон зуун хүн ирдэг байв. Харин баасан гаригийн орой ихэнхи Еврей эмэгтэйчүүд дараа өдөр болох Еврейчүүдийн амралтын өдөрт зориулан хоол унд бэлтгэн маш завгүй байдаг. Гэтэл нэг эмэгтэй Миеэр (Meyer) багшийн хичээлд маш их татагдан баасан гаригийн орой болгон хичээлд нь суухаар ирдэг байв. Нэг өдөр өнөөх эмэгтэйн нөхөр уурлан эхнэртээ ингэж хэлсэн байна. "Маргааш Еврейчүүдийн амралтын өдөр байхад одоо хүртэл хоол ундаа бэлтгээгүй байгаа юм уу? Чи тэр хичээлд нь суугаад байдаг багшийнхаа нүүр лүү нулимахаас нааш гэртээ орно гэж битгий санаарай" гэж хэлэв. Нөхөртөө ингэж хэлүүлэн гэрээсээ хөөгдсөн тэр эмэгтэйн талаар Миеэр (Meyer) багш сонсоод өнөөх эмэгтэйг гэртээ авчран "Миний нүд маш их өвдөж байна. Эмчээс асуусан шүлсээр эмчилж байж л гайгүй эдгэрнэ гэнэ. Чи надад туслаач" гэсэн байна. Тэр эмэгтэй яах ч аргагүй багшийнхаа нүд рүү нулимав. Өнөөх эмэгтэйг гэр лүүгээ явсны дараа багш бусад шавь нараа дуудан "Нэг гэр бүлийн амар тайван аз жаргалтай амьдралын төлөө юу ч байсан хийх хэрэгтэй" гэж хэлэв. (Талмуд номны хэсгээс)

Томас Хэрди (Thomas Hardy) гэдэг зохиолчийн бичсэн "Кэстербридж хотын захирагч/The Mayor of Casterbridge/" хэмээх зохиолд архи ууж согтуурхан өөрийн эхнэр болон дөнгөж төрсөн нялх охиноо худалдаачинд зарсан Майкл Хэнчард /Michael Henchard/ гэдэг хүний талаар гардаг. Ардчилалын өлгий нутаг хэмээн нэрлэгддэг Англи улсад ч 19-р зуун хүртэл нөхөр нь эхнэрээ бусдад зардаг үзэгдэл нээлттэй байсан. /хуулиар хүн худалдаалахыг хүлээн зөвшөөрсөн зүйл байхгүй боловч тэмдэглэлээс харвал 19-р зууны үед багаар бодоход 300 удаагийн эхнэрээ бусдад худалдсан гэмт хэрэг гарсан байдаг/ Харин сүүлийн үед АНУ, Англи, Герман гэх мэт барууны олон орнууд хүлээн зөвшөөрөөд байгаа "эхнэр нөхрийн хоорондох хүчирхийлэл"-ийн талаарх шүүхийн практик, хүмүүсийн ухамсар Солонгос улсын нийгэмд тогтвортой болоод нэг их удаагүй байна. (Солонгос улс 2009 оны 1 сар) Эрэгтэй эмэгтэй хүний эрх тэгш байдлын талаарх түүх бодсоноос илүү богинохон байдаг.

Нөхөр нь эхнэрээ 7 хоногт 3 дээш удаа тэвэрч хайрлаж халамжилж байгаагаа илэрхийлэх хэрэгтэй. Эхнэр нь хүсээгүй байх үед нөхөр нь хүчээр бэлгийн харьцаанд орохыг шаардвал үүнийг хүчирхийллийн гэмт хэрэгт тооцох бөгөөд эхнэрээ зодсон этгээдэд хүнд ял оноох хэрэгтэй. Иймэрхүү буруу зүйл хийсэн тохиолдолд эхнэр нь нөхрөөсөө салан сэтгэл санааны хохирлын төлбөр авах эрхтэй. (Талмуд номны хэсгээс)

Нэг гайхалтай зүйл нь Еврейчүүдийн шашны хуулинд нөхөр нь эхнэрээ маш чухал хүнд тооцон хайрлаж халамжлах хэрэгтэй талаар нарийн тодорхой зааж өгсөн байдаг. Эмэгтэй хүний эрх үүрэг их болсон өнөөгийн Еврейн нийгэмд шашны хууль гэсэн зүйл байдаг ч нэг их хэрэглэгддэггүй байна. Учир нь эдгээр хууль нь олон мянган жилийн өмнө хийсэн эртний шашны хууль байдаг. "Талмуд" номонд ийм үг байдаг.

Эхнэрээ өөрийгөө хайрлаж байгаа юм шиг хайрлан эрхэмд тооц. Эмэгтэй хүнийг уйлуулж болохгүй. Яагаад гэвэл Бурхан түүний нулимсыг нэг бүрчлэн тоолдог.

Хэрвээ эрэгтэй эмэгтэй өнчин хүүхэд байвал эмэгтэй хүүхдийг нь эхлээд сонгон үрчилж аваарай. Учир нь эрэгтэй хүүхэд гуйлга гуйж болох боловч эмэгтэй хүүхдийг тийм хүнд нөхцөл байдалд оруулж болохгүй.

Ийнхүү Еврей эрэгтэйчүүд өөрийн эхнэр болон эмэгтэй хүнийг эрхэмд тооцон хүндэтгэлтэй ханддаг учраас Еврей хүмүүс гэр бүл салалтын хувиараа дэлхийд хамгийн бага байдаг. Хүүхдийн талаарх хайр халамж нь ч мөн ялгаагүй байдаг. Еврей хүмүүс хүүхдээ хайрлаж халамжлан сайн хүн болгон өсгөж хүмүүжүүлэхийг Бурханаас тэдэнд өгсөн үүрэг гэж үздэг. Амар тайван аз жаргалтай гэр бүл бол Еврей хүмүүсийн бусадтай өрсөлдөх хамгийн гол хүч юм.

Гэр бүлээ эрхэмд тооцдоггүй хүн хаана ч байдаггүй. Харин Еврей хүмүүс гэр бүлээ чухалчлан эрхэмд тооцож буй байдал нь бусад үндэстнээс өөр байдаг. Еврей хүнд гэр бүл гэдэг бие мах бодиор төсөөлөөд үзвэл “хүний биеийн хүйс”-ний хэсэг юм. Еврей хүний гэрт очвол үүдний хаалганых нь баруун талд мод юмуу шилээр хийсэн 10 орчим сантиметрийн урттай гонзгой хэлбэрийн гоёл чимэглэлийн зүйл байхыг олж харна. Үүнийг Мэзүза (Mezuzah) гэж нэрлэдэг. Энэхүү чимэглэл нь Еврей хүний амьдардаг гэр гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд 3000 жилээс ч урт хугацаагаар уламжлагдан ирсэн ёс заншил юм. Еврей хүмүүс агуулах, морины зүчээ, угаалгын өрөөнөөс бусад гэрийн бүх хаалга болон өрөөндөө энэхүү тэмдгийг наадаг. Тэгээд гэртээ орж гарахдаа заавал Мэзүза (Mezuzah)-ндаа хүрэх юмуу амаа наан Бурханыхаа хайр ивээлийг мэдэрдэг.

Еврей хүмүүс хүн хэн нэгний эхнэр нөхөр болон гэр бүлийн амьдрал зохиосноор аз жаргал хэд дахин нэмэгддэг гэж итгэдэг. Тиймээс үнэнч гэрлэлтээр дамжуулан олон үр хүүхэд төрүүлэн өнөр өтгөн гэр бүлийг бий болгохыг хамгийн сайхан аз жаргалыг бий болгох зам гэж боддог. Еврейчүүдийн амралтын өдрийн урд өдөр болох баасан гаригийн оройн хоолны цагийг гэр бүлийн бүх гишүүд цугларан аз жаргалаа хуваалцах цагаар ашигладаг. Энэхүү оройн хоолны тухайд үзэсгэлэнтэй сайхан хувцасласан эхнэр охид эмэгтэйчүүд нь амралтын өдрийн бэлгэдэл бүхий лааг асаан нөхөр нь архины хундаганд дарс хундагалана. Дараа нь бүгд оройн зоогт уригдсан зочидтойгоо хамтдаа хооллон дарс уудаг. Хооллож байхдаа Еврей хүмүүсийн талаарх түүх болон хөгжилтэй зүйлсийг ярилцан хөгжилтэй дуу хүртэл дуулдаг. Энэ цаг дээр нөхөр нь заавал эхнэрээ магтаж дуу дуулдаг. “Чи минь энхрий ялдамхан. Чиний минь хэлж ярьж байгаа бүхэнд ухаан шингэсэн байдаг. Бурхан чамайг ерөөн чиний үр хүүхдүүдийг хайрлаж хамгаалдаг” гэх мэтээр эхнэртээ дуу дуулж өгдөг. Энэ бол Еврей гэр бүлийн нэг дүр төрх юм.

Еврей хүмүүс хооллохдоо өөрсдийн Бурхандаа залбирдаг бөгөөд хооллосныхоо дараа зочны өрөөндөө орон хамтдаа “Талмуд” номыг уншин уншсан зүйлийнхээ талаар харилцан ярилцдаг. Еврей гэр бүлд уламжлагдан ирсэн шашны сүсэг бишрэлт амьдрал нь Еврей үндэстний уламжлал болон шашны талаар хүүхдүүдэд зааж сургадаг. Еврей хүмүүс урт удаан хугацааны турш бусад улс үндэстэнд дарлагдан хүнд хэцүү зовлон бэрхшээлтэй байдалд амьдарч байсан ч оршин тогтнож үлдэж чадсан нь гэр бүлд уламжлагдан ирсэн шашны сүсэг бишрэлт амьдралынх хүч юм.

Солонгос хүмүүсийн хувьд боловсролын гол цөм нь сургууль бол Еврей хүмүүсийн хувьд гэр бүл нь байдаг. Еврей хүмүүс эцэг эх хүүхдийнхээ хамгийн сайн найз болон багш нь байх

ёстой гэж үздэг. Хүүхэдтэй болмогцоо хүүхэддээ сайн боловсролын орчинг бүрдүүлж өгөн сайн эцэг эх байхын тулд маш их хичээдэг. Хэнри Киссинжер (Henry Kissinger) бага байхдаа эцэг эхээсээ өвлөн авсан ширээ болон номыг “миний амьдралдаа авсан хамгийн үнэтэй бэлэг” гэж хэлсэн байдаг.

Тэгвэл Солонгос хүмүүсийн тухайд ямар байдалтай байна вэ? Яг үнэндээ хүүхдээ хэрхэн хайрлаж халамжлах, өсгөж хүмүүжүүлэх болон хүүхэдтэйгээ хэрхэн харилцах аргаа мэддэггүй. Тэр байтугай эцгийн эрхт ёсноос шалтгаалан эхнэр болон үр хүүхдээ захиргаадан дарамталдаг эрчүүд нийгэмд цөөнгүй байгаа нь харамсалтай юм. Эрчүүд маань үр хүүхдийнхээ боловсролын асуудлыг зөвхөн эхнэр болон хүүхдийн өөрийнх нь үүрэг хариуцлага гэж үзэн эцэг хүн бол хүүхдийн хамгийн сайн дотны туслагч багш гэсэн бодит үнэнийг хүлээн зөвшөөрдөггүй. Тэгсэн мөртлөө эхнэр хүүхэддээ хандан “Манай хүүхдийн сурлагын дүн яагаад ийм муу байгаа юм бэ?”, “Хичээлээ сайн хий гэж чамд хэлээ биз дээ” гэх мэт захиргаадсан өнгө аястайгаар харьцдаг. Эр нөхөр нь эхнэр хүүхэддээ анхаарал халамж тавин хайрлаж халамжлахгүй байгаа гэр бүл огтхон ч амар тайван байж чаддаггүй. Солонгос улс гэр бүл салалтын хувь болон амиа хорлолтын хувиараа эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын (OECD) гишүүн орнуудын дундаас хамгийн өндөр байгаа юм.

Хүүхдээ гайгүй сургуульд сурган сайн сайхан амьдруулахын тулд хичээх нь зөв ч энэ бүх зүйлийг хийхээсээ өмнө эцэг эхчүүд маань өөрсдийнхөө байгаа байдлыг эргэн нэг харах хэрэгтэй болсон гэж бодож байна. Хүүхэддээ гэрийн даалгавраа сайн хийгээрэй гэж хэлчихээд өөрсдөө телевиз үзээд суучихдаг хүмүүсийг яг үнэндээ эцэг эх гэж хэлэхэд хэцүү юм. Хүүхэддээ хичээлээ сайн хий гэж хэлэхээсээ өмнө өөрөө ном уншин хүүхэд өөрөөс нь үлгэр дууриал авахуйц дүр төрхийг хүүхэддээ харуулах хэрэгтэй. Яг үнэндээ бидний амьдралд тохиолддог өчүүхэн жижиг зүйлс бидний амьдралыг орвонгоор нь өөрчилж чаддаг. Тиймээс өнөөдрөөс эхлэн өглөө ажилдаа явахдаа эхнэр, хүүхдээ тэвэрч үнсээд “Та нартаа хайртай шүү” гэж хэлж сурцгаая. Учир нь амар тайван аз жаргалтай гэр бүл хүүхдийн боловсролын гол үндэс гэдгийг бид байнга санах хэрэгтэй.

Эхнэр нөхөр хоёр бие биеэ хайрлаж халамжилж буй дүр төрхөө хүүхэддээ харуулах

“Талмуд” номонд “Хуримын ёслол дээр хөгжимдөж буй хөгжмийн хүч цэргийн оркесторын хөгжмийн хүчтэй бараг адилхан байдаг” гэсэн үг гардаг. Хурим хийнэ гэдэг эхнэр нөхөр гэсэн цэрэг дайн хийхээр дайны талбарт гарч байгаатай адилхан юм. Хурим хийсэн тэр цаг мөчөөс эхлэн эхнэр нөхөр 2 бие биентэйгээ дайтан нэг нэгнийгээ шархтуулна. Ингээд амьдрах хугацаандаа цэргүүд маань бие биенийхээ шархыг эмчилдэг. Хуримын ёслолын хөгжим гоёмсог сүрлэг сайхан цэргийн оркесторын хөгжимтэй төстэй байдаг учир нь гэрлэсэн тэр цаг мөчөөс эхнэр нөхөр 2 дайны талбарт гарч байгаатай төстэй учраас юм. (Марвин Токаер)

Тэгвэл хүүхдийн боловсролын гол цөм болох гэр бүлээ амар тайван аз жаргалтай байлгая гэвэл юу хийх хэрэгтэй вэ?. Хамгийн чухал зүйл бол эхнэр нөхөр хоёр эв найрамдалтай байх юм. Эцэг эх нь хоорондоо сайн харилцаатай гэр бүлд өссөн хүүхэд муу байдалтай болно гэж бараг л байдаггүй. Еврей хүмүүсийн нийгэмд гэр бүл салалтын хувь маш бага байдаг учир нь эхнэр нөхөр хоёр бие биеэ хайрлаж халамжлан хүндэтгэх тал дээр маш сайн байдаг учраас юм. “Талмуд” номонд хайр сэтгэл болон гэрлэлтийн чухал чанарын талаар онцолсон үгнүүд маш их гардаг.

Бурхан эмэгтэй хүнийг эрэгтэй хүний хавирганы ясаар бүтээсэн учраас эмэгтэй хүнийг цаг ямагт эрэгтэй хүний сэтгэлд ойрхон байлгадаг. Түр зуурын сэтгэл хөдлөлөөр бий болж буй нүцгэн сохор дурлал аз жаргалтай амар тайван гэр бүлийг бий болгож чадахгүй учир өөрийгөө хайрлаж байгаа юм шиг нөгөө хүнээ хайрлаж хүндэтгэх хэрэгтэй.

Эрэгтэй эмэгтэй хүн гэрлэснийхээ дараа хайр дурлалдаа мансууран шатахаасаа илүү аль хэдийн халуун галд боловсрон буцаад хүйтэн болсон алт, мөнгөн таваг шиг энгийн сэтгэлээр өдөр тутам амьдрах нь илүү амар тайван амьдралыг бий болгодог.

Эхнэр нөхөр хоёр үнэхээр чин сэтгэлээсээ бие биенээ хайрлаж байгаа бол хутганы ир шиг жижигхэн давчуу орон дээр ч хамтдаа унтаж чадна. Харин хоорондоо харилцаа муутай байвал хичнээн өргөн том ор ч жижигхэн мэт санагдана.

Дэлхийд хатуу зүйл 12 байдаг. 1-рт чулуу. Харин чулуу төмрөнд дийлддэг. Төмөр галанд хайлдаг. Гал усанд унтардаг. Ус үүлэнд уусаж шингэдэг. Үүл салхинд туугддаг. Харин салхи хүнийг хийсгэж чаддаггүй. Гэвч хүн гэдэг амьтан зовлон бэрхшээл тохиолдох үед амархан шантарч бууж өгдөг. Хүн зовлон бэрхшээлээ түр зуур мартахын тулд архи уун согтож болох юм. Архи хүнийг түр зуур согтоон унтуулж чаддаг. Гэхдээ нойронд хүнийг үхүүлж чадах хүч байдаггүй. Гэвч хайр гэдэг зүйл бол үхлийг ч ялан дийлж чаддаг.

Еврей гэр бүлд эхнэр нөхөр бие биенээ хайрлаж халамжлан гэр бүлээ амар тайван аз жаргалтай байлгахын төлөө бүхий л хүчээ дайчилдаг. Учир нь эхнэр нөхөр хоёр бол гэр бүлийн гол цөм болохоор гэр бүлийнхээ гол түшиг тулгуур болж байж хүүхдүүд нь зөв өсч хүмүүжин зөв хүн болно гэдгийг сайн мэддэг. Хүүхдийн хамгийн сайн багш бол эцэг эх хоёр. Еврей хүмүүс гэрлэснийхээ дараа эцэг эхчүүдийн боловсролын төвд яван хүүхэдтэй хүмүүсээс хүүхдийг хэрхэн зөв өсгөж хүмүүжүүлэх арга барилын талаар суралцдаг. Эхнэр нь

жирэмсэн болвол хүүхдийн эрүүл мэнд юмуу бага насны хүүхэдтэй холбоотой ном сэтгүүл уншин судалгаа хийж эхнэр нөхөр хоёулаа идэвхтэй суралцдаг. Үүнээс харахад амар тайван аз жаргалтай гэр бүлийг бий болгож буй үндэс сууринд гэр бүлийн гишүүд хоорондын харилцаа, хайр халамж томоохон байр суурь эзэлж байгаа юм.

Ер нь Еврей болон Солонгос хүмүүсийг хүүхдийнхээ боловсролд бараг л амь насаа зориулах хэмжээгээр анхаарал хандуулдаг гэж хэлж болно. Гэвч үр дүнг нь харвал тэнгэр газар шиг ялгаатай байгаа юм. Ийнхүү ялгаатай байгаа учир шалтгаан гэр бүлийн гишүүдийн харилцаа холбоо, хайр халамжинд байгаа юм. Солонгос хүмүүс өөрийн хань ижил, үр хүүхдээ хайрлаж халамжлах тал дээр маш муу байдаг. Эцгийн эрхт ёсны чиг хандлагаас болоод ч тэрүү сэтгэл байгаа боловч хайр халамжаа илэрхийлэх арга барилаа мэддэггүй.

Харин Солонгос гэр бүлд хайр халамжийг орлох зүйл нь эд зүйл байдаг. Эд зүйлээр эхнэрийнхээ хайр халамжийг худалдан авч эд зүйлээр хүүхдээ сурах хүсэл эрмэлзэлтэй болгодог. Гэвч эд зүйлээс мэдрэх аз жаргалд тодорхой хэмжээ хязгаар байдаг. Хүн гэдэг амьтан хайр байхгүй бол амьдарч чадахгүй. Үнэндээ хүмүүст хийх зүйл зөндөө байдаг ч хайр халамжаар дүүрэн гэр бүлийг бий болгох нэн түрүүний хийх хэрэгтэй зүйл юм. Ингэж байж л хүүхдүүд аз жаргалтай амар тайван орчинд сурч боловсрохдоо анхаарч чаддаг.

Хүүхдээ хэрүүл маргаан, уур уцааргүй орчинд өсгөж хүмүүжүүлснээр бусдыг чин сэтгэлээсээ хайрлаж халамжлан аливаа зүйлд чин сэтгэлээсээ ханддаг хүн болдог. Хүүхдийнхээ өмнө эхнэр нөхөр хоёр өдөрт ядаж нэг удаа бие биенийгээ үнсэн хайрлаж халамжилж байгаагаа харуулах хэрэгтэй. Тогтмол үнсэлцсэнээр биеийн эсэргүүцэл сайжран дундаж наслалтыг 5 орчим жилээр уртасгадаг гэсэн судалгааны үр дүн ч байдаг учраас нэг сумаар 2 туулай буудаж байгаа хэрэг биш гэж үү. Хайр халамжаар дүүрэн гэр бүлд өссөн хүүхэд муу амьдарна гэж бараг байдаггүй. Хайр халамжаар дүүрэн орчинг бүрдүүлж өгснөөр эцэг эх нь хичээл номоо хий гэж хэлэхгүй байсан ч хүүхэд өөрийнхөө хийх ёстой зүйлийг өөрөө мэдэн хийж чаддаг.

Эхийн хэвлийд байх үеэс нь хүүхэддээ боловсрол олгох

Эмэгтэй хүний сарын тэмдэг ирсэн үед 5 хоног бэлгийн харьцаанд орохгүй байх хэрэгтэй бөгөөд сарын тэмдэг дууссаны дараа ч 7 хоногийн турш бэлгийн харьцаанд орохгүй байх хэрэгтэй. Сарын тэмдэг ирснээс хойш 12 дахь хоног дээр сүүтэй усанд биеэ угаадаг "Микбэ" гэж нэрлэдэг угаалгыг үйлдсэнийхээ дараа бэлгийн харьцаанд орж болно. Энэ бол Нитта (Nitta-Еврейчүүдийн жирэмслэх арга) жирэмслэх арга юм. Ер нь жирэмсэн болсны дараа эх хүүхдийн эрүүл мэндэд санаа тавих нь маш буруу юм. Тиймээс эрүүл чийрэг бие мах бодь, оюун ухаантай хүүхэдтэй болъё гэвэл жирэмслэхээсээ өмнө эцэг эхчүүд өөрсдийн эрүүл мэнддээ маш сайн анхааран жирэмслэх тохиромжтой үеийг сонгон төлөвлөгөөтэйгээр жирэмслэх хэрэгтэй.

Хун Ён Жэ зохиолчийн "Суут ухаантнуудыг төрүүлж буй Еврей хүмүүсийн төлөвлөгөөтэй жирэмслэлт, Нитта (Nitta-Еврейчүүдийн жирэмслэх арга) жирэмслэх арга/ номноос.

Еврей хүмүүсийн уламжлалт төлөвлөгөөт жирэмслэх арга болох Нитта (Nitta) нь Еврей хэлээр сарын тэмдэг гэсэн утгатай үг юм. Еврей хүмүүс хэдэн мянган жилийн турш Нитта (Nitta) жирэмслэх аргын дагуу жирэмслэн хүүхэд төрүүлсээр ирсэн. Эм бэлгийн эс хамгийн цэвэр эр бэлгийн эсийн чадвар хамгийн сайн байх үед жирэмсэлдэг энэхүү арга бол эрүүл чийрэг ухаантай хүүхэдтэй болох хамгийн шилдэг арга юм.

"Суут ухаантнуудыг төрүүлж буй Еврей хүмүүсийн төлөвлөгөөтэй жирэмслэлт, Нитта (Nitta-Еврейчүүдийн жирэмслэх арга) жирэмслэх арга" номын зохиолч Хун Ён Жэ доктор Нитта (Nitta) жирэмслэх аргын гол цөмийг 2 янзаар тайлбарласан байна. 1 дэхь арга нь сарын тэмдгийн хугацаа дууссаны дараа 1 долоо хоногийн турш бэлгийн харьцаанд орохыг хориглоно. Бэлгийн харьцааг хориглосон өдөр дуусахаас 1-2 хоногийн өмнө өндгөн эс ялгаран жирэмсэн болох магадлал хамгийн өндөр болдог. Бэлгийн харьцаанд орохыг хориглосон хугацаанд бүрэлдэн хуримтлагдсан олон тооны эрүүл эр бэлгийн эс дөнгөж боловсорсон шинэ эм бэлгийн эстэй нийлснээр эрүүл чийрэг бие мах бодь оюун ухаантай хүүхэд төрөх магадлал маш өндөр байдаг.

2 дахь арга бол сүүтэй усанд ордог "Микбэ" угаалгыг үйлдсэнийхээ дараа бэлгийн харьцаанд орох юм. Сүүтэй усанд биеэ угааснаар хүний үржлийн эрхтний ариун цэврийг сайн хангаж өгдөг бөгөөд арьсыг уян зөөлөн толигор болгодог. Сүүтэй усанд биеэ угаасны дараа бэлгийн харьцаанд орсноор арьсны хүрэлцэх мэдрэмж сайжран бэлгийн дур хүслийг нэмэгдүүлэн жирэмслэх хувь өндөр болдог.

Эхийн хэвлийд байхаас нь хүүхэддээ боловсрол олгож эхэлдэг үзэгдэл зөвхөн Еврей эмэгтэйчүүдийн хийдэг зүйл биш юм. Солонгос улс төдийгүй бараг бүх улсын эмэгтэйчүүд хүүхдээ эхийн хэвлийд байхаас нь боловсрол олгох тал дээр ихээхэн анхаарал хандуулдаг. Харин Еврей хүмүүсийн хүүхдээ эхийн хэвлийд байхаас нь боловсрол олгох арга барил болон бусад үндэстний хүмүүсийн арга барилд маш том ялгаа байдаг. Үнэндээ бодит байдал дээр ихэнхи хүмүүс жирэмсэн үед хийж болохгүй зүйлсийг хамгийн их хийдэг. Солонгос хүмүүсийн тухайд 6-р зууны дунд үеэс эхлэн эрүүл чийрэг бие мах бодь, оюун ухаантай хүүхэд төрүүлэхийн тулд эцэг эхийн сэтгэл санааны байдал болон бие мах бодийн байдалд

анхаарал хандуулсаар ирсэн.

Эмэгтэй хүн жирэмсэлсэн бол идэж ууж байгаа хоол хүнсэндээ анхааран сайн унтаж амарч байвал хөөрхөн хүүхэд төрүүлж чадна. (Кэнёшо)

Хүний сэтгэл санаа цэвэр ариун байвал ухаантай хүүхэд төрөн сэтгэл санаа тогтворгүй муу байдалтай байвал ухаан муутай хүүхэд төрнө. (Нэхүн)

Жирэмсэн байх үед эх үүр уцаартай байвал үр хөврөлийн цус өвчилдөг. Эх ямар нэгэн айдас түгшүүртэй байвал үр хөврөлийн оюун ухаан өвчлөн сэтгэл санаа зовиуртай байвал хүч тэнхээ муутай хүүхэд төрдөг. Мөн эх ямар нэгэн зүйлээс гэнэт цочвол татаж унадаг өвчтэй хүүхэд төрөх магадлал өндөр байдаг. (Тунабугам)

Жирэмсэн эхийн унтах, суух, харж байгаа зүйл, идэж ууж байгаа зүйл, хэлж үйлдэж байгаа зүйл гэх мэт бүхий л үйл хөдлөл нь зөв байвал төрөх хүүхдийн дүр төрх, царай зүс нь ч зөв байдаг бөгөөд авъяас чадварын хувьд ч гайхалтай байдаг. (Сонхагжибюу)

Гэтэл Еврей хүмүүсийн эхийн хэвлий дэхь хүүхдэд олгох боловсрол “нярай хүүхдийн төлөө хийх хэрэгтэй бүх зүйл”-ийг гол цөмөө болгон онцолдог. Эрүүл чийрэг бие мах бодь болон оюун ухаантай хүүхэдтэй болохын тулд төлөвлөгөөтэйгээр жирэмсэлдэг Нитта (Nitta-Еврейчүүдийн жирэмслэх арга) жирэмслэх арга нь Еврейчүүдийн гол арга юм. Еврей хүмүүс жирэмслэхээсээ 100 хоногийн өмнөөс хүүхэдтэй болох бэлтгэлээ хийж эхэлдэг. Яг л Солонгос улсад дээхэн үед хийдэг байсан уулын гүнд очин 100 хоногийн турш гуйж залбирсны дараа хүүхэдтэй болдог байсантай төстэй юм.

Жирэмсэлсэн бол эхнэр нөхөр хоёулаа сэтгэл санаагаа өөдрөг баяр хөөртэй байлгахын тулд хичээдэг. Жирэмсэн эх баяр хөөртэй сэтгэл хангалуун байснаар хүүхэд цэвэр ариун зан ааштай төрдөг. Жирэмсэн байх хугацаандаа эх сэтгэл санааны хувьд хэцүү зовлонтой байвал хүүхэд өсөж том болох явцдаа сэтгэл зүйн талаасаа бас тогтворгүй нэгэн болох магадлал өндөр байдаг.

Оюун ухааны хаан хэмээн нэрлэгддэг Соломоний зохиосон “Сургаалт үгс” номыг хүүхдээ төрөхийг хүлээж буй эцэг эх хоёр өдөр болгон эхийн хэвлийд байгаа хүүхэддээ уншиж өгдөг бөгөөд “Сургаалт үгс номыг уншиж өгөн эхийн хэвлийд байгаа хүүхдэд боловсрол олгох арга” нь ч Еврей хүмүүсийн эхийн хэвлий дэхь хүүхдийн боловсролын аргын нэг юм. Еврей эмэгтэйчүүд жирэмсэн байх үедээ мөнгөн хадгаламжийн сав бэлтгэн өдөр болгон түүндээ мөнгө хийн хуримтлал үүсгэж байгаад хүүхдээ төрсний дараа хүүхдийнхээ нэрээр ямар нэгэн газарт хандивладаг.

Нитта (Nitta-Еврейчүүдийн жирэмслэх арга) жирэмслэх арга болон эхийн хэвлий дэхь хүүхдэд боловсрол олгох аргыг ашиглан Еврей хүмүүс эрүүл саруул бие мах бодь болон оюун ухаантай хүүхэд төрүүлж чаддаг. Гэхдээ эхийн хэвлий дэхь хүүхдэд боловсрол олгохыг хэн нэгний тулган шаардалтаар хийдэггүй. Энэхүү аргыг олон мянган жилийн уламжлалын дагуу ашигласаар ирсэн.

Өнөө үед Солонгос улсын эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо ч гэсэн ихээр нэмэгдэж

байгаа бөгөөд төлөвлөгөөтэйгээр жирэмслэх үзэгдэл их байгаа боловч хүүхдэд эхийн хэвлийд байхаас нь боловсрол олгох тал дээр учир дутагдалтай байна. Жирэмсэлснийхээ дараа байнга баяр хөөртэй сэтгэлтэй байх, хэрэглэж буй хоол хүнсэндээ анхаарах гэх мэт уламжлалт хэвлий дэхь хүүхдийн боловсролын аргыг ашиглах нь энгийн зүйл. Тиймээс эрүүл чийрэг бие мах бодь болон оюун ухаантай хүүхэдтэй болохын тулд Еврейчүүдийн ашигладаг хэвлий дэхь хүүхдийн боловсролын арга барилыг туршаад үзэхэд илүүдэхгүй юм.

Бэлгийн амьдралын талаар хүүхэдтэйгээ илэн далангүй байх

Еврей хүмүүс мөнгө болон эр эмийн харьцааг /бэлгийн харьцаа/ хориглоод байдаггүй. Харин эсрэгээрээ хүний амьдралд тус болдог зүйл гэж боддог. Мөнгө болон бэлгийн харьцаанд нийтлэг тал байдаг. Хоёулаа хүний амьдралд чухал хэрэгтэй зүйл бөгөөд хэрвээ аль нэг нь дутагдвал хүн тэр дутагдаж байгаа зүйлийнхээ талаар байнга бодон тэр зүйлд хэтэрхий их анхаарал хандуулахаар болдог. Амьдралд шаардлагатай эдгээр зүйлс тодорхой хэмжээгээр бий болсноор хүний бусад зүйлсэд хандах хандлага ч өөрчлөгдөн амьдрал аяндаа амар тайван болдог. Тиймээс мөнгө болон бэлгийн харьцааны талаар чөлөөтэй байх нь дээр юм. Гэхдээ нэг анхаарах хэрэгтэй зүйл гэвэл тодорхой хэм хэмжээг хэтрүүлэхгүй байх нь чухал. (Марвин Токаер)

1970-аад оны үе буюу намайг улсын сургуульд сурч байх /одоогийн бага сургууль/ үед манай ангийн сурагчдын ихэнхи нь гүүрэн доороос олдсон хүүхдүүд байсан юм. Учир нь ихэнхи ээж нар хүүхэд нь “Ээжээ би хаанаас төрсөн юм бэ?” гэж асуувал яаж хариулахаа мэдэхгүй сандарч балмагдан “Чамайг гүүрэн доороос олж авсан юм“ гэж хариулдаг байсан учраас хүүхдүүд тэгэж ярьдаг байв. Харин сүүлийн үед хүүхдийнхээ асуултанд ингэж хариулдаг ээж нар бараг байхгүй болсон боловч эцэг эхчүүд бэлгийн боловсролын талаарх мэдлэг дутуу байдгаас шалтгаалан хүүхэд нь гэнэт эр эмийн харьцааны талаар асуулт асуухад хэрхэн хариулах учраа олохгүй сандарч тэвдэн хүнд байдалд орж байгаа байдал хэвээр байсаар байна.

L ..... нь 4, 5 насны жил дараалан гарсан хоёр хүүхэдтэй бөгөөд нэг өдөр хүүхдүүдээ усанд оруулж байгаад хүүхдийнхээ асуусан гэнэтийн асуултанд хэрхэн хариулахаа мэдэхгүй хүнд байдалд орсон байна. Яагаад хүнд байдалд орсон бэ гэвэл түүний охин нь усанд орж байхдаа гэнэт “Ээжээ ахад боожгой байхад надад яагаад байхгүй байгаа юм бэ?” гэж асуусан бөгөөд охиныхоо энэ асуултанд хэрхэн хариулахаа мэдэхгүй маш их сандарсан байна. Тэрээр хэрхэн хариулахаа мэдэхгүй “Харин ээ” гэж байтал ашгүй нэг юм хүүхдүүд нь хоорондоо тоглон анхаарал нь өөр тийш хандсанаар тэрээр аврагдсан байна.

Эртний Еврейн нийгэмд маш нарийн шашны ёс журмын дагуу гуйлтын амьдралаар амьдран “Назир хүн” хэмээн нэрлэгддэг шашны удирдагч нар байсан. Эдгээр хүмүүс нь архи дарс, зугаа цэнгэл, эмэгтэй хүмүүсээс хол цөлд 1 жил, бүр уртдаа 10 жилийн хугацаагаар ч амьдардаг байсан байна. Гэвч яг шашны ёс журмын дагуу амьдардаггүй хүмүүс нь Бурханаас уучлал гуйсны дараа архи дарс, эмэгтэй хүнтэй дахин ороцолдсон байна. Христийн шашинтай хүмүүсийн хувьд ойлгож хүлээн зөвшөөрөхөд үнэхээр хэцүү зүйл боловч Еврей хүмүүсийн хувьд энэ нь зүгээр нэг энгийн үзэгдэл юм.

Христийн шашны үндэс суурь болох Грек, Ромын үзэл санаа нь хүн төрөлхтний сүнс цэвэр ариун ч эсрэгээрээ бие мах бодь нь бузар гэж үздэг. Тиймээс бие мах бодийн хүсэл тачаалаа тэвчих үзэл суртал юмуу ганц бие амьдралыг илүүд үздэг. Одоо ч гэсэн Христийн шашинд ариун амралтын өдөр бэлгийн харьцааг тэвчих нь эрхэм дээд ёс суртахуун гэж үздэг. Харин Еврейн шашинд бэлгийн харьцааг жигшилгүй харин ч эсрэгээрээ амьдралд тус болдог зүйл гэж үздэг. Бурхан хүн төрөлхтнийг бүтээхдээ эрэгтэй эмэгтэй хүний хоорондбие мах бодийн хайрыг хүлээн зөвшөөрсөн учраас үүнд анхаарах хэрэгтэй гэж боддог. Тиймээс архи дарс, дуу

хуур, бэлгийн харьцаа гэх мэт амьдралд баяр хөөр өгдөг зүйлсийг няцаан эсэргүүцэхийг харин ч буруу зүйлд тооцдог. Еврей хүмүүс өөрсдийн амралтын өдрөө ч бэлгийн харьцаанд орохыг хүлээн зөвшөөрдөг. Еврей хүмүүс бэлгийн харьцаанд чөлөөтэй байхыг чухалчилдаг ч мэдээж эхнэр нөхрийн хоорондох ариун харилцааг хүлээн зөвшөөрдөг. “Талмуд” номонд бэлгийн харьцааны талаар ийнхүү бичсэн байдаг.

Бурхан хүн төрөлхтөнд эр эмийн харьцааг хүлээн зөвшөөрсөн учраас хүний амьдралд энэ зүйл байхгүй бол хүн амьдралын утга учрыг бүрэн дүүрэн мэдэрч өөрийгөө илэрхийлж чадахгүй.

Бэлгийн харьцаа бол байгалийн нэг хэсэг бөгөөд бэлгийн харьцаа байгалийнх бус гэж байдаггүй.

Тохиромжтой хувийн харилцааг бий болгон дотно уур амьсгалд бэлгийн харьцаанд орох хэрэгтэй. Ямар нэгэн байдлаар өөрийг чинь хязгаарлах орчинд бэлгийн харьцаанд орохгүй байх хэрэгтэй.

“Тора” номонд хүн төрөлхтний хамгийн анхны бэлгийн харьцааны талаар ингэж тэмдэглэсэн байдаг.

Адам өөрийн эхнэр болох Еватай унтсан бөгөөд эхнэр нь жирэмслэн Кайныг төрүүлснийхээ дараа “Би Бурханы ивээлээр эрэгтэй хүүхэд төрүүллээ” гэж хэлсэн байдаг.

“Тэврэх” гэдгийг Еврей хэлээр Яда(Yada) гэж нэрлэдэг бөгөөд үүнд “хамт унтах” болон “нөгөө хүнээ тэврэх” гэсэн 2 утга агуулагддаг. Еврей хүмүүс “хайртай гэдэг нь заавал тэврэх, хамт унтахыг хэлдэг” гэж ойлгодог.

Бэлгийн харьцааг хүний амьдралд байх ёстой энгийн чөлөөтэй зүйл гэж боддог Еврей хүмүүсийн бодол бэлгийн амьдралынх нь боловсролд бүрэн тусгалаа олсон байдаг. Еврей хүмүүсээс бэлгийн харьцааны талаар ямар нэгэн зүйл асууж лавлах юмуу ярилцах үед ичиж зовох юмуу уурлана гэж огтхон ч байдаггүй. Еврей хүмүүс хүүхдээ энэ талаар хэтэрхий их сонирхон буруу ойлголт хандлагатай болгохгүйн тулд хүүхэд эр эмийн харьцааны талаар сонирхож эхлэх үеэс нь эхлэн хүүхэдтэйгээ илэн далангүй ярилцаж эхэлдэг. Яагаад гэвэл хүүхдийн эр эмийн харьцааны талаарх сонирхлыг хүчээр хааж боох юмуу энэ талаарх сонирхсон асуултанд нь хариулалгүй нууж хаах тусам хүүхдийн сонирхол улам их татагдан бэлгийн харьцааны талаар буруу ойлголт, чиг хандлагатай болох аюул их байдаг. Еврей хүмүүс хүүхдээ асуугаагүй байхад хэлж өгөх шаардлагагүй гэж боддог ч мэдэхийг хүсэж байгаа зүйлийнх нь талаар нуугаад байлгүй үнэн зөвөөр нь тайлбарлан хэлж өгдөг. Эцэг эх нь ингэж хүүхэддээ тайлбарлан хэлж ойлгуулснаар хүүхэд эр эмийн харьцааны талаар хэрэггүй зүйлийг төсөөлөн бодох шаардлагагүй болдог. Бусад зүйлсийн талаар хүүхэд аяндаа өсөж том болох явцдаа өөрөө суралцдаг.

Еврей хүмүүс ихээр амьдардаг Нью-Йорк хотын нэгэн телевизийн нэвтрүүлгээр “Эцэг эх болон 10-19 насны залуучуудын зайлшгүй мэдэх шаардлагатай бэлгийн амьдрал” гэсэн сэдвээр өсвөр насныхны эрүүл мэндийн 2 мэргэжилтэн ярилцлага хийж байхыг үзсэн юм. Эдгээр мэргэжилтнүүд “Хүн өөрийнхөө хийж буй үйлдэлдээ хариуцлага хүлээж чадахаар

болсон бол бэлгийн харьцаанд ороход зүгээр” гэж үздэг Еврей хүмүүсийн бодол санаатай төстэй дараах зүйлийг ярьсан юм.

· 10-19 насны үеийн хүүхдүүд гар хангалга хийх нь хэвийн үзэгдэл юм. Энэ насанд ихэнхи залуучууд гар хангалга хийдэг. Хүүхэд 16-17 насандаа гар хангалга хийх нь улам эрчимждэг. Гэхдээ анагаах ухааны талаас нь авч үзвэл гар хангалга хийх нь хүний эрүүл мэндэд огтхон ч хор хөнөөлтэй зүйл биш юм. Харин ч эсрэгээрээ 10-19 насанд бие махбодид хүчтэйгээр үүсдэг бэлгийн хүсэл тачаалыг бууруулдаг сайн арга юм.

· Шилжилтийн насны эрэгтэй сурагч нойтон зүүд зүүдэлж эхлэхээс нь өмнө эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ярилцан энэ талаар тайлбарлаж өгөх хэрэгтэй. Энэ бол сарын тэмдэг нь ирэх дөхөж байгаа эмэгтэй хүүхдэд урьдчилан зөвлөгөө өгч байгаатай адилхан зүйл юм. Хэрвээ 10-19 настай эрэгтэй хүүхэд нойтон зүүдний талаар ямар ч ойлголтгүй байвал өөрийгөө орондоо шээсэн байна гэж боддог бөгөөд энэ байдал нь хүүхдийн сэтгэхүйд хүчтэйгээр нөлөөлөн яваандаа асуудал үүсгэдэг.

· 10-19 насны үед хүүхэд ижил хүйстэндээ татагдах тохиолдол их байдаг бөгөөд үүнийг хэвийн үзэгдэл гэж хэлж болно. Учир нь залуучууд ижил хүйстэндээ татагдаж байгаа нь өөрийнхөө бие мах бодийн өсөлтийг дүгнэн нас чацуутангуудтайгаа өөрийгөө харьцуулж байгаа нэг үзэгдэл юм. Тиймээс залуучуудын ижил хүйстэндээ татагдаж байгаа байдлыг “бэлгийн чиг хандлага(sexual behavior)”-аас тусад нь салгаж үзэх хэрэгтэй. Залуучууд нэг хэсэг ижил хүйстэндээ татагдаж байгаад өсөж том болоод өөрчлөгддөг тохиолдол их байдаг.

· 14-17 насны залуучуудын бэлгийн чиг хандлагын талаар хийсэн нэгэн судалгааны үр дүнгээс харвал АНУ-ын ахлах сургуулийн 3-р ангийн сурагчдын дунджаар 60 хувь нь бэлгийн харьцааны талаар туршлагатай байсан байна. Өнөөдрийн байдлаар ахлах сургуулийн сурагчдын байдлыг харвал тэдний бэлгийн харьцааны талаарх ойлголт нилээн сайн байгаа юм. Бэлгийн харьцааны талаар туршлагатай ахлах сургуулийн сурагчид туршлагагүй сурагчдаас их байгаа гэсэн үг юм.

· Бэлгийн амьдралынхаа талаар өөрөө бие даан шийдвэр гаргаж байгаа залуучуудын тухайд бэлгийн хүсэл тачаалаа тэвчих байдлыг тайван хүлээн зөвшөөрч байгаа эсэх, үүнээсээ стресс авч байгаа эсэх нь хувь хүн юмуу үеийн найз нөхдийнхөө нөлөөллөөс шалтгаалаад янз бүр байдаг. Тухайлбал үдэшлэгэн дээр найз нөхөдтэйгээ нийлэн архи дарс уун тамхи татдаг 10-19 насны залуус бэлгийн харьцаанд орох хугацаа нь маш эрт байдаг. Тиймээс та өөрийнхөө хүүхдийг бэлгийн амьдралын талаар буруу ойлголт, чиг хандлагатай болон буруу үйлдэл хийлгэхгүйн тулд эцэг эхчүүд хүүхдийнхээ сургуулийн амьдралд бас анхаарал хандуулах нь зүйтэй юм.

· Бүх улсыг хамруулан хийсэн хамгийн сүүлийн судалгаанаас харвал хамгийн анх бэлгийн харьцаанд орж байгаа 10-19 насны залуучуудын 3/2 хувь нь жирэмслэлтээс сэргийлсэн гэсэн үр дүн гарсан байна. Энэ бол 1970 онтой харьцуулахад 10-20 хувь өссөн үзүүлэлт юм.

Бэлгийн харьцааны тал дээр чөлөөтэй илэн далангүй байдаг гээд Еврей хүмүүсийг бэлгийн замбараагүй амьдралтай гэж ойлгох нь буруу юм. Еврей хүмүүсийн гэр бүл салалтын хувь бусад үндэстэнтэй харьцуулахад маш бага байдаг. Учир нь эрэгтэй хүн эмэгтэй хүнийг маш

үнэ цэнэтэйд тооцдог хатуу уламжлалтай учраас юм. Еврей хүмүүс залуу насандаа янз бүрийн хүнтэй хайр сэтгэлийн харилцаа үүсгэж байсан ч хуримаа хийн хүнтэй гэрлэснээсээ хойш зөвхөн өөрийн эхнэр, нөхөр, гэр бүлдээ үнэнч байдаг.

Бэлгийн харьцаа гэдэг бүхий л амьдралын турш зөвхөн нэг хүний хүсэл шаардлагаар хийдэг зүйл биш юм. Эхнэр нь зөвшөөрөөгүй байхад хүчээр бэлгийн харьцаанд орж болохгүй. Эхнэр нь хүсэхгүй байхад хүчээр бэлгийн харьцаанд орохыг хориглоно. (Талмуд номны хэсгээс)

Хүүхэд 4-5 наснаасаа эхлэн эрэгтэй эмэгтэй хүний ялгааны талаар ойлголттой болж эхэлдэг бөгөөд хүйсийн талаар сонирхож эхэлдэг. Тиймээс хүүхдийнхээ мэдэхийг хүсэж байгаа зүйлийнх нь талаар хүүхдийнхээ сэтгэхүйн түвшинд тааруулан хэлж тайлбарлаж өгч байх нь маш чухал юм. Хүүхдийнхээ асуусан гэнэтийн асуултанд сандарч балмагдан асуултыг нь булзааруулах юмуу хариулахаас татгалзвал хүүхэд “бэлгийн харьцааг тодорхой бус нууцлагдмал зүйл” гэж ойлгох нь амархан байдаг. Эрэгтэй эмэгтэй хүний бие мах бодийн ялгаатай тал, хайр сэтгэл, хүүхэд хаанаас төрдөг гэх мэт зүйлсийн талаар хүүхдийнхээ түвшинд тааруулан хэлж ярьж өгч байх хэрэгтэй.

Орчин үед тулгараад байгаа том асуудлын нэг бол шилжилтийн насны үеийн хүүхдийн бэлгийн боловсрол юм. Сүүлийн үеийн залуучуудын бэлгийн амьдралын талаарх ойлголт томчууд ч ойлгоход хэцүү хэмжээгээр хэтэрхий ил тод нээлттэй болж байна. Мэргэжилтнүүд бие мах бодийн хувьд боловсорч гүйцсэн залуучуудад зөвхөн бие мах бодийн хүсэл тачаалаа тэвчихийг онцлон зааж буй бэлгийн боловсрол нь орчин үед ямар ч үр дүнгүй зүйл болсон гэдгийг хэлж байна. Учир нь насанд хүрсэн хүмүүс ч алдаж эндэг энэ хорвоо ертөнцөд бүрэн нас биед хүрээгүй байгаа шилжилтийн насны залуучууд алдаж эндэх нь мэдээжийн зүйл юм. Биологийн талаас нь авч үзвэл залуу насанд бэлгийн дур хүсэл, шаардлага, сонирхол хамгийн их байдаг. Бидний ном зохиолоос уншиж байсан Ромео Жулиата, И Мун Рюун болон Чүн Хян И нь бие биедээ хайртай болохдоо 16 настай байгаагүй гэж үү.

Тиймээс залуучуудад юуны түрүүнд бие мах бодийн хүсэл тачаалаа тэвчиж хязгаарлах талаар бэлгийн боловсролыг олгох шаардлагатай боловч шилжилтийн насны үедээ хэрхэн аюулгүйгээр бэлгийн харьцаанд орж болох талаар тодорхой зааж ойлгуулах нь маш чухал юм. Хэрвээ бэлгийн харьцаанд орох тохиолдолд зөвхөн хайртай хүнтэйгээ бэлгийн харьцаанд орохыг чухалчлан заавал хамгаалалт хэрэглэж байхыг зааж өгөх хэрэгтэй. Бэлгийн харьцааны тал дээр туршлагатай 10-19 насны залуучуудын жирэмслэлтээс хамгаалах хувь АНУ-д 81 хувь байхад харин эсрэгээрээ Солонгос улсад 21 хувь ч хүрэхгүй байгаа гэсэн статистик мэдээ байдаг.

Суралцах чадвар

Хүний толгой доторх мэдлэг бол амьдрах зэвсэг

Хүүхдийн тархины хөгжил бол эцэг эхийн хариуцлага

- Зөгийн балаар бичдэг цагаан толгойн үсэг,

оньсого тааврааp дамжуулан сурдаг үг -

- Унтахаас нь өмнө хүүхэддээ 15 минут ном уншиж өгөх гайхалтай аргыг хэрэглэх -

- “Давхар хэлний боловсролоор” хүүхдийнхээ гадаад хэлний чадварыг сайжруулах -

- Эцэг эх бол хүүхдийнхээ ярилцлагын хамгийн гол хамтрагч -

- Онигоо ойлгож мэдэрдэг болгох дасгалжуулалт -

- Өдөр бүр өглөөний хоолоор хүүхдийнхээ тархийг сэргээх -

- “Талмуд” хэлбэрийн ярилцлагын аргыг ашиглан хүүхдийнхээ

асуултанд хариулахаас илүүтэйгээр хүүхэддээ асуулт тавих -

- Хүүхдийнхээ хийсэн ямар нэгэн зүйлийн үр дүнг хараад магтахаас илүүтэйгээр

тэрхүү зүйлийг хийх явцад сэтгэл санаaны дэмжлэг үзүүлэх -

- Цаг зав гарган хүүхэдтэйгээ хамт тоглон бүтээлч чадварын

гол цөм болох баруун тархийг нь хөгжүүлэх -

- Хичээл ном бол холын зайн гүйлт, эцэг эх бол дасгалжуулагч -

- Хүүхэддээ итгэл найдвар өгөн чи ийм байх ёстой гэсэн ямар нэгэн шалгуур тавихгүй байх -

Зөгийн балаар бичдэг цагаан толгойн үсэг, оньсого тааврааар дамжуулан сурдаг үг

Еврей хүмүүс дээр үеэс эхлэн "Оньсого таавар болон тоглоом наадмыг хүний тархийг хурцалдаг билүү" гэж үзэн хүүхдийнхээ боловсролд идэвхитэйгээр ашигласаар ирсэн. Тэдний судар ном болох "Талмуд" номонд ч оньсого тааврааар илэрхийлэгдсэн оюун ухааны зүйлс их бичигдсэн байдаг. Жишээ нь "Хүний нүдний хүүхэн хараа цагаан болон хар хэсгээс бүтсэн байдаг бөгөөд яагаад хар хэсгээр нь дамжуулан эд зүйлсийг хардаг юм бол? "Учир нь хүн амьдрах хугацаандаа харанхуйгаар дамжуулан гэгээтэй зүйлийг харж амьдрах хэрэгтэй гэсэн далд утгатай юм". Амьдрал бол буцах замын урт аян зам юм. Хүний амьдрах хугацаанд харанхуй, гэрэл гэгээ 2 байнга дагалдаж байдаг нь мэдээж зүйл юм. Хүний амьдралд хүнд хэцүү зүйл, уналт доройтол гэх мэт харанхуй хэсэг байдаг нь хэн ч маргашгүй үнэн бөгөөд бид үүнийг байгаа байдлаар нь хүлээн авч даван туулж амьдрах хэрэгтэй. Хүүхдүүд иймэрхүү маягаар эцэг эхийнхээ таалгаж байгаа сонирхолтой оньсого тааврааар дамжуулан амьдралын бодит үнэнийг ойлгож ухаардаг.

АНУ-ын иргэн Еврей хүмүүсийн боловсрол судлаач Бенжамин Блүм (Benjamin Bloom) 1980 оны эхээр дэлхийн нэр алдартай төгөлдөр хуурч, усан спортын тамирчин, теннисний спортын аварга, математикч, хүний оюун ухаан судлалын эрдэмтэн, барималч сийлбэрчин гэх мэт 120 орчим хүнийг оролцуулан "Суут хүмүүс ямар багшаас суралцсан" байдаг талаар судалгаа хийсэн байна. Гэтэл хүмүүсийн төсөөлж байснаас эсрэгээрээ эдгээр гайхалтай амжилтанд хүрсэн суут хүмүүст хамгийн анх хичээл зааж байсан багш нар мэргэжлийн болон туршлага талаараа бусдаас нэг их онцгойроод байхаар зүйл байхгүй эгэл жирийн хүмүүс байсан байна. Харин эдгээр хүмүүсийн хийж байсан нэг нийтлэг зүйл гэвэл тэд сурагчдаа байнга урамшуулан магтаж сурагчдаа дүрэлзэх гал мэт асааж байсан хүмүүс байв. Өөрөөр хэлвэл эдгээр багш нар шавь нартаа тавих хайр халамж сайн, тэдэнд юм заахдаа чин сэтгэлээсээ хандаж байсан хүмүүс юм.

Анх суралцаж эхлэх үеэсээ ийм маягаар хичээл заалгаж буй хүүхэд өөрөө ч мэдэхгүй /жишээ нь төгөлдөр хуур сурах, усанд сэлэх, тоо бодох гэх мэт/ суралцаж буй зүйлдээ сонирхолтой болон сэтгэл нь татагдаж эхэлдэг бөгөөд сурч байгаа зүйлдээ маш сайн төвлөрч анхаарахаар болдог. Ийнхүү цаашлаад тухайн сурч байгаа зүйлийнхээ талаар илүү их мэдээлэл мэдлэг хуримтлуулан мэргэшлийн талын боловсролоор суралцахаар болдог ба өөрийн сурахыг хүссэн түвшиндээ хүртлээ өсөж дэвжиж чаддаг. Тиймээс багш хүний мэргэжлийн хамгийн чухал ур чадвар бол хүүхдэд анхан шатны боловсрол олгохдоо хөгжилтэй, хүүхдэд урам зориг өгөх маягаар заах чадвар юм. Аливаа зүйлийг сурах нь эхэндээ тоглоом наадамтай адилхан зүйл юм. Багш хүний хамгийн чухал үүрэг бол хүүхдэд урам зориг өгөн авъяас чадварыг нь сайжруулах юм.

Еврей багш нар цэцэрлэг юмуу бага сургуульд анх элсэн суралцаж байгаа сурагчдад "Хичээл ном хийнэ гэдэг бол чихэр идэхтэй адилхан амттай зүйл" гэсэн ойлголтыг суулгаж өгдөг. Ингэхийн тулд сурагчдын гарын хуруунд зөгийн бал түрхэн Еврей цагаан толгойн 22 ширхэг үсгийг бичүүлснийхээ дараа гарын хурууг нь долоолгодог өвөрмөц аргыг хэрэглэдэг. Мөн Еврей цагаан толгойн үсгийн дүрсээр хийсэн жигнэмэгийг бэлтгэн сурагчдад идүүлдэг байна. Хичээл ном гэдэг жигнэмэг шиг амттай хөгжилтэй зүйл болохыг хүүхэд наснаас нь эхлэн сайн ойлгуулж заадаг.

Иймэрхүү арга барил нь дундад зууны үед ч байсан байна. Тухайн үед хүүхэд нь 3-н нас хүрвэл зөгийн бал бүхий самбар дээр Еврей цагаан толгойн үсгийг бичин хүүхдүүдээрээ долоолгох юмуу зөгийн балтай жигнэмэг идүүлэн цагаан толгойн бичиг үсэг заадаг байсан бөгөөд бага наснаас нь эхлэн хүүхдэд сурч боловсрох нь зөгийн бал шиг чихэрлэг амттай зүйл болохыг ойлгуулдаг ёс заншилтай байв.

Хүний амьдрал гэдэг бол ямар нэгэн зүйл сурахын үргэлжлэл юм. Мэдлэг мэдээллийн энэ эрин үед хүн гэдэг амьтан байнга суралцахаас өөр аргагүй болж байна. Аливаа зүйлийг суралцах нь богино зайн гүйлт шиг биш холын зайн марафон гүйлт шиг байх ёстой. Харин сайн бодвол өнөөгийн хатуу ширүүн нийгмээс шалтгаалан бидний бяцхан үрс маш эрт марафон гүйлтэнд оролцож байна. Марафон гүйлтийн замыг бүрэн дуусгая гэвэл биеийн хүч тамир сайн байх төдийгүй бие халаалт сайн хийсэн байх шаардлагатай. Гэтэл хараахан марафон гүйлтэнд оролцоход бие мах бодь болон оюун санааны хувьд бэлэн болоогүй байгаа хүүхдүүдээ марафон гүйлтийн шугам руу түлхэн оруулж буй гол буруутангууд бол эцэг эхчүүд юм. Эцэг эхчүүдийн энэ буруу үйлдлээс шалтгаалан хүүхдүүд маань амархан шантарч цуцан гүйлтээ дундаас нь орхин буцах тохиолдол их байна. Солонгос улсын дунд, ахлах сургуулийн сурагчдын сурлагын дүн дэлхийд хамгийн өндөр үзүүлэлттэй байдаг ч сурагчид их сургуульд ормогц сурлагын түвшин нь огцом муудан бусад улс орны сурлагын түвшинтэй харьцуулахад маш муу үзүүлэлттэй болдог. Энэ бол бүгд эцэг эхчүүдийн буруугаас болж байгаа юм.

Еврей хүмүүст Солонгос хүмүүс шиг яаруу адгуу зан чанар байдаггүй. Тэд хүүхдийнхээ насны онцлогт тохируулан эмх цэгцтэйгээр боловсрол олгодог. Солонгос улсын сурагчдын тухайд гэвэл бага сургуулиас дунд сургууль, ахлах сургууль гэх мэт анги өгсөх тусам хичээл ном хийх нь уйтгартай, залхмаар, хэцүү, сонирхолгүй зүйл болон хичээл номондоо дургүй байдалтай болдог бөгөөд бараг хичээлдээ хүчээр шахуу явж байхад харин Еврей сурагчдын тухайд эсрэгээрээ байдаг. Хичээл ном хийхийг зөгийн бал шиг амттай зүйл мэтээр бодон баяр баясгалантайгаар хичээл номоо хийдэг хүүхэд болон зөвхөн их сургуульд элсэн орохын тулд сонирхолгүй хичээлээ хүчээр хийж байгаа хүүхдийн сурлагын үзүүлэлтийн ялгаа ямар байх нь тодорхой юм.

Хүүхдийн сонирхол гэдэг бол тэдэнд Бурханаас заяасан бас нэгэн үнэтэй зүйл юм. Хүүхдэд зааж хэлж өгөөгүй байсан ч тэд дэлхийн ертөнцийн талаар сонирхон сонирхож буй зүйлээ олохын тулд эрэл хайгуул хийж эхэлдэг. Тиймээс хүүхдийн сониуч зан чанар хамгийн идэвхитэй байгаа үед нь сурна гэдэг хүнд хэцүү зовлон бэрхшээл биш сонирхолтой, хөгжилтэй зүйл гэдгийг сайн ойлгуулж өгөх хэрэгтэй. Иймээс хүүхдийнхээ дэлхий ертөнцийн талаарх сонирхлыг нь нэмэгдүүлэх анхан шатны боловсролд ашиглах хэрэгсэл бол “сонирхолтой яриа” юм. Еврей хүмүүс хүүхэддээ хамгийн анх худалдан авч өгдөг ном зурагтай үлгэрийн ном байдаг учир шалтгаан үүнд байгаа юм.

Еврей хүмүүс бусад үндэстнээс илүү түүх яриа ихтэй хүмүүс. Еврей хүний оюун ухааны цөм болох “Тора” номонд сонирхолтой түүх ярианууд маш ихээр бичигдсэн байдаг. Египетэд боолчлогдож байсан Еврейчүүдийг аварсан иш үзүүлэгч Мосе, дүүгүүрээр дайсныхаа жанжин Голеат (Goliath)-ийг цохиж алсан Давид, унтаж байхад үсийг нь тайрахад хүч чадлаа бүгдийг нь алдсан хүчит эр Самсон, халимны гэдсэнд ороод буцан гарч ирсэн Иона, гэр бүлийн гишүүд болон араатан амьтдыг усан онгоцондоо оруулан их үерээс амьд үлдэж

чадсан Ноа, хүүхдээ таллан хуваа гэсэн шийдвэрээр дамжуулан жинхэнэ ээжийг нь олсон Соломон хаан зэрэг ... олон арван хүмүүсийн талаарх түүх яриа энэ номонд багтсан байдаг. Еврей хүмүүс энэхүү баялаг түүх ярианууды хүүхэддээ сурч боловсроно гэдэг зөгийн бал идэхтэй адилхан чихэрлэг зүйл гэсэн ойлголтыг суулгаж өгөхийн тулд ихээр ашигладаг.

“Сайн боловсрол гэж юуг хэлэх вэ? Хүүхдийн сонирхлыг хөдөлгөж чадаж байгаа зүйл биш гэж үү? Сурна гэдэг амьдралыг илүү хөгжилтэй, зугаатай болгодог сонирхлын нэг төрөл учраас ямар нэгэн зүйл сургахын тулд хүүхдээ ядрааж зовоон дарамт шахалтыг мэдрүүлэхгүй байх хэрэгтэй” (Карл Виттигийн сурахын баяр хөөр номны хэсгээс)

Хэрэв хүүхдүүд маань сурахыг хүнд ачаа дарамт мэтээр тооцолгүй хөгжилтэй сонирхолтой зүйлээр хүлээн авбал сургалтын үр дүн гайхалтай сайжрах нь мэдээж юм. Гэтэл ихэнхи эцэг эхчүүд өөрсдөө ч нарийн учрыг нь мэдэхгүй байж “Сурна гэдэг бол сайн дүн авахын төлөө хийж байгаа зүйл” гэсэн ойлголтыг хүүхэддээ өгч байдаг. Тийм учраас хүүхдүүд маань сурч боловсрохдоо маш их стресс дарамт авахаас өөр зүйлгүй байна.

“Чи тооны хичээл дээрээ ямар дүн авсан?”

“Хэд алдсан бэ?, Хэдэн оноо авсан?”

“Ангидаа хэдэд жагсаж байна? Чиний дээр хэн хэн байна?”

Эцэг эхээсээ байнга иймэрхүү асуулт сонсдог хүүхэд бусад сурагчдын оноо, сурлагын түвшин, өөрийн эзлэж буй байр сууринд бүх анхаарлаа хандуулах нь мэдээж юм. Ийм байдлаас шалтгаалан хичээл номондоо сонирхолтой, баяр хөөртэйгээр хандахаасаа илүүтэй залхах хандлагатай болж эхэлдэг.

Еврей хүмүүс оньсого тааврыг хүүхдийнхээ боловсролд идэвхитэйгээр ашигладаг. Ихэнхи хүмүүс ерөнхийдөө нэг хэвийн амьдралаар амьдарсаар байдаг учраас урьд өмнө нь сонсож бодож байгаагүй зүйлийн талаар сонссоноор мэдрэлээ цочроож өгдөг бөгөөд энэхүү цочрол хүний үгийн сангийн чадварыг сайжруулан ууриг тархины хөгжилд ихээхэн тус нэмэр болдог. Еврей гэр бүлээс ажлаа тараад ирсэн аав нь оройн хоол идэж байхдаа хүүхдүүддээ янз бүрийн оньсого таавар таалгаж буй дүр төрхийг харж болно.

Оньсого таавар бол товчхон нэг асуултаар хүүхдийн төсөөлөн бодох чадварыг сайжруулдаг хамгийн сайн хэрэгсэл юм. Мөн хүүхэд бусдын хэлсэн ярьсныг ойлгож эхлэх үеэс нь сэтгэхүйн түвшинд нь тохирсон асуулт тавьж байвал хүүхдийн хэл зүйн чадвар болон дүрслэн бодох чадвар сайжирдаг. Тиймээс Еврей хүмүүс хүүхдээ хүний хэлсэн ярьсныг ойлгож эхлэх үеэс нь эхлэн оньсого таавар таалгаж эхэлдэг. Ихэвчлэн эд зүйлийн оноосон нэр болон хэрэглээний талаар хүүхэддээ заадаг бөгөөд бие мах бодийн аль нэг хэсгийг заан “Энийг юу гэж нэрлэдэг вэ?” гэх мэтээр асуулт тавьдаг. “Хүний бие мах бодьтой холбогдолтой оньсого тааврын тоглоом” бол Еврей хүмүүсийн хүүхдийнхээ боловсролд ашигладаг гол тоглоом юм.

Хүүхэд тодорхой хэмжээгээр ярьж чаддаг үе буюу 2 нас орчимтой болох үед хүүхэддээ “хөгжилтэй, гунигтай, үзэсгэлэнтэй” гэх мэт хийсвэр нэр томъёог зааж өгдөг. “Их гэдэг

үгийн эсрэг утгатай үг юу вэ?” “Хүйтэн гэдэг үгийн эсрэг утгатай үг юу вэ?” гэх мэт. Иймэрхүү маягаар эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хүрээлэн буй орчны эд зүйлийг ашиглан асууж хариулах маягаар ярилцсаар байвал хүүхэд аяндаа зөв хариултыг нь олж чаддаг болдог.

Хүүхэд өсөж том болон хийсвэр зүйлийг ойлгож харьцуулах чадвартай болох үед нь хүүхэдтэйгээ “Хорин асуулт” (Нэг хүн дотроо ямар нэгэн эд зүйлийн талаар төсөөлөн бодох бөгөөд нөгөө хүн нь 20 хүртэл асуулт тавин тухайн бодсон зүйлийг нь юу болохыг таадаг тоглоом) гэдэг тоглоомоор тоглож эхэлдэг. “Тайрах тусам улам том болдог зүйл юу вэ? / Хариулт: Нүх/ “Бүх улсын хэлийг мэддэг зүйл юу вэ? /хариулт: Цуурай/ гэх мэт.

Хүүхэд өсөж томрох тусам оюун санааных нь цар хүрээг улам тэлэх хэцүү оньсого таавар таалгадаг. Жишээ нь “Хүн 2 чихтэй 2 нүдтэй мөртлөө яагаад ганц амтай байдаг вэ? /Хариулт: Эхлээд ярихаасаа өмнө 2 дахин илүү сонсон, 2 дахин сайн ажиглахын тулд/ гэх мэт.

Унтахаас нь өмнө хүүхэддээ 15 минут ном уншиж өгөх гайхалтай аргыг хэрэглэх

Нэгэн цэцэн мэргэн хүнээс "Та яаж ийм цэцэн мэргэн болсон юм бэ?" гэж асуусан байна. Хариуд нь нөгөө хүн "Би өнөөдрийг хүртэл хоол унданд ашигладаг ургамлын тосноос илүүтэйгээр ном уншихдаа дэнлүү асаахад хэрэглэдэг гаршийн тосонд илүү их мөнгө зарцуулсан учраас юм. Нэг ёсондоо ном их уншсан учраас юм" гэж хариулсан байна. Еврей хүмүүс нэг нас буюу эцэг эх нь хүүхдээ орой унтахаас өмнө толгойных нь дэргэд очин ном уншиж өгөх үеэс номтой нөхөрлөж эхэлдэг бөгөөд ном унших гэдэг бол Еврей хүмүүсийн хувьд бүх л амьдралынхаа турш хийдэг чухал ажил юм. Бага наснаас нь эхлэн эцэг эхийнх нь ярьж өгдөг байсан сонирхолтой түүх ярианууд хүүхдэд бүхий л амьдралынх нь турш бүтээлч чанараа алдахгүй байх хүч болдог.

Еврей хүмүүс ихээр амьдардаг Нью-Йорк хотод би 1 жилийн хугацаанд суралцангаа амьдрах үедээ бага сургуулийн 3, 1-р ангийн 2 хүүхдээ тухайн бүс нутгийн сургуульд явуулсан юм. Боловсролыг чухалчилдаг үндэстэн болоод ч тэрүү Еврей хүмүүсийн амжилт гаргах хувь маш өндөр байдаг. Нью-Йорк хотын бүс нутагт байдаг бага, дунд, ахлах сургуулийн багш нарын 30 орчим хувь нь бүгд Еврей хүмүүс байдаг. Нью-Йорк хотын бага сургуулиудын боловсролдоо хамгийн их чухалчилдаг зүйл бол ном унших (Reading) юм. Нью-Йорк хотын боловсролын асуудал хариуцсан хороо жил бүр анги тус бүрээр нь ангилан унших ёстой номын жагсаалтыг бэлтгэн гаргадаг бөгөөд сурагчдыг доод курсээс нь эхлэн тасралтгүйгээр ном уншуулдаг байна. Сурагчдын түвшинд таарсан номыг аль болох ихээр, системтэйгээр уншуулдаг.

Том хүүхэд маань хэдийгээр бага сургуулийн 3-р ангийн сурагч боловч 1 жилийн хугацаанд 25 ном унших даалгавартай байв. Гэхдээ ном унших ёстой гээд ямар ч хамаагүй тааралдсан ном болгоноо уншина гэсэн үг биш юм. Унших номонд адилхан төрлийн юмуу нэг зохиолчийн номыг хамгийн багадаа 4 хэтрэхгүй орсон байх шаардлагатай. Ном уншсаныхаа дараа уншсан номынхоо талаарх сэтгэгдлийг товчхон бичиж тэмдэглэх бөгөөд энэхүү тэмдэглэлдээ номны гарчиг, зохиолчийн нэр, хэвлэлийн газрын нэр, хэвлэсэн огноо, номын гол агуулга зэргийг товчхон бичих ёстой. Хүүхдэд маань Колумбусийн өдөр /Columbus Day/, Ноён Мартин Рутер хааны төрсөн өдөр/Dr.Martin Ruther King, Jr.day/ гэх мэт түүхэн тэмдэглүүшт өдөрт хамаарах агуу хүмүүсийн талаарх ном уншин сэтгэгдлээ бичих даалгавар өгсөн байв. Ном уншсаны дараах сэтгэгдлийг номын талаарх товч тэмдэглэлээс илүү нарийн бичих хэрэгтэй. Номын агуулгыг товчлон хураангуйлсны дараа эдгээр хүмүүсийн ололт амжилт нь юу болох, хүн төрөлхтөнд ямар гавъяа байгуулсан эсэх, эдгээр хүмүүсийн хичээл зүтгэлээр нийгэмд ямар ямар өөрчлөлт гарсан зэрэг талаар нарийн бичих даалгавар байв.

Анги удирдсан багш нь сард 1 удаа сурагчдын уншсан номын талаарх товч тэмдэглэлийг шалгадаг. Үүнд өөрөө сонгон уншсан номноос гадна заавал унших ёстой номны гэрийн даалгавар ордог. Охины маань өвлийн амралтын гэрийн даалгавар 10 ном унших байв. Мэдээж уншсан номныхоо талаарх товч тэмдэглэлийг давхар хийнэ. Анги удирдсан багш нар нь амралтын хугацаа эхлэхээс өмнө сурагчдын гэр лүү "Хүүхэддээ ном уншиж өгөхөөс илүү гоё бэлэг байхгүй" бөгөөд хүүхдээрээ ном сайн уншуулаарай гэсэн агуулга бүхий захиаг илгээдэг.

Мөн сургуулийн захиргаанаас номын үзэсгэлэн яармаг нээх, алдартай зохиолчдыг урьж

авчран номын танилцуулга хийх гэх мэт олон арга хэмжээ аван сурагчид ном худалдан авч унших орчинг бүрдүүлдэг. Хүүхдүүдийн маань явдаг байсан сургуулиас сар бүр нэг удаа “Scholastic Book Club” нэртэй номын клубээс хүмүүст янз бүрийн номын жагсаалт гаргаж танилцуулан захиалга авдаг байв. Энэхүү номын клубээс зах зээлийн үнээс 30-70 хувь хямд үнээр төрөл бүрийн хүүхдийн номыг худалдан авах боломжтой байдаг. Ингээд сайн ажиглатал 2 хүүхэд маань Нью-Йорк хотод амьдарч байх хугацаандаа сард дунджаар 20 орчим ном худалдан авч уншсан байсан юм.

Еврей хүмүүсийн ном унших хувь дэлхийд хамгийн өндөр байдаг. Еврей эцэг эхчүүдийн нэг өдрийн ажлын хувиарт хэзээ ч орхиж болохгүй заавал хийх ёстой нэг зүйл байдаг бөгөөд энэ бол унтахаас нь өмнө хүүхэддээ ном уншиж өгөх юм. Тэд хүүхэд нь 1 нас хүрсэн үеэс эхлэн орных нь дэргэд суугаад хүүхэддээ үлгэрийн ном уншиж өгдөг. 2002 оноос Солонгос дахь Израйль улсын элчин сайдын яамнаас ажлын гараагаа эхлэн 2006 онд олон нийтийн мэдээллийн ажилтнаар ажиллаж байсан Еврей гаралтай дипломатч Абибид Бар Иллан /35 нас/ “Би 2 хүүхдээ Еврей хэлээ мартах вий гэсэндээ орой болгон унтахаас нь өмнө Еврей хэлээр бичигдсэн үлгэрийн ном уншиж өгдөг байсан. Ном бол хүүхдийн төсөөлөх чадвар болон хэлний чадварыг нэмэгдүүлдэг хамгийн чухал арга” гэж хэлсэн байна.

АНУ-ын сэтгэл судлаач Мэрян Волф (Maryanne Wolf) нь “Ном уншдаг тархи” хэмээх номондоо ном унших нь тархинд хамгийн сайн тэжээл болдог учир шалтгаан нь тархийг маш сайн цочроож өгдөг учраас юм гэж онцлон хэлсэн байдаг. Бичиг үсгийг ойлгон тэмдэглэгээг тайлбарладаг тархины хажуугийн хэсэг (Temporal Lobe-энэ хэсэг нь харах чадвар, хэлний чадвар зэргийг хариуцдаг), нөхцөл байдлыг задлан шинжилж ямар нэгэн зүйлийн хэлбэр дүрсийг харах мэдрэхүйгээр төсөөлдөг тархины урд хэсэг(Frontal Lobe-дүгнэх, үйл хөдлөл, заах чадварыг хариуцдаг), сэтгэл хөдлөлийг мэдэрдэг тархины төв хэсэг (Limbic System) гэх мэт ном уншсанаар цочрол авдаггүй тархины хэсэг гэж бараг байдаггүй.

Еврей хүүхдүүд 1 наснаасаа эхлэн унтахаасаа өмнө эцэг эхийнхээ уншиж өгдөг үлгэрийн номыг сонсож эхэлдэг. Үүнийг “Унтахын өмнөх яриа” ч гэж нэрлэж болно. Еврей хүмүүс “Унтахаас нь өмнө хүүхэддээ ном уншиж өгөхийг” эцэг эхийн нэг чухал үүрэг төдийгүй тухайн өдөр заавал хийх ёстой ажлуудын нэгд тооцдог. Хүүхэд хэлд орж эхлэх үеэс эхлэн эцэг эхийнхээ уншиж өгч байсан үлгэрийн номны үг хэллэг, өгүүлбэрийг хэрэглэн хэлзүйн чадвар болон хэрэглээний чадвар нь гайхалтай хурдан сайжирдаг.

Хүн төрөлхтний хамгийн шилдэг зэвсэг бол хэл юм. Хүн төрөлхтөн хэл яриаг ашигласнаар дэлхийн ертөнцийг удирдан эзэн сууж байгаа гэж хэлж болно. Хэлзүйн чадвар гадаад хэл, тооны ухаан, шинжлэх ухаан, нийгэм гэх мэт бүх хичээлийн үндэс суурь болдог. Мөн хэлийг хийсвэр бодол санааны чадвар юмуу эргэцүүлэн тунгаан бодох чадварыг нэмэгдүүлдэг эх үүсвэр ч гэж хэлдэг. 1 наснаас нь эхлэн эцэг эх нь тогтмол ном уншиж өгсний ачаар Еврей хүн 4 нас хүрэхдээ дунджаар 1,500 дээш үг хэллэг мэддэг болсон байдаг. Еврей хүмүүс хүүхдийнхээ сонгосон номыг унтахаас нь өмнө заавал уншиж өгдөг. Нимгэн ном байвал бүгдийг нь уншиж өгдөг бөгөөд харин зузаан ном байвал талыг нь юмуу 3/1-ийг гэх мэтээр хуваан уншиж өгдөг. Уншиж өгч байгаа ном нь зузаан дуусгаж амжихгүй тохиолдолд хүүхэддээ “Дараа нь юу болох бол? маргааш үргэлжлүүлэн уншиж өгье” гэж хэлээд хүүхдийнхээ сонирхлыг татаад орхичихдог.

Гэтэл Солонгос улсын тухайд залуучууд маань хичээлийнхээ сурах бичгийг арай ядан уншиж байна. Цэцэрлэг, бага сургуульд байх үедээ ном нилээн сайн уншиж байгаад дунд сургуульд ормогцоо их сургуулийн элсэлтийн шалгалтанд хамаг анхаарлаа хандуулан бараг л ном унших цаг завгүй болдог. Ном унших бол ямар нэгэн зүйлд дүгнэлт, задлан шинжилгээ хийх чадварыг сайжруулдаг хамгийн чухал арга юм. Солонгос улсын сурагчдын ямар нэгэн зүйлд дүн шинжилгээ хийх, тунгаан бодох чадвар маш муу байдаг учир шалтгааныг дунд, ахлах сургуулийн үедээ ном сайн уншддаггүй байдлаас болж байгаа гэж хэлж болно. Ном сайн уншдаггүй болохоор гэртээ юмуу сургууль дээрээ бусадтай харилцан ойлголцох тал дээр бас муу байдаг. Унших бичих боловсролын үндэс суурь мөн боловч хүүхдүүд зөвхөн мэдлэг хуримтлуулах, сурах бичиг цээжлэхэд анхаардаг боловсролд хамаг хүч чадлаа барж байгаа нь үнэхээр харамсмаар зүйл юм.

Эцэг эхчүүд хүүхэддээ системтэйгээр тогтмол ном уншиж өгснөөр хүүхдийн ном унших чадвар аяндаа сайжирдаг. Мэдээж хүүхдийн чадвар хурдан сайжрах тусам сайн. Нэгэн судалгаанаас харвал эхийн хэвлийд байхад нь ном уншиж өгөх аргаар хүүхэддээ боловсрол олгож байсан хүүхэд үеийнхэнтэйгээ харьцуулахад хэл ярианы чадвар гайхалтай сайн байсан байна. 2004 онд “Уншлагын нээлт” гэсэн телевизийн хөтөлбөрөөр дамжуулан иргэдийн дунд ном унших ажлыг хэрэгжүүлж эхэлсэн “Кэй Би Эс(KBS)” телевизийн Хун Гён Сү найруулагч өдөр болгон өөрийн ихэр хүүхдүүддээ унтахаас нь өмнө ном уншиж өгдөг байна. Тэрээр “Эцэг эх өөрсдийн дуу хоолойгоор хүүхэддээ ном уншиж өгөх нь өөрсдийн хайр халамжийг хүүхэддээ мэдрүүлж буй бас нэг чухал зүйл юм. Хүүхдэд ном тогтмол уншиж өгснөөр мэдрэмжийг нь цочроон хүүхдийн сэтгэл санааг тайвшруулан төсөөлөн бодох чадвар, бүтээлч чадвар, илэрхийлэх чадвар зэргийг нь гайхалтай сайжруулж өгдөг” гэж онцлон хэлсэн байна.

Унтахаас нь өмнө хүүхэддээ ном уншиж өгөх хугацааны тухайд 15-30 минут орчим байх нь тохиромжтой. 30 минутаас дээш хугацаагаар ном уншиж өгвөл хүүхэд залхах хандлагатай болдог. Гэхдээ хүүхэддээ ном уншиж өгөх цаг өдрийн аль ч цагт байж болно. Харин тогтсон газар, цагт тогтмол уншиж өгөх маш чухал юм.

Ном уншиж өгч байх явцад хүүхэд тань асуулт асуувал жижигхэн асуулт байсан ч үл тоомсорлон орхиж болохгүй бөгөөд хүүхдийнхээ түвшинд тохируулан чин сэтгэлээсээ хариултыг нь хэлж байх хэрэгтэй. Унших номоо сонгохдоо эцэг эх болон хүүхдийн сонирхлыг татахуйц номыг сонгох бөгөөд хүүхдийн нас, сэтгэхүйд тохируулан номоо сонгохоо мартаж болохгүй. Тиймээс эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамт номын дэлгүүрт очин хүүхэддээ уншиж өгөх номоо хамт сонгож байх хэрэгтэй.

Хүүхэддээ хэрхэн үр дүнтэй ном уншиж өгөх талаар мэргэжилтэн Мэм Фоксийн бичсэн “Хүүхэдтэйгээ хамт чанга дуугаар ном унших 15 минутын гайхамшиг” номонд бичсэн ном уншиж өгөх арга барилыг танилцуулж байна.

· Өдөр бүр хүүхэддээ 15-н минут ном уншиж өгөх. /Өдөр болгон хүүхэддээ тогтмол ном уншиж өгнө гэдэг бидний бодож байгаа шиг тийм ч амархан зүйл биш. Тийм болохоор мартахгүйн тулд гэрийнхээ өнцөг булан бүрт ном байрлуулах хэрэгтэй/

· Хүүхэддээ өдөрт хамгийн багадаа 3 төрлийн ямар нэгэн сонирхолтой зүйл ярьж өгөх.

· Хүүхэддээ ном уншиж өгч байхдаа эрч хүчтэй цоглог байх хэрэгтэй. /Ингэснээр хүүхэд залхахгүй төвлөрөн анхааралтай сонсож чаддаг/

· Номыг хөгжилтэйгээр уншин хүүхэдтэйгээ хамт инээж хөхрөх /Ингэснээр эцэг эх болон хүүхэд хоорондын харилцаа сайжран улам дотно болдог/

· Хүүхдийн тань байнга сонсох дуртай түүх яриаг хэдэн удаа ч байсан хамаагүй давтан уншиж өгч байх. /Ингэснээр хүүхэд ном уншихад улам сонирхолтой болдог/

· Дуу, хүүхдийн шүлэг гэх мэт төрөл бүрийн зүйлийг ашиглах. /янз бүрийн арга барилыг ашиглах нь хүүхдийн хэл зүйн чадварыг баяжуулдаг бөгөөд дуу, хүүхдийн шүлэг зэрэг нь хүүхдийн толгойд удаан хугацааны турш хадгалагдан үлддэг сайн талтай/

· Нэг үг хэллэг үе үе давтагдан гардаг ном уншиж өгөх. /Хүүхэд тухайн үг хэллэгийг мартахгүй санахад тус болдог/

· Хүүхэддээ ном уншина гэдгийг хичээл ном биш тоглоом наадам мэтээр ойлгуулах /Хүүхдээ их мэдлэгтэй болгох нь чухал биш ном уншихад сонирхолтой болгох нь хамгийн чухал юм. Эцэг эхчүүд өөрсдийн бодол санаагаа түрүүнд тавихаас болгоомжлох хэрэгтэй/

· Дургүй байхад нь хүүхэддээ хүчээр ном уншиж өгч болохгүй /Ингэснээр хүүхдийг ном уншихад сонирхолгүй болгодог муу талтай/

· Эцэг эхчүүд хүүхэддээ ном уншиж өгөхдөө сэтгэл санааны хувьд тайван тогтвортой байх хэрэгтэй /Хүүхэддээ ном уншиж өгөхдөө төвөгшөөн ядаргаатай ажил гэсэн сэтгэлээр хандвал ямар ч үр дүнгүй ажил болно. Тийм болохоор эцэг эхчүүд ч гэсэн өөрсдөө сонирхолтой номыг сонгон худалдаж авах хэрэгтэй.

“Давхар хэлний боловсролоор” хүүхдийнхээ гадаад хэлний чадварыг сайжруулах

“Еврейчүүдийн хүүхдийн боловсролын арга” номын зохиогч Еврей хүн болох Рүс Шиллу /73 настай/ хадагтай Еврей, Англи, Унгар, Франц, Виддиш хэл /Viddish Language-төв болон зүүн Европын гаралтай Еврей хүмүүсийн ашигладаг Герман болон Еврей хэлийг хольсон хэл/ мэддэг. Израйль улсад худалдаа наймаа эрхэлдэг түүний эцэг нь Еврей, Араб, Англи хэлнээс гадна Армин хэл мэддэг байна. Түүний нөхөр Виддиш хэл мэддэг учраас эхнэр нөхөр хоёр хүүхдүүддээ сонсгож болохгүй зүйлийн талаар ярилцахдаа Виддиш хэлээрээ хоорондоо ярилцдаг байна. Еврей хүмүүс давхар хэлний боловсролоор олон гадаад хэл эзэмшсэн байдаг учраас эхнэр нөхөр хоорондоо хэрэлдэж муудалцах юмуу хүүхдэд сонсгож болохгүй зүйлийн талаар ярилцахдаа хүүхдийнхээ мэдэхгүй хэлээр хоорондоо ярилцдаг тохиолдол их байдаг.

Хүний оюун ухааны задлан шинжилгээний шинжлэх ухааныг үндэслэгч Фрүд бага наснаасаа эхлэн гадаад хэлийг маш идэвхитэйгээр сурсан байна. Түүнийг 10 нас ч хүрээгүй байхад ээж нь Латин хэлний үйл үгийн нөхцлийн хувирал болон Хэлла хэлний /Эртний Грекийн хэл/ хэлзүйг заан өрөөнийх нь хананд наан цээжлүүлдэг байв. Фрүд ээжийнхээ өгсөн даалгаврыг бүгдийг нь хийж дуусаад өрөөнийхөө ханыг цохин бүгдийг нь цээжилсэн гэсэн дохио өгдөг байв. Түүний үр дүнд Фрүд Латин, Хэлла, Герман хэлийг маш амархан сурсан бөгөөд Англи, Франц, Итали хэлийг ч төгс эзэмшиж чадсан байна. Мөн тэрээр Грек болон Испани хэлээр бичигдсэн ном зохиолыг ч уншиж чаддаг.

Түүний найруулан бичих чадвар ч гайхалтай сайн байжээ. Өөрийн дурласан бүсгүйдээ 7 хоногт 2-с дээш удаа хайрын захиа бичиж явуулдаг байсан бөгөөд захианых нь хэмжээ хамгийн багадаа 4 хуудас, ихдээ 27 хуудас орчим болдог байсан байна. Тэрээр 1932 онд “Гоет(Goethe)-ийн утга зохиолын шагнал” авсан нь зөвхөн утга зохиолын бүтээлээр дамжуулан авсан биш түүний Герман хэлээр гайхалтай сайн найруулан бичсэн дипломын ажлынх нь үр дүн байсан юм.

2009 оны 10-р сарын 24-ний өдөр англи хэлний /TOFEL/ -ын шалгалтнаас 10,000 оноо авч чадсан Ким Хён Сү /тухайн үед 13 настай- Сөүлийн Тэвоний олон улсын дунд сургуулийн 1 курс/ нь англи хэлний курс дамжаанд огтхон ч сууж байгаагүй төдийгүй ямар нэгэн гадаадын улс орон руу явж үзэж байгаагүй нэгэн юм. Түүний ээж И Ү Сүг /тухайн үед 47 настай байсан/ нь шашны алба эрхэлдэг хүн байсан болохоор Еврей хэл /Израйлийн нийтээр зөвшөөрсөн хэл/-ийг сурсан бөгөөд суралцах явцдаа Еврей хүмүүсийн давхар хэлний боловсролд ихээхэн сонирхолтой болсон байна. Хэл сурах үедээ өөрийн орны хэл болон англи хэлийг хамт сурвал англи хэлийг эх хэл шигээ сурч чаддаг бөгөөд энэ арга нь Еврей хүмүүсийн хэлний боловсролын гол арга юм. И ..... охиноо хэлд орж эхэлсэн үеэс нь Солонгос, Англи хэлийг хамтад нь зааж эхэлсэн байна. Жишээ нь “Ээжээ, mommy” гэх мэт. Байнга Солонгос хэл болон Англи хэлийг хослуулан ярих нь төвөгтэй байсан боловч хүүхэддээ хичээнгүйлэн заасан байна. Үүний үр дүнд охин нь 2 хэлээр чөлөөтэй ярьж чаддаг болсон байна.

Еврей хүмүүс ихэвчлэн хоёроос дээш гадаад хэлийг чөлөөтэй эзэмшсэн байдаг. Их сургуулийн боловсрол эзэмшсэн Еврей хүн гэвэл 3-4 гадаад хэлийг эзэмшсэн байдаг. Тэгвэл Еврей хүмүүсийн гадаад хэлийг төгс эзэмшиж байгаа нууц юу юм бол? Юуны түрүүнд хэдэн

мянган жилийн турш дэлхийн янз бүрийн газраар тэнүүчлэн амьдарч ирсэн тэдний соёлын уламжлалыг дурьдах нь зүйтэй юм. Эртний Ромын үеэс эхлэн Еврей хүмүүс олноор сууршин амьдарч байсан Европт одоо хэдэн арван улс үндэстэн хоорондоо хил залгаа оршиж байгаа учраас автомашинаар хэдхэн цаг явахад л өөр улсын хил рүү амархан орчихдог. Тийм болохоор Еврей хүмүүсийг гадаад хэл сурахад ашигтай газар зүйн байршилтай гэж хэлж бас болно.

Жишээлбэл Германы баруун хэсгийн мөрний эрэгт оршдог Ахен (Aachen) гэдэг хот Бельги болон Нидерланд улстай хил залгаа оршдог. Автомашинаар 5 минут орчим явахад л нөгөө улсынхаа хил рүү ордог. Энэ хотод амьдардаг сурагчид 3-4 гадаад хэлийг гол хэлээрээ сонгон сурдаг. Нөхөр хүүхдүүдийнхээ хамт Герман улсад суралцахаар Ахен (Aachen) хотод ирсэн Пак Сон Сүг гэдэг хүн “Хүүхдүүд маань 2 дээш гадаад хэлийг гадаад хэл биш эх хэл шигээ ашигладаг болсон. Мэдээж Солонгос, Герман хэлийг эх хэл шигээ сайн сурсан бөгөөд мөн Англи хэлний чадварын хувьд хаана ч очсон гологдохооргүй болсон” гэж хэлсэн байна. Хүн янз бүрийн улс орны хэл, соёлтой байнга харьцах боломжтой орчинд амьдарснаар гадаад хэлийг сайн сурч чаддаг.

Соёлын уламжлалаас гадна гадаад хэлний боловсролыг чухалчилдаг гэр бүлийн боловсролын нөлөө ч их байдаг. Еврей хүмүүс Нацист Германы дарамт шахалтанд амьдарч байх үедээ ч хүүхдүүддээ Герман хэлийг хичээнгүйлэн зааж байсан. Тухайн улсын уугуул ард иргэдийн эсэргүүцлийг тэсч даван гаръя гэвэл тухайн улсын хэлийг эзэмших нь юунаас ч илүү чухал гэж үзсэн учраас юм. Еврей хүмүүс янз бүрийн улс оронд тархан амьдарч байхдаа тухайн орныхоо хэлийг маш сайн эзэмшиж байсан бөгөөд үүнээс шалтгаалан гадаад хэлний чадвар нь гайхалтай сайжирсан байна.

Энэхүү уламжлал нь одоо ч дэлхийн янз бүрийн улс оронд амьдарч байгаа Еврей хүмүүсийн амьдралд хэрэгжсээр байгаа юм. Гадны өөр улс оронд амьдарч буй Еврей хүмүүсийн ихэнхи нь хүүхдээ 2 төрлийн сургуульд явуулдаг. Амьдарч буй тухайн орныхоо сургууль болон Еврейчүүдийн сургуульд явуулдаг. Энэ нь хүүхэддээ эрт давхар хэлний боловсрол олгохын тулд юм. Израйль улсад Еврей болон Англи хэлийг үндсэн хэлээр сонгон заадаг.

Израйлийн дипломатч Абибит телевизийн хөтөлбөр үзэн Англи хэл сурсан байна. Израйль улс Англи хэлийг албан ёсныхоо хэлээр ашигладаггүй боловч олон нийтийн телевизэд нь Англи хэлээр явдаг мэдээний суваг байдаг. Тооны ухаан гэх мэт сургуулийн хичээлүүдийг Англи хэлээр заадаг хөтөлбөр ч их байдаг. Киног шууд Еврей хэлээр хөрвүүлэхийн оронд доод хэсэгт нь Англи хэлийг хадмал хэлбэрээр оруулж өгдөг. Еврей хүмүүс глобалчлалын энэ эрин үед Англи хэлний мэдлэг гол өрсөлдөх чадвар гэж боддог бөгөөд телевизүүд Англи хэлээр мэдээ, хөтөлбөрөө гаргахыг байх ёстой энгийн зүйл гэж ойлгодог.

Гадаад хэлийг сайн суръя гэвэл эхлээд ярьж сурахаасаа өмнө сонсож ойлгодог болох хэрэгтэй. Бага наснаасаа эхлэн хөгжим сонсож байгаа юм шиг гадаад хэлийг байнга сонсох орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Бага наснаасаа өөр улс оронд амьдарч байсан сурагчид өсөж том болоод хэлний чадвар гайхалтай сайн байдаг учир шалтгаан үүнд байгаа юм. Еврей хүмүүс бага наснаасаа эхлэн гадаад хэл сурч эхэлдэг болохоор зөвхөн ганц хэл мэддэг хүнээс илүү хэлний чадвар гайхалтай сайн байдаг. Гадаад хэлний чадвар нь суралцах болон бизнесийн өрсөлдөх чадварыг удирддаг гол цөм элемент юм. Еврей хүмүүс улс төр, эдийн засаг, хэвлэл

мэдээлэл, урлагийн салбар гэх мэт нийгмийн бүх салбарт гайхалтай амжилт гаргаж чаддаг нь тэдний гадаад хэлний чадвараас шалтгаалж байгаа юм.

Тэгвэл гадаад хэлийг хэрхэн үр дүнтэйгээр сурах вэ? Хэлний үндэс нь үг байдаг. АНУ хийсэн нэгэн судалгаанаас харвал хүн өдөр тутам байнга хэрэглэгддэг 600 орчим үг хэллэгийг цээжилж эзэмшсэнээр тухайн хэлийг сурч чаддаг байна. Өдөрт 20 шинэ үг цээжлээд байвал нэг сарын дараа гэхэд тухайн хэлээр бичигдсэн сонинг унших чадвартай болдог гэсэн үг юм. Еврей хүмүүс хэлний боловсролд маш их анхаарал хандуулдаг. Өдөр бүр шинэ үг цээжлэхэд анхаардаг бөгөөд цээжилсэн үгээ амьдралдаа шууд хэрэгжүүлэх дасгалжуулалтыг хийдэг. Болж өгвөл олон орны хэл сурахын тулд боломжтой бүх аргыг ашиглан цээжилсэн үгээ мартахгүйн тулд байнга хэрэглэдэг.

Бас нэг үр дүнтэй арга бол ном их унших юм. Еврей хүмүүс бас өдөр бүр хүүхэддээ гадаад хэлээр бичигдсэн ном уншиж өгдөг. Үүнийг барууны гадаад хэл сурах энгийн арга ч гэж нэрлэдэг. Би Нью-Йорк хотод сурч амьдарч байх үед хүүхэддээ ном их уншиж өгөх хэрэгтэй гэсэн үгийг чихээ дөжиртөл сонсож байв. Сургуулийн захиргаанаас цагаач юмуу гадаад сурагчдын эцэг эхийг дуудан хүүхэддээ ном уншиж өгч байхыг заадаг. “Хүүхдээ хурдан англи хэлтэй болгоё гэвэл эцэг эхийн үүрэг хамгийн чухал. Хүүхэддээ өдөр бүр англи хэлээр бичигдсэн номыг уншиж өгөөрэй. Магадгүй эцэг эхчүүд өөрсдөө англи хэлээр уншиж чаддаггүй бол эх хэлээрээ бичигдсэн ном ч болтугай уншиж өгч байх хэрэгтэй. Бүх хэл ерөнхийдөө адил төстэй байдаг учраас эцэг эх нь тогтмол ном уншиж өгснөөр хүүхэд гадаад хэл сурахад ихээхэн тус нэмэр болдог. Манай 2 хүүхдийн сурч байсан бага сургуулийн ESL (English as a Second language : Англи хэлийг эх хэлээ болгон ашигладаггүй сурагчдын боловсролын хөтөлбөр)-ийн анги удирдсан багш “Хүүхдүүд англи хэлийг хэр зэрэг хурдан сурах нь эцэг эхчүүдээс шалтгаалдаг. Эцэг эхчүүд хүүхдийнхээ сурах явцад байнга туслаж дэмжиж байх хэрэгтэй” гэж хэлдэг байв.

3 хүртэлх насны хүүхдэд уншиж өгөх гадаад хэлний номыг сонгохдоо амархан үг хэллэгтэй сонирхолтой үлгэрийн номыг сонгох хэрэгтэй бөгөөд олон дахин уншиж өгөх нь сайн юм. Нэг үг өгүүлбэр нь олон дахин давтагддаг гадаад хэлний үлгэрийн номыг хүүхэддээ тогтмол уншиж өгснөөр хүүхэд үг, өгүүлбэрийг амархан сурдаг. Ном уншиж өгч байхдаа тухайн гадаад хэлээрээ дуу дуулж өгвөл хүүхдүүд гадаад хэлийг хөгжилтэйгээр сурахад тус болдог. Хэрэв хүүхэддээ түүхийн сэдэвтэй үлгэрийн ном уншиж өгөхөөр бол гол баатрынх нь дүрд орон янз бүрийн дуу хоолой гарган жүжиглэх маягаар уншиж өгвөл бүр сайн. Мөн хүүхэд тань ном уншиж байх үед асуулт асуувал хариултыг нь тухайн сурч буй хэлээр нь юмуу эх хэлээрээ тайлбарлаж өгч болно.

Өөрсдөө дуудлага муутай болохоор англиар ном уншиж өгөхөөс татгалздаг эцэг эхчүүд бас байдаг. Иймэрхүү шалтгаанаар хүүхэддээ тухайн хэлний сидиг сонсгох нь сайн боловч аль болох эцэг эхчүүд өөрсдийн дуу хоолойгоор уншиж өгөх нь үр дүнтэй юм. Хүүхдүүд эцэг эх нь өөрсдөө ном уншиж өгвөл сонирхол нь илүү их татагдан дуртай байдаг бөгөөд эцэг эхийнхээ үйлдлийг даган дуурайдаг.

Эцэг эх бол хүүхдийнхээ ярилцлагын хамгийн гол хамтрагч

Гайхалтай ярилцах чадвараа зэвсэг болгон ашиглан ерөнхийлөгч болж чадсан Жон Кеннеди(John Kennedy)-гийн ард түүний ээж болох Рөүз Ёсо байсан. Рөүз Ёсо "Дэлхий ертөнцийн хувь тавилан сайн ч бай муу ч бай өөрийн бодол санаагаа бусдад дамжуулж чаддаг хүмүүсээр шийдвэрлэгдэж байдаг" гэсэн үзэл бодолтой нэгэн байсан. Тиймээс хүүхдүүдээ 4-5 нас хүрэх үеэс нь эхлэн ном уншуулах болон харилцан ярилцах аргаар дамжуулан хүүхдүүдээ сургаж эхэлсэн байна. Түүний ээж бага наснаас нь эхлэн хүүхдүүдийнхээ нийгмийн байдал, өөрчлөлтийг таньж мэдэх ойлголтыг сайжруулахын тулд сонинг ярилцлагынхаа гол материалаар ашигладаг байв. Тэрээр өдөр болгон өглөөний хоол идэхээс өмнө өглөөний сонин уншдаг байсан бөгөөд хооллож байх үедээ тэр өдрийн онцлох чухал үйл явдлын талаар хүүхдүүддээ ярьж өгдөг байжээ. Хүүхдүүдийнхээ нүдэнд ил харагдах газарт сонин, сэтгүүлээс хайчлан авсан чухал нийтлэлийг наадаг байв. Ээжийнх нь энэхүү дасгалжуулалт Кеннеди телевизийн ярилцлаганд Никсонийг ялах гол хүч болсон юм.

Англи улсын өмнөх ерөнхий сайд Броун(Brown)-ий үед гадаад хэргийн сайд болон эрчим хүч, цаг уурын сайдын албан тушаалыг хашиж байсан Дэвид Милибанд (David Miliband 46 нас), Эд Милибанд (Ed Miliband 42 нас) нар Польш гаралтай Еврей хүмүүсээс төрсөн ах дүү 2 юм. Ах дүү хоёр Англи улсын өмнөх ерөнхий сайдууд болох Тони Блэйр(Tony Blair), Броун (Brown) зэрэг хүмүүсийн илтгэлийн материал боловсруулах ажлыг хариуцан ажилладаг байсан бөгөөд найруулга зүйн чадвараараа олон хүнд хүлээн зөвшөөрөгдсөн байна. Энэ бол гэр бүлийн гишүүд хоорондоо ярилцах байдлыг голчлон анхаардаг байсан гэр бүлийн орчинд хүний суралцахын гол үндэс суурь болох унших, бичих эрдмийг хичээнгүйлэн сурсны ач тус юм. Тэдний эцэг болох Ральф Милибанд (Ralph Miliband) Лондонгийн улс төр, эдийн засгийн их сургууль (LSE)-д багшилдаг байсан бөгөөд зүүний боловсролтой нэгэн байсан юм. Тэрээр өөрийн бичсэн "Хурал зөвлөгөөний цаг үеийн нийгмийн үзэл баримтлал" номныхоо өмнөх үгэнд хоёр хүүхдийнхээ үр ашигтай хурц шийдэмгий шүүмжлэлд талархаж байгаагаа бичсэн байдаг. Гэр бүлийн гишүүд хоорондоо тухайн цаг үеийнхээ нөхцөл байдлын талаар санал бодлоо хуваалцах, бичсэн зүйлсээ хоорондоо солилцон унших, шүүмжлэн ярилцах зэрэг дүр зургийг Еврей гэр бүлээс харж болно.

Тэгвэл телевизийн ярилцлаганд оролцоогүй бол Жон Кеннеди (John Kennedy) ерөнхийлөгч болж чадах байсан болов уу? АНУ-д ерөнхийлөгчид нэр дэвшигчид хоорондын ярилцлага 1960 онд хамгийн анх телевизээр цацагдсан байна. Кеннеди бол хүний мэдрэмж болон дүр төрхөнд анхаардаг телевизийн соёлыг сайн ойлгосон АНУ-ын хамгийн анхны улс төрч байсан юм. Тухайн үед улс төрийн салбарт ид гялалзаж байсан Никсон (Nixon) Кеннеди-г ярилцлаганд дуудсан боловч тэрээр Никсон рүү харалгүй эсрэгээрээ телевизийн монитор руу харан ард түмэнтэйгээ ярилцаж байсан юм. Кеннеди нь Никсонийг илт давуу ялан ерөнхийлөгч болж чадсан нь түүнээс нас залуу царайлаг байсандаа биш юм. Түүний ярилцах, илтгэх ур чадвар гайхалтай сайн байсан учраас юм.

Кеннеди-г ийм чадвартай болгосон хүн бол түүний ээж Рөүз Ёсо юм. Рөүз Ёсо "Дэлхий ертөнцийн хувь тавилан сайн ч бай муу ч бай өөрийн бодол санаагаа бусдад дамжуулж чаддаг хүмүүсээр шийдвэрлэгдэж байдаг" гэсэн үзэл бодолтой нэгэн байсан. Тиймээс хүүхдүүдээ 4-5 нас хүрэх үеэс нь эхлэн ном уншуулах болон харилцан ярилцах аргаар дамжуулан

хүүхдүүдээ сургаж эхэлсэн байна. Сурагчдын ээж нарын уулзалт юмуу номын сангаас худалдан авсан номнуудаараа жагсаалт гарган өдөр болгон хүүхдээрээ ном уншуулдаг байжээ. Рөүз Ёсогийн номын жагсаалтанд /Арабын шөнүүд(Arabian Nights), Эрдэнэсийн арал, Артур хаан болон дугуй ширээний сэтгүүлчид, Питер Пэн/ зэрэг алдартай номнууд багтаж байв. Хүүхдээ нийгмийн амьдралд сонирхолтой болж эхлэх үеэс нь сонинг ярилцлагынхаа гол материал болгон ашиглаж эхэлсэн байна. Учир нь сонин бол нийгмийн өөрчлөлт, үйл явцыг өөртөө багтаасан байдаг. Кеннеди 15 наснаасаа эхлэн мэдлэг боловсролтой хүмүүсийн уншдаг “Нью-Йорк таймс” (NewYork Times) сонинг тогтмол уншдаг болов. Рөүз Ёсо өдөр болгон өглөөний хоол идэхээс өмнө өглөөний сонин уншдаг байсан бөгөөд хооллож байх үедээ тэр өдрийн онцлох чухал үйл явдлын талаар хүүхдүүддээ ярьж өгдөг байжээ.

Ямар нэгэн зүйлийн талаарх учир шалтгааныг тайлбарлан ярих, бичих эрдмийг сайн эзэмших нь удирдагч хүний бүрдүүлэх ёстой гол зүйл юм. Еврей хүмүүс бага наснаасаа эхлэн ном уншиж хоорондоо ярилцах аргаар дамжуулан ярилцах, бичих дасгалжуулалтыг маш их хийдэг. Тиймээс их сургуульд заадаг янз бүрийн бие даалт, дипломын ажил, эссэ зэргийг амархан хийчихдэг. Ийм арга барилаар бага наснаасаа суралцсан байдаг учраас Еврей хүмүүсээс учир шалтгааныг сайтар тунгаан бодох чадвар, хэлэлцээрийн чадвар шаарддаг чадварлаг улс төрч, хуульч зэрэг мэргэжилтэй хүмүүс олноор төрөн гарч байгаа юм.

АНУ-ын иргэн боловсролын сэтгэл судлаач Бенжамин Блүм (Benjamin Bloom) гэдэг Еврей хүн гэр бүлийнхээ хэлний орчинг сайжруулахад 3 төрлийн нөхцөл чухал гэж онцолсон байна.

1-рт. Гэрт хэрэглэгдэж буй үгийн сангийн тоо. Өдөр тутмын амьдралдаа цөөн тооны хэдхэн үгнүүдийг ашиглан ярилцдаг гэр бүл болон хоорондоо ярилцахдаа баялаг үгийн сан ашигладаг гэр бүлийн хүүхдүүдийн хэлний чадварт асар том ялгаа байдаг.

2-рт. Өдөр тутмын яриандаа ямар нэгэн ухагдахуун ойлголтыг ашиглах. Алим, банана, цаг, цүнх гэх мэт өдөр тутам байнга хэрэглэгдэн нүдэнд харагддаг эд зүйлийг илэрхийлдэг үг болон энх тайван, аз жаргал, хайр, урлаг, ирээдүй, үхэл гэх мэт хийсвэр нэр томъёо нь ухагдахууны түвшинд хоорондоо ихээхэн ялгаатай байдаг. Хүүхдүүд хүнд түвшний үгийн санг сайн ойлгож чаддаггүй боловч байнга ашигласаар байвал нэг мэдэхэд тухайн үгийн утга санааг ойлгохоор болдог.

Хүүхдэд хийсвэр ухагдахууныг заах тийм амархан ажил биш. Тоо юмуу шинжлэх ухааны тал дээр ойлголт муутай сурагчдыг ажиглавал ихэнхи нь хийсвэр ойлголт ухагдахууныг ойлгож чадахгүй байдаг. Еврей хүмүүс хийсвэр ойлголт ухагдахууныг сайн ойлгож чаддаг учир шалтгаан нь нүдэнд харагддаггүй ч хийсвэр ойлголтонд оршин байгаа Бурханыхаа талаар байнга судалж суралцаж байдаг учраас юм. Иймэрхүү маягаар өдөр тутмын амьдралдаа хийсвэр ойлголтыг ашиглан зуршил болгож чадвал хэлний чадвар болон ямар нэгэн зүйлд дүн шинжилгээ хийх чадвар гайхалтай сайжирдаг.

3-рт илэрхийлэх арга. Энгийн хэдхэн үгэнд багтаасан илэрхийлэл болон тодорхой түвшинд бүрэн дүүрэн өгүүлбэрээр илэрхийлэгдсэн илэрхийлэл нь хоорондоо ихээхэн ялгаатай байдаг. Энгийн ярианд тохиромжтой үгийн санг ашиглан хэлзүйд нийцсэн өгүүлбэрээр илэрхийлэх дасгалжуулалтыг сайн хийж байсан хүүхэд том болсон ч хэлний чадвар нь

гайхалтай сайн байдаг.

Сүүлийн үед их дээд сургууль болон ерөнхий боловсролын тусгай сургалттай сургуулиудын элсэлтэнд элсэлтийн хяналтын системийг нэвтрүүлж эхлээд байгаа бөгөөд шалгалтанд аман ярилцлагын эзлэх хувь нэмэгдэж байгаа нь илтгэх чадвар хичнээн чухал болж байгааг илэрхийлж байгаа юм. Хүмүүс хооронд харилцан ярилцах тал дээр муу Солонгос хүмүүс хүүхдийнхээ илтгэх чадварыг хэрхэн сайжруулах аргаа олохгүй сандарч буй тохиолдол их байна. Тэгвэл сургуулийн зүгээс сурагчдын илтгэх, ярилцах ур чадварыг сайжруулахын тулд юу хийх хэрэгтэй вэ?

Мэргэжилтнүүд илтгэх болон хэл ярианы боловсролд юуны түрүүнд “Бодох үндсэн техник”-ийг бий болгож өгдөг ном унших, харилцан ярилцах аргыг ашиглахыг чухал гэж үзэж байна. Ном унших үед дүн шинжилгээ хийх, шүүмжлэх, хэл зүйн чадварууд сайжирдаг. Ном уншихдаа болж өгвөл чанга дуугаар унших нь сайн. Учир нь чанга дуугаар ном уншсанаар тухайн уншиж буй зүйлийнхээ утга санааг илүү сайн ойлгодог бөгөөд мөн бусадтай ярилцах юмуу илтгэл тавих үед өөртөө итгэх итгэлтэй болгодог.

Тиймээс эцэг эхчүүд хүүхдээ ном уншсаных нь дараа номонд гарсан гол баатрын зан чанар, номын гол утга санаа гэх мэт тухайн номыг бүрдүүлж буй зүйлсийн талаар хүүхэдтэйгээ харилцан ярилцах зуршилтай болох хэрэгтэй. Ном уншсаны дараа уншсан зүйлийнхээ талаар хоорондоо ярилцснаар ямар нэгэн зүйлд дүн шинжилгээ хийн тунгаан бодох чадвар сайжирдаг. Мөн хүүхдүүдтэйгээ хамт танин мэдэхүйн нэвтрүүлэг юмуу кино үзсэнийхээ дараа ч ярилцаж байх нь сайн. Гэр бүлийн гишүүд бүгд хамтдаа суун хооллодог хоолны цаг дээр ч гэсэн ямар нэгэн сэдэв сонгон түүнийхээ талаар ярилцах зуршилтай болвол хүүхдийн бусадтай ярилцах, илтгэх чадвар сайжрахад ихээхэн тус нэмэр болдог. Мэдээж ярилцах зүйл маань эцэг эх болон хүүхдийн сонирхлыг татахуйц байвал сайн бөгөөд олон улсын шинж чанартай танин мэдэхүйн чанартай зүйл юмуу тухайн цаг үеийн нөхцөл байдлын талаарх сэдэв байвал илүү сайн. Харин ойлгоход хэтэрхий хүнд хэцүү сэдэв сонгон ярилцвал хүүхдийн ярих хандлага мууддаг.

Онигоо ойлгож мэдэрдэг болгох дасгалжуулалт

“Бүх амьтдын дотроос зөвхөн инээж чаддаг цорын ганц амьтан бол хүн юм. Хүмүүсийн дотроос ухаалаг хүн улам их инээдэг гэж “Талмуд” номонд бичсэн байдаг. Инээд бол хорт хавдрыг ч эмчилж чаддаг эм. Хэрвээ хүн инээхийг мэддэггүй байсан бол хичнээн их мэдлэг, оюун ухаан байгаад ч энэ нь хий хоосон дэмий зүйл юм. Инээд хөөр бол өөдрөг байдал болон эрх чөлөөтэй байгаагийн илэрхийлэл. Инээж чаддаггүй хүн байнга ямар нэгэн хүнд хэцүү асуудал тулгаран мухардалд орсон юм шиг байдалтай харагддаг. Инээдийг оюун ухааныг хурцалдаг билүү ч гэж нэрлэдэг. Хүмүүс бидэнд инээд хөөр, баяр баяслыг хамгийн ихээр бэлэглэж байдаг онигоо юмуу хөгжилтэй тоглоом наадам нь ямар нэгэн эд зүйлийн бодит байдлаас бага зэрэг хөндийрөн тухайн зүйлийг өөр өнцгөөс харах үед шинээр бий болж байдаг. Тиймээс онигоо, хөгжилтэй яриа зэрэг зүйлийг сайн ойлгохын тулд тархиа хурдан ажиллуулах шаардлага гардаг бөгөөд мөн өргөн мэдлэг, төсөөлөн бодох чадвар, байнгийн дасгалжуулалт шаардлагатай юм. (Марвин Токаер)

Гүйду гэдэг хүн Еврей хүн гэсэн шалтгаанаар Нацист Германы Еврейчүүдийг хорьдог “Auschwitz” гэдэг нэртэй хорих лагерьт хоригдсон байна. Тэрээр хэзээ ч үхэж магадгүй хүнд хэцүү байдалд байсан боловч хамт баривчлагдан ирсэн англи хэл мэддэггүй хүү Жошуа(Joshua)-гийнхаа итгэл найдварыг алдуулахгүйн тулд бүх хүчээ дайчлан хөөр баяртай байлгахыг хичээж байв. Тэднийг цагдан хорьж байсан Германы цэргийн офицеруудын хажууд ч хүүдээ худлаа орчуулга хийж өгөх гэх мэтээр маш өөдөрлөг байсан бөгөөд энэ байдал нь түүнийг ийм хүнд хэцүү үед ч баяр хөөртэй байлгаж чадсан юм. Гүйду нь өөрсдийгөө бусдаас онцгойлон сонгогдсон хүмүүс бөгөөд тулгарч байгаа хүнд хэцүү бэрхшээлийг даван туулснаар эрх чөлөө, сайн сайхан амьдрал хүлээж байгаа гэж хүүгээ тайвшруулж байв. Гэсэн хэдий ч үхлийн аюулаас мултрах аргагүй байдалд байсан юм. Тэрээр эмэгтэйчүүдийн хорих ангид хоригдож байгаа эхнэр Дурадаа өөрийнхөө амьд байгааг мэдүүлэхийн тулд бүх хүчээ дайчлан Оффенбач(Offenbach)-ийн дуурь болох “Хофмэний яриа”-нд усан цэргийн дуу дуулан жүжиглэж өөрийг нь харж байгаа хүүдээ зориулан тоглоомон цэргийн дүрд хүртэл тоглон жүжиглэж байв. Тэрээр маш хүнд хэцүү байдалд байсан ч үргэлж хүү рүүгээ харан баясгалантайгаар инээмсэглэж байсан юм.

Энэ бол Италийн “Амьдрал бол гайхалтай (Life is beautiful)” кино бөгөөд энэхүү кинонд дэлхийн 2-р дайны үед Еврейчүүдийн хорих газарт хоригдон зовж тарчилж байгаа хүүгээ аврахын тулд маш их зовлон бэрхшээлтэй тулгарч буй өр өвтгөм нэгэн эцэг хүний тухай гардаг. Хүн төрөлхтний түүхэн дэхь хамгийн аймшигт Нацист Германууд Еврейчүүдийг олноор нь тамлан алж байсан аллагын талбай дээр ч тэрээр инээмсэглэж байсан бөгөөд эхнэр, хүү хоёртоо “Юу ч болсон амьдрал бол гайхалтай зүйл” гэсэн итгэл найдварыг өөрийн биеэр харуулж чадсан юм.

“Бүх амьтдын дотроос зөвхөн инээж чаддаг цорын ганц амьтан бол хүн юм. Хүмүүсийн дотроос ухаалаг хүн улам их инээдэг” гэсэн Еврейчүүдийн сургааль үг байдаг.

Еврейчүүд онигоог зөвхөн инээж хөхрөөд баясаад өнгөрөх төдий зүйл гэж боддоггүй. Учир нь тэдний онигоонд Еврей хүмүүсийн өнгөрсөн амьдрал, хүнд хэцүү хавчлага дарамттай байсан амьдралынх нь түүх, үндэстнийх нь бахархал гүн гүнзгий шингэсэн байдаг учраас

юм. Еврей хэл юмуу Виддиш хэл шиг Еврей хүмүүсийг нэгтгэдэг бас нэг өөр хэл бол тэдний “Онигоо” юм. “Талмуд” номонд үндэслэн зохиогдсон Еврейчүүдийн олон арван онигоо нь хүнд хэцүү зовлон бэрхшээлийг даван туулахад нь тус болсон бас нэгэн чухал зүйл юм. Еврей хүмүүс хүнд хэцүү нөхцөлд зовж шаналан гуниглах үедээ хоорондоо онигоо, янз бүрийн хөгжилтэй зүйл ярин өөрсдийнхөө итгэл найдварыг бөхөөлгүй хамгаалсаар ирсэн юм.

Дэлхий даяар тархан янз бүрийн улс үндэстний дарамт шахалтанд амьдарч байсан ч Еврей хүмүүс бусад үндэстнээс илүү онигоонд хөгжилдөж чаддаг. Тиймээс “Онигоонд дуртай үндэстэн” ч гэж нэрлэгддэг. Еврей хүмүүс найз нөхөд, багш болон сурагчид, эцэг эх болон хүүхдүүд гэх мэтээр хоорондоо янз бүрийн хөгжилтэй инээдмийн зүйл маш их ярьдаг. Хичээлийн цаг дээр сурагчдад онигоо ярьж өгвөл сурагчдын сэтгэл санааг сэргээн хичээл номонд нухлагдсан тархи толгойг нь сэргээж өгдөг сайн талтай. Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ онигоо, янз бүрийн инээдтэй түүх яриа зэргийг ярилцсанаар хүүхдийг илүү нээлттэй болгож өгдөг бөгөөд мөн гэр бүлийн уур амьсгалыг ч улам сайхан болгодог.

Мөн онигоо, янз бүрийн хөгжилтэй яриа зэрэг нь боловсролын талаасаа ч ихээхэн тустай зүйл юм. Солонгос хүмүүс тоглоом наадам их хийдэг хүнийг нэг их сайшаадаггүй бол Еврей хүмүүс огтхон ч тэгэж боддоггүй. Онигоо юмуу инээдмийн зүйлийг Еврей хэлээр “Хупма” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь урьдчилан дүгнэх ба оюун ухаан гэсэн утгыг давхар илэрхийлдэг. Еврей хүмүүс онигоог зүгээр нэг энгийн тоглоом наадам төдийгөөр тооцолгүй өндөр түвшний оюуны үйл ажиллагаа гэж боддог.

Санхүүгийн корпорацийн эзэн Ротшильд (Rothschild) бол Еврей хүн юм. Тэрээр “Миний гол зэвсэг бол тоглоом наадам, инээд хөөр” гэж хэлсэн байдаг. Мөн Алберт Эйнштэн (Albert Einstein) Нобелийн физикийн шагнал авах тэр агшинд онигооны чухал чанарын талаар “Намайг бий болгосон зүйл бол онигоо байсан бөгөөд миний бусдад харуулж чадах хамгийн сайн чадвар бол тоглоом наадам хийх байсан юм. Хүмүүс дүрэм журмыг сахиж мөрдөхийг хамгийн чухал үнэ цэнэ гэж боддог боловч миний хувьд харин ч эсрэгээрээ дүрэм журмыг зөрчих үед бидэнд хамгийн хэрэгтэй шинэ дүрэм журам бий болдог гэж итгэдэг” гэж хэлсэн байна.

Онигоо нь хүний бүтээлч тунгаан бодох чадвартай нягт холбоотой байдаг. Тиймээс Еврей хүмүүс баян хөрөнгө чинээтэй болох юмуу нийгэмд өндөр байр суурь эзлэх тусмаа онигоог маш их чухалчилдаг. Онигоог хүн төрөлхтөнд байдаг хамгийн хүчирхэг зүйлсийн нэг гэж тэд боддог. Үнэндээ онигоо шиг өргөн цар хүрээгээр төсөөлөн бодох чадвар болон богинохон хугацаанд гүйлгээ ухаан шаарддаг зүйл байхгүй. Бусдын сэтгэл хөдлөл, бодол санааг агшин зуурт мэдсэнийхээ дараа түүнд тохирох инээдтэй зүйл ярин эсрэг хүнээ буулгаж авдаг нь онигооны давуу чанар юм. Онигоо нь дүрслэн бодох, богино хугацаанд сэтгэн бодох чадварыг ихээр шаарддаг. Ихэнхи алдартай алиалагчдын дотор Еврей хүмүүс их байдаг нь бас ор үндэсгүй зүйл биш юм. АНУ-ын алиалагчдын бараг 80-с дээш хувь нь Еврей хүн байдаг.

Онигоо нь нэр хүнд байр сууриа олоход ч ихээхэн тус болдог зүйл. Бизнесийн харилцааны үед сайхан уур амьсгалыг бий болгож чаддаг зүйл бол онигоо юм. Марвин Токаер “Өөрийн тавьсан зорилго руугаа тэмүүлэн явж байгаа хүнд онигоо гэдэг зүйл бол автомашины хурдны гишгүүртэй адилхан юм. Урьд нь сонсож байгаагүй нэг инээдмийн зүйл сонсох нь сайхан уур амьсгалыг бүрдүүлээд зогсохгүй өөрийн үнэ цэнэ, хүч чадлыг нэмэгдүүлэх гол хүч болдог”

гэж хэлсэн байна.

Тиймээс Еврей хүмүүс онигоо сайн мэддэггүй хүнтэй уулзвал “Толгойгоо билүүдэж хурцлах хэрэгтэй” хүн байна гэсэн хэллэгийг маш их хэрэглэдэг. Еврей хүмүүс хутганы ирийг билүү хурцалдаг шиг онигоо хүний оюун ухааныг хурцалж өгдөг гэж итгэдэг.

Онигоо сайн мэддэг хүн оюун ухаан сэргэг бүтээлч чадвар сайтай байдаг. Мөн шинэ нөхцөл байдалд амархан дасан зохицож дүн шинжилгээ хийх чадвар сайн хөгжсөн байдаг. Хүн зөвхөн хичээнгүй махран зүтгэснээр амжилтанд хүрнэ гэдэг боломжгүй зүйл юм. Еврей хүмүүс хүн зөвхөн хичээнгүй байснаар амжилтанд хүрэх хувь бага байдаг гэж үздэг. Яагаад гэвэл маш хичээнгүй, өндөр мэдлэг боловсролтой хүний тархинд төсөөлөн бодох чадвар, хувийн зан чанар бий болох орон зай бага байдаг. Байнга инээд хөөр баяр баяслаар дүүрэн байдаг орчин болон онигоо нь Еврей хүмүүсийн амжилтын бас нэг нууц юм. Инээж хөөрч баясч цэнгэх тал дээр муу манай Солонгос улсын иргэд Еврей хүмүүсийн энэ талыг сайн сурах хэрэгтэй гэж бодож байна.

“Бони хичээлдээ явах цаг чинь болчихлоо. Хурдан босоорой”

Хариуд нь Бони хөнжлөө толгой дээгүүрээ хөдрөн ингэж хэлэв. “Сургууль руугаа явмааргүй байна”

“Чи сургууль руугаа заавал явах хэрэгтэй”

“Сургууль руугаа явмааргүй байна гээд байна ш дээ. Учир нь багш нар, хүүхдүүд бүгд надад дургүй болохоор байнга надаар тоглоом шоглоом хийдэг”

Ээж нь Бонигийн хучиж байсан хөнжлийг хуу татаад ингэж хэлэв.

“Бони чамд ямар ч сонголт байхгүй. Сургууль руугаа заавал явах ёстой”

“За за ойлголоо” гээд Бони ингэж хэлэв. “Тэгвэл намайг сургууль руугаа явах ёстой гэсэн зөвхөн нэг учир шалтгааныг хэлээд өгөөч” гэв.

Гэтэл ээж нь “Учир нь чи 52 настай сургуулийн захирал хүн шүү дээ” гэж хэлэв.

Иймэрхүү маягаар хоорондоо онигоо, янз бүрийн инээдмийн зүйл ярин инээд хөөрөөр дүүрэн байдаг гэр бүлд өссөн хүүхэд онигоо ойлгох чадвар нь гайхалтай сайн байдаг. Насанд хүрсэн хүмүүс ч хүүхдүүд ч ялгаагүй гүнзгий далд утгатай онигоо сайн ойлгох нь үеийн хүмүүс дотроо нэр хүндтэй болох бас нэгэн чухал үзүүлэлт юм. Онигоо сайн ойлгодог хүүхдийн хэлний чадвар ч гайхалтай сайн байдаг бөгөөд хүмүүстэй харилцахдаа ч өөртөө итгэх итгэлтэй байдаг. Тиймээс өнөөдрөөс эхлэн бүгдээрээ хүүхдүүдтэйгээ янз бүрийн хөгжилтэй зүйл ярьж инээж хөхрөн аз жаргал инээд хөөрөөр бялхсан гэр бүлийг бий болгохын тулд хичээцгээе.

Өдөр бүр өглөөний хоолоор хүүхдийнхээ тархийг сэргээх

Өглөөний хоолыг илэрхийлдэг англи үг болох “Breakfast” нь өнгөрсөн шөнийн өлсгөлөн(fast)-г устгана(break)” гэсэн утгатай үг юм. Бид оройн хоол идсэний дараа 12 орчим цагийн турш хоол идэхгүй байдалтайгаар өглөөг угтдаг бөгөөд энэ үед цусан дахь сахрын хэмжээ багасан тэжээл шаардлагатай болсон байдаг. Бидний биеийн дотор эрхтнүүд дотроос 24 цагийн турш амралтгүй ажиллаж байдаг зүрхний нэг өдөрт зарцуулах энерги 140 каллори орчим байдаг. Гэтэл тархины нэг өдөрт зарцуулдаг энерги зүрхнийхээс 3 дахин их буюу 400 калори орчим байдаг. Хэдэн зуун тэрбум тархины мэдрэлийн эс хөдлөө гэвэл ийм хэмжээний энерги зарцуулах шаардлагатай байдаг. Хүн өглөөний хоол идээгүй үед тэжээл дутагдан тархины мэдрэлийн эс хэвийн ажиллахад хэцүү болдог.

Еврей хүмүүс хүүхдүүддээ өглөөний хоолыг нь бэлдэж өгдөггүй үе гэж байдаггүй. Хоол хүнс зөвхөн амьдрахын тулд иддэг зүйл биш бие мах бодь төдийгүй оюун ухааныг ч гэсэн дэмжиж өгдөг чухал зүйл юм. Хоол хүнс болон авъяас чадвар нь хоорондоо нягт уялдаа холбоотой байдаг. Өглөө хоол иддэггүй хүүхдүүд хичээл номондоо сайн төвлөрч чаддаггүй. Еврей ээж нар хүүхдийнхээ боловсрол болон идэж уух зүйлд нь ихээхэн анхаарал хандуулдаг учир шалтгаан үүнд байгаа юм.

Эрүүл мэнд нийгмийн хамгааллын яамны “2005 оны иргэдийн эрүүл мэндийн байдлын судалгаа”-ны тайлангаас харвал Солонгос улсын дунд, ахлах сургуулийн сурагчдын 23 хувь нь өглөөний хоол иддэггүй болох нь тодорхой болсон байна. Солонгос улсын боловсролын ерөнхий хорооноос бага, дунд, ахлах сургуулийн 12,000 орчим сурагчдыг оролцуулан хийсэн судалгаанд ч сурагчдын 32,9 хувь нь “Өглөөний хоол бараг иддэггүй” гэж хариулсан байна. Энэхүү хувь бага сургуулийн 3-р ангид 19,6 хувь, дунд сургуулийн 2-р ангид 36,9 хувь, ахлах сургуулийн 2-р ангид 43,7 хувь гэх мэт анги өгсөх тусам өссөн байна. Энэ нь анги өгсөх тусам улам нэмэгддэг хичээлийн дарамт, нойрны дутагдал, эрт хичээлдээ явах гэх мэт их сургуулийн элсэлтийг чухалчилсан боловсролын тогтолцооноос шалтгаалж байгаа юм.

Солонгос улсын тухайд сурагчид өглөөний хоолоо идэж чадахгүй байгаад тодорхой учир шалтгаанууд байгаа юм. Юуны түрүүнд хичээлийн ачаалал маш их байдаг учраас оройн 11 цагаас өмнө орондоо орох нь маш ховор байдаг. Оройтож унтсан болохоор өглөө жаахан илүү унтан оройтож босох нь бие мах бодийн талаасаа сайн боловч хичээлийн цагтаа хоцрохгүйн тулд яаран өглөөний хоолоо идэх цаг гардаггүй байна. Шөнө орой болтол хичээл хийн ядарсан байдаг болохоор биеэ дааж ядан ширээний ард суудаг ч хоол идээгүй болохоор хурдан хичээлийн цаг дуусахыг хүлээн хичээлдээ сайн төвлөрч чаддаггүй. АНУ-ын “Хүүхэд, залуучуудын анагаах ухааны суваг болох /APAM/-д нийтлэгдсэн нэгэн дипломын ажлаас харвал сургуулийн сурагчдын хичээл эхлэх цагийг 30 минутын хугацаагаар хойшлуулвал өглөөний хоолоо идэж чадах учраас хичээлд төвлөрөх чадвар нь гайхалтай сайжирна гэсэн дүгнэлт гарсан байна.

Сөүлийн их сургуулийн анагаахын сургуулийн эм зүйн ангийн Со Юү Хон багш өглөөний хоол заавал идэх ёстой учир шалтгааныг дараах байдлаар тайлбарласан байна.

· Хүн өглөөний хоол идэхгүй бол биеийн халуун буурдаг. Хүн унтаж байх үед биеийн халуун

бууран тархины үйл ажиллагаа удааширдаг. Үдээс өмнө тархины үйл ажиллагаагаа сайжруулан нэмэгдүүлье гэвэл унтаж байх үед буурсан биеийн дулааныг нэмэгдүүлэх хэрэгтэй бөгөөд үүнийг бий болгож өгдөг зүйл бол өглөөний хоол юм. Өглөөний хоол иддэггүй сурагчдын 70 хувь нь биеийн дулаан нь 35 градусаас хэтрэхгүй байсан гэсэн судалгаа гарсан байдаг.

· Өглөөний хоол идээгүй үед үдээс өмнө тархины өнчин тархинд хоолны дуршлын талаарх цочрол үүсэн бие мах бодь физиологийн хувьд тав тухгүй болдог. Хоолны дуршлыг багасгая гэвэл нүүрс ус хэрэглэн цусан дахь сахрын хэмжээг нэмэгдүүлэх хэрэгтэй.

· Энергийг бий болгон бодисын солилцооны үйл ажиллагааг эрчимжүүлдэг бөөрний булчирхайн гормон болох стероид (steroid) нь хоол идэх болгонд бага багаар ялгарч байдаг. Өглөө хоол идэхгүй үед бөөрний булчирхайн гормон ялгарахаа байн бие мах бодийн хэмнэл алдагддаг.

· Өглөөний хоол иддэггүй сурагчид түргэн хоол, хийжүүлсэн ундаа гэх мэт хэрэггүй муу хоол хүнс (Junk food) хэрэглэх хувь маш өндөр байдаг. Ийм төрлийн хоол хүнс нь илчлэг ихтэй шим тэжээл багатай байдаг учраас жин нэмэгдүүлэн сурах хүсэл сонирхлыг бууруулдаг.

Тэгвэл ямар хоол хүнс хэрэглэх хэрэгтэй вэ? Еврей хүмүүс өглөөний хоолондоо янз бүрийн витамин, кальци, төмөр гэх мэт хүний уураг тархинд сайн шим тэжээл ихтэй хоол хүнсийг хэрэглэдэг. Хүүхдийнхээ сэтгэн бодох, төвлөрөх чадварыг сайжруулахад тус болдог лецитин /lecithin/ болон коллин /colleen/ ихээр агуулсан вандуйны төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг ихэвчлэн хэрэглэдэг. Тархины үйл ажиллагааг цэвэрлэн сэргээдэг кали ихээр агуулдаг алим болон бананыг ч бас хүнсэндээ ихээр хэрэглэдэг. Хүний тархи биеийн эрхтнүүд дотроос тослогийн хувь хамгийн өндөр байдаг учир хүчилтөрөгчийн нөлөөллийг идэвхитэйгээр аван муудахдаа амархан байдаг. Еврей хүмүүс оюун ухаанаа муутгахгүйн тулд үл исэлдүүлэгч бүтээгдэхүүн болох витамин Е их хэмжээгээр агуулсан хушга, хушны самар, газрын самар гэх мэт самарны төрлийг хүнсэндээ их хэрэглэдэг.

Мөн хүүхдийнхээ хооллолтонд ихээхэн анхаарал хандуулан огтхон ч хүүхдийнхээ дуртай хоол болгоныг нь зөвшөөрөн бэлтгэж өгдөггүй. Хэрэв хүүхэд зөвхөн өөрийнхөө дуртай хоолыг иднэ гэж зөрүүдлэн хоолоо идэхгүй байвал бүр эсрэгээр нь дуртай хоолыг нь хүүхэддээ бэлтгэн өгдөггүй. Ингэж байгаа нь бүх хүмүүс хамтдаа суун хооллож байхад бусдыг хүндэтгэн ширээн дээр бэлтгэн тавьсан хоолыг идэх хэрэгтэй болохыг хүүхэддээ ухааруулж байгаа юм. Хэрэв ийм арга хэрэглээд ч хүүхэд нь ойлгохгүй зөрүүдлэвэл бүр хоол өгдөггүй байна. Еврей хүмүүсийн энэ байдал дуртай хоолоо идэх гэж зөрүүдлэх болгонд нь хүүхдээ эрхлүүлэн хүссэн хоолыг нь хийж өгдөг Солонгос хүмүүсээс өөр байгаа юм. Еврей хүмүүсийн хүүхдийнхээ хооллолтонд ихээхэн анхаарал хандуулдаг учир шалтгаан нь Кошер /Kosher-идэж болох хоол хүнс/ гэдэг өвөрмөц хоолны соёлоос нь үүдэлтэй юм. Еврей хүмүүс Еврейчүүдийн шашны хуулийнхаа дагуу идэж болдог зүйл болон идэж болдоггүй зүйлийг ангилдаг бөгөөд идэж болох хоол хүнсний зүйлийг ерөнхийд нь Кошер /Kosher/ гэж нэрлэдэг. Кошер/Kosher/ хоолны соёл нь хоолны үзэмжээс илүү материалын сонголтонд анхаардаг. Тухайлбал хүнсний ногоо юмуу жимс жимсгэнэ гэх мэт ургамлын гаралтай хоол хүнс бол ойлгомжтой Кошер /Kosher-идэж болох хоол хүнс/ хүнс боловч амьтны тухайд бол арай өөр юм. Еврей хүмүүс үхэр, хонь, ямаа, зээр гэх мэт хивдэг салаа туурайтан амьтны махыг л хоол

хүнсэндээ хэрэглэдэг. Гахай нь хивдэггүй учраас Кошер /Kosher-идэж болох хоол хүнс/ хүнс биш юм. Загасны төрлөөс сэрвээт загас болон хайрстай загасыг л хүнсэндээ хэрэглэдэг. Еврей хүмүүс бас хоол хүнсэнд хэрэглэж болох амьтныг алахдаа тамлаж зовоохгүй байхыг чухалчилдаг. Хурц хутгаар богинохон хугацаанд хоолойг нь хэрчин амьтныг зовоохгүй алах аргыг ихэвчлэн хэрэглэдэг. Ямар ч амьтан байсан цусыг нь бүрэн угааж цэвэрлэсний дараагаар махыг нь хүнсэндээ хэрэглэдэг.

Томчууд төдийгүй хүүхдүүд нь ч өөрсдийн мэддэг мах болон сүүний төрөл зүйлийг хамтад нь хольж иддэггүй. Бяслаг болон махыг хамтад нь иддэг хэмбургер (Hamburger) юмуу бяслагтай бургер (Cheese burger) бас хориглосон хүнсний бүтээгдэхүүнд ордог. Дарсны тухайд гэвэл эрт дээр үеэс шашны тахилга ёслолд ашигладаг байсан цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр зөвхөн Еврей хүний хийсэн дарсыг л сонгон хэрэглэдэг. Еврей хүмүүс энэхүү Кошер /Kosher-идэж болох хоол хүнс/ хоолны соёлоо 3,300 жилээс ч дээш хугацаагаар сахисаар ирсэн. Орчин үед Еврей хүмүүсийн 30 орчим хувь нь Кошер/Kosher-идэж болох хоол хүнс/ хоолны соёлыг өдөр тутмын амьдралдаа зохистой хэмжээгээр ашиглаж байгаа юм. Сүүлийн үед Кошер /Kosher-идэж болох хоол хүнс/ хоолны соёл “Эрүүл мэндийн хүнсний бүтээгдэхүүн”-ий гол загвар болж байгаа учраас энгийн хүмүүс ч гэсэн энэхүү хооллолтын арга барилыг өдөр тутмын амьдалдаа ихээр ашигладаг болж байна. АНУ-ын хүнсний бүтээгдэхүүний зах зээлд Кошер /Kosher-идэж болох хоол хүнс/ хүнсний бүтээгдэхүүний худалдаа, төрөл зүйл тасралтгүй өссөөр байгаа юм.

“Талмуд” хэлбэрийн ярилцлагын аргыг ашиглан хүүхдийнхээ асуултанд хариулахаас илүүтэйгээр хүүхэддээ асуулт тавих

Манай эриний 1-р зууны үед амьдарч байсан Жошуа (Joshua) гэдэг нэгэн шашны багш нэгэн хотыг чиглэн алхаж байв. Багш замын хажууд сууж байсан нэгэн охиноос “Энэ замнуудын аль замаар нь явбал хот руу очих вэ? гэж асуусан байна. Охин “Энэ замаар явбал зам нь богинохон боловч хугацаа их зарцуулна. Харин энэ замаар явбал зам нь урт боловч хугацаа бага зарцуулна” гэж хариулсан байна. Багш Жошуа (Joshua) охины хэлсэн “Богинохон боловч хугацаа их зарцуулагдана” гэсэн замыг сонгон хот руу алхсан байна. Алхсаар хотод ойрхон очтол жимсний модны цэцэрлэгт тулан ирсэн замаараа буцаж явахаас өөр аргагүй болсон байна. Тэрээр буцаж ирэн охиноос “Чи надад энэ замаар явбал богинохон гэж хэлээ биздээ” гэж хэлэв. Хариуд нь охин ингэж хариулав. “Тэгэж хэлсэн нь үнэн. Гэхдээ би танд хугацаа их зарцуулагдана гэж хэлээгүй гэж үү?” гэж хэлсэн байна. Энэ бол “Талмуд” номонд гардаг Еврей хүмүүсийн харилцааны арга барилын нэг төрөл юм.

1998 онд Силикон Валли (Silicon Valley) гэдэг газар нэгэн машины гражид “Гүүгл(Google)” компанийг үндэслэн байгуулсан Ларри Пэйж (Larry Page) болон Сергей Брин (Sergey Brin) нар 27 настай нас чацуутангууд бөгөөд тэд хоёулаа гэр бүлийн гишүүд хоорондоо сайн харилцан ярилцдаг Еврей гэр бүлд төрж өсөн хүмүүжсэн байна. Бриний өвөө нь тооны багш байсан бөгөөд эцэг Майкл болон эх Южина нь мөн математикчид байсан байна. Эцэг Майкл нь Бриний тооны чадварыг сайжруулж өгсөн сайн хувийн багш төдийгүй Бринтэй хамгийн сайн ярилцдаг нэгэн байсан юм. Тэдний гэр бүлд хоолны ширээ бол хоол иддэг газар төдийгүй гэр бүлийн гишүүд хоорондоо яриа өрнүүлдэг газар байсан. Пэйжийн гэр бүлийн гишүүдийн тухайд ч бүгд ном уншин түүнийхээ талаар хоорондоо харилцан ярилцдаг хүмүүс байв. Нэг удаа гэр бүлээрээ аялалаар явж байхдаа хувцас хэрэглэл хийж явсан цүнхээ бүгдийг нь хоослон очсон газрынхаа номын дэлгүүрээс цүнхээ дүүртэл ном худалдан авч байсан удаа ч байсан байна.

Еврей зүйр цэцэн үгэнд “Үг дуу цөөтэй хүүхэд юу ч сурч чаддаггүй” гэсэн үг байдаг. Еврей хүмүүс хүүхдээ өсгөх хүмүүжүүлэх явцдаа хэлний боловсролд нь маш их цаг зарцуулан анхаарал хандуулж хүүхдээ суралцах чин хүсэл эрмэлзэлтэй болгодог. Хүүхдийн бага насанд хамгийн чухал боловсрол бол “шийтгэлгүй боловсрол” болон “харилцан яриа” юм. Хүүхэд хичнээн зөрүүдлэсэн ч огтхон ч зодох юмуу шийтгэж болохгүй. (Хүүхэд тодорхой хэмжээгээр үг яриа ойлгодог болсон үед нь зөв аргаар зодож шийтгэж болно) Хүүхэд нь хичнээн зөрүүдлэж эсэргүүцсэн ч Еврей хүмүүс хүүхэдтэйгээ харилцан ярилцаж тухайн зүйлийн талаар сайтар тайлбарлан хүүхэддээ ойлгуулдаг. Хэн нэгэн хөндлөнгөөс харвал үнэхээр бачимдмаар хэцүү ажил. Гэвч энэхүү боловсролын арга барил нь хүүхдэд ямар нэгэн зүйлийг тунгаан бодож чадах үндэс суурийг бий болгоод зогсохгүй хүүхдийг өөрийн бодол санаагаа бусдад сайн ойлгуулж чадах чадвартай, өөртөө итгэх итгэлтэй болгодог.

Өөрийн хүүхдүүдээ Израйль улсад сурган боловсрол эзэмшүүлсэн Конгүг их сургуулийн Рю Тэ Ён багш (нийгмийн ухаан) Еврей хүмүүсийн хэл ярианы боловсролын арга барилыг бусдаас өөр гэж хэлсэн байна. “Еврей хүмүүс маш эрт хүүхдийнхээ хэл ярианы боловсролд анхаарал хандуулдаг учир шалтгаан нь хүүхдийнхээ бүтээлч чанарыг сайжруулахын тулд

байдаг. Хүмүүс хоорондоо сайн ярилцсанаар чөлөөтэйгээр сэтгэн бодож чаддаг бөгөөд энэ нь хүний бүтээлч чадвар болон ямар нэг зүйлд дүн шинжилгээ хийх чадварыг сайжруулдаг. Хэдийгээр Еврей хүмүүс хүүхдийнхээ хэл ярианы боловсролд маш их анхаардаг ч тусад нь цаг зав, мөнгө огтхон ч зарцуулдаггүй. Учир нь өдөр тутмын амьдралдаа эцэг эхчүүд хүүхэдтэйгээ чөлөөтэй харилцан ярилцах байдлаар дамжуулан хэл ярианы боловсролыг олгодог.

Ер нь хүүхдэд юу зөв, юу буруу болохыг зааж өгөхөд маш энгийн амархан байдаг. Гэвч хүүхэд яагаад зөв яагаад буруу болохыг тийм ч амархан ойлгож чаддаггүй. Цээжлүүлэх болон мэдээлэл дамжуулан сургах боловсролын арга нь ямар нэгэн мэдлэгийг хүүхдэд өнгөцхөн дамжуулах төдий байдаг бол харилцан ярилцах хэлбэрийн боловсролын арга барил нь мэдлэг болон хүн чанарын боловсролыг хамтад нь зааж байдаг. Тийм болохоор энэхүү боловсролын арга барилд цаг хугацаа их зарцуулагддаг бөгөөд эцэг эх, багш нарын тэсвэр тэвчээрийг ихээр шаарддаг хэцүү ажил юм. Гэвч маш үр дүнтэй.

“Талмуд” ном бол Еврей хүмүүсийн харилцан ярилцах боловсролд нь хамгийн түгээмэл ашиглагддаг шилдэг сурах бичиг юм. “Талмуд” ном бол ямар нэг сэдэв сонгон багш болон шавь нар хоорондоо тухайн сонгосон сэдвийнхээ талаар ярилцах явцаас бий болсон ном юм. Еврей хүмүүс хүүхэдтэйгээ “Талмуд” хэлбэрийн харилцан ярилцах аргыг ашиглан ярилцдаг бөгөөд үүнд үе шат байдаг. Юуны түрүүнд хүүхдийнхээ ярьж байгаа зүйлийг анхааралтай сайн сонсон хүүхдийнхээ сэтгэлзүйн байдлыг тодорхойлсныхоо дараа эцэг эх өөрийн санал бодлоо хэлэх хэрэгтэй. Түүний дараагаар тухайн тулгарч буй асуудлынхаа талаар хоорондоо хэлэлцэж ярилцана. Энэхүү системтэй харилцан ярилцах дасгалжуулалт хуримтлагдсаар хүний ямар нэгэн зүйлд дүн шинжилгээ хийх чадвар болон бүтээлч чадварыг гайхалтай сайжруулдаг байна.

Ийнхүү бага наснаасаа эхлэн харилцан ярилцах боловсролоор сайн суралцдаг учраас Еврей хүмүүс хэвлэл мэдээлэл, хуулийн салбарт гайхалтай амжилт гаргаж чаддаг. “Хэл ярианы ертөнц” гэж хэлж болох телевиз, хэвлэл мэдээллийн салбарыг Еврей хүмүүс бий болгосон гэхэд хэлсдэхгүй юм. АНУ-ын 3 том олон нийтийн телевиз болох ABC, CBS, NBC-ийг бүгдийг нь Еврей хүмүүс үндэслэн байгуулсан байдаг бөгөөд алдартай алиалагчдын 80 дээш хувь нь Еврей хүмүүс байдаг. Цаг үеийн хөтөлбөр болох “Шөнийн шугам” хөтөлбөрийг 20 дээш жил хийсэн ABC телевизийн эрэгтэй хөтлөгч Тэд Копл(Ted Couple), мөн тус телевизийн гол хөтөлбөр болох “20\20” нэвтрүүлгийн эмэгтэй хөтлөгч Барбара Валтерс (Barbara Walters) нар хоёулаа Еврей хүн юм.

Томоохон сонины компаниудын ихэнхийг ч Еврей хүмүүс удирдаж байна. Олон жилийн өмнө нөгөө ертөнцөд одсон Катрине Грэйм (Katharine Graham) “Вашингтон пост (Washington Post)” “Ньюс Вик (News Week)” сонингууд болон мөн Флорида төдийгүй АНУ-ын олон арван мужийн телевизийн компаниудыг эзэмшиж байсан нэгэн юм. Одоо түүний хүү Доналд Грэйм (Donald Graham) нь “Вашингтон пост (Washington Post)” сонины газрын захирлын албан тушаалыг хашдаг байна. “Нью-Йорк таймс (New York Times)” сонины Эдольф Оакс (Adolf Oaks) ч мөн Еврей гаралтай хүн юм. “Эрхэм Эбби” гэсэн нэрээр хэдэн зуун сонинд амьдралын талаар сонирхолтой нийтлэл бичдэг Энн Лэндерс (Ann Landers) ч Еврей хүн юм. АНУ-ын хэвлэл мэдээллийн салбарын гол шагнал болох “Пулитзерийн шагнал” нь Унгар

гаралтай Еврей хүн болох Жосеф Пулитзерийн нэрээр нэрлэгдсэн байдаг. Оросын гол сонины газар болон телевизийг өөрийн мэдэлдээ аван ерөнхийлөгч Путиний хяналтанд хүртэл орж байсан хэвлэлийн ертөнцийн хаан хочит Владимир Гүшински (Vladimir Gusinseuki) ч бас Еврей хүн юм. АНУ-ын томоохон хэвлэлийн компаниудын сэтгүүлч, редакторуудын 30 дээш хувь нь бүгд Еврей хүмүүс байдаг. Үйл ажиллагааны хувьд маш сайн байгаа ардчилсан намыг дэмжиж байгаа “New York Times” сонины дуу хоолой, томоохон аж ахуй нэгж болон бүгд найрамдах намын бодлогыг дэмжиж байгаа “Wall Street Journal”-ийн дуу хоолой, эцэст нь эдгээр зүйлсийг Еврей хүмүүс хоорондын хэлэлцээрийн өрсөлдөөн гэж хэлж болно.

Хууль эрхзүйн салбарт ч амжилт гаргаж буй Еврей хүмүүсийн хүч чадлыг харуулсан үйл явдал цөөнгүй байдаг. Жишээ нь 1998 оны 12-р сард АНУ-ын дээд шүүхийн төв хаалган дээр болсон эсэргүүцлийн жагсаал юм. Дээд шүүхийн ажил албыг хариуцдаг хуулийн протокол хөтлөгчид дотор өнгөт арьстан хүн 1.7 хувь, Испани хүн 1.2 хувь эзэлж байсан бөгөөд үүнийг хүмүүс арьс өнгөөр ялгаварлан гадуурхаж байна гэж үзэн эсэргүүцлийн жагсаал цуглаан хийсэн байна. Бодит байдал дээр хуулийн протокол хөтлөгчдийн ихэнхи нь цагаан арьст хүмүүс байсан бөгөөд 30 дээш хувь нь Еврей хүмүүс байсан юм. Клинтон ерөнхийлөгчийн үед дээд шүүгчийн тоо 9 байсан бөгөөд үүний 2 нь Еврей хүн байв. Барак Обама (Barack Obama)-гийн засгийн газрын үед Элэна Кэган, (Elena Kagan) Рүс Гинсбург (Ruth Ginsburg), Стивен Брэйр (Stephen Brier) гэх 3 хүн шинээр нэмэгдсэн байна. 1948 онд байгуулагдсан Еврей гаралтай “Брэндэйсийн их сургууль(Brandeis University)” нь АНУ-ын түүхэнд анх удаа дээд шүүхийн шүүгч болж байсан Лоус Брэндайс (Louis Brandeis) хэмээх Еврей хүний нэрээр нэрлэгдсэн байдаг.

АНУ-ын 74,000 өмгөөлөгч (1999 оны байдлаар)-ийн 16 хувь нь Еврей хүмүүс байдаг. Нью-Йорк болон Вашингтонтой нягт харилцаа холбоотой хуулийн байгууллагуудын 40 хувь нь Еврей хүмүүстэй шууд хамааралтай байдаг. АНУ-ын гол гол томоохон компаниуд болон хэвлэл мэдээллийн компаниудын ихэнхи нь Еврей хүмүүсээр удирдуулах юмуу Еврей хүмүүсийн хөрөнгө оруулалтаар үйл ажиллагаа нь явагдаж байдаг учраас өмгөөлөгчөөр Еврей хүнийг ажилд авахгүй бол ажил хэрэг бараг бүтэхгүй хэмжээгээр Еврей хүмүүсийн нөлөө маш их байдаг. Нэр хүндтэй их сургуулийн хуулийн сургуулийн сурагчдын 30 орчим хувь нь Еврей хүмүүс байдаг бөгөөд АНУ-ын хуулийн сургуулийн багш нарын 26 хувь нь мөн Еврей хүмүүс байдаг.

Хүүхдийнхээ хийсэн ямар нэгэн зүйлийн үр дүнг хараад магтахаас илүүтэйгээр тэрхүү зүйлийг хийх явцад сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх

Хичээл сурлагандаа сайн сурагчдад тодорхой нийтлэг тал байдаг. Энэ юу вэ гэвэл яагаад хичээл хийх хэрэгтэй, хичээл хийх зорилго нь тодорхой байдаг. Өөрөө хийхийг хүсээд хийх биш бусдын шахалтаар хийж байгаа хичээл ямар ч үнэ цэнэгүй зүйл юм. Цаг наргүй хичээллэдэг хувийн боловсрол болон хичээлийн программыг түрүүлж судлах нь хүүхдийн сонирхлыг бууруулан сурах хүсэл эрмэлзлийг нь байхгүй болгодог гол хүчин зүйл юм. Хүүхэд дотроо хүсэж мөрөөдөж байгаа зүйл болон ирээдүйн ажил мэргэжил гэх мэт дотоод хүсэл эрмэлзлийнхээ дагуу суралцан хичээл хийх нь маш чухал. Харин гадаад хүчин зүйлээс шалтгаалан хүчээр хийж байгаа хичээл ном нь хүнийг дэмий ядраахаас цаашгүй байдаг. Иймээс эцэг эхчүүд ч гэсэн мөн ялгаагүй өөрсдийн үүргээ зөв тодорхойлох хэрэгтэй юм. Эцэг эхчүүдийн хамгийн чухал үүрэг бол хүүхэд өөрөө юу хийх ёстойгоо ойлгож ухаарахад нь туслах юм. Үүний тулд хамгийн сайн арга бол хүүхэд өөрөө ямар нэгэн зүйл сонирхож хийж эхлэх үед нь "магтах" болон "урамшуулах" юм.

Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD) нь 2000 оноос эхлэн 3 жил тутамд 15 насны (ахлах сургуулийн 1-р анги) сурагчдыг хамруулан уншлага, тооны ухаан, шинжлэх ухааны салбарын олон улсын сурлагын амжилтын үзүүлэлтийн харьцуулсан үнэлгээ (PISA)-г хийж байгаа юм. Судалгааны үр дүнгээс харвал хойд Европт байдаг 5,200,000 хүн амтай жижигхэн улс болох Финлянд улс байнга 1-р байранд зогсдог байна. Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагаас тогтоосон зэрэглэлээр Солонгос улс ч гэсэн гайхалтай сайн үзүүлэлттэй гарсан байна. (2000 онд уншлагаар 2-р байр, 2003 онд тооны ухаанаар 3-р байр, 2006 онд уншлагаар 1-р байр, тооны ухаанаар 3-р байр эзэлсэн)

Харин сурч байгаа цаг тус бүрийнх нь сурлагын үзүүлэлтийн түвшингээр авч үзвэл Солонгос улс хамгийн муу байгаа юм. Өөрөөр хэлбэл Солонгос улсын сурагчид сайн дүн авахын тулд хичээл хийхдээ зарцуулсан цаг нь хамгийн их байгаа гэсэн үг юм. 2003 оны судалгааны материалаас харвал Солонгос улсын сурагчдын хичээл хийхэд 1 өдөрт зарцуулж байсан хугацаа нь 8 цаг 55 минут байсан байна. Энэ нь Финлянд (4 цаг 22 минут) улсын сурагчдаас 4 цаг 33 минут, Япон улс (6 цаг 22 минут)-ын сурагчдаас 2 цаг 33 минут илүү хугацаа зарцуулдаг гэсэн үг юм. 1 долоо хоногийн хугацаагаар нь тооцоолоод үзвэл Солонгос улсын сурагчид хичээл хийхдээ Финлянд улсын сурагчдаас 31 цаг 51 минут илүү хугацааг зарцуулж байгаа юм. Финлянд улсын сурагчид бага хугацаа зарцуулсан ч 1-р байранд орон харин эсрэгээрээ Солонгос улсын сурагчид хувийн боловсролдоо маш их мөнгө, цаг хугацаа зарцуулан суралцсан ч дөнгөн данган шагналт байр эзэлж байгаа юм. Бас нэг том ялгаатай зүйл нь юу гэвэл Финлянд улсын сурагчдын суралцах сонирхол, хүсэл эрмэлзэл нь маш өндөр байсан бөгөөд харин Солонгос улсын сурагчдын байдал үүний эсрэг байсан бөгөөд эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын 41 орны дотроос сурагчдын суралцах сонирхлын үзүүлэлтээрээ 31-д, хүсэл эрмэлзлийн түвшингээрээ 38-р байранд бичигдэн хамгийн муу үзүүлэлттэй гарсан байна. (2003 оны PISA тооны ухааны салбар)

Тэгвэл Солонгос улсын сурагчид шагналт байранд орохын тулд Финлянд улсын сурагчдаас 2 дахин их цаг хугацааг хичээл ном хийхэд зарцуулж байгаа бодит байдлыг юу гэж ойлгох вэ?

Энэ байдлыг дүгнэвэл хичээлийн чанар, үр дүн муудсан гэж хэлж болно. Үүний нэг бодит жишээ нь 2008 онд дэлхийн өндөр хөгжилтэй 30 (OECD) орныг хамруулан сургалтын үр дүн болон үзүүлэлтийн талаар судалгаа хийсэн бөгөөд Солонгос улс 24-р байранд бичигдсэн байна. Хичээл хийхэд маш их цаг хугацаа зарцуулдаг ч сурагч биш багш төвт цээжлүүлж сургах боловсролын аргыг Солонгос улс ашигладаг учраас сурагчид өөрөө бие даан асуудал шийдвэрлэх чадвартай болж чаддаггүй байна. Солонгос улсын боловсролын үнэлгээний газраас Сөүлийн бүс нутгийн дунд сургуулийн 700 орчим сурагчдыг хамруулан хийсэн судалгаанаас харвал хичээлийн агуулгаа сайн ойлгодог сурагчид 30 хувиас ч хэтрэхгүй байсан байна.

Хүмүүнлэгийн ухааны сургуулийн ахлах сургуулийн 1-р ангийн сурагч хүүгийнхээ хичээл хийдэг цагийг жишээ аваад үзье. Жирийн өдрийн хувьд өглөөний 7 цагт хичээлдээ яван 1 цагийн хугацаанд бие даан суралцан 8 цагаас үндсэн хичээл нь эхлэдэг. Үдээс хойш 5 цагийн үед үндсэн хичээл нь дуусдаг бөгөөд оройн хоол идээд үргэлжлүүлэн оройн 10 цаг хүртэл бие даан хичээлээ хийдэг. Ингээд гэртээ ирсээр байтал оройн 11 цаг болдог. Жирийн өдрүүдийн нэг өдөр хичээлээс гадуур тооны хичээлд суудаг бөгөөд үүрийн 1 цагийн үед гэртээ ирдэг. Яаж ч бодсон хэтэрхий их хичээл хийж байгаа юм. Ингэж их хичээл хийвэл толгой тархи хэтэрхий их ажиллан хэвийн ажиллаж байгаа эсэхэд ч санаа зовмоор санагдана.

Гэтэл манай эхнэр “Манайх хүүхдийнхээ хувийн боловсролд бага анхаарч байна хүүхдийн маань хичээл хийх цаг бага байна” гэж ярьдаг. Уг нь хүү маань өөрөө хүссэн учраас хичээлээс гадуур тооны хичээл заалгаж байгаа юм. Гэтэл хүү маань угаасаа амралтын өдрөөс бусад өдөр амьсгаа авах ч завгүй сургууль дээрээ хичээлээ хийдэг. Ингэж хүүхдээ бүтэн өдрийн турш ширээнээс нь уян шаргуу хичээл хийлгэснээр сурлагын дүн нь үнэхээр сайжрах эсэх, бусад хүмүүс хийж байгаа болохоор дагаж хийхээс өөр аргагүй болж байгаа эсэх, хүүхдүүдийнхээ сурлагын үзүүлэлтээр өрсөлдөж байгаа эцэг эхчүүдийн энэхүү буруутай үйл ажиллагаанд үнэхээр үр дүн байгаа эсэхийг бид сайтар тунгаан бодон эргэн нэг харах шаардлагатай болсон гэж бодож байна. Тиймээс хүүхдийг хэтэрхий их шахаж шаардан сургаж байгаа өнөөгийн боловсролын арга барил, тухайлбал боловсролын бүтээмжийн тал дээр ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай байна.

Маш их цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулан суралцаж байгаа ч үр дүн муутай байгаа учир шалтгаан нь хүүхдэд сурах сонирхол, хүсэл эрмэлзэл бага байгаа учраас юм. Тэгвэл Солонгос улсын сурагчдын сурах сонирхол, хүсэл эрмэлзэл нь Финлянд улсын сурагчдаас муу байгаа учир шалтгаан нь юу юм бол?

- Финлянд улсын ахлах сургууль болон их сургуульд сурагчдыг сурлагын дүнгээр нь ангилсан шугам гэх зүйл байдаггүй. Мөн элсэлтийн өрсөлдөөн, хувийн боловсрол гэсэн зүйл байдаггүй учраас сурагчид сургуульд сурахдаа дуртай сонирхолтой байдаг.

- Финлянд улс хувь хүн хоорондын өрсөлдөөнөөс илүүтэйгээр багаар ажиллан хамтран суралцах байдлыг илүүд үздэг. Багаар суралцах нь янз бүрийн түвшний сурагчид хоорондоо туршлага солилцон хамтдаа сурлагын түвшнээ нэмэгдүүлдэг сайн үр дүнтэй зүйл юм.

- Финлянд улс сурлагын дүн хэмээх хэрэгслээр сурагчдыг 1-р түвшнээс нь эхлэн хамгийн сүүл хүртэл нь шугам тавин жагсаадаггүй. Яагаад гэвэл сурагчдыг сурлагын дүнгээр жагсаах

нь хор шар, хэрүүл маргаан үүсгэхээс цаашгүй үр дүнгүй ажил бөгөөд сурагч нэг бүрийн хийхийг хүсэж байгаа зүйл юу болохыг тодорхойлон бүтээлч чанарыг нь сайжруулахыг өрсөлдөөнөөр дамжуулан суралцахаас илүү үр дүнтэй зүйл гэж үздэг.

- Финлянд улс хичээлийн төрөл онцлогоос шалтгаалан цагийн хувьд уян хатан хичээлийн цогц системийг боловсролдоо ашигладаг. Хичээлийн 1 жилийг 5 семестрт хуваан семестр тус бүрд судлах хичээлийн тоог багасгадаг. Энэ нь хичээлийн агуулгыг ойлгох хувийг нэмэгдүүлэхийн тулд юм.

- Боловсрол олгох аргын тал дээр ч ихээхэн ялгаатай байдаг. Жишээлбэл тооны хичээлийн нэмэх үйлдлийн талаар зааж байна гэж бодъё. Солонгос улсын тухайд сурагчдад 2+7= ... тэнцүү хэд вэ гэх маягаар хичээл заадаг. Үүний зөв хариулт нь 9 юм. Финлянд улсын тухайд .... + ... = 9 хэлбэрийн асуулт тавьдаг. Ийм төрлийн асуултын зөв хариулт 1 болон 8, 2 болон 7, 3 болон 6 гэх мэт янз бүр байдаг. Асуултын зөв хариулт зөвхөн нэг л байгаа гэсэн бодол болон асуултын хариулт олон янз байгаа гэсэн бодлын хооронд асар том ялгаа байдаг.

Солонгос улсын боловсролын үнэлгээний хорооны Хун Ми Ён докторын баг 2009 онд Солонгос болон Финлянд, Австрали гэх мэт 3-н орны дунд сургуулиар аялан судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнгээс харвал Солонгос улсын сурагчид “Хичээлийн явцад багшаасаа асуулт асуух хувь” нь хамгийн бага буюу 24 хувь байсан байна. Харин эсрэгээрээ нэг анги нь 20-с хэтрэхгүй тооны сурагчтай Финлянд улсын тухайд сурагчид хичээлийн явцад багшдаа тасралтгүй асуулт тавин хоорондоо ярилцах байдлаар хичээллэдэг болохыг мэдсэн байна. Энэ ялгаатай байдал л бүтээлч чадвар бүхий боловсон хүчнийг бий болгож байгаа Финлянд улсын боловсролын нууц юм.

Ахлах сургуулийн 2-р ангидаа Финлянд улсад суралцахаар ирэн 1 жилийн хугацаанд амьдран тодорхой хэмжээгээр туршлага сууж байгаа Япон эмэгтэй Жискава Маюү /23 нас/-гийн ярианд анхаарлаа хандуулцгаая. “Японд байхад надад зөвхөн ганцхан сурах арга барил байсан. Энэ бол бүх зүйлийг цээжлэх. Шалгалт нүүрний өмнө тулаад ирвэл номын агуулгыг бүхэлд нь автоматаар цээжлэн шалгалт өнгөрвөл толгойд юу ч үлддэггүй бүгдийг мартчихдаг байсан. Намайг дунд ахлах сургууль суралцах үед ч энэ зүйл давтагдсаар байсан. Харин Финлянд улсын тухайд шалгалтын өмнө сургууль дээр найз нар маань зузаан ном тэврэн ирж очицгоож байв. “Ямар нэгэн зүйлд хэрэглэх гэж байгаа юмуу?” гэж асуувал “Өнөөдөр хичээлийн цаг дээр шалгалттай учраас унших ёстой” гэж хариулсан юм. Финлянд улс сурагчдаас шалгалт авахдаа эссэ бичүүлэн шалгалт авдаг. Англи хэл, эх хэлний шалгалтыг ийм арга барилаар авах нь мэдээж бөгөөд хими, биологи, хөгжмийн хичээлийн шалгалтыг ч гэсэн сурагч өөрийн бодол санаагаа илэрхийлэн бичих аргаар авдаг. Энэ бол Финлянд улсын ахлах сургуулийн шалгалт авах энгийн арга барил юм. (Финлянд улсын боловсролын нууцаас)

Сэтгэл судлаачид хүн өөрөө дурлан хийж байгаа ажил болон бусад хүн хийлгэж байгаа учраас хийж байгаа ажил юмуу ямар нэгэн ашиг олохын тулд хийж байгаа ажлын үр дүн тэнгэр газар шиг ялгаатай байдаг гэж хэлж байна. Хүн өөрөө чин сэтгэлээсээ хийхийг хүсэн хийж байгаа ажлын тухайд тогтвортой удаан хугацаагаар үргэлжилдэг бөгөөд хүн тэр ажилдаа төвлөрөх чадвар нь ч гайхалтай сайн байдаг. Хүний тэсвэр тэвчээр болон тухайн хийж буй ажилдаа төвлөрөх чадвар гадаад хүчин зүйлээс шалтгаалан үүсдэг зүйл биш хүний дотоод

сэдэл, хүсэл эрмэлзлээс үүсдэг зүйл гэдгийг мэргэжилтнүүд нэгэн дуугаар хэлж байна.

Гэтэл Солонгос улсын сурагчид гадаад хүчин зүйлээс хамааралтайгаар суралцах хандлагатай байгаа юм. Суралцахын мөн чанарыг ойлгон үүнд анхаарал хандуулахаас илүүтэйгээр түүний араас ирэх ашиг орлогод хамаг анхаарлаа хандуулж байна. Эцэг эхчүүд ч гэсэн бага наснаас нь эхлэн “Энэ удаагийн шалгалтанд 90-с дээш оноо авч чадвал тоглоом авч өгье” гэх маягаар хандан хүүхдийг буруу ойлголттой бие хүн болгон хүмүүжүүлж байна. Тиймээс зөвхөн ашиг бодон хичээл ном хийж байгаа хүүхдээс төвлөрөх чадвар, ямар нэгэн зүйлийг тууштай тогтмол хийх тэсвэр хатуужилтай байдлыг олж харна гэдэг хэцүү юм.

Хүний юу хийж чадах, юу хийхийг хүсэж байгааг нь зөв тодорхойлоход “магтах” болон “урамшуулах”-аас илүү сайн арга байдаггүй. “Магтаал нь халимыг ч бүжиглүүлж чаддаг” гэсэн үг байдаг шиг хүүхдийнхээ сайн талыг олж харан үе үе магтаж урамшуулах нь хүүхэд өөрийгөө таньж мэдэн хүсэл мөрөөдлөө биелүүлэхэд ихээхэн тус нэмэр болдог. Хүүхдийг урамшуулах магтахаас илүү чухал зүйл юм. Магтаал нь ажлын үр дүн сайн байх юмуу ямар нэгэн зүйлийг сайн хийсэн үед “Сайн байна” гэсэн үнэлгээ өгдөг зүйл бол харин урамшуулал нь ямар нэгэн зүйлийг муу юмуу жаахан дутуу хийсэн үед ч сайн байсан гэж сэтгэл санаагаар дэмжин урам зориг, өөртөө итгэх итгэлийг нь бий болгож өгдөг зүйл юм. “Чи маш их хичээсэн болохоор зүгээрээ. Битгий бууж өгөөрэй. Дараагийн удаа чи улам сайн байж чадна. Бүх хүчээ дайчилсан ч сайн дүн авч чадаагүй болохоор жаахан хэцүү байгаа биз. Гэхдээ зүгээрээ. Хичээнгүй хийгээд л байвал нэг л өдөр чи хүсэж байгаа зүйлдээ хүрч чадна” гэх мэтээр үр дүнгээс илүүтэйгээр хүүхдийнхээ хичээл зүтгэлд анхааран хүүхдээ урамшуулах нь хүүхэд хүнд хэцүү зүйлд шантран сэтгэл санаагаар унасан үед нь дахин сэргээн асааж өгдөг чухал хөдөлгөх хүч болдог.

Эйнштэн дунд сургууль хүртлээ “Ямар ч хичээл хийсэн амжилт гаргаж чадахгүй” гэсэн үнэлгээг багш нараасаа байнга авдаг байжээ. Гэвч түүний ээж нь шантралгүйгээр түүнийг байнга магтаж урамшуулж байсан байна. Хүү нь хүнд хэцүү зүйлтэй тулгаран сэтгэл санаагаар унах үед “Чи бусдаас өөр гайхалтай авъяас чадвартай учраас алдартай хүн болно” гэсэн үгээр байнга урамшуулдаг байсан бөгөөд эцэст нь хүүгийнх нь тооны ухааны чадвар гайхалтай сайжирсан бөгөөд 20-р зууны шилдэг физикч болж чадсан юм.

Сүүлийн үед бидний хүүхдүүд хэтэрхий эрх танхил, сайн орчинд өсөж торниж байгаа болоод ч тэрүү өчүүхэн хэцүү зүйл тохиолдоход л амархан эмзэглэн шантарч бууж өгөх тохиолдол их болж байна. Сэтгэл зүйн хувьд маш сул дорой болж байгаа бөгөөд амьдралд нь өчүүхэн хэцүү зүйл тохиолдох төдийд өөрийгөө гаргуунд нь хаях юмуу бүр хүнд хэцүү зүйл тохиолдвол амь насаа хорлох тохиолдол ч улам ихсэж байна. Тиймээс ийм сул дорой байдалтай байгаа хүүхдүүдэд эцэг эхийн нөлөө юу юунаас илүү чухал юм. Бага зэргийн алдаа дутагдал, сул талыг нь хараад байнга загнаж зэмлэн шүүмжлэлтэй хандах нь хүүхэд зөв өсөж торниход огтхон ч тус болдоггүй. Еврей хүмүүсийн тухайд хүүхдийнхээ сул талаас илүүтэйгээр давуу талыг нь олж харан түүнийг нь хөгжүүлэхийн тулд бүхий л хүчээ дайчилдаг. Өөрөөр хэлвэл хүүхдээ загнаж зэмлэн шүүмжлэхээсээ илүүтэйгээр магтаж урамшуулах маягаар өсгөдөг гэсэн үг юм.

Бид үүний өмнө Финлянд улсын боловсролын талаар уншсан. Харин АНУ-ын Еврей гаралтай сурагчид цагаан арьстан юмуу хар арьстан хүмүүстэй харьцуулахад сурлагын дүн нь

гайхалтай сайн байдаг. Учир нь Еврей сурагчид юу хийх талаарх хүсэл эрмэлзэл нь тодорхой байдаг учраас юм. Еврей сурагчдын боловсрол эзэмших ёстой гэсэн хүсэл эрмэлзэл, бодол санаа нь бусдаас өөр бөгөөд гэр бүл болон хамт олон хоорондын харилцаа холбоог чухалчилдаг сэтгэлгээнийхээ ачаар хичээл зүтгэл болон тэсвэр тэвчээрийн хувьд бусад орны сурагчдаас илүү байдаг гэж АНУ-ын сэтгэл судлаач Ричард Нисбэтт (Richard Nisbett-Мичиганий их сургууль) багш өөрийн хийсэн судалгааныхаа үр дүнгээр тодорхойлсон байна.

Тиймээс Солонгос орны маань сурагчид ч гэсэн яг одооноос эхлэн ирээдүйд юу хийхийг хүсэж байгаагаа зөв тодорхойлон түүндээ чин сэтгэлээсээ хандан суралцах байдлаар дамжуулан сурлагынхаа түвшинг сайжруулах хэрэгтэй байгаа юм. Хүүхэд үнэхээр өөрийн хийхийг хүсэж байгаа зүйлээ тодорхойлон өмнөө зорилго тавин баяр хөөртэйгээр суралцах үед төвлөрөх чадвар сайжран амжилт гаргах хувь нь ч нэмэгддэг. Тиймээс эцэг эхчүүд маань хүүхэддээ хичээлээс гадуурх боловсрол олгох тал дээр анхаарахаасаа илүүтэйгээр яагаад боловсрол эзэмших хэрэгтэй талаар хүүхэддээ сайн ойлгуулах нь чухал юм. Хичээл ном хийх нь хүн өмнөө тавьсан зорилгоо биелүүлэхийн тулд заавал хийн даван туулах ёстой амьдралын явц гэдгийг хүүхэддээ сайн ойлгуулах хэрэгтэй гэсэн үг юм.

Үүний тулд хүүхэд өөрийн чадвар, зан чанарт тохируулан зорилгоо нарийн тодорхойлоход нь эцэг эхчүүд удирдан чиглүүлэх үүрэгтэй. “Би ч гэсэн ийм хүн болохыг хүсэж байна” гэсэн ухамсартай болтол нь янз бүрийн агуу хүмүүсийн хувийн түүх намтрын талаар уншуулан шаардлагатай бол холбогдох салбарын мэргэжилтнүүдтэй хүртэл уулзуулж өгвөл маш үр дүнтэй. Хүүхэд зорилгоо зөв тодорхойлон юу хийхээ шийдсэн бол богино, дунд, урт хугацааны хэрэгжүүлэх төлөвлөгөөг нарийвчлан боловсруулахад нь мөн туслах хэрэгтэй. Мөн хүүхэд өөрийн боловсруулсан төлөвлөгөөгөө гэр бүлийн гишүүддээ хэлэх юмуу цаасан дээр бичээд өдөр болгон түүнийгээ харах нь сайн юм.

Цаг зав гарган хүүхэдтэйгээ хамт тоглон бүтээлч чадварын гол цөм болох баруун тархийг нь хөгжүүлэх

Сайн тоглодог хүүхдийн толгой сайн байдаг гэдгийг шинжлэх ухаанаар батлаад байна. Хүний баруун тархи бүтээлч чадвар, шууд ухаарах чадвар гэх мэт мэдрэхүйн үйл ажиллагааг хариуцдаг бөгөөд харин зүүн тархи хэлний чадвар, ямар нэгэн зүйлд дүн шинжилгээ хийх чадвар гэх мэт тунгаан бодох үйл ажиллагааг хариуцдаг. Харин хүний зүүн тархи болон баруун тархины хөгжлийн үе шатанд ялгаа байдаг. 7 нас хүртэл хүний баруун тархи хөгжин түүнээс хойш зүүн тархи хөгжиж эхэлдэг. Тиймээс хүүхдийн тархины хөгжлийн үе шатанд тохируулан тархийг нь тэнцвэртэй хөгжүүлэх чухал юм. Гэтэл Солонгос улсын залуу эцэг эхчүүд баруун тархийг нь хөгжүүлэх ёстой 3-4 насны хүүхэддээ өөрсдөө биечлэн зааж өгөхөөсөө илүү шинжлэх ухааны аргаар зохиогдсон сургалтын материал тэврүүлэх юмуу тооны ухааны ойлголтыг хүүхдэд заан тооцоолон бодох чадварыг нь хөгжүүлдэг сургалтын материалд хүүхдээ даатгаж орхидог. Ингэж хүүхдийн зүүн тархийг хөгжүүлэх ёстой 7 наснаас нь өмнө шинжлэх ухааны хэрэгсэл болон тооны сурах бичиг зэргийг ашигласнаар хүүхдийн бүтээлч чадвар болон шууд ухаарах чадварыг сайн хөгжүүлж болох үнэ цэнэтэй боломжийг алддаг.

Израйль улсын дипломатч Авивит (Avivit) “Хүн хүүхэд насандаа дурааараа сайн тоглох нь хамгийн сайн хичээл” гэж үздэг нэгэн юм. Тиймээс цэцэрлэгт бичих, унших гэх мэт үндсэн хичээлийн цаг дуусвал үлдсэн цагт нь хүүхдүүдийг аль болох сайн тоглуулж байх хэрэгтэй гэж хэлсэн байна. Ер нь хүүхэд гэдэг амьтан тоглох маш дуртай байдаг. Гэрийнхээ ойр тоглоомын талбайд хувцас хунараа бохир заваан болтол нь шороотой холилдон тоглож байгаад гэртээ орж ирээд үргэлжлүүлэн хоол хийж тоглох, хүүхэлдэйгээр тоглох гэх мэтээр янз бүрээр тоглодог. Хоол хийж тоглох юмуу шороогоор тоглох нь хүүхдийн бүтээлч чадварыг сайжруулдаг хамгийн шилдэг сургалтын материал юм. Мэдээж гайхалтай сайхан хоол хийж элсэн даланг гайхалтай сайхан барих нь чухал биш. Хүүхэд адилхан материал ашиглан өөрийн хувийн зан чанарыг илэрхийлсэн олон янзын зүйл хийх нь чухал юм.

Еврей хүмүүс хүүхдийн анхан шатны боловсролыг хамгийн их чухалчилдаг. Солонгос хүмүүс шиг ганц хоёрхон үг суран дөнгөж хэлд орж эхэлж байгаа хүүхэддээ сурах бичиг тэврүүлээд хаячихаж болохгүй. Хүүхэддээ ном уншиж өгөн хамтдаа сайн тоглож байх нь хүүхдийн боловсролын үндэс суурийг зөв тавьж өгдөг. Хүний тархи судлаачдын (физиологч) хийсэн судалгаагаар хүний тархины 70-80 хувь 3 нас хүртэл хөгждөг болохыг тогтоосон байна. Энэ үе бол хүүхэд цэцэрлэгт явахаас өмнөх үе бөгөөд бүх зүйлийг эцэг эхээсээ суралцдаг үе юм.

Хүүхдийг тоглуулахдаа ч гэсэн тархины хөгжлийн үе шатанд нь таарч тохирсон тоглоомоор тоглуулах хэрэгтэй. Эвлүүлдэг тоглоом (Puzzle) юмуу зураг эвлүүлэх, шоо эвлүүлэх, шавраар тоглох, зураг зурах зэрэг нь Еврей хүмүүс бараг өдөр болгон хүүхэдтэйгээ хамт тоглодог гол тоглоомын төрлүүд юм. Хүүхэд эцэг эхийнхээ хэн нэгэнтэй хамт тогтмол тоглон хоорондоо ярилцсанаар байнга шинэ зүйлийг суралцаж байдаг. Еврей хүмүүс тооны ухаан, шинжлэх ухаан гэх мэт ур чадвар шаардсан боловсролыг хүүхдээ 3 нас хүрэхээс нь өмнө огтхон ч заадаггүй. Мөн дөнгөж хөлд орон ганц хоёр алхаж эхэлж байгаа хүүхэддээ төгөлдөр хуур юмуу хийл хөгжмийн хичээл заахынхаа оронд янз бүрийн хөгжим сонсгодог. Янз бүрийн

тооны ухааны ном сурах бичиг хүүхэддээ тэврүүлэхийн оронд зураг болон тоглоомоор дамжуулан хүүхэддээ тооны ухааны талаар зааж өгдөг.

Хүүхэдтэйгээ хамт тоглохыг маш их чухалчилдаг шигээ мөн тоглох зүйлд нь ихээхэн анхаарал хандуулдаг. Зөвхөн хүүхдийн сурах чадварыг нь сайжруулах зорилго бүхий хэтэрхий их авъяас чадвар шаардсан тоглоомын хэрэгсэл ашиглахаас зайлсхийдэг. Эсрэгээрээ толь юмуу шил, хайрцаг гэх мэт энгийн ахуйн эд зүйлийг хүүхдэд сэтгэл хөдлөл, цочролыг бий болгож өгдөг хамгийн сайн тоглоомын хэрэгсэл гэж үздэг. Еврей гэр бүлээс Солонгос улсын гэр бүлд байдаг шиг гэр бүл болж тоглодог багц тоглоом юмуу алсын удирдлагатай машин, галт тэрэг гэх мэт боловсронгуй тоглоомнуудыг олж харах бараг боломжгүй. Гэхдээ Еврей хүмүүс шинжлэх ухаан техникийн боловсролыг ихэд чухалчлан хүүхэддээ компьютерын тоглоом нилээн эрт авч өгдөг. Энэ нь компьютерын тоглоомоор дамжуулан хүүхдээ компьютерт дасгахын тулд бөгөөд мэдээж компьютер ашиглах цагт нь хязгаар тавьдаг.

Бага наснаас нь эхлэн хүүхдийн зүүн тархины хөгжилд анхаарснаар суралцах чадвар нь сайжирдаг гэж ойлгож болохгүй. Харин ч эсрэгээрээ сургуульд орон зүүн тархиа хөгжүүлж эхлэх хэрэгтэй үе нь болоход хүүхдийн сурах сонирхол буурах амархан байдаг. Тиймээс хүүхдийн баруун тархины хөгжилд анхааран хөгжүүлэх хэрэгтэй үе болох 7 наснаас нь өмнө хүүхэд өөрөө дурааараа үсэрч харайн тоглож наадан бүтээлч чадвар болон шууд ухаарах чадвараа сайжруулахад нь эцэг эхчүүд хамгийн сайн туслах хэрэгтэй.

Англи улсын шинжлэх ухааны сургалтын төв (NSLC)-ийн Миранда Стивенсон (Miranda Stephenson) доктор Солонгос улсын сурагчид олон улсын сурлагын амжилтын үзүүлэлтийн харьцуулсан үнэлгээнээс тооны ухаан, шинжлэх ухааны хичээлийн төрөлд сайн үнэлгээ авдаг ч бүтээлч чадвар муу байдаг учир шалтгааныг “Тоглох цаг нь дутмаг байдаг учраас” гэж хэлсэн байна. Өөрөөр хэлвэл Солонгос сурагчид үүр цайхаас эхлэн шөнө болтол сургууль юмуу курс дамжааныхаа байранд байнга хичээллэн сурлагын дүнгийн өрсөлдөөнд улайран суралцдаг учраас төсөөлөн бодох чадвараа хөгжүүлэх орчин байдаггүй гэсэн үг юм.

Тоглох нь мэдлэгийг өөрчлөн шинэ ойлголтыг бий болгодог хүч юм. Пенциллин(Penicillin)-ийг нээсэн Нобелийн шагналт Александр Флеминг (Alexander Fleming) зөвхөн эрдэмтний амьдралаар амьдраад зогсохгүй буудлага, гольф, биллиард, покер, ширээний теннис гэх мэт олон төрлийн спортоор хичээллэдэг нэгэн байсан юм. Тэрээр тоглоом наадамд идэвхитэй нэгэн байсан бөгөөд түүнээсээ баяр баяслыг мэдэрдэг байв. Жишээлбэл тэрээр гольф тоглох үедээ зөвхөн 1 цохиураар л 18 нүхэнд бөмбөг оруулдаг байсан бөгөөд цохиураа заримдаа билиардын цохиур шиг атган тоглодог байсан байна. Мөн тэрээр ажил хийхдээ ч ялгаагүй баяр баяслыг мэдэрдэг нэгэн байсан юм.

Тэрээр “Би бичил биетнүүдээр тоглодог. Миний энэ тоглоомонд маш олон дүрэм журам байдаг. Харин хэдий хэр энэ тоглоомонд дасна тэр хэмжээгээр дүрэм журмыг ойлгож ухаарч чадахаар болдог бөгөөд энэ бол маш сонирхолтой ажил. Ингэснээр бусад хүмүүсийн бодож ч үзээгүй зүйлийг олж мэдэж чадна” гэж тэрээр хэлсэн байдаг.

Тэгэхээр Флеминг ажилламгаа тоглон, тоглонгоо ажиллаж байсан гэсэн үг юм. Бичил биетнийг судлан удаан хугацааны турш тоглосны үр дүнд Пенциллин(Penicillin) хэмээх гайхалтай зүйлийг нээж чадсан байна. Тэрээр судалгааны ажлаа тоглоом наадам гэж бодон

баяр хөөртэйгээр хийж байсан учраас шинжлэх ухааны салбарт ийнхүү агуу том амжилтанд хүрч чадсан юм.

Цахилгааны инженер мэргэжилтэй АНУ-ын иргэн Элмер Сперри (Elmer Sperry) гэдэг залуу хүүхдүүдийнхээ тоглоомоор тоглож байхдаа “Gyro Compass” /усан онгоц юмуу агаарын онгоцны байршлыг тодорхойлох төхөөрөмж/ төхөөрөмжийг зохион бүтээсэн байна.

Тэрээр “Би эхлээд эргэлдэх хөдөлгөөний (Gyroscope) талаар ойлголттой болохоор номын санд очсон. Гэтэл үүнтэй холбоотой ном, танилцуулгын материалд дээд шатны тооны ухааны талаарх материал маш их байсан. Эдгээр зүйлээс надад тус болох зүйл бараг байгаагүй. Гэтэл нэг талархалтай зүйл нь надад 3 хүүхэд байсан бөгөөд би хүүхдүүддээ тойрон эргэх хөдөлгөөн хийдэг янз бүрийн тоглоом худалдан авч өгдөг байсан. Би тэр тоглоомнуудыг ажиглан хүүхдүүдээсээ илүү их зүйлийг сурч чадсан. Эдгээр тоглоомнууд надад урьд нь мэдэж байсан эргэлдэх хөдөлгөөний хариу үйлдэл хийх хэмжээг тооцоолоход ихээхэн тус болсон” гэж ярьсан байна.

Еврей хүмүүс бол тоглож наадахын чухал чанарыг сайн мэддэг үндэстэн юм. Шашны хууль дүрмээ баримтлан амьдардаг Еврейчүүдийн хүүхдүүд сэтгэл зүйн хувьд маш амар тайван байдаг учир нь бага наснаасаа эхлэн янз бүрийн хичээл номыг хүчээр хийлгүй дурааараа тоглож наадан өссөн байдаг учраас юм. Хүүхдүүд тоглож наадах байдлаар дамжуулан ямар нэгэн дүрэм журманд захирагдан баригдаж байсан сэтгэл хөдлөлөө бусдад ил гарган илэн далангүй ярилцан найз нөхөдтэйгээ зохицон хамт тоглонгоо нийгэмших байдлыг сайн суралцдаг бөгөөд мөн өөрийн бодол санаагаа бусдад чөлөөтэй илэрхийлэх арга барилыг ч давхар суралцдаг. Харин Солонгос хүмүүс шиг бага наснаас нь эхлэн хүүхдийг хэтэрхий их хичээл номоор шахан хүчээр хийлгэх нь хүүхэд зөв хүн чанартай болж төлөвшихөд маш муу нөлөө үзүүлдэг. Учир нь хүүхэд тоглоом наадмаар дамжуулан тухайн үед сурах ёстой чухал зүйлсийг бүгдийг суралцаж чаддаг байна.

Хичээл ном бол холын зайн гүйлт, эцэг эх бол дасгалжуулагч

“Талмуд” номонд “Нэг удаагийн оролдлогоор далайг бий болгох боломжгүй. Эхлээд горхины уснаас эхлэн бага багаар цуглуулах хэрэгтэй гэсэн” үг гардаг. Энэ ертөнцөд гэнэтийн аз таарч зөвхөн нэг удаагийн оролдлогоор далайг бий болгож чадсан хүн байдаггүй биш байдаг. Гэхдээ гэнэтийн аз тохиолдохыг хүсэж хүлээх нь яг л автомашин юмуу нисэх онгоцны осол гэх мэт гэнэтийн муу зүйлээс айн ямар нэгэн зүйл хийж чадалгүй нэг суурин дээрээ байгаад байгаатай ялгаагүй юм. Хүн зөвхөн нэг удаагийн оролдлогоор л агуу том далайг бий болгож чадахгүй. Маш их горхины усыг цуглуулж байж далайг бий болгодог. (Марвин Токаер)

2010 онд Харвардын их сургуулийн хуулийн сургуулийг нийт 589 сурагч төгссөн байна. Төгссөн нийт сурагчдын бараг 1 хувь болох 6 хүнд шилдэг төгсөгчийн нэр хүнд бүхий “Summa Cum Laude” шагналыг өгсөн байна. Район Пак /28 настай, Солонгос нэр нь Пак Ён Жин/ энэхүү шагналыг авсан хамгийн анхны Солонгос хүн болсон юм. Тэгвэл энэхүү шагналыг авч чадсан түүний нууц юу юм бол? Бусад сурагчид шиг бага сургуульд сурч байх үеэсээ эхлэн Харвардын их сургуульд суралцахыг зорилгоо болгон хичээнгүйгээр хичээл номоо хийн сурсны үр дүн юм болов уу? Эсвэл бүх хичээлдээ гайхалтай сайн байсан учраас уу? Гэхдээ түүний хариулт бидний төсөөлж байгаагаас огт өөр байсан юм.

Тэрээр “Хүн бүр өөр өөр авъяас чадвартайгаар хорвоо ертөнцөд мэндэлдэг. Миний хувьд хууль маш энгийн амархан санагддаг боловч бусад зүйл тийм байгаагүй. Хэлний тал дээр надад авъяас байхгүй юм шиг санагддаг. Бид хичээл номыг удаан хугацаагаар шаргуу хийснээр сурлагын дүн сайжирдаг гэж итгэдэг нь маш том алдаа юм. Ямар нэгэн зүйлийг сурахыг би яг л марафон гүйлттэй адилхан зүйл гэж боддог. Марафон гүйлтэнд ялагдаж байгаа хүмүүсийн алдаа бол удаан гүйж байгаадаа биш юм. Харин эсрэгээрээ хэтэрхий хичээн хурдан гүйх нь хамгийн том алдаа юм. Эхэндээ ингэж их хичээвэл эцэст нь сэтгэл зүйн марафон гүйлтийг даван туулах хэрэгтэй чухал үе тулгарахад амархан ядарч туйлдан ялагддаг. Би Амхерст коллежи(Amherst College)-д сурч байхдаа зураг, биологи, гүн ухаан, тооны ухаан гэх мэтийн янз бүрийн хичээлийг чөлөөтэй сонсож суралцан бодол санааныхаа цар хүрээг тэлж байсан маань хуулийн сургуульд сурахад ихээхэн тус нэмэр болсон” гэх хэлсэн байна.

Солонгос улсын сурагчдын сурлагын үзүүлэлт дэлхийн бусад улс орны сурагчидтай харьцуулахад гайхалтай сайн байдаг. Харин их сургуульд ормогцоо сурлагын дүн нь муудан өрсөлдөөнд амархан ялагддаг. АНУ-д амьдардаг Ким Сын Ги докторын АНУ-ын Колумбийн их сургууль (Columbia University)-ийн докторын (Нэр хүндтэй их сургуульд суралцаж буй оюутнуудын талаарх судалгаа) дипломын ажилд бичсэнээр бол АНУ-ын нэр хүндтэй их сургуульд элсэн суралцаж буй Солонгос сурагчдын 44 орчим хувь нь сургуулиа дундаас нь хаядаг байна. Ким доктор мөн АНУ-ын эдийн засгийн сэтгүүл болох “Фортун(Fortune)” сэтгүүлээс сонгон шалгаруулсан 500 томоохон аж ахуй нэгжид ажилладаг Солонгос гаралтай удирдах ажилтнуудын талаар судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнд удирдах албан тушаалд ажиллаж байгаа Солонгос хүмүүсийн эзлэх хувь 0,3 байхад харин Еврей хүмүүсийн эзлэх хувь 41,5 хувь байсан юм. АНУ-д суралцаж буй гадаад иргэдийн дотроос Солонгос улсын иргэд дэлхийд 1, 2-р байранд бичигдэх хэмжээгээр их боловч АНУ-н томоохон компаниудад ажилд орон хүлээн зөвшөөрөгдөх хувь нь маш бага байгаа юм.

Ким доктор үүнийг Солонгос хүмүүс хэтэрхий элсэлт голчилсон боловсролд анхаарал хандуулан хүн чанарын боловсрол юмуу бүтээлч чанарыг өөртөө бий болгож чадаагүй байдаг учраас гэж тайлбарласан байна. Өөрөөр хэлвэл их сургуульд элсэн орох хүртлээ хамаг хүчээ дайчлан суралцаж байгаад их сургуульд ормогцоо хэрхэн суралцахаа мэдэхгүй байдалтай болдог гэсэн үг юм. Их сургууль юмуу докторантурын сургуулийн сургалтын орчин хүнээс өөрөө бие даан суралцах чадварыг шаарддаг. Гэтэл бусдын тогтоосон дүрэм журмын дагуу бусдаас шууд хамааралтайгаар суралцаж байсан сурагчид эцэг эх болон багшийнхаа шахалт, хараа хяналтаас гармагцаа сурах талаар идэвхигүй болон хичээл номоо амархан орхидог.

Солонгос улсад дунд ахлах сургуулийн үед их сургуулийн элсэлтийн өрсөлдөөн маш хатуу ширүүн байдаг учир сурагчдад санаа зовох асуудал маш их байдаг. Хүн байнга сэтгэл зүйгээрээ түгшүүртэй амьдрах үнэхээр зовлонтой асуудал. Тархи толгойгоо сэргээхгүй байнга ажиллуулаад байвал нэг их удаан тэсэхгүй. Солонгос улсын сурагчид ахлах сургууль хүртлээ хичээл номоо маш сайн хийж байгаад их сургуульд ормогцоо хичээл номондоо анхаарахаа байчихдаг.

Боловсролын зөвлөх мэргэжилтэн, түргэвчилсэн боловсролын судалгааны газрын Пак Жэ Вон дарга “Суралцана гэдэг бол урт хугацааны уралдаан тэмцээнд оролцож байгаатай ялгаагүй зүйл болохоор амралтгүйгээр байнга махран зүтгээд байвал барианд орж чадахгүй байх магадлал маш өндөр байдаг” гэж хэлсэн байна. Хичээл номыг богино хугацаагаар тогтмол хийснээр амжилт гаргах магадлал өндөр байдаг. Тиймээс хичээл номыг урт хугацааны тэмцээн наадам гэж бодох хэрэгтэй. Хувь хүн тус бүрийн ялгаа, хичээл тус бүрийн ялгаа, цаг үеийн ялгаа зэргийг харгалзан хэтэрхий их хичээн махран зүтгээд байлгүй өөрийнхөө хүссэнээр байх нь хамгийн сайн юм.

Еврейчүүдийн дунд, ахлах сургуулийн сурагчдын олон улсын сурлагын амжилт болон олимпиадны дүнгийн үзүүлэлт нь Солонгос, Сингапур, Хятад, Вьетнам гэх мэт Азийн орнуудын сурагчидтай харьцуулахад тийм ч сайн байдаггүй. Харин их сургууль юмуу докторантурын сургуульд гаргаж байгаа амжилтын үзүүлэлт нь үнэхээр гайхалтай сайн байдаг. Их сургууль төгссөний дараа хийж буй судалгааны ажлын ололт амжилт нь ч байнга өссөөр байдаг. Одоогоор шинжлэх ухаан, анагаах ухааны салбараас Нобелийн шагнал авсан Солонгос хүн нэг ч байхгүй байхад Еврей хүмүүсийн энэхүү салбараас авсан Нобелийн шагналын хэмжээ нийт шагналын 3/1-г эзэлж байгаа юм. Үүний учир шалтгаан нь Еврей хүмүүс суралцахыг амьдралынхаа турш хийх ёстой урт хугацааны тэмцээн гэж боддогт байгаа юм.

Еврей хүнд боловсрол бол амьдралынх хамгийн чухал зүйл. Тэдэнд хичээл ном хийнэ гэдэг бол зөвхөн сургуульд суралцаж байх үед л хийдэг зүйл биш бүхий л амьдралынх нь турш үргэлжлэх марафон гүйлтийн тэмцээн юм. Марафон гүйлтийн спортонд байдаг нэг үнэн зүйл бол эхлээд хурдан гүйвэл хурдан ядран дундаас нь ухран барианд орж чаддаггүй. Еврей хүмүүс гэрт байгаа номын тавиураа хэзээ ч хоосон байлгах ёсгүй гэж боддог. Учир нь ном бол бүх амьдралынх нь турш хамт байх ёстой эрхэм үнэ цэнэтэй хөрөнгө төдийгүй өөрийн үр хүүхдүүддээ өвлүүлэн үлдээх үнэ цэнэтэй зүйл гэж Еврей хүмүүс боддог. Еврей хүмүүс бага наснаасаа өөрийнхөө хийх дуртай зүйлийг хайж олон өөрөө бие даан суралцах аргыг системтэйгээр суралцсан байдаг. АНУ-ын нэр хүндтэй их сургуулиуд боловсролын арга

барилдаа харилцан ярилцах, хэлэлцэх аргыг голлон ашиглаж байгаа нь Еврей хүмүүсийн боловсролын арга барил онцлогийг илэрхийлж буй нэг тод томруун жишээ юм.

Еврей хүмүүсийн боловсролын бүтээмж, үр дүн хэзээ хойно ихээхэн амжилтыг бий болгож чаддаг учир шалтгаан нь тэд зөвхөн хүүхдийнхээ сурлагын дүнд анхаарал хандуулаад байдаггүй учраас юм. Еврей хүмүүс хүүхдийнхээ хувийн зан чанарт ихээхэн анхаарал хандуулдаг. Хүүхдийнхээ сурлагын дүнд хамаг анхаарлаа хандуулан хүүхдээ шахаж шаардан хэтэрхий их хичээл номоор дараад байдаггүй. Сурлагын дүнгээс илүүтэйгээр боловсролын үнэ цэнийг чухалд тооцон хүүхдээ сурах сонирхол, хүсэл эрмэлзэл, өөртөө итгэх итгэлтэй болгохын тулд маш их хичээдэг. Гэтэл Солонгос хүмүүс хүүхэд нь нэг л удаагийн өрсөлдөөнд ялагдвал бүх амьдралынхаа турш хүнд хэцүү байдалтай болох юм шиг айн зөвхөн хүүхдийнхээ сурлагын дүнд анхаарал хандуулдаг. Энэ байдал нь маш буруу юм. Харин үүний оронд эцэг эхчүүд хүүхдийн өсөлтийн үе шатанд тохируулан хүүхдийнхээ тэсвэр тэвчээр, хийж чадах боломжтой зүйлийг нээж олон түүнийгээ хөгжүүлэхэд нь туслах хэрэгтэй. Эцэг эхчүүд хүүхдийнхээ хувийн зан чанарыг зөв тодорхойлон хүүхэд өөрөө сайн дураараа хичээнгүйлэн суралцдаг болтол нь удирдан чиглүүлж өгөх нь таны хүүхдийг амжилтанд хүргэх гол зүйл юм.

Хүүхэддээ итгэл найдвар өгөн чи ийм байх ёстой гэсэн ямар нэгэн шалгуур тавихгүй байх

Роусси (Rousseau) гэдэг зохиолчийн "Эмил (Emile)" гэдэг зохиолд "Хүүхдийнхээ амьдралыг харанхуй болгох хамгийн шилдэг арга бол хүүхдийнхээ хүссэн юм бүхнийг хийж өгөх" гэсэн үг гардаг. Үнэхээр үр хүүхдээ чин сэтгэлээсээ хайрладаг эцэг эх бол энэ үгийг дотроо сайтар тунгаан бодох хэрэгтэй. Эцэг эх гэсэн байр сууринаас хүүхдийнхээ ирээдүйн амьдралыг өөрсдөө дур мэдэн тодорхойлж түүнд нь шаардлагатай хичээл номыг хүчээр хийлгэх нь хүүхдийнхээ амьдралыг бүрхэг болгох хамгийн дөт зам юм. Хүүхдийнхээ хувийн зан чанарыг зөв тодорхойлон хүүхэд өөрөө ирээдүйн амьдралынхаа төлөвлөгөөг нарийн боловсруулахад туслах нь хүүхдийнхээ аз жаргалтай амьдралын төлөө эцэг эхчүүдийн хийж буй хамгийн сайн зүйл гэдгийг бүү мартаарай.

Олон улс оронд салбар нэгжтэй Солонгос улсын томоохон компаниудын ерөнхий захирлуудын 1 долоо хоногийн цагийн хувиар минут, секундээр хэмжигдэх хэмжээний маш завгүй ачаалалтай байдаг. Амралтын өдөр ч гэсэн бизнесийн харилцагчидтайгаа уулзан гольф тоглох юмуу гадаадад томилолтоор явах гэх мэтээр гэр бүлийнхэнтэйгээ хамт байх цаг хугацааны хувьд үнэхээр хомс байдаг. Харин "Гүүгл Корea (Google Korea)" компаний И Вон Жин (43 нас) захирлын хувьд бол өөр юм. Тэрээр амралтынхаа өдрийг 2 охиндоо зарцуулан ийж тийш явалгүйгээр гэр бүлийнхэнтэйгээ хамт цагийг өнгөрөөдөг.

И Вон Жин захирал боловсролын тухайд хүүхдэд том хүмүүсийн байр суурийг огтхон ч тулгаж болохгүй гэж үздэг. Тэрээр 2 охин нь үнэхээр чин сэтгэлээсээ хийхийг хүсч байгаа зүйл байвал мөнгө сайн олж чадахааргүй ажил байсан ч хамаагүй сайн туслаж дэмжих хэрэгтэй гэж боддог. Мөн хүүхдийн өөрөө хийхийг хүсэн тэмүүлж байгаа чин сэтгэлийг дэмжиж өгөх нь хүүхдийг аз жаргалтай байлгах хамгийн сайн арга гэж тэрээр итгэдэг. Түүний 2 дахь хүүхэд нь бага сургуулийн 4-р ангид сурдаг бөгөөд мөрөөдөл нь тогооч болох юм. Тиймээс амралтын өдрөөр хүүхэдтэйгээ хамт хоолтой холбогдолтой телевизийн хөтөлбөр үздэг байна. Мөн тэрээр хүүхдийнхээ ирээдүйн амьдралд тус болохын тулд Францийн алдартай тогоочийн сургуулиудын талаар ч судлах бодолтой байгаа юм. Хүүхэддээ "Чи хоол сайн хийж суръя гэвэл Францад суралцах хэрэгтэй. Тийм болохоор Франц хэл сурах хэрэгтэй" гэж хэлдэг байна.

Түүний энэхүү бодол амьдралын туршлагаас нь урган гарсан байна. Бусад хүмүүсийн хувьд мэдээлэл технологийн салбарт олон улс оронд салбар нэгжтэй томоохон компаний ажлыг их хүнд хэцүү гэж боддог бол тэрээр энэхүү ажилдаа маш дуртай байдаг. Хүн хийх дуртай ажлаа хийх үед хичнээн их ажилласан ч ядардаггүй гэж тэр боддог.

Солонгос хүмүүсээс хамгийн анх Харвардын их сургуулийн хуулийн сургуулийг шилдэг оноотойгоор (шагналт байрын 1 хувь) төгссөн АНУ-д амьдардаг Район Пак ч "Өөрийн сонирхол, чадварт тааруулан үнэхээр хийхийг хүсч байгаа ажлаа хий" гэж хэлсэн байдаг.

Тэр мөн "Ээж маань үр хүүхдүүддээ маш их анхаарал хандуулдаг байсан ч ямар нэгэн зүйлийг надаар албадан хийлгэдэггүй байсан. Бүр нэг ч удаа ийм тийм курс дамжаанд сур, их сургуульд ор гэж хэлж байсан удаа байхгүй. Харин биднийг ямар нэгэн зүйл хийж эхлэвэл

огтхон ч дундаас нь болиулдаггүй байсан. Бид хийх зүйлээ сонгон эцсийн дүнг нь хүртэл хийлгэх ажлыг ээж маань хариуцдаг байсан. Эцэг эх нь хий гэсэн учраас хийж байгаа биш өөрөө сонгосон болохоор хийх хэрэгтэй гэдгийг бидэнд сайн ойлгуулдаг байсан. Хүүхдээ үнэхээр амжилтанд хүргэхийг хүсвэл эцэг эхчүүд өөрсдийн хүсэж байгаа зүйлийг хүүхэддээ огтхон ч тулган шаардаж болохгүй. Хүн үнэхээр өөрөө чин сэтгэлээсээ хийхийг хүсэхгүй зүйлээ хийх нь зүгээр л амжилтын төлөө улайрч буй шуналаас цаашгүй зүйл юм" гэж хэлсэн байна.

Хүүхдийнхээ хийхийг хүсэж байгаа зүйлийг хийлгэхээс илүү бас нэг чухал зүйл бол сайн хийдэг зүйлийг нь хийлгэх юм. Дэлхийн 2-р дайны баатар болох Англи улсын ерөнхий сайд Винстон Черчиль(Winston Churchill) сургуульд суралцаж байх үедээ бусдад анзаарагдахаар тийм ч онцгой нэгэн байгаагүй юм. Эцэг нь түүнийг бага байхад нас барсан бөгөөд бага насаа нилээн хүнд хэцүү орчинд өнгөрөөсөн байна. Түүний ээж нь ч гэсэн эх хүний үүргээ бүрэн дүүрэн биелүүлж чадаагүй юм. Английн түүх судлаач Жиофри Бэст (Geoffrey Best) Черчилийн хувийн "Хэзээ ч шантрахгүй" гэсэн нэртэй намтарт бичигдсэн эх Жэнигийнх нь талаар "Түүний эх Жэни нь бэлэвсэрснээсээ хойш байнга санхүүгийн асуудалтай тулгарч байсан бөгөөд нийгмийн дээд давхаргын хэд хэдэн хүнтэй хайр дурлалын харилцаа үүсгэж байсан. Өөрөөсөө насаар дүү хүнтэй 2 ч удаа гэрлэн амьдрал зохиосон боловч хайр дурлал нь бүтэлгүйтэн салж байсан" гэж бичсэн байдаг. Түүний ээж ийм байдалтай байсан учраас Черчиль хичээл номондоо шамдан суралцах ямар ч боломжгүй байсан. Тиймээс Черчиль хэл ярианы тал дээр маш муу ярихдаа ээрч түгдэрдэг, дуудлага муутай байсан. Тэрээр Английн хамгийн шилдэг хувийн ахлах сургууль болох Этон (Eton) сургуулийг орхин оронд нь орсон Хэрров (Harrow) сургуульд 3-н жил сурахдаа дандаа шалгалтандаа унадаг байв. Ахлах сургуулиа төгсөөд Сэндхарст (Sandhurst) хуурай замын сургуульд орсон боловч сурлагын дүн муу байсан болохоор явган цэргийн ангийн оронд морьт цэргийн ангид хувиарлагдсан байна.

Гэвч Черчильд нэг тодорхой чадвар байсан юм. Энэ бол түүний бичих чадвар юм. Түүнд ямар нэгэн зүйлийн учир шалтгааныг чөлөөтэй найруулан бичдэг гайхалтай чадвар байсан юм. 1941 онд Черчиль Хэрров (Harrow) сургуулийн төгсөлтийн баяр дээр илтгэл тавихдаа дараах үгийг хэлсэн бөгөөд энэхүү үг нь өнөөг хүртэл хүмүүст хэрэглэгдэж байгаа алдартай үг юм.

"Never give in. Never give in. Never, never, never-in nothing, great or small, large or petty-never give in, except to convictions of honor and good sense. (Хэзээ ч бүү шантар. Хэзээ ч бүү шантар. Хэзээ ч, хэзээ ч, хэзээ ч нэр хүндтэй байсан ч, ялгаварлан гадуурхагдаж байсан ч, бүх зүйл тань гайхалтай сайн байсан ч, хүнд хэцүү зовлон бэрхшээлтэй байсан ч, өчүүхэн нэгэн байсан ч агуу нэгэн байсан ч хэзээ ч битгий бууж өг).

Черчиль цэргийн офицероор томилогдон 1885-1899 онд Куб, Энэтхэг, Өмнөд Африк гэх мэт улсуудын дайнд оролцож байсан бөгөөд тэрээр дайны талбар дээр байлдаж байх үедээ өөрийн авъяас чадварыг ашиглан өдөр тутмын сонинд нийтлэл бичдэг байв. Мөн сонинд бичсэн нийтлэлээсээ санаа аван янз бүрийн ном зохиолч бас бичсэн байна. Түүний гол авъяас болох найруулан бичих чадвар түүнийг олон нийтэд таниулан улс төрч болох үндэс суурь нь болсон юм. Черчильд Нобелийн шагнал өгсөн зүйл бол дэлхийн 2-р дайнд ялсан улс төрийн хүч (энх тайвны шагнал) биш түүний бичсэн "Дэлхийн 2-р дайн" гэсэн ном нь (утга

зохиолын шагнал) байсан юм.

Тэгвэл хувь хүнд төрөлхөөс заяасан авъяас чадварыг нь үл тоомсорлон хүүхдээ бүх хичээл дээр заавал 1-р байранд байх ёстой гэж хүчилдэг Солонгос хүмүүс байсан бол яах байсан бол? Солонгосын боловсролын системийн тухайд системтэй боловсролд анхаарал хандуулан 1-р түвшнээс эхлэн хамгийн муу түвшин хүртэл зэрэглэл тогтоохоос өөр зүйл бараг хийдэггүй. Тиймээс эцэг эхчүүд энэ байдалд зохицуулан өөрийн хүүхдээ ямар ч аргаар хамаагүй бусдаас илүү авъяас чадвартай хүн болгохоор улайран зүтгэдэг. Өнөө үед дэлхий ертөнц маш хурдацтай хөгжиж байгаа ч Солонгос улсын нийгэм нэг л хэвийн боловсролын арга барилаар чанаргүй муу боловсон хүчнийг бэлтгэсээр байгаа юм.

Солонгос хүмүүс мэдээж өөрийн хүүхдээ бусдаас шилдэг нь байж амжилт гаргахыг хүсдэг. Үүний тулд бараг бүгд л хүүхэддээ хувийн боловсрол олгон тусгай сургалттай ахлах сургуульд явуулах гэж хичээдэг. Учир нь хүүхэддээ ийм орчин бүрдүүлж өгснөөр илүү хурдан амжилт гаргаж чадна гэж итгэдэг байна. Гэвч үүний үр дүнд хүүхэд өөрөө бие даан ямар нэгэн зүйл хийх чадваргүй болдог. Эцэг эхийнхээ зааврын дагуу сурч боловсорч байсан хүүхэд насанд хүрсэн хойноо өөрөө бие даан шийдвэр гаргах тал дээр тааруухан болдог. Тиймээс хэрэв та хүүхдээ амжилт гаргахыг хүсэж байгаа бол огтхон ч эцэг эхийн байр суурьнаас хандан хүүхдийнхээ өмнөөс хийх ажил мэргэжил юмуу ирээдүйн амьдралынх нь замыг сонгон хүүхэддээ тулган шаардаж болохгүй. Хүүхэд өөрөө хийхийг хүсэхгүй байгаа зүйлийг хийснээр амжилт гаргана гэдэг бараг боломжгүй зүйл юм.

Еврей хүмүүс хүүхдийнхээ сонголт, шийдвэрийг маш их хүндэтгэж хүүхэдтэйгээ харьцдаг. Тийнхүү хүүхэд нь өөрөө өөртөө эзэн болон өөрийн гэсэн амьдралыг бий болгох хүртэл нь хүүхдээ тэвчээртэйгээр хүлээн ажигладаг. Хүүхдийнхээ сайн хийж чаддаг зүйл юу болохыг сайтар ажиглан олж мэдсэнийхээ дараа хүүхдээ байнга урамшуулан хийж байгаа зүйлд нь туслаж дэмжих ажилд Еврей хүмүүс огтхон ч залхууран хойрго ханддаггүй. Эцэг эхчүүд хүүхэддээ ирээдүйн амьдралынх нь талаар хэлж зөвлөхдөө маш сайн анхаарал хандуулах хэрэгтэй. Ийм тийм юм хийх хэрэгтэй гэх маягаар ямар нэгэн зүйлийг хүүхэддээ тулган шаардах нь маш буруу зүйл юм. Хүүхдэд өөрийнхөө талаар эргэцүүлэн тунгаан бодох боломжийг бүрдүүлж өгөн “Аав ээж хоёр нь ..... гэж бодож байна харин чиний хувьд ямар бодолтой байна?” гэх маягаар хүүхэдтэйгээ сайн харилцан ярилцаж байх хэрэгтэй.

Дэлхийн шилдэг эрэгтэй хувцасны брэндийн нэг болох “Ermenegildo Zegna” нь гэр бүлийн 4 үеэрээ удирдаж ирсэн Италийн компани юм. 2009 оны орлого нь гэхэд Солонгос улсын воноор 1 триллон 200 тэрбум вонд хүрсэн дэлхийн томоохон компани бөгөөд 5 хүн компаний цөм хэсгийг хариуцдаг. Харин захирлууд нь хүүхдүүдээ компаний удирдлагын үйл ажиллагаанд оролцуулахдаа хүүхдүүдийнхээ сонголтонд бүгдийг даатгадаг байна.

Компаний ерөнхий захирлын үеэл дүү болох загвар, дэлгүүрийн захирлын албыг хариуцдаг Анна Зегна (Anna Zegna) “Компаний ажлыг хийхдээ хүн өөрөө сонирхолтой байж чин сэтгэлээсээ хандах хэрэгтэй. Хүн дүргүй хандлагатайгаар ажиллах шиг хамгийн таагүй зүйл байхгүй” гэж хэлсэн байна. Гүн ухаантан Калил Гибрэн (Khalil Gibran) “Ажил бол хувь хүний зорилго, амьдрал бол жинхэнэ бэлэг” гэж хэлсэн байдаг. Эцэг эх гэдэг нумын хөвчийг чангалж өгөх үүрэгтэй хүмүүс бөгөөд ямар бай онохоо шийдэх нь хүүхдийн үүрэг юм.

Бүтээлч чадвар

Бүтээлч чадвар бол амжилтын үр тариа

Хүүхэддээ асуулт их тавих

- Тэвчээртэйгээр хүүхэддээ асуулт тавихад анхаарах -

- Хүүхдээ ямар нэг зүйлийг “бусад хүн шиг сайн хийдэг хүн” биш

“бусдаас өөр хийдэг хүн” болоход нь туслаж дэмжин урамшуулах -

- “Хүүхэд хичээл хийж байгаад нозоорон залхуу нь хүрвэл

босоод өөр зүйл хийж” болохыг зөвшөөрөх-

- Бүтээлч хүүхэд асуудал ихтэй байдаг -

- Цээжлэх чадварын нууц -

- Мэдлэг нь “урлаг” хэмээх нэг талын далавчаа зүүж байж нисэж чаддаг -

- Ирээдүй нь олон талт чадвартай боловсон хүчний эрин үе, хүүхдийнхээ сонирхож буй салбарыг нэмэгдүүлэх -

Тэвчээртэйгээр хүүхэддээ асуулт тавихад анхаарах

Еврей хүмүүс аливаа зүйлд маш сониуч зангаар ханддаг учраас аливаа эд юмсыг бүх талаас нь харахыг хичээдэг. "Еврей" гэсэн үгэнд "Бас өөр нэг талд нь зогсох" гэсэн бас нэг утга ч агуулагддаг. Еврей хүмүүс ер нь асуулт их тавьдаг. Еврей хүнээс ямар нэгэн зүйл асуувал буцаад өөр нэг төрлийн асуулт болон ирэх тохиолдол их байдаг. Бусдаас мэдэхгүй зүйлийнхээ талаар тэвчээртэйгээр нэг бүрчлэн нарийн асууж лавладаггүй хүн амжилтанд хүрч чаддаггүй. (Марвин Токаер)

Асуулт бол хүүхдийн тунгаан бодох чадварыг сайжруулах хамгийн шилдэг арга юм. Хэн нэгнээс асуулт асуувал түүнд хариулахын тулд тунгаан бодох шаардлага бий болдог. Нэгэн сэтгэн бодох чадварын мэргэжилтэн цэцэрлэгийн хүүхдээс

"Тэнд харагдаж байгаа том уул яаж чиний энэ жижигхэн нүдэн дотор багтаж чадаж байгаа юм бол?" гэж асуусан байна.

Гэтэл хүүхэд "Миний нүд ид шидтэй учраас" гэж хариулсан байна.

Сэтгэлгээнийхээ цар хүрээг хязгаарлаагүй хүүхэд байсан учраас энэ асуултанд хариулж чадсан байна. Гэтэл магадгүй хүүхэд ингэж хариулах үед нь "Чиний хариулт буруу. Алслалтын хууль гэж зүйл байдаг учраас ингэж харагдаж байгаа юм" гэх мэтээр хүүхдийн сэтгэн бодох цар хүрээг хязгаарлавал яах бол?

Хүүхэддээ асуулт тавих үедээ жирийн мэдлэг юмуу тогтсон үзэл баримтлалаас бага зэрэг хөндийрөн "Яагаад юм бол?" гэсэн эргэлзээ төрүүлэн бодол санааных нь цар хүрээг тэлэхүйц агуулга бүхий асуулт тавих нь сайн юм. Зөвхөн зөв хариултыг нь олоод болчих асуулт биш холимог учир шалтгаан, үндэслэлийг мэдэж болохуйц асуулт асуух хэрэгтэй. Жишээлбэл "Аюул тулгарсан найзыгаа аврахын тулд худлаа ярих нь сайн зүйл мөн үү?", "Хэн нэгэн усанд унан живж үхэхийн даваан дээр байх үед чи усанд огт сэлж чаддаггүй бол яах вэ?" гэх мэт хүүхдэд олон зүйл бодогдуулах асуулт тавих нь маш сайн юм.

Гэхдээ энэ үед нэг анхаарах хэрэгтэй зүйл гэвэл асуулт асуусан тэр агшинд хүүхэд шууд зөв хариултыг хэлж чадахгүй байх бодит байдлыг хүлээн зөвшөөрөх юм. Ихэнхи хүүхдүүд эцэг эхийнхээ тавьсан иймэрхүү төрлийн асуултыг сонин жигтэй зүйл мэтээр хүлээн авах нь түгээмэл байдаг. Харин хүүхэддээ улам их зүйлийг зааж сургахыг хүсэж байгаа эцэг эхчүүд энэ агшныг тэвчиж чадалгүй хүүхэд рүүгээ уурлаж уцаарладаг. Тэд "Тоглоод байлгүй хурдан хариулж чадахгүй байна уу?" гэх маягаар хүүхэдтэйгээ буруу харьцан уурлаж загнадаг.

"Талмуд" номонд "Зааж байгаа зүйлийг ямар ч утга учиргүйгээр сурч байгаа хүн өөрөө өөрийгөө ялзруулж байгаагаас цаашгүй" гэсэн үг байдаг. Еврей хүмүүс ямар нэгэн зүйлийг ямар ч зорилгогүй утга учиргүйгээр суралцаад байдаггүй. Тэд цав цагаан цаасан дээр зураг зурж байгаа юм шиг сэтгэн бодох цар хүрээгээ хязгаарлаад байлгүй мэдэхгүй чадахгүй зүйлийнхээ талаар бусдаас байнга асууж лавладаг. Жишээ нь "Ингэхэд би зөв бодож байна уу?" "Илүү сайн арга байхгүй юу?" гэх мэтээр. Еврей хүмүүсээс бүтээлч шинэлэг санаа байнга урган гарч байдаг нь тэдний эмх цэгцтэй дахин дахин сайтар тунгаан боддог арга

барилд байгаа юм. Ихэнхи хүмүүсийн нийтлэг сэтгэн бодох арга барил, тогтсон хэв маягаас өөрөөр сэтгэн бодох үед шинэлэг санаа урган гарах магадлал хамгийн өндөр байдаг. Еврей хүмүүс сэтгэн бодох цар хүрээгээ хязгаарлан бусдын бодол санаанд баригдалгүйгээр чөлөөтэйгээр сэтгэн бодож чаддаг учраас гайхалтай амжилтуудыг бий болгосоор байна.

Компьютерийн гол үйлдлийн төхөөрөмж (CPU) үйлдвэрлэдэг “Интел (Intel)”компанийг дэлхийн нэртэй том компани болгож чадсан Еврей гаралтай Америкийн иргэн Эндрю Гроув (Andrew Grove) нь “Кассандра (Cassandra)-гийн хэлсэн үгэнд сайн анхаарах хэрэгтэй” гэсэн үгийг байнга хэрэглэдэг. Кассандра (Cassandra) нь эртний Грекийн домогт гардаг эмэгтэй иш үзүүлэгч бөгөөд “Хүний амьдралд тохиолдох хүнд хэцүү асуудлын талаар урьдчилан хараад иш үзүүлдэг хүн” гэсэн утгатай юм. Иш үзүүлэгч гэдэг нь ямар нэгэн зүйлийн шинж байдлын өөрчлөлтийг бусад хүнээс түрүүлж мэдээд хүмүүст анхааруулга өгдөг хүн юм. Гроув нь уурхайчид уурхайн ухсан нүх рүү орохоосоо өмнө хорт бодис байгаа эсэхийг шалгахын тулд хорт бодисыг мэдэрдэг канари болжморыг нүх рүү урьдчилан оруулдаг шиг компаний ажилчдад ямар нэгэн эрсдэл аюулыг урьдчилан мэдүүлдэг Кассандра (Cassandra) шиг хүн компанид байх хэрэгтэй гэж боддог нэгэн байв.

Мэдээж тэрхүү Кассандра(Cassandra) шиг хүн хэн ч болж болно. Гол нь компанийг бүрдүүлж байгаа ажилчид чөлөөтэй сэтгэн бодож өөрсдийн санал бодлоо илэрхийлж болох уур амьсгал орчинг бүрдүүлж өгөх нь чухал юм. Тиймээс Гроув хичнээн муу мэдээ байсан ч ажилчид өөрийн бодол санаагаа бусдад чөлөөтэй дамжуулан илэрхийлж болох (constructive confrontation) соёлыг бий болгосон юм. Компаний ажилчид бүгд зөв гэж үзэж байгаа зүйлийг ч сайтар нягтлан шалгах, хэн нэгэн бүтэхгүй санал дэвшүүлсэн ч түүнд маш сайн анхаарал хандуулан сонсох хэрэгтэй гэсэн удирдлагын гүн ухааны үзэл баримтлалд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулсны үр дүнд “Интел (Intel)” дэлхийн шилдэг компани болж чадсан юм.

“Талмуд” номонд бичигдсэн Талмуд хэлбэрийн харилцан ярилцах арга барилд тодорхой дүрэм журам байдаг. Энэ бол “Бусдын янз бүрийн санал бодлыг сонсох, янз бүрийн өөр санал бодол дэвшүүлэх, бүгд санал нэгдэх” гэх мэт юм. Еврей хүмүүс бусдын санал бодлыг маш анхааралтай сайн сонсдог бөгөөд магадгүй бусадтай санал бодлын хувьд нийцэхгүй байх үед өөрийн бодол санаагаа бусдад чөлөөтэй илэрхийлж чаддаг нь энэхүү харилцан ярилцах арга барилыг мэддэг учраас юм. Чөлөөтэй сэтгэн бодож бусадтай харилцан ярилцах нь бусдын бодол санаанд баригдалгүй бие даан оновчтой шийдвэр гаргах гол хүч болдог.

Хүүхдээ ямар нэг зүйлийг “бусад хүн шиг сайн хийдэг хүн” биш “бусдаас өөр хийдэг хүн” болоход нь туслаж дэмжин урамшуулах

Кэлвин Клэйн (Calvin Klein) 1942 онд Нью-Йорк хотын Бронкс (Bronx)-ийн ядуучуудын хороололд төрсөн байна. Түүний эцэг Унгар гаралтай Еврей хүн байсан бөгөөд хүнсний дэлгүүр ажиллуулан эх нь жирийн нэг гэрийн эзэгтэй байсан байна. Тэрээр оёдолчин байсан эмээгийнхээ нөлөөгөөр 5 настайгаасаа эхлэн хувцасны загвар зохион бүтээж эхэлсэн бөгөөд эмэгтэй дүүгийнхээ хүүхэлдэйнд хувцас оёж өгсөн байна. Түүний байдал нас чацуу бусад эрэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад маш өөр байсан юм. Тэр “Би 5 нас хүрээд өөрийгөө хувцас загвар зохион бүтээгч болохыг хүсэж байгаагаа ухаарсан. Тэр үеэс цаасан дээр янз бүрийн хувцасны загвар зохион бүтээн зурж эхэлсэн бөгөөд ээж маань миний загвар өмсөгч байсан. Ээж маань байнга цагаан өнгийн хувцас өмсдөг байсан. Би өнөөг хүртэл цагаан өнгөнд дуртай байдаг шалтгаан энэ юм” гэж хэлсэн байна. Ахлах сургуульд элсэн орсон ч Кэлвин Клэйн (Calvin Klein)-ий эмэгтэй хүний хувцасны загвар зохион бүтээх сонирхол нь огтхон ч өөрчлөгдөөгүй юм. Гэвч эцэг эх нь түүний энэ байдалд санаа зовохынхоо оронд харин түүнийг дэмжин Манхэттэн(Manhattan)-ий дизайны сургуульд элсэж ороход нь тусалсан байна.

Дэлхийн нэрт кино найруулагч Стивен Спилберг (Steven Spielberg) бага байхдаа нэг их хүмүүст анзаарагдаад байхааргүй хүүхэд байсан юм. Харин түүний дэлхий ертөнц болон эд зүйлийн талаарх сониуч зан нь маш хүчтэй байсан байна. Түүний эх Спилбергийг Еврейчүүд амьдардаг газар биш Христийн шашинтай хүмүүсийн амьдардаг газарт өсгөсөн байна. Ээж нь түүнийг сургуульдаа явмааргүй байна гэвэл хүүхдээ өвдсөн гэсэн хуурамч бичиг хүртэл үйлдэн сургууль руу нь явуулж байсан бөгөөд Спилбергийн бага байхдаа хийсэн кинонд жүжигчнээр дуртайяа тоглосон байна. Түүний ээж эхлээд хүүхдүүдийнхээ яриаг сайтар сонсон зөв гэж бодвол хийхийг хүссэн бүхнийг нь зөвшөөрдөг байв. Түүний ээж хүүхдүүд нь үнэхээр их сонирхож байгаа зүйлд эцэг эх сайтар анхаарал хандуулах хэрэгтэй бөгөөд хичээл сурлагын дүнтэй нь зууралдахаас илүүтэйгээр хүүхдийнх нь сонирхлыг татан бүхий л амьдралынх нь турш аз жаргалтай байлгаж чадах зүйлийг хүүхэддээ олж өгөх хэрэгтэй гэж боддог нэгэн байв.

Түүний ээж “Үнэнийг хэлэхэд би нэг ч удаа жинхэнэ ээж шиг байсан удаа байхгүй. Хүүгийнхээ хийхийг хүсэж байгаа зүйлийг сайн сонсох хэрэгтэй гэхээс өөр бодол надад бараг байгаагүй. Гэвч би үүнийг хүүгийнхээ шинэ зүйлийг хийж бүтээх чадварыг бий болгох хамгийн сайн арга гэдэгт итгэлтэй байсан” гэж хэлсэн байдаг.

Түүний ээж эх хүний хийх ёстой зүйлийг орхисон өвөрмөц хүн байсан боловч бусдаас нэг ялгаатай тал нь хүүгийнхээ хийхийг хүссэн зүйлийг бүгдийг хүлээн зөвшөөрдөг байсан ба түүний боловсролын энэхүү өвөрмөц арга барил нь Спилбергийн бүтээлч сэтгэн бодох чадварыг сайн хөгжүүлж чадсан юм. Спилберг нэг ярилцлагандаа “Миний яриаг сонирхон сонсож надтай харилцан ярилцаж байнга хажууд маань байж чадах хүн бол зөвхөн ээж минь гэж бодож байна” гэж хэлсэн байна.

Түүний эцэг ч мөн ялгаагүй хүүхдийнхээ боловсролд их анхаардаг нэгэн байсан юм. Тэрээр нэг өдөр орой тэнгэрт од харвана гэсэн цаг уурын мэдээг сонссоныхоо дараа 13 настай

хүүгээ дагуулан элсэн цөл рүү явсан байна. Элсэн цөлд очоод гудас дэвсэн хүүтэйгээ хамт хэвтэн тэнгэр лүү харж байтал үнэхээр тэнгэрт од харвасан байна. Тэр өдөр харсан энэ зүйл 5 жилийн дараа Спилбергийн анхны кино болох “Галын дөл” кино болон бодит амьдрал дээр биеллээ олсон бөгөөд шинжлэх ухааны зөгнөлт (SF-Science Fiction) кино болох “Ирээдүйтэй урьдчилан уулзах” киногоо бүтээх үндэс суурь ч болсон байна. Түүний эцэг дотроо хүүгээ инженер болгохыг хүсэж байсан ч 8 мм-ийн камерт сонирхол нь хөтлөгдөж байгааг хараад хүүгийнхээ хүсэл сонирхлыг хорьж цагдаагүй юм. Харин тэрээр Солонгос хүмүүс шиг хүүхдийнхээ хувийн зан чанарыг сайжруулахаас илүүтэйгээр сайн ажил мэргэжилтэй болгон амжилтанд хүргэхийн тулд хамаг анхаарлаа хандуулсан бол дэлхийн алдартай кино найруулагчийг төрүүлж чадахгүй байх байсан юм.

Надад 2001 оны 06-р сараас эхлэн 1 жилийн хугацаанд АНУ-ын Нью-Йорк хотод гэр бүлийн хамт амьдрах боломж гарсан юм. Амралтын өдрөөр хамаа дэлгүүрээс пицца юмуу мөхөөлдөс захиалж идэх үе гардаг бөгөөд захиалга өгөх маш ядаргаатай ажил байв. Дэлгүүрийн ажилтан та ямар пицца захиалахыг хүсэж байна гэж асуух бөгөөд Солонгос улс шиг ногоотой пицца юмуу үхрийн махтай пицца юу гэж асуудаггүй. Ажилтан нарийвчлан пиццаны талхны зузаан, хэмжээ, пиццаны чимэглэлийн төрөл зэргийг асуудаг байв. Зайрмагны хувьд ч гэсэн мөн ялгаагүй. Ресторанд ч гэсэн бүх хоол, хачирууд нь хувь хүн тус бүр өөрийн хүссэн зүйлийг захиалж болохуйц маш олон янзын төрөл зүйлтэй байв.

Солонгос хүмүүсийн тухайд гэр бүлээрээ гадуур хооллох юмуу ажлын газрынхантайгаа олнооруу хоолонд орох үед ихэнхидээ ижил төрлийн хоол захиалах тохиолдол их байдаг. Энэ нь хүмүүс хоорондын харилцааг улам сайжруулах төдийгүй хоол ч хурдан бэлэн болох сайн талтай. Архи, ундаа гэх мэт уух юмаа ч ихэнхидээ адилхан захиалдаг. Цуг ажилладаг хүмүүстэйгээ өдрийн хоолны цагаараа Хятад хоолны газарт очвол жантай гоймон, шөлтэй гоймон (жамбун) гэх мэт хоолыг нийтээрээ захиалах тохиолдол их байдаг. Нэг үгээр хэлэхэд бусдын нөлөөнд хэт автан өөрийн хувийн онцлог чанаргүй болж байгаа гэсэн үг юм. Хүмүүс бусад хүн хийж байгаа болохоор би ч дуурайх ёстой гэсэн үзэл бодолтой болж байгаа гэсэн үг юм. Телевизийн олон ангит кинонд гарч байгаа алдартай жүжигчний өмссөн хувцас юмуу гоёл чимэглэлийн зүйл тун удалгүй моодонд орон нийгмийн бүхий л хүрээнд даган дуурайж эхэлдэг. Харин энэхүү бусдыг дуурайх байдлын сул тал нь хүний бүтээлч чанарыг үгүй болгодог.

Еврей хүмүүс хүүхдийнхээ хувийн зан чанарыг ихэд хүндэтгэн түүнийг нь сайжруулахын тулд маш их хичээдэг. Еврей хүмүүс хүүхэддээ “Чи бусад сурагчидтай өрсөлдөн тэднийг ялах хэрэгтэй” гэж заахаасаа илүү “Чи бусдаас өөр хүн болох хэрэгтэй” гэж байнга зааж сургадаг. Хүүхэд болгон өөр өөр авъяас чадвартай байдаг. Төрсөн ах дүү, эгч дүү байлаа ч зан чанар юмуу сонирхлын тал дээр маш их ялгаатай байдаг. Тийм болохоор үр хүүхдээ зөв өсгөж хүмүүжүүлэхийн тулд Еврей эцэг эхчүүдийн нэн түрүүний баримталдаг зарчим бол “уян хатан чанар” юм. Тэд эцэг эхчүүд хүүхдийнхээ хувийн зан чанарыг сайтар ажиглан зөв тодорхойлсны дараагаар түүнд нь тохирсон зүйлийг хүүхэддээ зааж сургахыг хамгийн чухал зүйл гэж үздэг. Хүүхдийнхээ бусад хүүхдүүдээс илүү сайн хийж чадах зүйл нь юу болох, хүүхдийнхээ давуу талыг олж мэдэхийн тулд маш их хичээдэг. Тиймээс хүүхдээ янз бүрийн хичээл номоор зай завсаргүй шахан төрөл бүрийн курс, дугуйланд хүчээр явуулахынхаа оронд урлаг спорт, одон орон судлал, уран илтгэл, робот гэх мэт янз бүрийн сонирхолтой зүйлийн

талаар сонирхон суралцахад нь тусалдаг байна.

Хүүхэд залуучуудад тулгарч буй асуудлын талаар судалгаа хийдэг мэргэжилтэн АНУ-ын Вермонт их сургууль(The University of Vermont)-ийн сэтгэл судлалын тэнхимийн Томас Аченбач (Thomas Achenbach) багш “Солонгос улсын сурагчид янз бүрийн курс дамжаанд яван цаг наргүй хичээл ном хийн маш их стресстэй байдаг төдийгүй гэр бүлийн гишүүд хоорондын харилцаа бараг байдаггүй. Эцэг эх хүүхдийн хооронд үүсч буй асуудал болон хүүхдийн сэтгэл зүй, үйл хөдлөлөөс үүсч байгаа олон олон асуудлууд зөвхөн “хичээл ном” гэсэн ганцхан шалгууураар хүүхдүүдээ үнэлж дүгнэж байгаа Солонгос хүмүүсийн буруугаас болж байгаа” гэж хэлсэн байна.

Хүүхэд болгонд өөрийн хийх дуртай сайн хийдэг хичээл байдаг бөгөөд тэр хичээлдээ маш их сонирхолтой дуртай байдаг учраас сайн төвлөрч анхаарч чаддаг. Харин Солонгос хүмүүс хүүхдээ бүх хичээлдээ номер 1 байхыг хүсдэг бөгөөд хүүхдийнхээ хичээлийн дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалан баярлах үедээ баярлан гуниглах үедээ гуниглан сэтгэл зүйн хувьд маш тогтворгүй байдаг. Сурлагын дүн нь муу байвал ихэнхидээ хүүхэддээ уурлаж уцаарлан шийтгэх гэх мэтээр янз бүрийн арга хэмжээ авдаг. Мөн хүүхдээ төрсөн ах, эгч, дүү юмуу найз нөхөд гэх мэт бусад хүмүүстэй маш их харьцуулдаг. Гэтэл хүүхэд эцэг эхчүүдийнхээ энэхүү буруу үйл ажиллагаанаас болон өөртөө итгэх итгэлдээ том шарх аван өөртөө итгэх итгэлгүй болохдоо амархан байдаг. Ийм байдалтайгаар цаг хугацаа удаан үргэлжилсээр байвал хүүхдийн сурлагын дүн маш мууддаг. Хүүхэд Англи хэлэндээ сайн байж болох ч тооны хичээлдээ муу байж болох бодит үнэнийг эцэг эхчүүд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ингэж байж л хүүхдийнхээ ирээдүйн амьдралд тусалж чадна.

“Ах дүү хоёрын толгойг харьцуулвал хоёуланг нь алж байгаа хэрэг харин хувийн зан чанарыг нь харьцуулвал хоёуланг нь амьдруулж байгаа хэрэг” гэсэн Еврей сургааль үг байдаг. Хүн бүрийн царай зүс, зан чанар, чадвар өөр өөр байдаг. Хүн гэдэг амьтан өөр өөрийн гэсэн давтагдашгүй зан чанартай амьтан. Тэрхүү зан чанарыг нь сайн амьдруулж чадаж байгаа нь Еврей хүмүүсийн хүүхдийн боловсролын хамгийн гол нууц юм. Тиймээс дэлхий ертөнцийг удирдан чиглүүлж байгаа агуу Еврей хүмүүсийг зан чанараа зөв тодорхойлон түүнийгээ хөгжүүлэхийн тулд хичээсэн боловсролын үр дүнд бий болсон хүмүүс гэж хэлж болно.

Оюун ухаантай суут хүүхэд гэвэл хичээл номоо шаргуу сайн хийдэг хүүхдийг хэлж байгаа биш харин бусдаас өөр хүүхдийг хэлнэ. Гэтэл Солонгос хүмүүс энэхүү байдлыг үл тоомсорлодог. Тиймээс өөрийнхөө хүүхдийг бусдын хүүхэдтэй байнга харьцуулдаг. Тэдний харьцуулдаг зүйл бол зөвхөн сурлагын дүн. Тэгээд бас хүүхдээ бүх хичээлдээ гайхалтай сайн байхыг хүсдэг. Хүүхдийнх нь хүсэл сонирхол бүтээлч чанарын үндэс суурь гэдгийг огтхон ч хүлээн зөвшөөрдөггүй. Хүүхдээ зөвхөн нөхцөл байдалд дасан зохицон бусдын үгийг сайн сонсдог ухаантай үлгэр жишээ сурагч болгохыг хүсэхээс өөр зүйл хийдэггүй.

Иймээс эцэг эхчүүд бид яг энэ цаг мөчөөс эхлэн хүүхдээ ямар хувийн зан чанартай болох, ямар зүйлд дуртай болохыг нь сайн ажиглаж эхлэх хэрэгтэй. Болж өгвөл хүүхэдтэйгээ хамт байх цагаа уртасган хөгжим, урлаг, спорт, гадаад хэл гэх мэт янз бүрийн зүйлийг хамтдаа суралцан хүүхдээ янз бүрийн зүйлээр оролдон туршлага хуримтлуулахад нь туслах хэрэгтэй. Хүүхэдтэйгээ хамт аялалаар явах юмуу урлаг соёлын газраар явах, музей үзэж сонирхох, хөгжмийн тоглолт концерт зэргийг үзэх нь хүүхдийн зан чанарыг олж илрүүлэхэд ихээхэн тус

болдог.

“Хүүхэд хичээл хийж байгаад нозоорон залхуу нь хүрвэл босоод өөр зүйл хийж” болохыг зөвшөөрөх

“Талмуд” номонд “Багш мэдэж байгаа зүйлээ зөвхөн ганцаараа яриад байх нь буруу. Сурагчид зөвхөн багшийнхаа ярихыг сонсоод л байвал энэ нь сурагчдад юм зааж байгаа биш харин тоть шувуу тэжээж байгаагаас өөрцгүй зүйл юм. Багш ямар нэгэн зүйлийн талаар ярих үед сурагчид тэр зүйлтэй холбогдолтой зүйлийг багшаасаа сайн асууж лавлаж байх хэрэгтэй. Багш сурагчид хоорондоо асуулт тавьж харилцан ярилцах аргаар суралцсанаар боловсролын үр дүн нэмэгддэг” гэсэн үг гардаг. Ямар нэгэн тогтсон хэв маяг болон ерөнхий ухагдахууны талаар байнга асуулт дэвшүүлэн хоорондоо харилцан ярилцан хүн өөрөө бүх зүйлийг ойлгодог болтол зааж сургадаг сургалтын арга барил нь дэлхийн томоохон нээлтүүдийг бий болгосон гол хүч юм.

Еврей хүмүүс хүүхдийг Бурханы бэлэг гэж тооцон хүүхэд гаргахаас татгалздаггүй учраас маш олон хүүхэдтэй болдог. (Еврейн шашны хуулийн дагуу бол эрэгтэй эмэгтэй хүн хамгийн багадаа хоёр хүүхэд гарган өсгөх үүрэгтэй. Мөн эх хүүхдийн эрүүл мэнд сайнгүй байх тохиолдолд тусдаа хүүхэд үрчлэн авахыг ч хүлээн зөвшөөрдөг) Нэг удаа Солонгос улсын нэгэн телевизээр 10 хүүхэдтэй Михайл Канух /44 нас/, Дибура Рэа/40 нас/ гэдэг эхнэр нөхөр хоёрын талаар нэвтрүүлэг гарсан юм. Сүүлийн үед ийм олон хүүхэдтэй гэр бүлийг Солонгос улсаас хайж олно гэдэг бараг л өвсөн дотроос зүү хайхтай адил хэцүү зүйл юм. Хоёрхон хүүхэдтэй болоход л хоорондоо хэрэлдэж маргалдан зодолдох, уйлалдаж орилолдох дуу чимээнээс гадна эцэг эхийнх нь чанга дуу нэмэгдэн бөөн чимээ шуугиан болж байхад харин энэ гэр бүлийн хувьд эсрэгээрээ маш эмх цэгцтэй тайван уур амьсгалтай байдаг байна. Энэ гэр бүлд ямар нэгэн буруу зүйл хийлээ гээд эцэг эх нь хүүхдүүд рүүгээ муухай хашхирч орилон загнах тохиолдол бараг гардаггүй. Харин хүүхдүүдтэйгээ байнга асуулт хариулт маягаар ярилцан хүүхдүүд өөрсдөө хийх зүйлээ олоход эцэг эх нь тусалдаг байна.

Тэд “Яагаад ах руугаа ингэж муухай орилоод байгаа юм бэ? Ах чинь гайхахгүй гэж үү?”

“Өрөө чинь ийм замбараагүй заваан байгаад байвал тоос шороо нь ихдэн эрүүл мэндэд чинь муугаар нөлөөлөхгүй гэж үү?” гэх маягаар хүүхдүүдтэйгээ харилцан ярилцдаг байна.

Надад Нью-Йорк хотын нэгэн бага сургуулийн 1-р ангийн анги удирдсан багштай ярилцсан удаа бий. Тэр багшийг Сантимауро (Santimauro) гэдэг байсан бөгөөд 40-45 орчим насны эмэгтэй багш байсан юм. Тэрээр “Солонгос улсын сурагчид бичиг цаасны зүйлтэй их зууралддаг болоод ч тэрүү тестийн шалгалтанд маш сайн дүн авдаг. Бичгээр авч буй шалгалтанд чадвар нь гайхалтай сайн байдаг. Гэвч АНУ-ын сургалтын арга барил жаахан өөр байдаг. АНУ-ын сургалтын систем нь багш сурагчид хоорондоо харилцан ярилцах боловсролын арга барилыг чухалчилдаг. Солонгос сурагчдад хичээл зааж байхад надаас дотогшоо зан чанартай асуулт асуудаггүй байсан нь үнэхээр бачимдмаар зүйл байсан. Мэдэхгүй зүйл гарвал асуулт тавин бусадтай харилцан ярилцах байдлаар дамжуулан өөрөө зөв хариултыг олох явц нь хүний бүтээлч чадварыг сайжруулах хамгийн сайн арга байхад бүтэн өдрийн турш зөвхөн багшийнхаа ярьж байгаа зүйлийг сонсон зөвхөн сурлагын дүндээ анхаараад байвал хүн юу хийж чадах юм бэ” гэж ярьсан юм.

Хүүхэд 3 нас хүртлээ эцэг эхийнхээ үг яриа, үйл хөдлөлийг дуурайн эцэг эхээсээ алхам тутамд суралцаж байдаг. Үүнийг өгөгдсөн мэдээллийг хүлээж аван дахин дахин давтан идэвхигүйгээр суралцаж байгаа нэг хэлбэр ч гэж хэлж болно. Харин 4 наснаасаа эхлэн “Энэ юу вэ?” “Яагаад ингэж байгаа юм?” “Яагаад ингэж болохгүй гэж?” гэх мэтээр олон зүйлийн талаар асууж сонирхож эхэлдэг. Хүүхдийн энэхүү сониуч зан чанар хөдлөж эхлэх үед түүнийг нь сайн хөгжүүлэх маш чухал юм. Яагаад гэвэл эцэг эх хүүхэдтэйгээ хэрхэн харьцаж ямар хариу үйлдэл үзүүлж байгаагаас шалтгаалан хүүхдийн чадвар нэг шат ахих, эсвэл эсрэгээрээ зөвхөн мэдээлэл хүлээн авч хадгалдаг идэвхигүй хүүхэд болдог учраас юм. Хүүхдийн сонирхлыг хүчээр барьж хоригловол тэр хэмжээгээр авъяас чадвар нь хөгжилгүй зогсонги байдалтай болдог.

Ионсей их сургууль(Yonsei University)-д Англи хэлний багшаар ажиллаж байсан Израйль улсын нэгэн гадаад хэргийн ажилтан Солонгос болон Израйль улсын хичээлийн анги танхимын хамгийн том ялгааг “Асуулт асуух хандлага” гэж онцлон хэлсэн байна. Еврей сурагчид хичээлийн цаг дээр багшаасаа маш олон зүйлийг асууж лавладаг. Янз бүрийн асуулт асуун багштайгаа харилцан ярилцсаар байвал хүүхэд аяндаа зөв хариултыг нь олж чаддаг. Гэтэл Солонгос сурагчдын тухайд хичээлийнхээ цаг дээр чив чимээгүй зөвхөн багшийнхаа ярихыг сонсоод л суугаад байдаг.

Муугаар хэлвэл Солонгос хүмүүсийг өөрсдийн хүүхдүүдээ идэвхигүй сурагч болгож өсгөхдөө гаргууд сайн хүмүүс гэж хэлж болох юм. Мэдэхгүй зүйлийнхээ талаар бусдаас сайн асууж лавлан харилцан ярилцдаг хүн болгон өсгөж хүмүүжүүлэх нь байтугай хүүхдээ асуулт асуух үед нь асуултанд нь хариулахаас хүртэл төвөгшөөдөг. Үүнд тодорхой учир шалтгаанууд байж бас болох юм. БНСУ-ын 30-50 насны хүмүүс улс орныхоо хатуу ширүүн нийгмийн өрсөлдөөнөөс болоод маш их ядардаг. Ажлаа тараад гэртээ очсон ч бүх зүйл төвөгтэй санагдан буйдан дээр хэвтэн телевизийнхээ удирдлагаар хэсэг оролдож байгаад унтаад өгдөг. Тийм болохоор дэлхий ертөнцийн талаар ид сонирхон сониуч зан нь хөдөлж ийм тийм юм асуун урдуур хойгуур нь гүйж байгаа хүүхдийнхээ асуултанд хариулахаас ч төвөгшөөн амархан уурлаж уцаарладаг. Жишээ нь :

“Аавaа машин яагаад унадаг дугуйнаас хурдан юм бэ?”

“Машин угаасаа л хурдан байдаг юм аа”

“Сармагчны бөгс яагаад улаан байдаг юм бэ?”

“Ядаргаатай юм аа. Яагаад ийм хачин юм асуугаад байгаа юм бэ?” гэх мэтээр ихэнхи эцэг эхчүүд хүүхэдтэйгээ маш буруу харьцдаг.

Гэтэл Еврей эцэг эхчүүдийн тухайд ямар байдаг юм бол? Тэд бага байхаас нь эхлэн хүүхдээ асуулт асуухад нь дуртайяа хариулж хүүхэдтэйгээ харилцан ярилцдаг бөгөөд хүүхэд улам их зүйлийг асууж мэдэх боломжийг бүрдүүлэн хүүхэддээ эелдэг зөөлөн ханддаг. Жишээ нь тэд хүүхэд 1 ой хүрсэн үеэс эхлэн хүүхдээ унтах үед ном уншиж өгдөг бөгөөд үүндээ огтхон ч төвөгшөөн залхуурдаггүй. Мөн хүүхэд ойлгоход амархан үг хэллэг ашиглан хүүхдээсээ асуулт асуудаг.

“Гүнж яагаад хан хүүд хайртай болсон юм бол?”

“Шулмас гүнжид дургүй байдаг учир шалтгаан нь юу юм бол?” гэх мэтээр.

Хүүхэд эхэндээ ямар утгатай болохыг сайн ойлгож чаддаггүй боловч цаг хугацаа өнгөрөх тусам бага багаар аав ээжийнхээ асуултын утгыг ойлгохоор болдог. Иймэрхүү арга барилаар хүүхэдтэйгээ ярилцсаар байвал хүүхэд төд удалгүй өөрийн бодол санаагаа бага багаар бусдад ойлгуулж чаддаг болдог. Энэ нь асуулт хариултаар дамжуулан хүүхдийн тунгаан бодох чадвар, ямар нэгэн зүйлд дүн шинжилгээ хийх чадварыг сайжруулж байгаа арга юм.

Еврей хүмүүс асуулт хариултыг голчилсон сургалтын арга барилыг боловсролдоо маш түлхүү ашигладаг. Багш нарын хамгийн их онцолдог зүйл бол “идэвхитэйгээр асуулт тавих” юм. Солонгос хүмүүсийн тухайд хичээлдээ явж байгаа хүүхэддээ “Хичээлийн цаг дээр багшийнхаа ярьж байгаа зүйлийг сайн сонсоорой. Өөр юм хийгээд байлгүй багшийнхаа хий гэснийг хийх хэрэгтэй” гэж хэлдэг. Харин Еврей хүмүүсийн захиасын тухайд бол эсрэгээрээ шал өөр байдаг. “Багш чинь маш их мэдлэг чадвартай хүн учраас мэдэхгүй зүйл гарвал багшаасаа сайн асууж лавлаж байх хэрэгтэй. Багшид чинь мэдэхгүй зүйл ховор учраас мэдэхийг хүссэн бүхнээ багшаасаа сайн асууж байгаарай” гэж хэлдэг.

Израйлийн шашны сургууль Yeshiva-д сурагчдад “Хичээл хийж байгаад залхуу хүрч нозоорох юм бол чөлөөтэй босож болох”-ыг нь зөвшөөрдөг. Яг адилхан зүйлийг босоод гар хөлөө хөдөлгөн толгойгоо сэргээсний дараа суралцвал сургалт үр дүнтэй болдог гэж Еврей хүмүүс үздэг. Цуг суралцаж байгаа бусад найз нөхөдтэйгээ асуулт хариулт хэлбэрээр харилцан ярилцдаг “харилцан ярилцах арга”-ыг ашиглах шашны сургуулийнх нь бас нэг онцлог юм. Хажууд зэрэгцэн сууж байгаа хэн нэгэн найзтайгаа асуулт хариулт маягаар харилцан ярилцаж суралцах нь ямар ч залхуутай хичээлийг сонирхолтой болгон асуудлыг шийдвэрлэх чадварыг сайжруулдаг. Нэг нэгэндээ тасралтгүй асуулт тавин нөгөө тал нь асуултанд хариулах маягаар суралцсанаар сурагчид тухайн ярилцаж буй зүйлийнхээ талаар сонирхолтой болон илүү сайн төвлөрч анхаарах чадвар нь сайжирдаг.

Хүний бодлогогүй үйлдэл хийдэг сэтгэл зүйн учир шалтгааны талаар судалсан “Sway” номын зохиолч Ром Брэфмэн (Rom Brafman) гэдэг Еврей хүн асуулт хариултыг сургалтын хамгийн шилдэг арга барил гэж онцолсон байна. Тэрээр “Сурагчид асуулт хариултаар дамжуулан хичээлд идэвхитэй оролцдог. Ихэнхи сурагчид хичээлийн цаг дээр багшийнхаа ярьж байгаа зүйлийг дэвтэр дээрээ бичиж авахыг хичээлээ сайн хийж байна гэж боддог боловч энэ нь үнэндээ идэвхигүй хичээллэлт юм. Хамгийн чухал зүйл бол сурч байгаа зүйлийнхээ агуулгыг дэвтэртээ бичих биш толгой дотроо үлдээж ямар ч үед түүнийгээ ашиглаж чаддаг байх юм. Тэгэж байж л жинхэнэ сурсан гэж хэлж болно. Суралцах хүсэл эрмэлзлийг алдуулахгүй байх хамгийн чухал арга бол асуулт хариулт юм. Хэрвээ хүүхэд хичээлийн цаг дээр биеэ барин чөлөөтэй асуулт асууж чадахгүй байвал хичээлийн цаг дууссаны дараа багштайгаа тусдаа уулзан мэдэхийг хүссэн зүйлийнхээ талаар асууж лавлаж байх хэрэгтэй” гэж зөвлөсөн байна.

Ой санамжийн чадвараараа гайхагддаг суут Еврей хүн Эран Катз (Eran Katz, 45 нас)-ийн тайлбар ч бас үүнтэй төстэй байгаа юм. Тэрээр “Еврей сурагчид сурч байгаа зүйл нь сонирхолгүй байвал суудлаасаа босон маш чухал асуудлын талаар ярилцаж байгаа юм шиг

багш болон бусад сурагчидтай асуулт хариулт тавин ярилцдаг. Хүн ер нь аливаа зүйлд сониуч зангаар хандан сонирхсон зүйлийнхээ талаар бусдаас сайн асууж лавлаж байх хэрэгтэй. Сонирхсон зүйлийнхээ талаар бусдаас тогтмол асуулт асууж байх нь хүүхэд мэдлэг олж авах хамгийн сайн арга юм" гэж хэлсэн байна. Хүн нүдээрээ ном уншин өөртөө олж авсан мэдлэг амархан мартагддаг боловч асуулт хариулт маягаар хоорондоо ярилцаж олж авсан мэдлэг толгойноос тийм ч амархан арчигдаж алга болдоггүй. Хүмүүстэй харилцан ярилцах тал дээр идэвхитэй сайн байдаг хүмүүсийн ой санамж бусад хүмүүстэй харьцуулахад хамаагүй сайн байдаг учир шалтгаан үүнд байгаа юм.

Хүүхдүүд "Энэ яагаад ингэж байгаа юм бэ?" "Тэр юу вэ?" гэх мэт янз бүрийн зүйл байнга асуун эцэг эхээ залхаадаг. Ийм үед хүүхдийнхээ тавьсан асуултанд хариулахаас зайлсхийх юмуу хальт хариулсан болоод хаявал хүүхдийн эцэг эхийнхээ талаарх итгэл найдвар мууддаг. Эцэг эх нь өөрийнх нь асуусан асуултанд өнгөцхөн хариулвал өөрийнх нь сэтгэл хөдлөл, сонирхлыг үл тоомсорлож байна гэж тэд боддог. Хүүхэд их зүйл асууж лавлаж байна гэдэг түүний сониуч зан ихтэйг илэрхийлж байгаа юм. Хүүхдийн төсөөлөн бодох чадвар болон сонирхлыг нь сайжруулснаар хүүхдийн бүтээлч чадвар сайжран өөртөө итгэх итгэлтэй болдог. Тиймээс эцэг эхчүүд хүүхэд ямар нэгэн зүйлийн талаар асууж сонирхсон үед нь өөрсдийн мэдэж байгаа хэмжээгээрээ чин сэтгэлээсээ хариулж байх нь маш сайн юм. Ингэснээр эцэг эх болон хүүхдийн хоорондох итгэл үнэмшил, харилцаа сайжран хүүхэд сурах хүсэл эрмэлзэл дүүрэн болдог.

Мөн хүүхдийнхээ асуусан асуултанд хариулдаг байдлаасаа нэг шат ахин буцаагаад хүүхдээсээ асуулт асуугаад үзэцгээе. "Чи яагаад тэгэж бодож байгаа юм бэ?" "Ингэж бодвол муу хүн гэж үү?" гэх мэтээр хүүхдээсээ буцаагаад асуулт асуух хэрэгтэй. Асуусан асуултанд хүүхэд тань сонин хачин байдлаар буруу хариулсан ч шүүмжлэлгүй сайн байна гэж магтаж байх хэрэгтэй. Ингэснээр хүүхэд өөртөө итгэх итгэлтэй болон аливаа зүйлийг олон талаас нь харан сэтгэхүйн цар хүрээ нь тэлдэг.

Бүтээлч хүүхэд асуудал ихтэй байдаг

“Маш ховор сонин хачин техник хэрэгслийг харъя гэвэл Израйль улс руу яваарай” гэсэн үг байдаг. Ийм хэмжээгээр гайхалтай бүтээлч чадвар бүхий боловсон хүчин хамгийн ихтэй улс бол Израйль юм. 1990 оны дунд үед Еврейн их сургуулийн генетик судлалын судалгааны төвд бидний аттархан иддэг улаан лооль хамгийн анх мэндэлсэн бөгөөд мөн интернэт мессенжер(Messenger)-ийн программыг зохион олон тэрбум долларын ашиг орлого олсон компани ч Израйль улсын компани юм. Тэд элсэн цөлд далайн усыг хуримтлуулан далайн байцааг ч ургуулж чадсан хүмүүс. Өөрийн техник хэрэгслээр судалгааны зориулалттай хиймэл дагуул болох (TECHSAT)–ыг хөөргөсөн Technion техникийн их сургууль бол Израйлийн шинжлэх ухаан, инженерийн боловсон хүчний 70 хувийг бэлтгэн гаргадаг сургууль юм. Энэ сургуулийн нано шинжлэх ухааны судалгааны газрын Эрэж Хасман багш “Ирээдүйн хамгийн чухал зүйл бол бүтээлч чадвар. Өнөө цагт нэг хэв маягт баригдсан сэтгэхүйн арга барилаар техник технологийг хөгжүүлнэ гэдэг зүгээр хий хоосон мөрөөдлөөс цаашгүй зүйл” гэж хэлсэн байна.

“Гүүгл(Google)” компанийг хамтдаа үүсгэн байгуулсан Сергей Брин (Sergey Brin) болон Ларри Пэйж (Larry Page) хоёрт нийтлэг тал маш их байдаг. Юуны өмнө тэд 27 настай нас чацуутангууд бөгөөд хоёулаа Еврей хүн юм. Хоёулангийнх нь эцэг их сургуулийн багш харин эх нь шинжлэх ухааны эрдэмтэн байсан байна. Мөн хоёулаа Монтессори (Montessori) бага сургуулийг төгссөн. Багш хичээлийг удирдах биш хүүхдүүд өөрсдөө сургалтын хэрэгсэл ашиглан хичээлийг удирдах нь Монтессори (Montessori) сургуулийн боловсролын онцлог байв. “Хэн нэгэн ингэж тэгэж хий гэж огтхон ч бусдыг захиргаадаж болохгүй. Хүн өөрийнхөө амьдралын замыг өөрөө зурах хэрэгтэй. Монтессори (Monterssori) сургууль сурагчдад “Сонирхон мэдэхийг хүсэж байгаа зүйлийнхээ талаар байнга асууж лавлаж байх хэрэгтэй” гэж заадаг байна. Сергей Брин (Sergey Brin), Ларри Пэйж (Larry Page) хоёр Монтессори (Montessori) сургуульд сурч байхдаа өөрсдийн хийхийг хүссэн зүйлээ дурааараа хийх эрх чөлөөг харин ч нэг сайн эдэлсэн байна.

Мөн тэд байнга хоорондоо өрсөлддөг байв. Тэд хоол идэж байхдаа ямар нэгэн зүйлийн талаар бусадтай ярилцдаг байв. Бүтээлч хүмүүсд нийтлэг байдаг зөрүүд хандлага ч тэдэнд байсан юм. Брин бүр өөрийгөө “гаж хүн” гэж тодорхойлдог байсан бөгөөд тэрээр бодит амьдрал дээр бусдаар маш их даажигнаж тоглоом тохуу хийдэг нэгэн байсан юм. 12 настайдаа эцэг эхийн хамт Оросын холбоот улсаар аялж байхдаа замын цагдаа руу чулуу шидэн асуудал үүсгэж байсан удаа ч түүнд байдаг. Харин Пэйжийн хувьд тэрээр ганцаараа байх их дуртай байсан бөгөөд насанд хүрсэн хойноо ч бүрэг ичимхий бусадтай найзалж нөхөрлөх тал дээр муу өвөрмөц зан чанартай нэгэн байв.

Сергей Брин (Sergey Brin), Ларри Пэйж (Larry Page) хоёр ахлах сургуулиа төгсөөд Стэнфордийн их сургууль (Stanford University)-д элсэн орсон байна. АНУ-ын өгүүлэл бичигч Кэн Аулетта (Ken Auletta)-гийн бичсэн “Googled” номонд бичсэнээр Стэнфордийн их сургуульд энэ хоёр сурагчийн удирдагч багшаар ажиллаж байсан Разив Мотвани багш хоёр сурагчийн онцлогийг “Яагаад?(Why)” гэсэн ганцхан үгээр илэрхийлсэн байдаг. Сергей Брин (Sergey Brin), Ларри Пэйж (Larry Page) хоёртой нас чацуу “Гүүгл(Google)” компаний нэгэн ажилтан “Энэ хоёр залууд ямар ч дүрэм журам, систем гэсэн зүйл байдаггүй. Тиймээс

өөрсдийнхөө хийхийг хүсэж байгаа зүйлийг хийж байж сая нэг сэтгэл санаа нь амардаг. Ямар нэгэн зүйлийн талаар асууж лавлан сайтар тунгаан бодох арга барилаар боловсрол эзэмшсэн хүмүүс. Жишээ нь зураг зурахыг хүссэн үедээ зураг зурж хийхийг хүссэн зүйлээ хийдэг Монтессори (Montessori) сургуулийн сурагчидтай адилхан хүмүүс" гэж хэлсэн байна.

Нэг ёсондоо эдгээр залуус нэг хэв маягт баригдан тогтоосон дүрэм журам, ерөнхий ухагдахуун ойлголтоор аливаа зүйлийг бодож сэтгэх байдлаас татгалзан бүхий л зүйлийн талаар бусдаас асууж лавлан ойлгож ухаардаг бүтээлч зан чанартай хүмүүс байсан гэсэн үг юм. "Гүүгл(Google)" компани шинээр ажилчид сонгон шалгаруулж авахдаа өвөрмөц ярилцлагын арга барилыг ашиглан сонгодог бөгөөд энэхүү ярилцлаганд орж байгаа хүмүүс ч гэсэн бусдаас өөр сонин хачин үзэл бодолтой гаж хүмүүс байдаг. Жишээ нь Брин нэг удаа компаний гэрээ хариуцсан өмгөөлөгчийн албан тушаалд ажилтан сонгон шалгаруулахдаа өгсөн даалгавар нь "Ад чөтгөрт миний сүнсийг зарах" гэсэн сэдвээр 30 минутын дотор гэрээ боловсруулах даалгавар байсан байна. Их сургуулийн орчин шиг тохижуулж янзалсан Силикон Валли (Silicon Valley)-д байдаг "Гүүгл(Google)" компаний толгой компани нь "Бусдын бодож үзэж байгаагүй ертөнцийг" мөрөөддөг этгээд сонин залуусын судалгааны үр дүнд 24 цагийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулсаар байгаа юм.

Ямар нэгэн шинэ бүтээл гаргана гэдэг бол бусад зүйлийг дуурайх юмуу тэр зүйлийг шинэчлэхийг хэлдэггүй. Шинэ бүтээл гаргана гэдэг бол аль хэдийн тогтсон хэв загвар, ерөнхий ойлголт ухагдахууныг эвдэж сүйтгэж буй нэг төрлийн сүйтгэх үйл ажиллагаа юм. Тийм болохоор ихэнхи зүйлд бүтээлч сэтгэлгээгээр хандан шинэ санаа гаргах амаргүй байдаг. АНУ-ын хүний тархи судлаач эрдэмтэн Григори Бэрнс(Gregory Berns) "Хуучин үзэл баримтлалыг эсэргүүцэгч (Iconoclast)" гэдэг номондоо үүний учир шалтгааныг 3 төрөлд хуваан бичсэн байдаг. Юуны түрүүнд хүний тархи дассан зүйлдээ маш дуртай дасаагүй шинэ зүйлд маш дургүй байдаг байна. Мөн хүн ямар нэгэн шинэ санаа олвол тэрийг нь бусад хүмүүс тоглоом шоглоом болгон үл тоомсорлоно гэдгээс битүүхэн айдаг байна. Хэдийгээр амжилт гаргах шинэ санаа олсон ч түүнийгээ бусдад таниулан бодит байдал болгох тал дээр ихэнхи хүмүүс муу байдаг.

Гэвч Брин, Пэйж хоёр тогтсон хэв маягт баригдалгүй байнга шинэлэг зүйлийн араас хөөцөлддөг хүмүүс байсан юм. Тэд нэгэнт тогтсон хэв маяг, дүрэм журманд баригдалгүй аливаа зүйлийн талаар бодож тунгаахдаа энгийн ухаанаар сэтгэн бодож бусдаас байнга асууж лавладаг байсан болохоор гайхалтай бүтээлч зан чанартай болж чадсан юм. Эйнштэн ч гэсэн Нобелийн физикийн ухааны шагнал авах үедээ "Хүмүүс дүрэм журмыг сахиж мөрдөхийг хамгийн чухал үнэ цэнэ гэж боддог боловч миний хувьд харин ч эсрэгээрээ дүрэм журмыг зөрчих үед бидэнд хамгийн хэрэгтэй шинэ дүрэм журам бий болдог гэж итгэдэг" гэж хэлсэн байдаг.

I Phone болон I Pod-аар мэдээлэл технологийн салбарын түүхэнд шинэ хуудас нээж чадсан "Apple" компаний захирал Стив Жобс (56 нас) ч гэсэн мөн өөрийн шинэ санааг бусдад таниулж ойлгуулах чадвартай хуучирсан хэв маяг, үзэл баримтлалыг эсэргүүцэгч нэгэн байсан юм. Жобс 2010 оны 06-р сард АНУ-ын Лос Анжелес хотод нээлтээ хийсэн "I Phone 4"-г танилцуулах нээлтийн үйл ажиллагаан дээр "Apple" компани бол зүгээр нэг энгийн техник технологийн компани биш. "Apple" компани уламжлалт нийлүүлэгчийн байр

суурьнаас ангижран “хүн”-ийг төв болгосон бүтээлч бараа бүтээгдэхүүнийг шинээр зохион бүтээж чадсан нь хүмүүнлэгийн тал дээр анхаарал хандуулан үүндээ үндэслэн технологийг холбож чадсан учраас юм” гэж хэлсэн байна.

Еврей хүмүүс бага наснаасаа эхлэн Бурхан хэмээх хийсвэр оршигч байдаг гэдэгт итгэдэг учраас төсөөлөн бодох чадвар сайн байдаг. “Хүүхдийн бодол санаа үүл шиг энэ тэнүүгээр хэрэн тэнэх хэрэгтэй” гэж Еврей хүмүүс боддог. “Хоёр Еврей хүн уулзвал 3 шинэ санаа төрөн гардаг” гэсэн үг ч байдаг. Еврей хүмүүс хоорондоо харилцан ярилцах байдлаар дамжуулан аливаа зүйлийг шийдвэрлэх арга замыг хайж олдог. Еврей хэлбэрийн боловсрол гэвэл харилцан ярилцах, хэлэлцээр хийх аргыг голчилсон боловсрол юм.

Бүтээлч чадвар гэж нэгэнт тогтсон бодол санааны хэв маягийг эвддэг чөлөөт шинэлэг бодол санааг хэлнэ. Бүтээлч чадвараа сайжруулахын тулд нүдэнд ил харагддаггүй хийсвэр зүйлийн талаар бодон төсөөлөн бодох чадварын дасгалжуулалтыг сайн хийх хэрэгтэй. Бага наснаасаа эхлэн тогтмол ном унших, хоорондоо харилцан ярилцах, аливаа зүйлд сониуч сэтгэхүйгээр хандан чөлөөтэй сэтгэн боддог учраас Еврей хүмүүсийн бүтээлч чадвар гайхалтай сайн байдаг.

Гэтэл эсрэгээрээ Солонгос хүмүүс үр хүүхэддээ нэгэнт тогтсон үзэл бодол, хэв маягийн дагуу сэтгэн бодож суралцах хэрэгтэй гэж заан үүнийгээ бараг тулган шаарддаг. Нийтлэг тогтсон үзэл бодол, хэв маягаас өөрөөр сэтгэн бодож байгаа хүүхэд гэр бүлдээ ч сургуульдаа ч гаж буруу хүн мэтээр тооцогдон дарамт шахалтанд байдаг. АНУ-ын эдийн засагч Эрик Ханушик (Eric Hanushek) багш (Стэнфорд их сургууль) “Тогтсон үзэл бодол, хэв маягийг хэтэрхий баримталдаг Солонгос улсын соёл хүмүүсийн бүтээлч чанарыг хорьж байгаа хамгийн гол зүйл” гэж хэлсэн байна.

Мөн тэрээр “Бүтээлч чадварыг сургуульд заадаг юм биш. Тогтсон үзэл бодол, хэв маягаас өөрөөр сэтгэн шинэлэг зүйл рүү тэмүүлж байж л хүний бүтээлч чадвар сайжирдаг. Солонгос сурагчдад хичээл зааж байх үед тэд тогтсон үзэл бодол, дүрэм журманд хэтэрхий их баригдсан байдалтай байдаг байсан учраас намайг ямар нэгэн өөр зүйл ярьж эхэлвэл юу ч ярихгүй чимээгүй болчихдог байсан. Иймэрхүү хэт нэг хэв маягт баригдсан арга барилаар суралцвал хүн ажлын байран дээр гараад ч бүтээлч чадвараа хөгжүүлж чадахгүй байдалтай болдог” гэж онцлон хэлсэн байдаг.

Бүтээлч чадвар нь зөвхөн хичээл ном хийснээр сайжирдаг зүйл биш юм. Хүн чөлөөтэй байж тоглож наадах хэрэгтэй. 2002 онд химийн шинжлэх ухааны төрлөөр Нобелийн шагнал авсан Курт Вудрич (Kurt Hermann Wuthrich, 73 нас) доктор Солонгос улсын сурагчдын бүтээлч чадвар муудаж байгаа учир шалтгааныг сурагчдаас зөвхөн хичээлээ сайн хийхийг тулган шаарддаг боловсролын системээс болж байгаа гэж хэлсэн байдаг.

“Солонгос улсын дунд ахлах сургуулийн сурагчид өдөр шөнөө ялгахгүй хэмжээгээр маш их хичээл ном хийдэг. Учир нь сайн нэр хүндтэй их сургуульд элсэн суралцахын тулд юм. Гэтэл зөвхөн их сургуульд элсэн орохын тулд хичээх хэрэгтэй гэсэн бодлоор суралцвал сурагчдын бүтээлч чадвар сайжрах боломжгүй. Тиймээс хүүхэд сайн тоглож наадаж байх хэрэгтэй. Сонирхолтой зүйлээ ч хийж үзэх хэрэгтэй. Тэгэж байж л хүүхэд бүтээлч чадвартай болно. Солонгос улсын ахлах сургуулийн сурагчид өдөр нь сургууль дээрээ хичээллэн шөнө ч гэсэн

хичээлийн гадуурх боловсролын системээр суралцдаг. Шөнө хичээллэсэн үедээ өдөр нь хичээл дээрээ нойрмоглон хичээлдээ анхаарч чаддаггүй. Хичээл номноос болон хэтэрхий их ядардаг бөгөөд үүнээсээ болон хичээлдээ төвлөрч чадалгүй хичээлийн программаасаа хоцордог. Хоцорсон хичээлээ нөхөхийн тулд дахин хичээлээс гадуурх боловсролын системээр суралцдаг. Иймэрхүү байдалтай суралцсан сурагчид их сургуульд элсэн орох үедээ хичээл ном хийх тал дээр сонирхолгүй болон төвлөрөх чадвар муутай болсон байдаг. Ахлах сургуульдаа хэтэрхий их хичээн суралцсан болохоор их сургуульд ормогцоо хичээл ном хийхийг нэг их чухал зүйл биш гэсэн бодолтой болчихдог.

Сүүлийн үед компаниуд сурлагын дүн сайтай юмуу Англи хэлний мэдлэгийн түвшин өндөр хүнийг ажилд сонгохоосоо илүүтэй ямар нэгэн асуудлыг олж илрүүлэн түүнийгээ шийдвэрлэхийн тулд бүтээлч сэтгэхүйгээр хандан зөв зүйтэй шийдвэрлэх арга замыг олж чаддаг боловсон хүчнийг илүүд үзэх болсон байна. Өөрөөр хэлвэл ямар нэгэн асуудлыг өөрөө олж илрүүлэн шийдвэрлэж чаддаг “асуудлыг шийдвэрлэх чадвар бүхий боловсон хүчин” өнөөгийн компаниудын жинхэнэ хүсэж байгаа боловсон хүчин гэсэн үг юм. Компани бүтээлч удирдлагыг бий болгоё гэвэл мэдээж асуудалд бүтээлч сэтгэлгээгээр ханддаг боловсон хүчин шаардлагатай юм.

Асуудал юу гэвэл Солонгос улсын боловсролын систем ийм боловсон хүчнийг бий болгож чадахгүй байдалтай байгаа юм. Ахлах сургуулиасаа эхлэн зөвхөн их сургуульд элсэн орохыг гол зорилгоо болгон сурлагын дүнгээр өрсөлдөх байдалтайгаар суралцаж байхад бүтээлч чадвартай боловсон хүчин төрөн гарна гэдэг үнэхээр хэцүү зүйл. Солонгос улсын өнөөгийн хэрэглэж буй боловсролын системээр байгалийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн ухаан, урлаг гэх мэт олон талын мэдлэгтэй шилдэг боловсон хүчнийг төрүүлэн гаргах боломжгүй.

Компаниудын байдал ч гэсэн өөрчлөгдөх хэрэгтэй. Сүүлийн үед сонсохнээ олон компаниуд компаний удирдлагаас зорилгыг нь тодорхойлон үйл ажиллагаагаа явуулдаг “Top Down”-ий оронд ажилчдынхаа янз бүрийн санал бодлыг сонсон үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлдэг “Bottom-Up” гэсэн аргыг үйл ажиллагаандаа ашигладаг болж байна. Харин Солонгос улсын компаниуд бүтээлч, хувийн зохион байгуулалт сайтай, нөхцөл байдалд дасан зохицож чаддаг, үнэнч шударга боловсон хүчнийг илүүд үзэж байна. Зохион байгуулалтанд хэт баригдсан байдал, дээд албан тушаалтнуудын тушаалыг доод хүмүүс нь дагаж мөрдөх зэрэг байдлыг чухалчилж буй өнөөгийн энэ хэв маягаас шалтгаалан нийгэм маань өөрөө өвөрмөц сод хүнийг хүлээн зөвшөөрч чадахгүй байна.

Гэтэл бүтээлч сэтгэхүйтэй мөртлөө үнэнч шударга хичээнгүй хүнийг олно гэдэг үнэхээр хэцүү ажил. Бүтээлч чанар бүхий хүн ерөнхийдөө зан чанарын хувьд зөрүүд бусдын үзэл бодолтой эсрэг байдаг. Өөрийгөө “гаж хүн” гэж тодорхойлдог байсан Брин насанд хүрээд ч томоожилгүй 10 настай хүүхэд шиг бусдаар доог тохуу хийдэг байсан бөгөөд чухал уулзалтанд ролек унан очсон удаа ч байдаг. Даяанч лам шиг олны хөлөөс хол хөндий нуугдмал амьдралаар амьдардаг эрдэмтэн Пэйж ажил төрлийн хэлэлцээр уулзалтын үеэр гар утсаараа оролдон бусдыг хүндэтгэж байгаа шинж огтхон ч харуулдаггүй байна. Стив Жобс ч гэсэн нилээн хурц ширүүн хувирамтгай зан ааштай нэгэн юм.

Би хувийн ажлаар нэгэн томоохон компаний ажилтантай уулзсан юм. Тэр ажилтан бүтээлч чадвар бүхий боловсон хүчинтэй болоход хэцүү байгаа дотоодын компаниудын нөхцөл

байдлын талаар “Бүтээлч чадвар бүхий хүмүүс энгийн хүмүүсээс өөр байдаг. Тэдний зан ааш хатуу ширүүн олон зан ааштай байх тохиолдол их байдаг. Харин ихэнхи компаниуд бүтээлч чадвартай мөртлөө зан аашны хувьд сайхан хүнийг ажилд авахыг хүсдэг” гэж хэлсэн юм.

“Гүүгл” компаний ажилчид массаж, үсчин, шүдний эмчилгээ гэх мэт үйлчилгээ үзүүлдэг оффист ажлаа хийдэг. Компаний зүгээс ажилчиддаа биллиардын ширээ бүхий амралтын өрөө, органик хоол хүнс, кофе гэх мэт зүйлсийг хүссэн хэмжээгээр нь үнэ төлбөргүй хангаж өгдөг. Ажлынхаа цагийн 20 хувийг өөрийнхөө хийхийг хүсэж байгаа зүйлдээ ашиглахыг ч зөвшөөрдөг. Солонгос улсын интернэт технологийн томоохон компаниуд ч “Гүүгл” компани шиг чөлөөтэй нээлттэй ажлын орчныг бүрдүүлж болно. Гэвч Солонгос улсын компаний удирдлагууд нэг хэвийн тогтсон хэв маяг, дүрэм журманд баригддаггүй бүтээлч чадвар бүхий боловсон хүчин, хоорондоо харилцан ярилцан асуудлыг шийдвэрлэдэг тогтолцоог бий болгож чадах эсэх нь өнөөг хүртэл эргэлзээтэй байгаа юм.

Цээжлэх чадварын нууц

Соломон Сэрашебски гэдэг Орос гаралтай Еврей хүн бол хоорондоо ямар ч хамааралгүй олон зуун үгийг зөвхөн нэг удаа сонсоод дэс дарааллаар нь хэлж чаддаг "гайхалтай ойл тогтоолтын чадвартай" хүн юм. Түүний энэхүү ой тогтоолтын чадварын нууц бол төсөөлөн бодох чадвар юм. Тэрээр тоо болон үгнүүдийн дуудлагыг нарийн тодорхой дүр төрхтэй холбон ямар нэгэн өнгө, амт мэтээр төсөөлөн боддог. Тэрээр 5 мэдрэхүйгээ дээд зэргээр ашигладаг бөгөөд ямар нэгэн үгийг сонсмогцоо өнгө, амт мэт зүйлсээр орлуулан мэдэрч чаддаг. Үүгээр зогсохгүй бүр хүний хэлж ярьж байгаа үгээр дамжуулан зовлон бэрхшээлийг хүртэл мэдэрч чаддаг байна. Хүмүүсийн дуу хоолойг сонсохдоо ч гэсэн ялгаагүй эдгээр чадваруудаа ашигладаг. Тэрээр "Чиний дуу хоолой яг л тун удахгүй хагарах гэж байгаа зүйл шиг шар өнгөтэй байна" "Даавуу энд тэндээс нь цухуйн гарсан юм шиг галын дөл намайг чиглэн даган ирж байна" гэх мэтээр сонин хачин дүрслэн төсөөлөн бодох аргыг ашигладаг. Тэрээр ганцхан удаа явж үзсэн замынхаа талаар хэзээ ч хамаагүй сайн санаж чаддаг. "Тэр зам дээр байсан хашааны амт маш шорвог, хурц ширүүн ямар нэгэн зүйлийг нэвтлэн гарч ирж байгаа юм шиг дуу чимээ гарч байсан" гэх мэтээр төсөөлөн ярьдаг байна.

Уран сэтгэмж бодит үзэл баримтлалаараа алдартай Аргентин улсын зохиолч Хурхэ Рүис Бурхэс-ийн бүтээлүүдийн дунд "Гайхалтай ой тогтоолтын чадвартай Пүнэс" гэсэн бүтээл байдаг. Зохиолын гол баатар болох Пүнэс нь төгс ой ухаантай эмэгтэй юм. Тэр зөвхөн нэг удаа харж, сонсож, мэдэрсэн зүйлээ хэзээ ч мартдаггүй. Усан үзмийн мөлхөө ургамлын ишэнд байгаа бүх төрлийн нахиа, мөчир болон үр жимсийг мэдэрч чаддаг бөгөөд нилээн дээр харсан өмнө зүгт тэнгэрт хөвж байсан үүлний хэлбэрийг ч сайн санаж чаддаг байна. Зөвхөн нэг удаа харсан номынхоо шугам хэлбэр дүрс, голын хөөс, харсан үүлнийхээ хэлбэр дүрсийг хүртэл санаж чаддаг. Англи, Франц, Португаль, Латин хэлийг ч маш амархан сурсан байна.

Соломон Сэрашебски бол яг л Пүнэсийн хойд нас шиг авъяас чадвартай нэгэн юм. Тэрээр хоорондоо ямар ч хамааралгүй хэдэн зуун үгийг ганцхан удаа сонсоод дэс дарааллаар нь хэлж чаддаг "агуу ойл тогтоолтын чадвартай" хүн юм. Үг болон тоо, үсэг гэх мэт олон зүйл холилдсон жагсаалтыг ч гэсэн ганцхан удаа хараад л цээжилчихдэг байна. Түүний энэхүү чадварын нууц бол чөлөөтэй төсөөлөн бодох чадварт үндэслэсэн дүрслэн бодох арга юм. Ямар нэгэн үг сонсвол таван мэдрэхүйгээ ашиглан нарийн тодорхой дүр төрхтэй холбон санадаг байна. Тоог өнгөтэй, дуудлагыг амттай, хэлбэр байдлыг дуу хоолойтой холбодог гэсэн үг юм.

Тэрээр "Чиний дуу хоолой яг л тун удахгүй хагарах гэж байгаа зүйл шиг шар өнгөтэй байна" "Даавуу энд тэндээс нь цухуйн гарсан юм шиг галын дөл намайг чиглэн даган ирж байна" гэх мэтээр сонин хачин дүрслэн төсөөлөн бодох аргыг ашигладаг. Тэрээр ганцхан удаа явж үзсэн замынхаа талаар хэзээ ч хамаагүй сайн санаж чаддаг. "Тэр зам дээр байсан хашааны амт маш шорвог, хурц ширүүн ямар нэгэн зүйлийг нэвтлэн гарч ирж байгаа юм шиг дуу чимээ гарч байсан" гэх мэтээр төсөөлөн ярьдаг байна.

Эран Кач гэдэг хүн 500 ширхэг тоог нэг удаа сонсоод дэс дараагаар нь цээжлэн гайхалтай ой тогтоолтын чадвараараа Геннисийн номонд бичигдсэн Еврей хүн юм. Тэрээр "Хүний тархи

гэдэг зүйл бол хэр зэрэг дасгалжуулахаас шалтгаалдаг” гэж хэлсэн байдаг. Хүний тархин доторх эс биеийн булчинтай адилхан байдаг. Тийм болохоор булчинг дасгалжуулж байгаа юм шиг тархиа дасгалжуулж чадвал хэн ч байсан амжилт гаргаж чадна гэсэн үг юм. Эран Кач ой тогтоолтын чадвараа сайжруулахын тулд төсөөлөн бодох чадвараа ашигладаг байна.

Эран Кач “Гиматриа(Gimatria)” гэж нэрлэгддэг Еврейчүүдийн ой тогтоолтын чадвар сайжруулах аргыг ашигладаг. Энэ нь 1-20 хүртэл тоог сонгон тоо тус бүрийг тогтооход амархан тэмдэглэгээгээр тэмдэглэсний дараа тэмдэглэгээ тус бүрд санахад амархан үгийг оноож тавих арга юм. Тооны оронд цагаан толгойн үсгээр солин тогтоох арга юм. 2 ширхэг тоог ашиглан 1 ширхэг үгийг бүтээвэл 40 ширхэг тоо нь 20 ширхэг үг болдог бөгөөд 20 ширхэг үг нь 40 ширхэг тоо цээжлэхээс амархан байдаг.

“Мэдлэгээс илүү чухал зүйл бол төсөөлөн бодох чадвар” (Алберт Эйнштэн)

“Төсөөлөн бодох чадвар бол хүн төрөлхтний үндсэн чадваруудын нэг. Төсөөлөн бодох байдлаар дамжуулан бид бодит байдлаас ангижран бодол санааны ертөнцөд хязгааргүй эрх чөлөөг мэдэрч чаддаг. (Томас Муо)

Микрософт компаний цорын ганц үнэ цэнэтэй хөрөнгө бол хүний төсөөлөн бодох чадвар. (Билл Гейтс)

Төсөөлөн бодох чадвар гэж “Нэг хэвийн тогтсон хэв маягаар бий болсон энгийн зүйлийг шинэ хэлбэрээр дахин бүрдүүлдэг оюун санааны үйлдэл юмуу дүрслэн бодох үйл ажилагаа юм. Тухайлбал ямар нэгэн зүйлийг сэтгэл дотроо төсөөлөн зурах чадварыг хэлдэг. “Шинэ бодол санааг бий болгодог чадвар” болох бүтээлч чадвар нь төсөөлөн бодох чадвараар дамжин хөгжиж байдаг.

Еврей сургааль үгэнд “Учир шалтгаангүй зүйл төсөөлөн бодох чадвараар дамжин учир шалтгаантай зүйл болон хувирч чаддаг” гэсэн үг байдаг. Дундад зууны үед амьдарч байсан нэг хүн “Хожмын нэгэн өдөр хүн төрөлхтөн сар луу явна” гэж хэлж байсан бөгөөд тухайн үед энэ хүний ярьсан зүйл хүмүүст ямар ч утга учиргүй зүйл мэт санагдаж байсан нь мэдээж юм. Гэвч өнөөдөр хүн төрөлхтөн пуужин зохион бүтээн саран дээр нэгэнт хөл тавиад байна. Хүн төрөлхтөнд тэнгэрт шувуу шиг дүүлэн нисэхийг хүссэн төсөөлөл байсан учраас онгоц бүтээгдэн загас шиг усан доогуур шумбахыг хүссэн төсөөлөл байсан учраас усан онгоц бүтээгдсэн юм. 3D кино Аватар (Avatar) ч, “Apple” компаний “I Pad”, “I Phone” ч төсөөлөн бодох чадварын бодит үр дүнд бий болсон зүйлс юм. Төсөөлөн бодсоноор бодит зүйл болдог.

Нью-Йорк Таймс (New York Times) сонины редактор Томас Фридмэн (Thomas Friedman) төсөөлөн бодох чадварын чухал чанарын талаар “Сүүлийн үед интернэтийн сүлжээгээр аалзны шүлс шиг хэрсэн дэлхий ертөнцөд улс орны эдийн засгийн өрсөлдөөний хамгийн чухал элемент бол улс хооронд юмуу компани хоорондын өрсөлдөөн биш, хувь хүн болон тухайн хүнд байгаа төсөөлөн бодох чадвар юм. Миний ажигласнаар сүүлийн үед хүүхдүүдийн ямар нэгэн зүйлийг төсөөлөн бодох чадвар дээр үетэй харьцуулахад маш сайн болсон байгаа юм. Өнөө үед дэлхий ертөнцийн бүхий л зүйлс улам амар хялбар боловсронгуй болсоор байгаа бөгөөд энэ цаг үед бидний хамгийн амархан өөртөө бий болгож чадах зүйл бол төсөөлөн бодох чадвар” гэж хэлсэн байна.

Еврей хүмүүс өөрийгөө хөгжүүлэхийн тулд төсөөлөн бодох чадвараа сайжруулдаг уламжлалтай болсон шалтгаан нь үнэндээ тэдний шүтдэг “Хийсвэр оршин байдаг Бурхан” гэсэн ойлголттой нь нягт холбоотой юм. Бусад улс үндэстэн хөрөг шүтээн бүтээн түүнийгээ тахиж шүтэж байхад Еврей хүмүүс нүдэнд үл харагдах ер бусын гайхалтай оршигч амьд Бурхан байгаа гэж итгэдэг байна. Тухайлбал төсөөлөн бодох хүч чадлаараа амьд Бурхан оршин байгаа гэж боддог бөгөөд төсөөлөн бодох байдлаа бодит байдалтай холбосон гэсэн үг юм.

Туршлага хүний төсөөлөн бодох чадварт нөлөө үзүүлдэг. Бүгдээрээ нүдээ аниад далайн эргийн нар жаргаж буй байдлыг төсөөлөн бодоод үзэцгээе. Хүн болгонд өөр өөрийн үзэж харсан далайн эргийн нар жаргаж буй байдал ч юмуу киноноос үзсэн Хавайн сувдан арлын нар жаргаж буй байдал гэх мэт урьд өмнө нь үзэж харж байсан бүхэн санаанд орох нь мэдээж юм. Харин өөрөө урьд өмнө нь явж үзэж байгаагүй газрын нар жаргаж байгаа байдлыг төсөөлөн бодоод үзвэл хар ухаанаар бодож байснаас өөр дүр зураг харагддаг. Нэг ч удаа харж байгаагүй хүн, эд зүйл, газар зэргийн талаар төсөөлөн бодон шинэ зүйлийг туршиж үзэх нь бүтээлчээр төсөөлөн бодох чадварыг хөгжүүлэх хамгийн сайн арга юм. Иймэрхүү төсөөлөн бодох чадварын үндсэнд тулгуурлан ямар нэгэн зүйлийг ой ухаандаа дүрслэн бодох байдлаар дамжуулан ой тогтоолтынхоо чадварыг сайжруулах нь Еврей хүмүүсийн арга юм.

Сурна гэдэг бол мэдэхгүй зүйлээ сайтар судлан түүний талаар ойлголт чадвараа нэмэгдүүлэхийг хэлдэг. Мөн ой тогтоолтын чадварыг аливаа зүйлийг сурах үндэс суурь ч гэж ярьдаг. Хүний тархи судлалын эрдэмтэд хүний тархинд тусгай уургийн дагуу уялдаа холбоо бий болон богино хугацааны ой санамжийн тодорхой хэсэг урт хугацааны ой санамж болон өөрчлөгддөг гэж тайлбарласан байна. Ой ухааны уургийг бий болгодог гол зүйл бол сурах юм. Еврей хүмүүс төсөөлөн бодох чадварыг ашигласан ой санамжийн чадварын нууц арга барилыг ашиглан сургалтынхаа үр дүнг сайжруулж чаддаг. Үүнийг тэдний нийгмийн бүхий л салбарт том амжилт гаргаж буй нууцуудынх нь бас нэг гэж хэлж болно.

Солонгос улсын сурагчид анхан шатны боловсрол, хичээлийн программ түрүүлж үзэхдээ ихээхэн цаг хугацаа хөрөнгө мөнгө зарцуулдаг. Солонгос хүмүүсийн хувьд ерөнхийдөө сурна гэдэг маш их өрсөлдөөн бараг багахан хэмжээний дайн болдог гэсэн үг юм. Олон улсын дунд сургууль, тусгай сургалттай ахлах сургууль гэх мэт сургуульд суралцан бага сургуулийн үедээ математикийн тэгшитгэлийг урьдчилан суран дунд сургуулийн үедээ математикийн функц болон анализ хийх гэх мэт зүйлийг сурчихдаг. Гэвч нэг харамсалтай зүйл гэвэл сурагчид ингэж их хичээл ном хийсэн ч толгойд нь үлдсэн юм бараг байдаггүй. Зүгээр л сурч байх явцдаа бусад сурагчидтай өрсөлдөн шалгалтандаа сайн үнэлгээ авахын тулд хамаг хүчээ дайчилснаас цаашгүй зүйл болдог бөгөөд толгойд нь тодорхой үлдсэн зүйл бараг нэг ч байдаггүй.

Мэдлэг нь “урлаг” хэмээх нэг талын далавчаа зүүж байж нисэж чаддаг

“Бүх шинжлэх ухаан урлагт байдаг. Бүх урлагт шинжлэх ухааны онцлог агуулагддаг. Хамгийн муу шинжлэх ухааны эрдэмтэн гэвэл урлагийн хүн биш эрдэмтэн бөгөөд хамгийн муу урлагийн хүн гэвэл эрдэмтэн биш урлагийн хүнийг хэлнэ. (Францийн физикч Арманд Троусси (Armand Trousseau). Еврей хүмүүс зөвхөн гадаад хэл, тооны ухаан, шинжлэх ухаан гэлтгүй урлагийн хичээлийг ч гэсэн чухалчлан үздэг. Бага наснаасаа эхлэн хөгжмийн боловсролдоо анхааран суралцдаг учраас хамгийн багадаа л гэхэд хөгжмийн нэг зэмсгийг маш сайн эзэмшсэн байдаг. Урлагт хэрэглэгддэг төсөөлөн бодох хэрэгсэл нь хүмүүнлэгийн ухаан төдийгүй шинжлэх ухааны салбарт ч гэсэн чухал нөлөө үзүүлдэг. Боловсролын хамгийн том зорилго бол болж өгвөл бүх сурагчдыг зураач, шинжлэх ухааны эрдэмтэн, хөгжимчин, математикч, бүжигчин гэх мэт олон талын чадвартай болгох байдаг бөгөөд зөвхөн өөрийн сонирхож сонгосон салбараас бусдыг мэддэггүй боловсон хүчнийг бий болгодог соёл хүмүүжлийн хичээл болон шинжлэх ухааны хичээл нь ямар ч утга учиргүй зүйл гэж Еврей хүмүүс боддог.

“Хүүхдээ эрдэмтэн болгохыг хүсэж байвал урлагийн талаар ч мөн заах хэрэгтэй, урлагийн хүн болгохыг хүсэж байвал шинжлэх ухаан ч мөн заах хэрэгтэй”

Суут ухаантнуудын сэтгэн бодох арга барилын талаар судлан “Бодол төрөх” гэсэн ном бичин хамгийн сайн борлуулалттай номоор шалгаран дэлхий дахинд нэр алдартай болж чадсан Рүт Бэрнстин (Root Bernstein)-ий гэр бүлийн талаар сонирхоцгооё. Нөхөр Роберт Рүт Бэрнстин (Robert Root Bernstein, 57 нас) нь эрдэмтэн /АНУ-ын Мичикан мужийн их сургуулийн физиологийн тэнхмийн багш/ бөгөөд түүнтэй нас чацуу түүний эхнэр Мишел (Michel) нь түүх ч /Мичиканий их сургуулийн багш/ юм. Эхнэр нөхөр хоёр олон зуун шинжлэх ухааны эрдэмтэн, математикч, урлагийн хүмүүсийн сэтгэхүйн талаар судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнд эдгээр хүмүүс ямар нэгэн байдлаар урлагийн талаар сонирхолтой үүгээрээ дамжуулан бүтээлч хүн болж чадсан гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна.

“Бодол төрөх” гэсэн ном ч гэсэн урлагийн талаар сонирхолтой эрдэмтэн эхнэр нөхөр хоёрын хамтын бүтээл юм. Роберт 10 жил морин хийл тоглосон бөгөөд фото зураг, урлагийн бүтээл, ямар нэгэн зүйлийн загвар зохион бүтээх гэх мэт зүйлд ихээхэн сонирхолтой байна. Тэрээр “Нарийн зураг ажиглах юмуу пластикаар ямар нэгэн зүйлийн загвар зохион бүтээх гэх мэт сонирхол нь уураг хэрхэн бүрэлдэх, эс хэрхэн хувьсан өөрчлөгдөж байгаа зэргийг судлахад ихээхэн тус болдог. Хамгийн сайн компьютерыг ашиглаж буй эрдэмтнээс ч илүү хурдан загварыг төсөөлөн бодож чаддаг. Хөгжим ч гэсэн ялгаагүй бүтээлч чанарыг ойлгон ном бичихэд ихээхэн тус болдог” гэж хэлсэн байна.

Мишел ч гэсэн нөхрийнхөө үзэл бодолтой адилхан бодолтой хүн юм. “Эйнштэнтэй адилхан гайхалтай оюун ухаантай эрдэмтэд бүгд урлагт сонирхолтой хүмүүс байсан бөгөөд өөрсдийн сонирхлоороо дамжуулан сонгосон салбартаа гарамгай амжилт гаргаж чадсан байна. Мишел “Хүн түүхийн ухааны талаар суралцахдаа төсөөлөн бодох чадвар байхгүй бол судалгааны сайн үр дүнд хүрэхэд хэцүү” гэж хэлсэн байдаг. Түүхийн ухааны тухайд өгөгдсөн бодит байдал дотор аль болох дэлхий ертөнцийг төсөөлөн бодож байж л нөхцөл байдлыг ойлгож ухаарч чаддаг. Тиймээс энэ эхнэр нөхөр хоёр хүүхдүүдээ өсгөхдөө хамгийн их анхаарсан зүйл

нь урлагийн талын янз бүрийн хичээлийг хүүхдүүддээ түлхүү зааж сургасан байна.

Рүт Бэрнстиний гэр бүл шинжлэх ухааны салбарын Нобелийн шагнал авсан 510 хүн болон энгийн /Английн хааны нэрэмжит нийгэмлэг, АНУ-ын улсын шинжлэх ухааны хорооны гишүүн гэх мэт/ эрдэмтдийг харьцуулан судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнд Нобелийн шагнал авсан эрдэмтэд энгийн эрдэмтдээс илүү хөгжимчин болж чадах магадлал 4 дахин их, зохиолч юмуу шүлэгч болох магадлал 25 дахин их болохыг олж мэдсэн байна. Үнэндээ Эйнштэнийг хөгжим хойноос нь түлхэж өгсний хүчинд харьцангуйн онолыг нээж чадсан гэж ярьдаг. Тэрээр “Эцэг эх маань намайг 6 настайгаас минь эхлэн хийл хөгжим тоглуулж сургасан. Миний энэ нээлт бол хөгжмийн үр дүн” гэж хэлсэн удаа ч бий.

“Хөгжим сурангаа өмгөөлөгчийн хувьд үйлчлүүлэгчийнхээ байр суурийг нэг шат илүү харж чадах мэдрэмжийг өөртөө бий болгож чадсан” гэж ярьдаг өмгөөлөгч, дуучин И Ин Мин /32 нас, тайзны нэр/ 2009 оны 09-р сард 2 дахь альбом болох “Rihart”-аа гаргасан бөгөөд тэрээр хөгжмийг сонирхол биш бас нэг мэргэжлээрээ тооцсон байна. Энэ эмэгтэйн хувьд бага наснаасаа эхлэн хөгжимгүй амьдралыг огтхон ч төсөөлж байгаагүй юм. Тиймээс их сургуульд элссэнийхээ дараа гоцлол дуучнаар ажиллаж байсан бөгөөд хуулийн шалгалтанд бэлдэж байхдаа ч агентлагт очин жүжигчний сонгон шалгаруулалтанд хүртэл орж байсан байна. Өөрийнхөө дуу хоолойг бусдад хүлээн зөвшөөрүүлэхийг хүсдэг энэ эмэгтэй дуучин болох мөрөөдлөө орхиогүй бөгөөд олон улсын хууль зүйн маргаан хариуцдаг хууль зүйн томоохон компанид өмгөөлөгчөөр 4 дэхь жилдээ ажиллаж байгаа нууц юу юм бол. Өөрийнх нь хэлж байгаагаар бол хөгжим юм.

2010 оны эхээр Кёнги Юнин гадаад хэлний ахлах сургуулийг төгссөн Гүон Хы Вон/19 нас/ сурагч АНУ-ын хуурай замын цэргийн академи төдийгүй АНУ-ын 6 их сургуулиас элсэн суралцах урилга авсан байна. Гүон нь 1-р курсдээ сагсан бөмбөгийн дугуйланд явдаг байсан бөгөөд хичээл тарсны дараа таеквондогоор тасралтгүй хичээллэн ахлах сургуулийн 3-р ангидаа таеквондогийн 2-р зэрэгтэй болсон байна. Ахлах сургуулийн 3-р ангийн 1-р семестр хүртлээ сургуулийн лакросс /хоккейтэй төстэй спорт/-ын дугуйланд яван тэмцээнд ч оролцож байжээ. Эргэн тойрных нь хүмүүс “Гаргасан амжилт байхгүй байж ингэтлээ спортоор хичээллээд байх хэрэг байгаа юмуу” гэж түүнд хэлдэг байсан ч Гүон спортоор сайн хичээллэвэл биед хуримтлагдсан ядаргаа стресс амархан тайлагддаг. Тийм болохоор хичээл ном хийх үед төвлөрөх чадвар сайжирдаг гэж тэдэнд хэлдэг байв. Сул дорой идэвхигүй байдлаа биеийн тамираар хичээллэн өөрчилж чадан өөртөө итгэх итгэлтэй болж чадсан нь түүний амжилт гаргасан нууц юм.

Түүний биеийн тамирын олон төрлөөр хичээллэж байсан нь түүнийг их сургуульд элсэн ороход ихээхэн тус болсон байна. Их сургуульд элсэн орох анкетандаа өөрийн хичээллэж байсан спортын төрлүүдийнхээ талаар бичсэн бөгөөд өөрийнхөө танилцуулга дээр ч спортын төрлөөр гаргасан амжилт, туршлагаа нарийн тодорхой бичсэнээр сургуулиудаас өндөр үнэлгээ авч чадсан юм. АНУ-ын их сургуулиуд нилээн дээр үеэс эхлэн хөгжим, урлаг, биеийн тамир гэх мэт олон талын авъяас чадвартай боловсон хүчнийг илүүд үзсээр ирсэн. Ийм чадвартай сурагчид бүтээлч чадвар, удирдах чадвар болон харилцах чадварын хувьд гайхалтай сайн байдаг учраас юм. АНУ-ын Харвардийн их сургуулийг төгссөнийхөө дараа НҮБ-ийн гамшигт нэрвэгдэгсдийн байгууллагад ажиллаж эхэлсэн Сон Су Ра /25 нас/ ч гэсэн

бага наснаасаа эхлэн сурсан хөгжмийнхөө авьяас чадварыг сургуульд элсэн ороходоо ашигласан жишээ байдаг. Сон Харвардийн их сургуульд сурч байхдаа төгөлдөр хуур, хийл зэрэг хөгжмийн зэмсгээр хөгжим тоглосон CD болон ахлах сургуулийн үедээ зурсан зураг зэргээрээ сургуулийн зүгээс өндөр үнэлгээ авч чадсан юм.

Ирээдүй нь олон талт чадвартай боловсон хүчний эрин үе, хүүхдийнхээ сонирхож буй салбарыг нэмэгдүүлэх

Еврей гаралтай АНУ-ын иргэн Томас Фридмэн(Thomas Friedman) "Дэлхий бол хавтгай", "Лексус болон оливийн мод", "Бейрутээс Иерусалим хүртэл" гэх мэт дэлхийд алдартай зохиолуудыг бичсэн бөгөөд Пулитзерийн шагналыг 3 удаа авч олонд танигдсан хэвлэл мэдээллийн салбарын ажилтан юм. Тэрээр АНУ-ын Брэндайс (Brandies) их сургуульд газрын дундад тэнгисийн талаар мэргэжил эзэмшин Английн Оксфордын их сургуульд Дорнодын ухааны чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан байна. Түүний дараагаар Бэрүт(Beirut)-ийн сурвалжлагчаар удаан хугацааны турш ажилласан бөгөөд "Wall street" сэтгүүлийн санхүүгийн ажилтнаар ч ажиллаж байсан туршлагатай нэгэн юм. Тэрээр "глобалчлал"-ын талаар алдартай олон арван ном бичиж чадсан нь түүний Дорнодын түүхийн талаарх мэдлэг болон Дорнодын улс оронд сурвалжлагчаар ажиллаж байсан ажлын туршлага, "Wall street" сэтгүүлд ажилласан туршлага зэргийнх нь хүч юм. Тусгай салбараас хуримтлуулсан мэдлэг болон туршлагаа бусад мэдлэгтэй холбон шинэ үнэ цэнийг бий болгосон гэсэн үг юм.

"Атомын бөмбөгний эцэг" хэмээн нэрлэгддэг Герман гаралтай Еврей хүн Роберт Оппеннхимер (Robert Oppenheimer) бага байхдаа бусад хүүхдүүдтэй сайн таарч тохирдоггүй хүүхэд байжээ. Найз нарынх нь түүнд өгсөн хоч "Сүнсгүй золиг" гэсэн хоч байв. Түүний үйл хөдлөл маш болхи удаан байсан бөгөөд ямар нэгэн асуудал тулгарвал царай нь минчийж улайн сэтгэлзүйн хувьд хүнд байдалд ордог нэгэн байв. Хэдийгээр ийм бүрэг ичимхий зан чанартай байсан ч түүний эцэг эх хүүхдийнхээ авъяас чадварт найдан олон янзын зүйл хийхэд нь идэвхитэйгээр тусалж дэмждэг байсан байна. Тухайн үед АНУ-д хамгийн ирээдүйтэй сургуульд тооцогдож байсан Нью-Йоркийн төв паркын баруун талд байрладаг "Ethical Culture School"-д хүүгээ явуулсан нь хүүхдийнхээ сонирхлыг улам нэмэгдүүлэхийн тулд байсан юм. Энэ сургуулийн тухайд сургалтын арга барилаараа сурагчдад "Хүн өөрөө дэлхий ертөнцийг өөрчилж чадах эзэн нь гэсэн өөртөө итгэх итгэлийг" бат суулгаж өгдөг байв.

Бага, дунд, ахлах сургуульд суралцаж байх үедээ тэрээр эрдэс бодисын дээж цуглуулах, физик, хими мөн уран зохиолд сонирхолтой болсон байна. Тэрээр бага наснаасаа эхлэн маш олон төрлийн чулуу цуглуулсан бөгөөд 12 настайдаа Нью-Йорк хотын газар зүйн эрдэмтэдтэй хамт үндэсний хүрээлэнгээс олсон чулууныхаа бүтцийг судлан Нью-Йорк хотын газар зүйн хүрээлэнгээс урилга хүртэл авсан байна. Тэрээр хэл шинжлэлд ч маш сонирхолтой байсан. Германы "Готтенген(Gottengen)" их сургуульд суралцаж байхдаа Данте(Dante) гэдэг зохиолчийн "Тэнгэрлэг туульс" зохиолыг эх хувилбараар нь уншихын тулд Итали хэл сурсан бөгөөд UC Berkeley-д Энэтхэгийн гүн ухаанд сонирхолтой байсан болохоор Санскрет хэлийг /Энэтхэгийн эртний хэл/ сурсан байдаг. Ахлах сургуулийн үедээ Хомерос(Homeros), Платон(Platon) зэрэг зохиолчдын бүтээлийг уншихыг хүсэн Грек (Хираб хэл) хэлийг сурсан байна.

Түүнийг нас барахаас 1 жилийн өмнө болох 1966 онд Принстон(Princeton) их сургуулиас түүнд олгосон докторын дипломон дээр нь "Физикч, далайчин, гүн ухаантан, илбэчин, хэл судлаач, тогооч, дарс болон шүлгийн хорхойтон" гэж бичсэн байжээ. Түүнд ажлын туршлага

гээд байх зүйл огт байхгүй онолын физикч байсан ч олон мянган эрдэмтдийг удирдан атомын бөмбөгийн хөгжилд амжилт гаргаж чадсан нь хүмүүнлэгийн ухаан болон байгалийн ухааныг давсан олон төрлийн судалгааны туршлагаар дамжуулан боловсролын тогтолцоо болон судалгааны чухал чанарыг ойлгосон учраас юм.

Нэгэн эмэгтэй “Би бүр багаасаа эхлэн шүлгэнд чин сэтгэлээсээ хайртай болсон. Шүлгийн хэлбэр болон хэмнэл надад маш их таалагдан намайг догдлуулдаг байсан. Миний зүрх сэтгэлийг хөдөлгөж чадсан Оросын шүлэгчдийн шүлгийг маш олныг цээжилсэн. Үнэндээ шүлэг унших тусам гоё санагддаг. Шүлгэнд хэтэрхий их татагдан дуртай болсон учраас би 5 настайгаасаа эхлэн өөрөө шүлэг бичиж эхэлсэн. 12 нас хүрээд би шүлэгч болно гэсэн бодолдоо жаахан ч гэсэн эргэлзэхээ больсон” гэж хэлсэн байна.

Том болоод шүлэгч болно гэдэгтээ баталгаатай байсан энэ эмэгтэй бол Европоос хамгийн анх удаа их сургуулийн эмэгтэй багш болсон Оросын математикч Софиа Ковалевскаяа (Sofia Kovalevskaya) юм. Тэрээр хувийнхаа намтарт ингэж бичсэн байдаг. “Хүмүүс намайг утга зохиол болон тооны ухааныг хамтад нь судалсан гэвэл гайхах байх. Тооны ухааны талаар сайн сурч чаддаггүй хүмүүс тооны ухааныг тоо бодлоготой хольж хутган маш хэцүү сонирхолгүй шинжлэх ухаан гэж бодон орхидог. Харин тооны ухаан бол маш их төсөөлөн бодох чадвар шаарддаг шинжлэх ухаан юм. Нэгэн агуу математикч “Оюун сүнсний хувьд шүлэгч болохгүй бол математикч болж чадахгүй” гэж хэлсэн байдаг. Шүлэгч хүн бусад хүний харж чаддаггүй зүйлийг олж хардаг бөгөөд бусад хүнээс илүү гүнзгий тунгаан бодож чаддаг. Яг л математикч хүнтэй адилхан”

Зохиолч Роберт Шуманн(Robert Schumann)-ий бодол ч гэсэн үүнтэй төстэй юм. Тэрээр “Боловсрол мэдлэгтэй хөгжимчин гэвэл Раффаелло(Raffaello) зураачийн Мадонна (Madonna) зургийг судлах хэрэгтэй. Зураач гэвэл Моцартийн найрал хөгжмийг сонсох хэрэгтэй. Ингэснээр давуу тал бий болж чадна. Мөн жүжигчин хүн сийлбэр хийж сурвал үйл хөдлөлөө сайн хянадаг болдог бөгөөд сийлбэрчин хүн жүжгийн талаар судласнаар бүтээл нь жүжигтэй адилхан амьд болдог. Зураач хүн шүлгийг зураг шиг өөрчлөн хөгжимчин хүн зурганд хөгжмийн хэмнэлийг оруулж чаддаг” гэж хэлсэн байна.

2005 оны 04 сард АНУ-ын Харвардын их сургуулийн Эдвард Уолсон (Edward Wilson) багшийн бичсэн “Мэдлэгийн нэгдэл” гэсэн ном орчуулагдан гарснаар “нэгдэл” гэсэн үг Солонгос улсын нийгэмд нэг хэсэг гол ярианы сэдэв болсон юм. Уолсон багш хүмүүнлэгийн ухаан, нийгмийн шинжлэх ухаан, урлаг гэх мэт зүйл бүгд хүн төрөлхтний талаарх эрдэм мэдлэг учраас генетикийн ухаан, хувьслын ухаан, тархины шинжлэх ухааныг үндэслэн дахин тайлбарлан нэгдүүлэх боломжтой гэж ирээдүйн төлөв байдлын талаар номондоо бичсэн байна.

Энэхүү номыг орчуулсан Ихуа эмэгтэйчүүдийн их сургуулийн Чой Жэ Чон багш “Худгийг гүнзгий ухахын тулд өргөн ухах нь нэгдэл” гэж хэлсэн байна. Чой багш өнөөг хүртэл янз бүрийн эрдэм ухааны үсрэнгүй хөгжлийг олон талт мэдлэгийн нэгдэл бий болгосон гэж ярьдаг. Физикийн ухаан юмуу химийн ухааныг судалсан хүмүүс биологийн ухааны салбарт ч гайхалтай амжилт гарган молекулын биологийн ухааныг шинээр бий болгож чадсан нь үүний нэг жишээ юм. Өнгөрсөн үеийн биологийн ухааны эрдэмтэд бүх зүйлд ихээхэн анхаарал хандуулдаг байсан. Харин физик болон химийн ухааны эрдэмтэд дүн шинжилгээ хийх чадвар

нь гайхалтай сайн байсан бөгөөд эдгээр хүмүүс биологийн ухааны салбарт анхаарал хандуулан шинэ хүрээллийг бий болгож чадсан гэж тайлбарладаг.

АНУ-ын Харвардын их сургуульд 1933 онд байгуулагдсан ‘Society of Fellows’ гэдэг судалгааны байгууллага байдаг. Гүн ухаан, тооны ухаан, биологийн ухаан гэх мэт янз бүрийн салбарын томоохон байр суурь бүхий хүмүүс цугларан хэлэлцээр ярилцлага хийдэг газар бөгөөд энэ газар нь өнөөдрийг хүртэл Нобелийн шагналтан 17 хүн, Пулитзерийн шагналтан 20 хүнийг төрүүлээд байгаа юм. Мичиганий их сургуульд ч үүнтэй төстэй уулзалт хэлэлцээр хийдэг газар байдаг. Энэхүү уулзалтанд тасралтгүй 3 жилийн хугацаанд оролцон томоохон хэмжээний 150 орчим сэдвийн талаар хэлэлцэж ярилцаж байсан туршлага бүхий Чой багш “Хүмүүс хоорондын хэлэлцэж ярилцах явцаас шинэ мэдлэг, шинэ судалгааны арга зам үүсдэг” гэж тайлбарлан хэлсэн байна.

Сурч боловсрохын үндэс бол бодит үнэнийг судалж мэдэх юм. Жишээ нь зааны зөвхөн хөлөнд нь хүрэх биш зааны дүр төрхийг бүхэлд нь харж байж заан гэдэг амьтны бодит байдлыг таньж мэднэ гэсэн үг юм. Гэвч өнөөгийн хүмүүсийн сурч боловсорч буй байдал мэргэшил гэсэн нэрийн доор хүрээлэл нь бага багаар улам олон жижиг хэсэг болон хуваагдан салж нарийвчлагдан олон янз болж байна. Хатуу ширүүн өрсөлдөөнтэй нийгэм хүмүүсийн амьдралын эрх чөлөөг булаан одсон юм шиг бидний сурч боловсрох цар хүрээнд ч гэсэн ямар нэгэн зүйлийн талаар нарийн судлах чиг хандлага улам нэмэгдэж байна. Өнөө үед хүмүүс янз бүрийн салбарын талаар мэдлэгтэй болохоос илүү зөвхөн өөрийнхөө сонгосон салбарт бүх анхаарлаа хандуулж байна.

Хэдийгээр ийм боловч энэхүү байдлыг өөрчлөн олон талын цогц мэдлэгээр дамжуулан хүн төрөлхтний түүхэнд үлдэж чадах гайхалтай амжилтыг гаргах боломж хүн болгонд байгаа юм.

Тэгвэл бид хүүхдээ нэгдмэл олон талт боловсролын чадвартай болгохын тулд юу хийх хэрэгтэй вэ? Эмч, компьютерийн вирусын мэргэжилтэн, шинээр нээгдэж буй компаний захирал, шилдэг борлуулалттай ном бичин одоо Солонгос улсын шинжлэх ухаан технологийн (KAIST) хорооны удирдлагын ухааны докторантурын сургуулийн багшаар ажиллаж байгаа Ан Чол Сү доктор /48нас/ “Ирээдүй бол олон талын нэгдмэл мэдлэг боловсрол бүхий боловсон хүчний эрин үе” гэж онцлон хэлсэн байна.

Ан докторын хамгийн их чухалчилдаг зүйл бол дэлхийн хэмжээгээр сэтгэн бодох юм. Ингээд бодоход гадаад хэл үндэс суурь болж байгаа юм. Глобалчлалын энэ эрин үед янз бүрийн соёл иргэншилтэй хүмүүс хоорондын харилцаа холбоо өсөн нэмэгдэж байгаа бөгөөд эдгээр зүйлийг холбож өгөх зам болох гадаад хэл, тэр тусмаа Англи хэлийг хичнээн сайн сурсан ч илүүдэхгүй юм. Харин Англи хэлний чадвар гайхалтай сайн байлаа гээд дэлхийн хэмжээгээр бодож сэтгэнэ гэсэн үг биш юм. Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамт янз бүрийн ном уншин тунгаан бодож хоорондоо харилцан ярилцах аргаар хүүхдийнхээ дэлхийн хэмжээгээр сэтгэн бодох чадвар, цар хүрээг нэмэгдүүлж чадна. Харин дэлхий ертөнцийн талаар нарийн тодорхойлолт шийдвэрийг хүүхэд өөрөө гаргах нь үр дүнтэй төдийгүй чухал зүйл юм.

Глобалчлалын энэ цаг үед бусдын манлайлагч больё гэвэл бусдын бий болгосон арга барилаас өөрөөр сэтгэн бодож бүтээлчээр асуудлыг шийдвэрлэх чадвараа сайжруулах хэрэгтэй. Үүний тулд мэдээж өөрийн сонгож эзэмшсэн мэргэжилдээ сайн байгаад зогсохгүй

бусад салбарын талаарх ерөнхий мэдлэгээ сайжруулах нь чухал юм. “Apple” компаниас гаргасан “I-Pad” нэгхэн бөөрөнхий мэдрэгч товчлуураар бүх үйлдлээ хийж чаддаг. Дизайн төдийгүй электроникийн ухааны талаар өргөн мэдлэгтэй дизайнерууд байсан болохоор ийм бүтээл гаргаж чадсан байна.

Мөн хүнд бусдыг ятгаж чаддаг харилцаа холбооны чадвар шаардлагатай байгаа юм. Өнөөгийн нийгэмд хичнээн их мэдлэгийг өөртөө бий болгосон ч үүнийг бусад хүнд үр дүнтэйгээр дамжуулж чадах чадвар байхгүй бол сурсан бүх зүйл хий хоосон зүйл юм. Ан доктор залуучуудад “Өөрийн сонгосон мэргэжлийн гүнзгий мэдлэг(Expertise), янз бүрийн бусад салбарын талаарх ерөнхий мэдлэг(Broad-mindedness), харилцааны чадварыг (communication) бүгдийг өөртөө бий болгосон боловсон хүчин болох хэрэгтэй” гэж зөвлөж байна.

Хүн чанарын боловсрол

Түүх гэдэг бол хэвтээ шугам, нийгэм гэдэг бол босоо шугам

Хүүхдээ бусдыг гэсэн нийтэч зан чанартай болгох

- “Талмуд” номноос илүү чухал “өөрийн гэр бүлийн байдлыг” тодорхойлох -

- Хүүхдээ чиг үүргийн загвараа олоход нь туслах -

- 13 насны насанд хүрсний баяр, бага наснаасаа биеэ дааж сурахад нь хүүхэддээ туслах - - Өвөг дээдэс болон үндэсний өв уламжлалынхаа үнэ цэнийг мэддэг болгох -

- Хүүхэддээ эхлээд мэдлэгээс илүү амьдралын ухааныг заах -

- Хүүхэддээ бусдад хандив тусламж үзүүлж туслаж дэмжихийн

үнэ цэнийг ойлгуулан амьдралд нь хэрэгжүүлүүлэх -

- Хүүхдэд эдийн засгийн боловсролыг эрт заах тусам сайн -

- Найз нөхдөө зөв таньж сонгон дотно нөхөрлөх талаар зааж ойлгуулах -

- Хамгийн анхны өрсөлдөгч болох ах, эгч, дүү нарын харилцааны талаар зааж сургах -

- Үнэнч шударга байдал хамгийн шилдэг зэвсэг болохыг хүүхэддээ ойлгуулах -

- Байнга талархалтайгаар амьдрах зуршлыг сургах -

- Цаг хугацааны үнэ цэнийг ойлгодог болгох -

- Эгэл жирийн даруу амьдрал хамгийн сайхан амьдрал болохыг ойлгуулах -

- Хүүхдээ бүх зүйлд дасан зохицож чадахуйц амьдралын чиг хандлагатай болгох -

- Бусдыг хайрлаж халамжлах, буруу зүйл хийсэн бол уучлал гуйхыг мэддэг нийгмийн харилцааны талаар хүүхэддээ зааж сургах -

- Хүүхдээ алдаа гаргасан үед нь туслаж дэмжин нэг алдаагаа дахин давтсаар байвал загнаж зэмлэх -

- Хүүхдээ аливаа зүйлийг сайтар сонссоныхоо дараа бодож тунгаан зөв ярьдаг хүн болгон төлөвшүүлэх -

- Хүүхдээ бусдад хамаагүй амлалт өгдөггүй, хэрвээ амласан бол амлалтаа заавал биелүүлдэг хүн болгон төлөвшүүлэх -

- Хүүхэддээ эмх цэгцтэй байдал болон ёс зүйн талаар зааж сургах -

“Талмуд” номноос илүү чухал “өөрийн гэр бүлийн байдлыг” тодорхойлох

“Тора” номыг Израйль улсын ард түмэнд огт мартуулахгүй байхын тулд Хияа гэдэг шашны багшийн хийсэн зүйл нь юу вэ? Тэрээр маалинганы үр цацсан бөгөөд түүгээрээ сүрэл сулжин тор хийсэн. Тэрхүү тороороо халиун буга барин махыг нь өнчин хүүхдүүдэд өгөн арьсаар нь хуйлмал ном хийсэн. Тэрхүү хуйлмал номон дээр Мосегийн 5 ишлэлийг бичээд багш байхгүй тосгон руу явсан. Тэр газраа 5 хүүхдэд Мосегийн 5 ишлэл, 6 хүүхдэд Мишна /Mishna-Талмуд номны нэг хэсгийг бүрдүүлдэг Еврейчүүдийн амаар дамжин ирсэн хууль/-гийн 6 сургаалийг заасан. Тэрээр хүүхэд тус бүр “Тора” болон “Мишна” номын агуулгыг бүгдийг сайн сурч эзэмштэл нь хичээл заасан. (Талмуд номны хэсгээс)

Тэнгэрээс Бурхан бууж ирээд Израйлийн ард иргэдэд ийнхүү хэлсэн байна.

“Би та нарт энэ дэлхий ертөнцийн хамгийн үнэтэй бэлгийг өгөхөөр ирлээ”

Энэ үед Еврейчүүдийн удирдагч Мосе энэ үгийг сонсоод ихэд баярлан бэлгийг зүгээр авч чадахгүй гээд удирдагчидтайгаа хэлэлцсэн байна. Гэтэл нэг мэргэн хүн ингэж хэлэв.

“Бидэнд байгаа зүйлсээс хамгийн үнэ цэнэтэй зүйлийг Бурханд өргөцгөөе. Харин чухам тэр зүйл юу юм бол? Энэ бол бидний ирээдүй. Бидний ирээдүй гэдэг нь өөрөөр бидний үр хүүхэд юм.

“Энэ бол зөв. Бид өөрсдийн үр хүүхдүүдээ Бурханд өргөцгөөе”

Энэхүү үгийг сонсоод Бурхан ихээр баярласан байна.

“Үр хүүхдүүдээ надад өгсөн та бүхэнд энэ дэлхийн хамгийн эрхэм бэлэг болох Ариун Библийг өгөн үр хүүхдүүдийг чинь та бүхэнд буцаан даатгаж байгаа учраас хүүхдүүддээ Ариун Библийг хичээнгүйлэн заан гайхалтай сайн хүн болгон өсгөж хүмүүжүүлээрэй” гэж Бурхан хэлсэн байна.

Тэрхүү Ариун Библи бол “Тора” ном юм. Тийм болохоор Еврей хүмүүс хүүхдийнхээ боловсролыг Бурханаас тэдэнд өгсөн үүрэг гэж үзэн бүх хүчээ дайчлан анхаардаг. “Тора” номыг ашиглан заадаг уламжлалт боловсролын арга барил нь өнөөг хүртэл хэрэглэгдэн Еврей хүмүүсийн бүх мэдлэг, чадварынх нь эх үүсвэр болсоор байна.

Еврей хүмүүс өдөр тутмын амьдралдаа ч мөн тодорхой хэмжээгээр “Тора” номонд бичсэн шашны хуулиа сахьдаг. Эцэг эхээ хүндэл, хөршөө өөрийн адил хайрла, үнэнч шударга бай гэх мэт олон шашны хуулиудын талаар “Тора” номонд гардаг. Шашны дагуу тогтоосон амралтын өдрөөр телевиз үзэх юмуу жолоо барих гэх мэт ямар нэгэн өөр ажил хийхгүйгээр гэр бүлийн гишүүдтэйгээ цагийг өнгөрөөн Кошер(kosher) иддэг. Рош Хашана (Rosh Hashana) / Еврейчүүдийн календарийн он тооллоор шинэ оны эхний өдөр/-ны өдөр Супа /хонины эврээр хийсэн бүрээ/ бүрээ үлээн, “Нүглээ наминчлах өдөр” нэртэй баяраар тахиа ашиглан нүглээ наминчлах ёс заншлыг үйлдэх гэх мэт нарийн агуулгууд орсон байдаг.

“Талмуд” бол 5000 жилийн түүхтэй ном бөгөөд цэцэн мэргэн Еврей хүмүүсийн мэдлэг ухаан хуримтлагдсан амьдралын цогц сурах бичиг, заавал унших ёстой ном юм. “Талмуд” нь 5-7 зууны үед амьдарч байсан шашны удирдагч багш нар хоорондоо хууль, ёс зүй, оюун ухаан, түүхийн талаар хэлэлцэн тэмдэглэж үлдээсэн 63 ном бүхий 12000 хуудас том ном юм. Библийн хуучин гэрээний үеэс хойш Еврей хүмүүс нэвтэрхий толь бичиг болгон улсынхаа боловсролын гол цөм сургалтын материалаар ашигласаар ирсэн. Хүний амьдралын аз жаргал болон хайр, хүн төрөлхтний чанд сахих ёстой зүйл гэх мэт бидний амьдралд зайлшгүй байх хэрэгтэй зүйлийн талаарх мэргэн цэцэн хүмүүсийн зөвлөгөө, оюун ухаан энэхүү номонд багтсан байдаг. Нэг ёсондоо Еврей хүмүүсийн 5000 жилийн амьдралын хэв маяг, амьдралын ухаан цогцоороо тусгагдсан сурах бичиг юм. Энэхүү ном нь оньсого тааварт ихээр хэрэглэгдэн Еврей хүмүүсийн сургуульд сурах бичгээр ашиглагдаж байсан бөгөөд мөн одоо ч гэсэн энэ номны талаар арван хуруу шигээ сайн мэддэг шашны багш нар дасгалжуулалтын хамгийн чухал сургалтын материалаар ашиглаж байна.

Угаасаа “Талмуд” гэдэг нь сурах гэсэн утгатай үг бөгөөд сүүлийн үед Еврей хүмүүсийн боловсролын арга барилыг тодорхойлох үгээр их ашиглагдаж байгаа юм. Еврей хүмүүс үг уншиж эхлэх үеэсээ эхлэн хөгширч нүд нь юм сайн харахаа байх үе хүртлээ өдөр бүр “Талмуд” номыг хичээнгүйлэн уншиж суралцдаг. Эхлээд эцэг эхтэйгээ хамт өдөрт 2 нүүрийг уншин 7 жилийн хугацаанд бүрэн уншиж дуусгадаг бөгөөд үүний дараа дахин давтан эхнээс нь унщдаг. Хууль, эдийн засаг, газар зүй, түүх, анагаах, шинжлэх ухаан гэх мэт бүх талын мэдлэг бүхий “Талмуд” ном бол олон талын чадвар шаардагдаж байгаа өнөө үед хамгийн сайн сурах бичиг юм. Олон мянган асуулт хариулт давтагдаж буй явцаар дамжуулан ямар нэгэн зүйлд дүн шинжилгээ хийх чадвар, тунгаан бодох чадвар, бүтээлч чадвар сайжирч чаддаг.

“Талмуд” номыг Еврей хүмүүсийн амьдралын хууль ч гэж нэрлэдэг. Еврей хүмүүс “Дүрэм журмынхаа дагуу амьдран дүрэм журмынхаа дагуу үхэх” хэмжээгээр “Талмуд” номонд заасан дүрэм журмыг өдөр тутмынхаа амьдралд хатуу чанд сахиж мөрддөг. Тэд “Талмуд” номонд заасны дагуу хүүхэд төрүүлэн, оршуулах ёслолыг үйлдэн, хүүхэддээ боловсрол олгон, хөрштэйгээ эвтэй найртай амьдардаг. Ийнхүү Еврей хүмүүсийн амжилтын үндэс бол 5000 жилийн түүхтэй “Тора” болон “Талмуд” номонд үндэслэн сурч байгаа боловсрол юм.

Хүүхдээ чиг үүргийн загвараа олоход нь туслах

Мэеэр(Mayer) гэдэг багшаас нэг сурагч "Багш аа, яагаад хүүхэддээ ажиллаж хөдөлмөрлөн амьдрахын эрхэм чанарыг заагаагүй эцэг эх хүүхдээ хулгайч болгон өсгөж байгаатай ялгаагүй гэж байгаа юм бэ?" гэж асуусан байна. Багш хариуд нь "Ур хүүхэддээ ажиллаж хөдөлмөрлөн амьдрахын эрхэм чанарыг заадаг хүн бол хүүхэддээ усан үзмийн талбай өвлүүлэн үлдээж байгаатай адил юм. Усан үзмийн талбай гадууpаа хашаагаар хүрээлэгдсэн байдаг бөгөөд дотор нь ямар нэгэн амьтан орж чаддаггүй. Үүнтэй нэгэн адил хүүхэд өөрөө ажиллаж хөдөлмөрлөн амьдрахын чухал чанарыг мэддэг бол ямар нэгэн муу бодол санаа хүүхдийн сэтгэл дотор орохгүй зөв аргаар амьдрана гэсэн үг юм". Хүүхдийг зөв замаар удирдах хамгийн сайн арга бол эцэг эх өөрсдөө хүүхэддээ үлгэр жишээ үзүүлэн хүүхдийнхээ загвар хүн болох юм. (Талмуд номны хэсгээс)

Орос гаралтай Еврей хүн болох Сергей Брин (Sergey Brin) хүүхэд байхаасаа хөгжим сонсох юмуу телевиз үзэх тал дээр ямар ч сонирхолгүй нэгэн байсан байна. Хичээл ном хийх тал дээр ч сонирхолгүй нэгэн байсан. Харин түүний сонирхлыг хамгийн ихээр татаж байсан зүйл бол Нобелийн шагналтан суут ухаантан физикч Ричард Фэинмэн (Richard Feynman)-ий амьдрал байсан юм. Брин "Өөрийн салбартаа маш том амжилтанд хүрээд зогсохгүй Леонорда Да Винчи шиг шинжлэх ухааны эрдэмтний ажлаа орхилгүй урлагийн хүн болж чадсан Фэинмэнийг өөрийн загвар хүнээрээ /өөрийн дуурайж адилхан болохыг хүссэн хүн/ сонгон түүнийг дуурайн шаргуу хичээж ажилласны үр дүнд дэлхийн хамгийн шилдэг хайлтын системийн компани болох "Гүүгл(Google)" компанийг үндэслэн байгуулж чадсан юм. "Гүүгл(Google)" компанийг үндэслэн байгуулсныхаа дараа тэрээр дахин "Apple" компаний захирал Стив Жобс (Steve Jobs) болон хөрөнгө оруулалтын салбарын суут хүн гэж нэрлэгддэг Варен Баббет (Warren Buffett) -ийг өөрийн загвар хүнээр сонгосон байна.

"Гүүгл(Google)" компанийг хамтран үндэслэгч Еврей (Иудэ) хүн болох Ларри Пэйж (Larry Page) ч 12 настайдаа Никола Тэсла (Nikola Tesla, 1856-1943 он)-гийн намтрыг уншаад түүний гаргасан нээлтэнд ихээхэн татагдсан байдаг. Тэслагийн зохион бүтээсэн хувьсах гүйдлийн генератор нь цахилгаан, цахилгааны солбилцол, Х шугам, утасгүй харилцаа холбоо болон хөгжин орчин үеийн цахилгаан, эрчим хүчний салбарын гол үндэс суурь болсон юм. Тэсла бусдаас онцгой нэгэн байсан боловч хэн нэгнээс хэзээ ч магтаал сонсож байгаагүй бөгөөд тухайн үедээ "Хөрөнгө мөнгө нэр хүндгүй ядуу Эдисон" гэж нэрлэгдэж байсан юм. Тэрээр олон янзын нээлт хийхийн тулд бүх анхаарлаа хандуулан бүхий л амьдралынхаа турш ганц бие гоонь эрийн амьдралаар амьдарч байгаад Нью-Йоркийн нэгэн зочид буудалд амьсгал хураасан юм. Тэгвэл Пэйж Тэслагаас чухам юу сурсан юм бол?

Уг нь Тэсла үнэхээр гайхалтай чадвартай хүн байсан ч зөвхөн шинэ зүйл зохион бүтээснээрээ том амжилт гаргаж чадаагүй юм. Энэ бол үнэхээр харамсалтай хэрэг. Тэсла ажил хэрэг юмуу хүнтэй харьцах тал дээр бага зэргийн авъяастай байсан бол маш том амжилтанд хүрч чадах байсан юм.

Пэйж Тэслагийн амьдралыг ажиглан "Ямар нэгэн ажилд зөвхөн гайхалтай шинэ санаа байх нь хангалтгүй. Цаг хугацаа, тогтвортой байдал, хүч хөдөлмөр гэх мэт зүйл ч гэсэн мөн адил чухал байдаг" гэдгийг ухаарсан байна.

Еврей хүмүүс хүүхэддээ бага байх үед нь ирээдүйд адилхан болохыг хүссэн загвар хүнийг нь тодорхойлж өгдөг. Гэр бүлийн гишүүд бүгд цуглардаг оройн хоолны цаг дээр агуу том амжилт гаргасан хүмүүсийн талаар хоорондоо чөлөөтэй ярилцдаг. Улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, шинжлэх ухаан гэх мэт янз бүрийн салбарт дэлхий дахинд нэр алдраа дуурсгасан Еврей хүмүүс тоо томшгүй олон байдаг.

Жишээлбэл хүүхэд утга зохиолын талаар сонирхолтой байвал "Эмч Живаго/Doctor Zhivago/" гэсэн бүтээлээр Нобелийн шагнал авсан Борис Пастернак (Boris Pasternak), мөн Нобелийн шагналтан зохиолч "Шидэт уул" "Паустус доктор (Doctor Faustus)" гэх зэрэг зохиол бичсэн Томас Мэнн (Thomas Mann), романтик үзлийн шүлэгч Хайне(Heine), экзистенциалист үзлийн утга зохиолын анхдагч "Хувьсал" номын зохиолч болох Капка гэх мэт хүмүүсийг загвар хүмүүсээр санал болгож болох юм. Хөгжимд авъяастай хүүхдэд хөгжимчин Мэндэлсон(Mendelsohn) юмуу удирдаач Леонард Бернстин (Leonard Bernstein), том бизнесмэн болохыг мөрөөддөг хүүхдэд санхүүгийн томоохон хөрөнгөтөн Ротшильд (Rothschild), нефтийн корпорацийн эзэн Рокфеллер (Rockefeller), Hedge сангийн тэргүүн Жорж Сорс (George Soros) гэх мэт хүмүүсийг загвар хүнээр сонгож болох юм.

Дэлхийн хамгийн баян хүн болох Билл Гейтс (Bill Gates) ч гэсэн өөрийнхөө загвар хүнээр эцэг эхээ сонгосон байдаг. Тэрээр бага наснаасаа эхлэн эцэг эхийнхээ ном уншиж буй байдлаар дамжуулан гэр бүлийн уламжлал хамгийн эрхэм зүйл болохыг сурсан. Тэрээр 50 тэрбум доллар давсан их хэмжээний мөнгийг нийгэмд буцаан хандивласан нь хөрөнгийн байгууллагын захирлын албан тушаал хашиж байсан түүний ээжийнх нь нөлөө байсан юм.

Еврей хүмүүс өдөр бүр хүүхэдтэйгээ ярилцах юмуу хүүхэддээ унтахаас нь өмнө алдартай хүмүүсийн намтрын талаар уншиж өгдөг бөгөөд ингэхдээ заавал Еврей хүмүүсийн уламжлалыг сахисан хүмүүсийн талаар ярьж өгдөг. Өөрийн сонгосон салбартаа гайхалтай амжилт гаргасан Еврей хүмүүсийн талаарх яриаг сонссон хүүхдүүд тэдгээр хүмүүстэй адилхан болохыг хүсэн атаархаж өөрөө том зүйлийг мөрөөдөж эхэлдэг. Үүнийг "Өөрийгөө бусадтай адилтгах" гэж хэлж болно.

Хүүхэд ямар хүнийг өөрийн загвар хүнээр сонгож байгаа нь боловсролын талаасаа маш чухал зүйл юм. Хүүхэд нийгэмших явцдаа бусдыг дуурайх байдлаар дамжуулан өөрийнхөө дуртай хүндэлдэг хүнийг дуурайж тэр хүнтэйгээ адилхан болохын тулд хичээдэг. Тухайн хүний хандлага, үнэ цэнэтэй байдал, үг яриа гэх мэт гадаад байдлыг нь хараад дотоод сэтгэлгээндээ оруулах чиг хандлагатай байдаг. Өөрийн үндэстнээс төрөн гарсан агуу хүмүүсийн үйл хөдлөл, амьдрал, биеэ авч яваа байдал, үнэ цэнийг дотоод сэтгэлгээндээ оруулснаар үндэстнийхээ бахархлыг ч мэдрэхээр болдог. Хүүхэд үнэхээр чин сэтгэлээсээ хүндэтгэн тэр хүнээсээ суралцах өөрт тохирсон загвар хүнийг өөртөө бий болгох нь хүүхдийн ирээдүйн амьдралд томоохон нөлөө үзүүлдэг. Энэ нь хүүхдийн ирээдүйн амьдралынх нь чиг хандлагыг тодорхойлж өгдөг үүрэгтэй.

Тэгвэл бид хүүхэддээ ямар загвар хүнийг сонгож өгөх хэрэгтэй вэ?. Солонгос улсын бага сургуулийн сурагчдаас шүтэн бишрч хүндэтгэж явдаг хүнийх нь талаар асуувал 10 сурагчийн 8-9 нь ямар нэгэн спортын хүн юмуу жүжигчнийг нэрлэдэг. Өөр бусад агуу хүмүүсээс сонго гэвэл Напелеон(Napoleon), Александр хаан(Alexander Wang), Швейцер (Schweitzer), Кюри Бүин, Билл Гейтс гэх мэт өөр бусад орны хүмүүсийг нэрлэх тохиолдол их

байдаг. Яагаад гэвэл эцэг эх нь Солонгос улсынхаа нэр хүндтэй агуу хүмүүсийн талаар сонирхол багатай, сайн мэддэггүй мөн дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслээр өөр бусад улс үндэстний нэр алдартай хүмүүсийн түүх намтрын талаар их бичиж нийтэлдэг хандлага их байгаа учраас юм.

Гэвч бидний үр хүүхдүүд Напелеон, Күри Бүин гэх мэт өөр бусад улс үндэстний нэр алдартай агуу хүмүүстэй өөрийгөө адилтгах тийм ч амар биш. Яагаад гэвэл оюун санааны болон соёлын ялгаа хоорондоо тохирох нь хэцүү байдаг. Тиймээс өөрийн улс орны түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг нэр алдартай хүмүүсийг өөрийн загвар хүнээ болгон сонгох нь илүү хүсүүштэй зүйл юм. Илжимүндог жанжин, Кан Гам Чон жанжин, Хэсанван Жанбугу, Сэжүн хаан, И Сүн Шин жанжин, Бэггом Гимгү багш, Ан Жүн Гын эмч, үргүй тарвасын сортыг шинээр гаргасан ургамлын эрлийзжүүлэлтийн мэргэжилтэн Ү Жан Чүн доктор гэх мэт багагүй хүмүүсийг бид загвар хүмүүсээ болгож болох юм.

Хүүхэд өөрийн загвар хүнээ сонгох үед бидний нэг анхаарах хэрэгтэй зүйл гэвэл эдгээр түүхэнд нэр алдраа мөнхлөн үлдээж чадсан агуу хүмүүс анхнаасаа онцгой авъяас чадвартай төрсөн “баатар” биш байсан гэдгийг хүүхэддээ сайн ойлгуулах юм. Хүүхэддээ хүн гэдэг амьтан мөнхөд ялагдашгүй агуу хүч чадалтай баатар биш зарим үед хүнд хэцүү байдлаас шалтгаалан уналтанд ордог эгэл жирийн амьтан бөгөөд бусад хүмүүсийн тусламж, хамтын хүчээр амьдралд тулгараад байгаа хүнд хэцүү зовлон бэрхшээлийг даван туулдаг гэдгийг сайн ойлгуулах хэрэгтэй. Ингэснээр эдгээр хүмүүсийн амьдрал бидний хүүхдийн амьдралд илүү ойр бодитоор нөлөөлнө.

Солонгос хүмүүсийн тухайд загвар хүнээр нэг үе олонд танигдан ихээхэн нэр хүндийг олж чадсан хүмүүсийг танилцуулж болох юм. Жишээ нь эмч мэргэжилтэй ч шинээр компани байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа Ан Чол Сү, тусламжийн үйл ажиллагаа эрхэлдэг Хан Би Я гэдэг ах дүү хоёр гэх мэт. Яг тухайн цаг үед олонд танигдан хүмүүст үлгэр жишээ болж байгаа хүмүүсийн амьдрал, амжилт, уналт, зовлон бэрхшээлийг даван туулсан байдал зэрэг нь хүүхдийн сэтгэлд илүү хурдан хүрэн сэтгэлийг нь хөдөлгөж чаддаг.

13 насны насанд хүрсний баяр, бага наснаасаа биеэ дааж сурахад нь хүүхэддээ туслах

Эцэг эхчүүд хүүхэддээ огтхон ч худлаа ярьж болохгүй бөгөөд амласан зүйлээ заавал биелүүлж байх хэрэгтэй. Ингэхгүй бол хүүхэд эцэг эхээ дуурайн худлаа ярьж сурдаг. Хүүхдийг заналхийлэх юмуу айлгаж сүрдүүлэх нь маш буруу зүйл. Мөн эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ хэн нэгэнд онцгой сайн хандан буснуг нь ялгаварлах маш буруу. Библи номонд гардаг Иаков 12 хүүхэдтэй байсан бөгөөд тэрээр Иосефт хамгийн хайртай байсан. Иосефтээ гоё торгон хувцас өгснөөс болж ах дүү нар нь Иосефийг гадуурхаж эхлэх болсон бөгөөд энэ байдал нь улам хурцдан эцэстээ өвөг дээдэс нь Египетэд боолын хөдөлмөр эрхлэхээр болсон. Хүүхдийг байгаа байдлаар нь хүндэтгэж харьцах маш чухал. "Багш Жосеф Тэллүшүкин"

Еврей хүмүүс хүүхэд нь 13 нас хүрвэл насанд хүрсэн гэж үзэн насанд хүрсний баярыг тэмдэглэдэг. Эрэгтэй хүүхдийн насанд хүрсний баярыг /Bar Mitzbah-буюу тушаалын хүү/, эмэгтэй хүүхдийн насанд хүрсний баярыг /Bat Mitzvah-буюу тушаалын охин/ гэж нэрлэдэг. / Зарим нэгэн шашны урсгалд эмэгтэй хүүхдийн биеийн өсөлт түргэн явагддаг учраас үүнээс шалтгаалан эмэгтэй хүүхдийн насанд хүрсний баярыг 12 настайд нь тэмдэглэдэг/ Ийнхүү насанд хүрсний баярыг тэмдэглэн өнгөрснөөс хойш хариуцлага хүлээж чадахуйц хүн тухайлбал нас биенд хүрсэн хүн гэж тооцдог. Насанд хүрсний баярыг Еврей хүмүүсийн шашны цугларалтын газар болох Синогогт тухайн бүс нутгийн нийгмийн томоохон арга хэмжээний хүрээнд тэмдэглэдэг. Хуримын ёслол дээр ирж байгаа мэт бүх хамаатан садан найз нөхөд нь цугларан баяр хүргэдэг. Баярын үеэр 13 нас хүрч байгаа баярын эзэн өнөөг хүртэл сурсан бүх зүйлийнхээ талаар баярт хүрэлцэн ирсэн зочдын өмнө илтгэл тавих маягаар ярьдаг. Энэхүү илтгэлээ хүүхэд 1 жилийн өмнөөс бэлтгэдэг.

Ийнхүү насанд хүрсний баярын эхний үйл ажиллагаа дуусвал ямар нэгэн үдэшлэг арга хэмжээ явуулж болохуйц танхим юмуу томоохон ресторанд хуримын ёслолын бэлэг дурсгал өгдөг арга хэмжээтэй төстэй уулзалт зохион байгуулдаг. Энэ үеэр баярт ирсэн зочид баярын эзэнд бэлэг болгон бэлэн мөнгө өгдөг. Жишээ нь Нью-Йорк хотод ажилладаг албан байгууллагын ажилтны тухайд барагцаагаар 200 орчим доллар бэлгэнд өгдөг. Ингээд баярт 100 гаруй хүн ирсэн гэж тооцвол 20,000 орчим доллартай болдог. Эцэг эх нь энэ өдөр хүүхдийнхээ бэлгэнд цугларсан мөнгийг хадгаламжинд хийх юмуу хүнд зээлүүлдэг бөгөөд хүүхэд нь нийгмийн амьдралд оролцож эхлэх үе нь болохоор хүүхэддээ буцаан өгдөг. Ийнхүү Еврей залуучууд нийгмийн амьдралд хөл тавихдаа тодорхой хэмжээний мөнгөтэй байдаг учраас амьдрахын тулд нэн даруй мөнгө олох хэрэгтэй гэсэн бодлоос ангид байж бусад зүйлд анхаарал хандуулж чаддаг. Өрнө дахины хүмүүсийг дорно дахины хүмүүстэй харьцуулахад биеэ даах чадварын хувьд маш сайн байдаг. Харин эсрэгээрээ дорно дахины хүмүүс өрнө дахины хүмүүстэй харьцуулахад биеэ даах чадварын хувьд маш муу бусдын гар харах хандлагатай байдаг. Гэхдээ энэхүү зан чанарын ялгаа бол төрөлхийнх биш эзэмшиж буй боловсролоос нь шалтгаалж байгаа юм. Өрнө дахины хүмүүс бага байхаас нь эхлэн хүүхдийнхээ биеэ даах чадварыг сайжруулахын тулд байнга зааж сурган дасгалжуулдаг. Тухайлбал хүүхэд тодорхой хэмжээгээр өсөж том болох үед өөрийнх нь өрөөг өөрөөр нь цэвэрлүүлж янзлуулдаг. Өрөөндөө хүүхэд уйлвал шууд ороод аргадаж тайтгаруулах биш өрөөнийх нь үүдэнд зогсоод "Ээж нь энд байна тийм болохоор битгий уйлаарай" гэж хэлэн

хүүхдээ өөрөө дуугай болохыг нь хүлээдэг. Ингэж байгаа нь хүүхдийн зан чанар бүрэлдэн бий болдог бага насанд нь биеэ даах чадвартай болгон оюун ухааныг нь зөв төлөвшүүлэхийн тулд юм. Мөн ингэснээр хүүхдийн сэтгэхүй хурдан хөгждөг сайн талтай.

Дорно дахины хүмүүс, ялангуяа Солонгос хүмүүсийн хувьд эцэг эх болон хүүхдийн хоорондох харилцааг маш их чухалчлан хүүхдээ дураар нь байлгах хандлагатай байдаг. Эцэг эх болон хүүхдийн хооронд гүн бат харилцааг бий болгодог сайн тал байгаа ч хүүхэд өсөж том болон биеэ даах чадвартай болоход нь саад болдог муу тал байдаг. Сургуулиа төгсөөд биеэ даан амьдрах нас нь болсон ч ажилд орохгүй байх юмуу ажилд орсон ч биеэ даан амьдарч чадахгүй эцэг эхээсээ эдийн засгийн тусламж дэмжлэг аван амьдардаг хүмүүс болдог. Солонгос улсын 21-39 насны ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн 5 хүн тутмын 1 нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа ч эцэг эхээсээ санхүүгийн туслалцаа дэмжлэг аван амьдардаг гэсэн судалгаа байдаг.

Ихэнхи улс оронд хүн 20 нас хүрвэл насанд хүрсний баяр тэмдэглэдэг. Солонгос улсын уламжлалт насанд хүрсний баяр гэвэл язгууртан эрэгтэйгийн хувьд насанд хүрсний баярын ёслол үйлдэн титэм өмсөн бийр болон бэх бэлгэнд авдаг. Эмэгтэйчүүдийн хувьд ч гэсэн үүнтэй төстэй ёслол үйлддэг. Ихэвчлэн хурим хийхээсээ өмнөхөн хуримын ёслолтой хамт ёслол үйлдэх нь түгээмэл байдаг. Харин 1985 оноос хойш 5-р сарын 3 дахь ням гаригийг “Насанд хүрсэн өдөр”-өөр сонгон 20 нас хүрсэн залуучуудад баяр хүргэдэг өдөр болгоод байгаа юм.

Ингээд үзэхээр Еврей хүмүүс насанд хүрсний баяраа бусад үндэстнээс 7-8 жилийн өмнө хийдэг байна. Еврей хүмүүс хүүхдийнхээ насанд хүрсний баярыг ийнхүү эрт тэмдэглэдэг учир шалтгаан нь хүүхдээ эрт биеэ дааж сургахын тулд юм. Тиймээс Еврей хүмүүс дунд сургуульд орох насандаа бүх зүйлд өөрөө бие даан шийдвэр гаргах чадвартай болсон байдаг. Энэ үе бол сэтгэл зүйн талаасаа эцэг эхийнхээ удирдлага юмуу гэр бүлийн харъяаллаас гарахыг хүсдэг “Залуу насны эхэн үе”-д хамаардаг. Яг энэ үед хүний бие даах чанар бүрэлдэн аливаа асуудалд хариуцлагатай хандан өөрийгөө нас биенд хүрсэн гэсэн ойлголттой болдог. Тэдний хувьд насанд хүрсэн гэдэг нь архи уух, тамхи татах гэх мэт буруу зүйл хийх биш Еврейн шашны хууль, уламжлалыг дагаж мөрдөн аливаа асуудалд хариуцлагатай хандан Еврей хүмүүсийн амьдралын бүхий л хүрээнд оролцон өөрийн байр суурийг чөлөөтэй илэрхийлэх онцгой эрхтэй болсон гэсэн үг юм.

Солонгос улс төдийгүй бараг ихэнхи улс орны насанд хүрсний баяр гэвэл насанд хүрч байгаа залуучууддаа бие даан хариуцлага хүлээж чадах болсон гэдгийг нь анхааруулан баяр хүргэдэг арга хэмжээ боловч Еврей хүмүүсийн тухайд баярын гол эзэн өнөөг хүртэл сурсан мэдсэн зүйлээ бэлдэн үүнийхээ талаар баярт ирсэн зочдод илтгэл тавьснаар бусдад бие даах чадвараа харуулж байгаараа онцлог давуу байдаг.

Өвөг дээдэс болон үндэсний өв уламжлалынхаа үнэ цэнийг мэддэг болгох

“Талмуд” номонд “Өндөр настай хүнийг хүндэтгэдэггүй залуу хүнд аз жаргал оройтож ирнэ” гэсэн үг гардаг. Өндөр настай хүмүүс нь хүндэтгэл хүлээдэг нийгэм амар тайван байдаг. Настай хүмүүс залуу хүмүүст буян заяаг дууддаг. Хүн нас ахихаараа угаасаа муу зүйл хийхгээд ч хүч чадал нь хүрдэггүй учраас гэж хэлж болох ч өндөр настангуудаа хайрлаж хүндэтгэдэг улсыг сайн нийгэмтэй улс гэж хэлж болно. Залуу наснаасаа эхлэн өөрөөсөө ахмад настай хүмүүсийг үнэхээр чин сэтгэлээсээ хүндэтгэж хайрлаж ирсэн хүн өөрөө нас өндөр болсон хойноо ч өөртөө итгэх итгэлээ алддаггүй. Мөн “Талмуд” номонд “Хичнээн урт сайн төмөр гинж байсан ч зөвхөн 1 хэлхээ нь л эвдэрвэл тэр гинж ямар ч хэрэггүй зүйл болдог” гэсэн үг гардаг. Энэ нь нэг нэг ширхэг тус бүр холбогдон урт гинжийг бий болгодог гэсэн үг юм. Үүгээр чухам юу илэрхийлэх гээд байна вэ гэвэл Еврей хүмүүс өөрсдийгөө бүгд нэг гэр бүл гэж ойлгодог бөгөөд дэлхийн янз бүрийн улс оронд тархан амьдарч байгаа ч Еврей гэсэн нэг том гэр бүлд харъяалагдаж байгааг илэрхийлж байгаа юм. Бид өнөөг хүртэл олон мянган жилийн өмнөх өвөг дээдэс шигээ амьдарч чадаж байгаа нь энэхүү зүйлийг сурсны ач тус юм. (Марвин Токаер)

“Израйль улсын нэг гайхамшиг бол бидний түүх болон уламжлалын маань хүч юм. Бид бол маш бага буурай үндэстэн байсан. Бидний амьдалд үргэлж л ямар нэгэн улс үндэстэн дайсагнан цаг ямагт аюултай нөхцөл байдалд амьдарч байсан. Мосегийн үеэс хойш бид нөхцөл байдлаа сайжруулахын тулд тэмцсээр ирсэн бөгөөд энэ бол манай Еврей хүмүүсийн ерөнхий онцлог юм. Мосегийн 10 тушаал нэг төрлийн орчин үеийн соёл иргэншлийн үндэс суурь болсон юм. Эйнштэн харьцангуйн онол гэсэн шинэ зүйлийг нээж чадсан бол Мосе хувиршгүй үнэ цэнийг санал болгосон юм. Энэ 2 хүн хоёулаа Еврей хүн байсан бөгөөд адилхан уламжлалтай байсан. Эрдэмтэн гэхээрээ зөвхөн мэдлэгтэй л байвал болдог юм биш. Эрдэмтэн гэвэл тогтсон хэв маяг, ёс заншлын эсрэг байр суурь бүхий хувьсгалч хүнийг хэлнэ. Тэрхүү хувьсгалыг сэтгэлээрээ хийх хэрэгтэй. Еврей хүмүүс байнга тогтсон хэв маяг, ёс заншлын эсрэг байр суурьтай байсаар ирсэн. Хөрөг шүтээнд мөргөж шүтэх байдлыг эсэргүүцэж байсан бөгөөд боолын тогтолцооны талаар ч гэсэн эсрэг байр суурьтай байсан” (Шимон Пэрэс Израйль улсын ерөнхийлөгч)

Еврей хүмүүс шиг түүх болон уламжлал, ёс заншлаа чухалчилдаг үндэстэн ховор. Хүүхдээ өвөө эмээ, өндөр настай хүмүүс, өвөг дээдсээ хайрлаж халамжлан хүндэтгэлтэй харьцдаг хүн болгон хүмүүжүүлэхийн тулд ихээхэн анхаарал хандуулдаг. Гэр бүлийн гишүүд бүгд цугларах үед өвөг дээдсийнхээ талаарх түүх яриаг хүүхдүүддээ ярьж өгөн уламжлал, ёс заншлаа мартуулахгүйн тулд их зүйлийг зааж ойлгуулдаг. Еврей хүмүүс өдөр бүр хүүхэддээ Бурханаас залбиран гуйх зүйлийнх нь агуулгыг хэлж зааж өгдөг бөгөөд энэ үед өвөө эмээгийнхээ эрүүл мэндийн төлөө, өвөг дээдэсдээ талархаж буйгаа илэрхийлэн Бурханд залбирахыг зааж өгдөг бөгөөд ингэснээр хүүхэд бусдыг хайрлаж хүндэтгэх, бусдад талархах талаар сайн ойлгож ухаарахаар болдог.

Хүүхэд ийнхүү өвөө эмээгээ хайрлаж хүндэтгэхийг сурснаар эцэг эхээ ч хайрлаж хүндэтгэдэг болон төлөвшдөг бөгөөд гэр бүл гэсэн нэг бүхэл зүйл бүрэлдэн бий болоход ихээхэн тус болдог. Гэр бүлд ямар нэгэн хүнд хэцүү зүйл тохиолдох юмуу асуудал үүсэх үед бие мах бодь, сүнс нэг бүхэл зүйл болж байж тухайн асуудлыг даван туулах гол хүч болдог. Ийнхүү бага

наснаасаа эхлэн өвөг дээдэс болон уламжлал, ёс заншлынхаа эрхэм үнэ цэнэтэй чанарыг суралцан ойлгосон байдаг болоод ч тэр үү Еврей хүмүүс гэр бүлд нь ямар нэгэн асуудал үүсвэл энэ нь бусдын асуудал биш миний ч асуудал гэсэн байр суурьнаас хандан асуудлыг шийдэхийн тулд бусаддаа туслаж дэмжих тал дээр маш сайн байдаг. Аав нь хүүтэйгээ хөлсөө урсган гэр орныхоо гаднах ажлаа хийн цэцэрлэгээ янзалж тохижуулан ээж нь охинтойгоо дотно яриа өрнүүлэн гэр орноо цэвэрлэн хоол ундаа хийж байгаа дүр зургийг Еврей гэр бүлээс бид байнга харж болно.

Нацист Германы дарамтан дор тарчилж зовсоор амь үрэгдсэн Еврей хүмүүсийн тоо 6,000,000 хүрнэ. Энэ тоо бол тухайн үед дэлхий дээр амьдарч байсан Еврей хүмүүсийн бараг тал нь юм. Еврей хүмүүсийн дунд гэр бүлийнх нь хэн нэгэн хүн юмуу хамаатан садных нь хэн нэгнээс хүнд хэцүү зовлон бэрхшээл амсаж байгаагүй хүнийг олоход тун хэцүү. Еврей хүмүүс хүүхэддээ бага наснаас нь эхлэн өөрийн үндэстний туулж ирсэн зовлон бэрхшээл, хүнд хэцүү түүхийн талаар ярьж өгдөг. Өвөг дээдсийнх нь даван туулж ирсэн хавчлага дарамт, хүнд хэцүү зовлон бэрхшээлийн талаарх түүх нь хүүхдүүдийг бага зэргийн айлгадаг боловч хүүхдийг өөрийн улс үндэстэн, эх орноо гэсэн халуун сэтгэлтэй болгодог.

1967 онд Израйль болон Арабын улсуудын хооронд дайн дэгдсэн бөгөөд энэ үед АНУ-ын томоохон олон улсын нисэх онгоцны буудал Израйль улс руу нисэх онгоцонд суух гэж буй Еврей хүмүүсээр дүүрсэн байна. Энэ нь хэдийгээр АНУ-д төрөн АНУ-ын иргэний харъяалалтай боловч амь нас нь хутганы ирэн дээр тулаад байгаа эх орноо гэсэн халуун сэтгэлээр өөрийн улс орон руу явах гэж тэмүүлж байсан Еврей хүмүүсийн сэтгэлийн нэг илэрхийлэл байсан юм. Энэ бол ямар нэгэн хүнд хэцүү нөхцөл байдал дотор ч өөрийн улс үндэстний уламжлалаа алдахгүй хадгалж ирж чадсан Еврейчүүдийн боловсролын хүч чадлын нэг илэрхийлэл юм.

Мөн Еврей хүмүүс энэхүү хүнд хэцүү зовлон бэрхшээл, Еврей үндэстнийг дарамтлан тарчлаан зовоож байсан дайсныхаа талаарх түүхийг хүүхэддээ ярьж өгөн огтхон ч мартаж болохгүй гэж заадаг. Гэхдээ “Дайснаа үзэн ядалгүй уучлах хэрэгтэй” гэж давхар заадаг. Хүүхэддээ “Чи хичээнгүй суралцан гайхалтай чадвартай хүн болвол ийм муу түүх бидний амьдралд дахин давтагдахгүй” гэж заан өөдөрлөг үзэл бодлыг суулгаж өгдөг.

Солонгос хүмүүс ч гэсэн гэр бүлийн боловсролоороо дамжуулан өвөг дээдсийнхээ талаар хүүхэддээ хэлж зааж өгдөг ч Еврей хүмүүсийн боловсролын арга барилтай харьцуулахад ихээхэн ялгаатай байдаг. Жишээ нь манай аав биднийг бага байхаас маань эхлэн хүүхдүүдээ хамтад нь суулган манай гэр бүл бол хааны үр хойч гэж байнга хэлдэг байв. Тамна /Чэжүду/ улсын хаан Гу Жа Гёний үр ач Курё улсад ирсэн бөгөөд өөрсдийгөө Гумаллугийн өвөг эцгийнх нь үр хойч гэдэг байв. Найз нарын маань аав нар ч гэсэн ялгаагүй иймэрхүү зүйл ярьдаг байв. Өвөг дээдэс нь хааны удам угсаа юмуу язгууртан гаралтай байсан гэх мэт нийгмийн гарал болон удам угсааг онцлон ярих тал дээр их анхаардаг боловч үндэстнийхээ яг гол мөн чанар нь юу болохыг онцлон хүүхэддээ ярьж хэлж өгдөг эцэг эх тийм ч их байдаггүй.

Солонгос хүмүүс “Имжинуэраний дайн (1592-1598 онд үргэлжилсэн Чусон болон Япон улсын хоорондох дайн) юмуу Солонгосын дайн гэх мэт үндэстнийхээ талаарх эмгэнэлтэй түүхийг ярьж өгөхдөө ч хүүхэддээ өшөө авах, үзэн ядах сэтгэлийг суулгаж өгдөг. Дайснаасаа

өшөөгөө заавал авах хэрэгтэй гэх мэтээр хүүхэддээ буруу зүйл заадаг. Хүмүүсийн энэхүү үзэл бодлын илэрхийллийг Пак Дү Жин үг, Ким Дун Жин аяыг нь зохиосон “6 сарын 25” гэсэн дуунаас бэлхнээ харж болно. Энэ дуунд “Аа аа, Бид мартана гэж үү!. Бид энэ өдрийг, эх орныг маань дайснууд гишгэчсэн энэ өдрийг, нүцгэн гараараа дайснуудтайгаа тэмцэн цусаа урсгасан энэ өдрийг мартана гэж үү! Одоо бид өшөөгөө авах хэрэгтэй. Тэр өдөр үлдсэн дайснуудыг бүгдийг нь буцаан хөөгөөрэй. Дайсныг нэгийг ч үлдээхгүй бүгдийг нь хөөн гаргаарай” гэж гардаг.

Солонгос улс бол Күнзийн сургаал үзэл баримтлалын үндэс гүнзгий орон юм. Дорнодын ёс зүйт улс хэмээн дуудагдах хэмжээгээр үнэнч байдал болон бусдыг хайрлаж халамжлах үзэл бодлыг онцолсоор ирсэн үндэстэн. Гэтэл өнөөгийн улс орны нийгмийн өөрчлөлтөөс шалтгаалан өрсөлдөөн болон бүтээмж, үр дүнг чухалчилдаг шинэ чөлөөт үзэл баримтлал нэвтрэн орж ахмад болон залуу хүмүүсийн хооронд байдаг нандин сайхан харилцаа үгүй болон бүх зүйлийг мөнгө, эрх мэдлээр шийддэг муу ёрын нийгэм болон хувираад байна. Эцэг эх хүүхдийн хоорондох нягт харилцаа холбоо ч устаж үгүй болон хүн бүр зөвхөн өөрийгөө боддог үзэл бодолтой болж байгаа нь өнөөдрийн БНСУ-ын гэр бүлийн дүр төрх гэвэл нэг их хэтэрсэн болохгүй.

Хүүхэддээ эхлээд мэдлэгээс илүү амьдралын ухааныг заах

Нэгэн шашны багш усан завиар аялж байсан бөгөөд завинд хамт явж байсан хүмүүс нь бүгд маш баян хүмүүс байв. Тэд өөрсдийн эд хөрөнгөө хооронд нь харьцуулан бие биедээ баярхсан байна. Нэг баян хүн багш дээр ирээд "Та аль хэр хөрөнгө чинээтэй хүн бэ?" гэж асуув. Багш хариуд нь "Би өөрийгөө хамгийн баян хүн гэж боддог ч яг одоо та нарт батлан харуулж чадахгүй" гэж хариулав. Яг энэ үеэр далайн дээрэмчид онгоц руу дайран өнөөх баян хүмүүсийн биедээ авч явж байсан алт, үнэт эдлэлийг бүгдийг нь дээрэмдэн одсон байна. Онгоц явсаар нэгэн үл таних усан боомтонд хүрч ирэв. Өнөөх багш маш өндөр боловсролтой нэгэн байсан болохоор тэрхүү боомтын сургуульд сурагчдад хичээл зааж эхэлсэн байна. Ингээд нилээн хэсэг хугацаа өнгөрсний дараа явж байгаад усан онгоцонд хамт явж байсан өнөөх баян хүмүүстэйгээ таартал бүгд ядуу гуйлгачид болсон байв. Тэд багшийг хараад "Таны тэр үед хэлсэн зүйл үнэхээр үнэн байж. Мэдлэг боловсролтой хүнд бүх юм байдаг юм байна"гэж хэлсэн гэдэг. (Талмуд номны хэсгээс)

Хүнд мэдлэг болон ухаан хоёулаа хэрэгтэй. Мэдлэг болон ухаан нь төстэй зүйл боловч асар том ялгаатай ойлголт юм. Мэдлэг гэдэг бол ямар нэгэн эд зүйл болон дэлхий ертөнцийн талаарх мэдээлэл юм. Харин ухаан гэж аливаа зүйлд ухаалаг хандан шийдвэр гаргах чадвар юм. Их мэдлэгтэй болон мэдэж байгаа зүйл маш их байлаа ч хүнд ухаан байхгүй бол байнга мунхаг буруу шийдвэр гаргахаар болно. Хүн мэдлэг болон ухааныг хоёуланг нь өөртөө бүрдүүлж байж л мэдлэг боловсролтой ухаалаг хүн болж чадна.

"Боловсролын арга барил байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Нэг чухал зүйл гэвэл бид хүүхдүүдээ зөвхөн мэдлэгтэй болгох биш тэдний зан чанарыг нээж илрүүлэн сонирхлыг нь сайжруулах, бусдыг өөртөө татах чадвартай хүн болтол нь зааж сургах хэрэгтэй. Одоо бол бидний халаасан дотор байгаа мөнгө биш бидний толгой доторх мэдлэг хүнийг хооллодог цаг үе". /Шимон Пэрэс Израйль улсын ерөнхийлөгч/

21-р зуун бол мэдлэг мэдээллийн эрин үе юм. Өнгөрсөн үеүдэд мэдээллийг дамжуулах тал дээр маш муу тодорхой хязгаар байсан бол орчин үед мэдээллийн хэрэгсэл маш өндөр түвшинд хөгжин интернэт, гар утас гэх мэт олон хэрэгслээр дамжуулан хэн ч байсан бүх төрлийн мэдээллийг амархан авдаг болсон. Улс орны удирдагч юмуу компаний удирдлагууд мэдлэг дутан хүнд хэцүү зүйлтэй тулгарах тохиолдол бараг байхгүй болсон. Гэвч ухаан дутуу удирдагч юмуу компаний удирдлагууд маш их байна. Улс орныг удирдан чиглүүлж байгаа хүмүүс юмуу томоохон компаниудын удирдлагууд буруу шийдвэр гаргавал тухайн хувь хүний амьдрал төдийгүй өөрийнх нь удирдан чиглүүлж байгаа бүхэн хоромхон зуур уналтанд орох нь мэдээж юм. Хүн мэдлэгийг өөртөө бий болгохоосоо өмнө ухаантай болох хэрэгтэй.

Солонгос улсын өнөөгийн боловсролын тухайд зөвхөн хүүхдийн мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэхэд хэт анхаарч байна. Эцэг эхчүүд хүүхдийнхээ мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэхийн тулд өр зээл тавьсан ч хамаагүй хүүхэддээ хувийн боловсрол олгон ийш тийш нүүж суухыг юман чинээ бодохоо больсон. Сургуулиудын тухайд ч гэсэн мөн ялгаагүй их мэдлэгтэй болгохын тулд сурагчдыг маш их шахаж шаардан учир утгагүй олон хичээл номоор бөмбөгдөж орхидог. Хүүхдүүд маш их хэмжээний мэдээлэлд нухлагдан ядарч туйлдаж байсан ч үүнийг нэг их тоолгүй толгойдоо маш их мэдлэг хуримтлуулан сайн их

сургуульд элсэн суралцах хэрэгтэй гэж хүүхдийг хүчээр шахаж шаарддаг газар бол мэдээж гэр бүл бөгөөд сүүлийн үед сургуулиуд ч гэсэн ийм байдалтай болж байна.

Гэвч нэг харамсалтай зүйл гэвэл ингэж хүчээр хийлгэснээр мэдлэг тухайн хүнийх болно гэдэг боломжгүй. Хүн өөрөө сайн ойлгон түүнийгээ хэрэгтэй үедээ ашиглаж чадаж байвал түүнийг жинхэнэ мэдлэг гэнэ. Хүчээр цээжилсэн мэдлэг нэг их удаан амьдрахгүй. “Бодол төрөх” номын зохиолч Рүт Бэрнстиний гэр бүлийн тодорхойлсноор бол ийм төрлийн боловсрол нь ”Үнэндээ сул дорой ямар ч үр дүнгүй боловсрол бөгөөд зөвхөн гадна талаас нь харахад сайн амжилттай юм шиг харагдахаас цаашгүй зүйл” юм.

Мэдлэг гэдэг бол хүний амьдралд шаардлагатай янз бүрийн нөхцлүүдийн нэг юм. Хэрхэн зөв амьдрах уу, мэдлэгийг өөрийнхөө амьдралд хэрхэн ашиглахыг зааж шийдвэрлэж өгдөг зүйл бол ухаан юм. Еврей хүмүүс хүүхэддээ мэдлэгээс өмнө ухааныг эхлээд заадаг. Яагаад гэвэл хүн ухаантай байвал мэдлэгийг угаасаа сайн ашиглаж чадна гэж тэд боддог.

“Загас барьж өгөөрэй. Түүгээр нэгхэн удаа хоол хийж иднэ. Загас барих аргыг зааж өгөөрэй. Тэгвэл бүхий л амьдралынхаа турш өөрийгөө хооллож чадна”

Энэ бол “Талмуд” номонд гардаг үг. Мэдлэг гэдэг бол загастай адилхан зүйл юм. Эцэг эх хүүхдээ мэдлэгтэй болгох юмуу эд хөрөнгөө шилжүүлэн өгч байгааг өөрсдийн барьсан загасаа хүүхэддээ өгч байгаа гэж ойлгож болно. Мэдээж ямар нэгэн асуудал тулгарсан үед мэдлэгийн хэмжээ, цар хүрээ чухал байдаг. Эцэг эхээсээ хичнээн их хөрөнгө мөнгө болон мэдлэгийг авч чадсан ч үүнийгээ хэрхэн ашиглахаа мэдэхгүй бол энэ нь хэрэггүй зүйл юм. Ухаан бол мэдлэгийг зөв ашиглан амьдралыг зөв зүйтэй удирддаг гол зүйл юм. Мэдлэгтэй ч ухаан муутай хүн зөвхөн өөрийнхөө ашиг сонирхлыг бодон бусдад муу нөлөө үзүүлдэг. Ухаан бол хэн ч булааж чадахгүй хүний хамгийн эрхэм хөрөнгө юм.

Мэдлэг голлосон боловсрол нь “Бүх талын мэдлэгтэй хүн”-ийг бий болгодог юм биш. АНУ-ын гоо сайхны брэнд бүтээгдэхүүн болох Бобби Браун (Bobbi Brown)-ий Ази номхон далайн бүс нутгийг хариуцсан ерөнхий захирлаар ажилладаг Жан Жэ Ён Нью-Йорк хотод байрлах толгой компаний ажилчидтай ярилцах болгондоо тэдний мэдлэгийг маш их гайхдаг байна.

“Тэд хооллож байхдаа алдарт зураач Пикассогийн талаар 2 цаг орчим ярилцсан байна. Зөвхөн гол хэдхэн зүйлийн талаар ярилцаагүй байна. Ажилчид дунд урлагийн салбарын хүн нэг ч байхгүй байсан ч бүгд Пикассогийн төрсөн цагаас эхлээд түүний уран бүтээлээ хэрхэн туурвисан, хэрхэн нэр алдартай болсон, хамгийн сүүлд болсон дуудлага худалдааны үнэ зэргийг бүгдийг нь мэдэж байв. Нэг удаа рестораны цонхоор гадагшаа хартал нарны бүтэн хиртэлт болж байсан бөгөөд тэр өдөр нар, сарны бүтэн хиртэлт, одон орон судлалын талаар ярилцсан юм. Цаашлаад Азийн талаар ярилцах үед ч өрнө дахины улс орны хүмүүсийн мэдлэгийн түвшин төсөөлж байснаас асар өндөр байсан юм. Өрнө дахины хүмүүс Азийн талаар хэр зэрэг мэдлэгтэй байдаг бол гэдгийг мэдэхийг хүсэж байсан бөгөөд тэд Хятадын цагаан хэрмийн барилгын ажил, тоон хэмжээг хүртэл түүхийн номноос хараад ярьж байгаа юм шиг сайн мэдэж байв.

Мэдлэг боловсрол эзэмших боловсролын арга барил бүрэн өөрчлөгдөж байхад нэг хэвийн арга барилаар хүчээр суралцаж буй Солонгос хүмүүсийн мэдлэгийн өрсөлдөх чадвар суурь

муутай ажил болж байгааг илэрхийлж буй нэг жишээ юм. Хүн үнэхээр л дэлхийд танигдсан шилдэг удирдагч, манлайлагч болохыг хүсэж байгаа бол мэдээж өргөн цар хүрээтэй мэдлэг, зөв зүйтэй шийдвэр гаргах чадвар, хүн болон нийгмийн талаар ойлгох чадвар, урлагийн мэдрэмж зэргийг бүгдийг өөртөө бий болгох хэрэгтэй.

Эцэг эх нь өөрсдийн барьсан загасаа хүүхдийнхээ ам руу хүчээр хийж өгч байгаа юм шиг Солонгос маягийн боловсрол болон хүүхэддээ загас барих аргыг зааж өгч буй Еврей маягийн боловсролын үр дүн мэдээж тэнгэр газар шиг ялгаатай юм. Янз бүрийн ном унших болон хоорондоо харилцан ярилцах арга барилаар бүх л амьдралынхаа турш амьдралын ухаанд суралцдаг Еврей хүн болон зөвхөн их сургуульд элсэн орохын тулд амьдралынхаа хамгийн чухал цаг хугацааг мэдлэг хуримтлуулахад зориулдаг Солонгос хүмүүс. Өнөөдөр Еврей хүмүүсийн гаргаж байгаа энэ их агуу амжилт бол мэдлэгээс илүү ухааныг түрүүнд тавьсан боловсролынх нь хүч чадлыг илэрхийлж буй тодорхой нэг жишээ юм.

Хүүхэддээ бусдад хандив тусламж үзүүлж туслаж дэмжихийн үнэ цэнийг ойлгуулан амьдралд нь хэрэгжүүлүүлэх

Нэг үнэг усан үзмийн талбай тойрон шүлсээ гоожуулан явж байв. Усан үзмийн талбайг тойруулан хашаа барьсан учраас дотогшоо орж чадахгүй байв. Үнэг 3 хоног юу ч идэлгүй өлсөж цанган байж нилээн жин хассаны эцэст хашааны жижигхэн зайгаар арай гэж багтан усан үзмийн талбай руу оров. Амттай усан үзэмнээс ханатлаа идэж аваад буцаад гарах гэтэл гэдэс нь тулаад гарч чадсангүй. Дахин 3 хоног юу ч идэлгүй байсны эцэст усан үзмийн талбайгаас гарсан байна. Талбайгаас гарсныхаа дараа үнэг ингэж бодов. "Намайг хашаа руу орж гарах үед гэдэс маань ямар ч ялгаагүй өлсгөлөн байсан" гэж. Хүний амьдрал ч гэсэн үүнтэй яг адилхан юм. Хүн хэн ч байсан хамаагүй энэ хорвоо ертөнцөд нүцгэн ирээд нүцгэн буцдаг. Хүн энэ хорвоогоос явах үедээ гэр бүл, эд хөрөнгө, сайн үйлс(буян) гэсэн 3 зүйлийг л үлдээж чаддаг. Харин сайн үйлсээс бусад нь тийм ч агуу зүйл биш юм. (Талмуд номны хэсгээс)

Симон гэдэг шашны багш нэгэн өдөр диваажинд өөрийнх нь суух суудал аль хавьд байгаа бол гэдгийг мэдэхийг хүсээд Бурханаас гуйсан байна. Бурхан Симоний суудлыг нэгэн мөнгө хүүлэгчийн хажууд байна гэж хэлэв. Үүнийг сонсмогцоо тэрээр сэтгэл санаагаар унан эвгүйрхэн нөгөө мөнгө хүүлэгчийн гэрийг хайж олон очоод нилээд хэдэн хоног түүнтэй ярилцаж гэнэ. Симон мөнгө хүүлэгчид "Та өнөөг хүртэл ямар сайн үйл хийснээ надад нэг хэлээд өгөөч" гэв. Мөнгө хүүлэгч "Надад хийсэн сайн үйл гээд байх зүйл бараг байхгүй нүгэл ихтэй хүн болохоор Библи уншсан удаа бараг байхгүй. Удаан хугацааны турш мөнгө хүүлэгчийн ажил хийж нилээн мөнгө олсон доо. Долоо хоногийн амралтын өдөр болгон ядуу хүмүүст мах өгөн хандив тусламж өгдөг" гэж хариулав.

Иймхэн юм хийчихээд энэ хүн миний хажуу талын суудал дээр суух ёсгүйдээ гэж бодсоор Симон дахин "Танд үүнээс өөр хийсэн сайн үйлс үнэхээр байхгүй юм уу?" гэж үргэлжлүүлэн асуув. Гэтэл мөнгө хүүлэгч өнгөрсөн хугацаанд татварын ажилтнаар хэсэг хугацаанд ажиллаж байхдаа өөрт нь тохиолдсон нэг зүйлээ түүнд ярьж өгсөн байна.

"Би нэг өдөр боомтонд ирсэн усан онгоцноос татвараа хураагаад буцах гэж байсан юм. Гэтэл усан онгоцны ахмад намайг дуудан "Надад маш гоё бараа байна. Би зөвхөн чамд л зарахыг хүсэж байна" гэсэн юм. Тэгэхээр нь би "Юу болохыг нь харж байж худалдаж авах хэрэгтэй биз дээ" гэтэл "Эхлээд мөнгөө төл. Мөнгөө төлөхөөс нааш үзүүлж болохгүй" гэсэн. Үнийг нь асуутал 10,000 зооснoос 40,000 зоос гэв. Ямар ч байсан эхлээд мөнгөө төл гэж зөрүүдлэж байсан болохоор чухам юу байгааг нь мэдэхгүй ч маш ховор бараа байгаа байх гэж бодоод би худалдан авахаар болсон. Ингээд онгоцны ахмад мөнгөө авмагцаа онгоцны хамгийн доод талд байдаг агуулахаасаа олзлогдсон 200 Еврей хүн гаргаж ирсэн. Тэгээд надад "Та худалдан аваагүй бол бүгд далайн усанд живж үхэн загасны хоол болох байсан юм" гэж надад хэлсэн юм.

Би тэр хүмүүсийг гэртээ дагуулж ирээд хувцаслаж хоол унд өгсөн. Залуусыг нь хооронд нь гэрлүүлэн хуримын ёслол хүртэл хийж өгсөн. Тэр хүмүүс дотор нэгэн үзэсгэлэнтэй бүсгүй байсан болохоор түүнийг өөрийн хүүтэйгээ гэрлүүлэхээр болсон. Ингээд би хүүгийнхээ хуримын өдрийг товлон хурим найраа хийн бүх хүмүүс баяр хөөртэй аз жаргалаар дүүрэн

байтал харин нэг залуу маш их гунигтай харагдсан юм. Би тэр залууг дуудан учир шалтгааныг нь асуутал тэрээр надад ингэж хэлсэн юм.

“Өнөөдөр танай хүүтэй суух тэр эмэгтэй миний эхнэр болох эмэгтэй байсан юм. Олзлогдсон тэр өдөр бидний хуримын ёслолын өдөр байсан юм” гэв. Тэр үгийг сонсоод би түүнд 200 зоос өгөөд асуусан юм. “Тэр эмэгтэйг мартаж чадах уу?” гэж. Гэтэл тэр залуу “Би тэр эмэгтэйд энэ дэлхийн юунаас ч илүү хайртай. Гэвч та миний эзэн шүү дээ. Тэр эмэгтэйг бэрээ болгохыг хүсэж байгаа бол хүссэнээр тань болог. Надад мөнгө хэрэггүй” гэв. Би хүүдээ тэр залуугийн ярьсан зүйлийг хэлсэн. Гэтэл хүү маань тэрхүү залууд хайртай эмэгтэйг нь өгөх хэрэгтэй гэсэн шийдвэр гаргасан юм. Ингээд би тэр залууг нөгөө эмэгтэйтэй гэрлүүлсэн юм” гэж хэлжээ. Энэхүү яриаг сонссон багш Симон ингэж хэлэв. “Диваажинд чиний хажууд суух болсондоо би маш их баяртай байна” гэв. (Талмуд номны хэсгээс)

АНУ-ын бага сургуульд “Сурагчийн эцэг эх, багш нарын зөвлөл /PTA/” байдаг. Энэ нь хүүхдийн боловсролыг эцэг эх багш хамт хариуцна гэсэн утгыг илэрхийлж байгаа бөгөөд багш нарийн үйл ажиллагаанаас ангид чөлөөт уулзалт юм. Энэхүү зөвлөлийн чөлөөт уулзалтанд зөвхөн хэдхэн сурагчийн эцэг эх оролцох биш бараг бүх сурагчийн эцэг эхчүүд идэвхитэй оролцон багш нартай сурагчдын боловсролын асуудлын талаар санал бодлоо солилцон ярилцдаг.

Нью-Йорк хотод суралцаж байх үед манай эцэг эх ч гэсэн сард 1 удаа сургуулийн гуанзанд зохион байгуулдаг “Сурагчийн эцэг эх, багш нарын зөвлөл /PTA/”-ийн хуралд алгасалгүй оролцдог байсан. Гуанзанд дүүрэн цугларсан эцэг эхчүүд сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч зэрэг хүмүүсийг энэхүү уулзалтандаа оролцуулан сургуулийн хөгжлийн бодлогын талаар санал бодлоо илэрхийлэн сурагчдын эцэг эхчүүдийн үүргийн талаар ч ярилцдаг. Хандивын мөнгө цуглуулах ажил бол “Сурагчийн эцэг эх, багш нарын зөвлөл /PTA/”-ийн гол үйл ажиллагааны нэг юм. Тэд огтхон ч манай Солонгос улсын сургуулиудын сурагчдын зөвлөлийн эцэг эхчүүд шиг дургүй байдалтайгаар бэлэн мөнгө хандивладаггүй. Харин хаягдал бүтээгдэхүүн цуглуулах, ямар нэгэн үзэсгэлэн яармаг нээн бараа бүтээгдэхүүн зарж борлуулах гэх мэт үйл ажиллагаагаар дамжуулан хуримтлал үүсгэдэг.

10 сарын дундуур болдог “Чихрийн худалдаа(Candy Sale)” нь хуримтлалын мөнгө цуглуулах хамгийн том арга хэмжээ юм. Нэрний хувьд зөвхөн чихрийн худалдаа гэж байгаа боловч шоколад, царцмаг, зөгийн балтай газрын самар, лаа гэх мэт янз бүрийн бараа бүтээгдэхүүн зардаг. “Сурагчийн эцэг эх, багш нарын зөвлөл /PTA/” сурагчдын эцэг эхэд “Та бүхэн зөвхөн нэг уут чихэр худалдан авснаар сургуулийн үйл ажиллагаанд ихээхэн тус нэмэр болох болно” гэсэн бичиг илгээн хандивын үйл ажиллагаанд идэвхитэйгээр оролцохыг уриалдаг. Сурагчид “Сурагчийн эцэг эх, багш нарын зөвлөл /PTA/”-ийн зохион байгуулж буй арга хэмжээнээс чихэр юмуу лаа гэх мэт бараа бүтээгдэхүүн худалдан аваад түүнийгээ найз нөхөд юмуу төрөл садан, тосгоны хүмүүстээ буцаан зарж болдог. Сурагчид бараа бүтээгдэхүүн зарахдаа маш их өрсөлдөөнтэй байдаг. Яагаад гэвэл хамгийн их бараа зарсан сурагчдыг байр эзлүүлэн 1-р байр 500 доллар, 2-р байр 250 доллар, 3-р байр 175 долларын бэлэн мөнгийг шагнал болгон өгдөг.

Курс тус бүрээс 1-р байранд орсон ангид тоглоомын их дэлгүүрийн “(ToysRus)” 20 долларын барааны эрхийг өгөн чихэр хамгийн их зарсан ангид зориулан “Пиццаны үдэшлэг” арга

хэмжээг зохион байгуулдаг. Энэ нь Солонгос улсын бага хэмжээний мөнгө зарцуулан их хэмжээний мөнгө олдог олон нийтийн арга хэмжээтэй төстэй зүйл боловч АНУ-ын хувьд сурагчдын эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамт цаг хугацааг хөгжилтэй өнгөрөөдөг арга хэмжээ юм. Мэдээж борлуулсан бараанаас олсон бүх ашгийг сурагчдын боловсролын үйл ажиллагаанд зарцуулдаг.

“Сурагчийн эцэг эх, багш нарын зөвлөл /РТА/” нь гэр юмуу оффисд хэрэглэдэг факс, принтер, канон гэх мэт хэрэгсэлд ашигладаг хор, лазер, хорны сав гэх мэт зүйлийг цуглуулах үйл ажиллагааг ч явуулдаг. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрээлэн буй орчныг бохирдуулахаас хамгаалдаг сайн талтай төдийгүй эдгээр зүйлийг худалдан авдаг газар зарвал 1 савнаас 1 доллар олж болно. Сурагчид хичээлдээ ирэхдээ сургуулийн танхимд ил байрлуулсан хайрцаганд бэхний сав, принтерийн хорны сав гэх мэт гэртээ хэрэглэхээ байсан зүйлээ хийдэг бөгөөд “Сурагчийн эцэг эх, багш нарын зөвлөл /РТА/”-ийн ажилчид үүнийг нь цуглуулан авдаг. “Женерал Миллс (General Mills)” гэдэг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаний бараа бүтээгдэхүүний савлагаан дээр /Box Top-сав баглааны дээд талд хэрэглэгч та сав баглаа боодлоо буцаан авчирч өгвөл тухайн барааны үнийн дүнгийн тодорхой хэмжээний мөнгөн дүнг буцаан олгоно гэж бичсэн байдаг маркетингийн арга/ бүтээгдэхүүний сав баглаа тус бүрээс 10 цент буцаан авахыг хүсэж байгаа бол компанид бүтээгдэхүүний сав баглааг буцаан авчирч өгнө үү гэж бичсэн байдаг. Еврей хүмүүс иймэрхүү маягаар хуримтлал үүсгэх ажлыг хэзээ ч хамаагүй хүссэн үедээ хийж чадахаар хуримтлалын талаар сайн ойлголттой байдаг. “Бид сар бүр хэдхэн хайрцаг цуглуулснаар хүүхдийнхээ боловсролын орчин нөхцлийг сайжруулахад ихээхэн тус нэмэр болж чадна” гэж эцэг эхчүүд үздэг байна.

Английн Дубон далайтай хил залгаа оршдог Францийн хойд хэсэгт Калайс (Calais) гэдэг жижигхэн хот байдаг. Англи болон Франц улсууд 14-р зууны дунд үед хаадын хэргэм зэргээс шалтгаалан хоорондоо зөрчилдөж тэмцэлдэж байсан 100 жилийн дайны /1337-1453/ эхэн үе бол 1345 он юм. Английн 3-р Эдвард хаан Норманд улсад очин цэвэрлэгээ хийн Францийн цэргийг хөөн гаргасан. Ялалт нүдний өмнө байсан ч Калайс хотод Францийн цэргүүдийн ширүүн эсэргүүцэлтэй тулгарсан юм. Калайс хотын ард иргэд нэг сэтгэлээр тэмцэн Англи улсын цэргийн довтолгооныг 11 сар орчим тэсч чадсан байна. Энэ үед Англи улсын цэргийн тактикт бага зэргийн бэрхшээл тулгарч байсан нь мэдээж юм. Ийнхүү ард иргэдийг арай ядан буулгаж авсны дараа 3-р Эдвард хаан тэднийг олноор нь хомроголон устгах арга хэмжээ авч байгаад бодлоо өөрчлөн хүмүүсээс зөвхөн 6 хүнийг л цаазаар авахаар болсон байна. Харин цаазаар авах иргэдийг хүмүүсээр өөрсдөөр нь сонгуулахаар болсон байна.

Хотын иргэд хэнийг золиослох эсэхээ мэдэхгүй үймээн самуун болон сандарцгааж байсан бөгөөд өөрийн саналаар гарч ирэх хүн нэг ч байсангүй. Гэтэл тэр үед нэг хүн гараа өргөн “Би цаазлуулах хүний нэг нь больё” гэж хэлэв. Тэр хүн бол Калайс хотын хамгийн их хөрөнгө мөнгөтэй нэгэн болох Уисташюу Ди Сэнпиэр гэдэг хүн байв. Түүнийг гараа өргөтөл үргэлжлүүлэн Калайс хотын наймаачин, хуульч гэх мэт нийгмийн язгууртан гаралтай 5 хүн ээлжлэн гараа өргөн өөрсдийгөө цаазлуулахыг зөвшөөрсөн байна. Ийнхүү энэ 6 хүн дараагийн өдөр хүзүүндээ уяа уян хөл нүцгэн Английн цэргийн бэхлэлт рүү очсон байна. Ингээд тэднийг яг цаазлах гэж байтал жирэмсэн хатныхаа хүсэлтийг сонсон 3-р Эдвард хаан эдгээр хүмүүсийг цаазлахаа больсон байна. Үүнээс хойш Калайс хотын энэ 6 язгууртан хүний эр зориг болон амьд үлдэж чадсан явдал нь “Нийгмийн дээд давхаргын хүмүүсийн үүрэг

хариуцлага”-ын бэлэг тэмдэг болсон юм.

Нийгмийн дээд давхаргын хүмүүсийн үүрэг хариуцлага нь анх Ромын үед хаан болон дээд язгууртан хүмүүсийг илэрхийлсэн тодорхой ёс суртахууны ухаан болон үлгэр дуурайлыг илэрхийлсэн зүйл байсан юм. Харин орчин үед “Нийгмийн дээд давхаргын хүмүүст хамаарах буяны үүрэг” гэсэн утгаар хэрэглэгдэж байна. Барууны орны удирдах давхаргын хүмүүс улс орон нь хямралд орох үед язгууртан хүмүүсийн үүрэг хариуцлагыг нэн түрүүнд тавин хэрэгжүүлдэг уламжлалыг сахисаар ирсэн. Эдгээр хүмүүс дундаас Еврей хүмүүсийн түүх, нийгмийн хариуцлагын ухаан гайхалтай сайн байдаг. Еврей хүмүүсийн нийгмийн дээд давхаргын хүмүүсийн үүрэг хариуцлагын талаар үзүүлж буй нэг жишээ бол тэдний хандив тусламж үзүүлдэг байдал юм. Еврей хүмүүс өөрөө ядуу зүдүү байсан ч хамаагүй өөрөөсөө илүү хүнд хэцүү нөхцөлд байгаа хүнд туслах хандив тусламжийн үйл ажиллагаанд сайн дураараа идэвхитэй оролцдог.

Сайн үйлс хийх нь хүнд төрөлхөөс заяасан чанар гэж үү!. Тийм биш. Хүн буяны үйлс хийх болон бусдад хандив тусламж үзүүлэхийг боловсрол, хүмүүжлээр дамжуулан сурдаг. “Микрософт” компаний захирал, үүсгэн байгуулагч Билл Гейтс Сийтл(Seattle)-ийн нэгэн нэр бүхий банкны ажилтан болон өмгөөлөгчийн гэр бүлд төрсөн. Гэвч эцэг эх нь түүнийг хөрөнгө мөнгөөр огтхон ч эрхлүүлдэггүй байсан байна. Яагаад гэвэл хүүхэддээ бүх зүйлийг нь бэлдэж өгөөд байвал бүтээлч хүн болж чадахгүй гэж эцэг эх нь үздэг байв. Харин түүний оронд өөрсдөө хүүхдийнхээ загвар хүн болж баян чинээлэг хүн бусдын өмнө ямар үүрэг, хариуцлагыг үүрэх хэрэгтэй талаар бодит жишээг хүүхэддээ харуулсан байна.

Билл Гейтсийг том амжилтанд хүрсний дараа түүний эцэг эх “Хэрэв бид Билл-д их хэмжээний хөрөнгө мөнгө өгсөн бол тэр “Микрософт” компанийг үүсгэн байгуулж чадахгүй байх байсан” гэж хэлсэн байдаг. Билл Гейтс “Микрософт” компаний удирдлагаас гарсныхаа дараа ёс суртахууны үүрэг хариуцлагыг чухалчилдаг гэр бүлийнхээ уламжлалын дагуу эхнэр Мэлландатайгаа хамт “Билл болон Мэлландагийн сан”-г байгуулан буяны үйл ажиллагаа эрхэлж байна. Өнөөг хүртэл энэхүү сангийнхаа үйл ажиллагаанд оруулсан нийт хөрөнгө нь 280 тэрбум ам.долларт хүрээд байгаа юм.

“Солонгосын хөгжмийн ертөнцийн амьд түүх” хэмээн нэрлэгддэг дуучин Ха Чүн Хуа нь 1974 онд хамгийн анхны тоглолтынхоо орлого болох 5,000,000 воныг Анян хотын уяман өвчтэй хүүхдүүдэд хандивласнаасаа хойш тасралтгүй хандив тусламжийн үйл ажиллагаа явуулсаар байгаа юм. 2011 оны анхны тоглолтынхоо 50 жилийн ойд зориулсан тоглолтоо ч мөн нийгмийн сайн үйлсийн үйл ажиллагаатай холбоотойгоор хийхээр төлөвлөж байгаа юм. Энэ эмэгтэй өөрийнхөө энэхүү бусдад хандив тусламж өгдөг үйл ажиллагаагаа аавынхаа нөлөө гэж хэлдэг. Тэрээр аавынхаа заасан зүйлийг маш сайн сурсан байна. Нэр хүндтэй болж эхэлсэн 16 наснаасаа эхлэн бусдад хандив тусламж өгч эхэлсэн бөгөөд энэ нь түүний эцгийн нөлөө байсан юм. Эцэг нь түүнд зөвхөн олон нийтийн хайр энэрлийг хүртдэг хүн төдийгүй тэрхүү хайр энэрлийг нийгэмд буцаан өгч чаддаг “Урлагийн хүн болоорой” гэж түүнд байнга захидаг байсан юм.

Дорнодын улс орнуудын нийгэмд ч гэсэн дээр үеэс эхлэн сайн үйлсийн талаар чухалчилсаар ирсэн. Хятадын зүйр үгэнд “Нэг цаг аз жаргалтай байя гэвэл өдөр унтаарай. Нэг өдөр аз жаргалтай байя гэвэл загасанд яваарай. Нэг сар аз жаргалтай байя гэвэл хүнтэй гэрлээрэй.

Нэг жил аз жаргалтай байя гэвэл хөрөнгө мөнгөтэй болоорой. Харин бүхий л амьдралынхаа турш аз жаргалтай байя гэвэл эргэн тойрондоо байгаа хэн нэгэн ядуу хүнд туслаарай" гэсэн үг байдаг. Гэвч өнөөгийн Солонгос улсын нийгмээс Ха Чүн Хуа шиг гар таталгүй бусдад хандив тусламж өгдөг хүнийг хайж олоход хэцүү юм. "Самсунг" компаний эдийн засгийн судалгааны газраас 2010 оны 05-р сард эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын 30 гишүүн орныг хамруулан судалгаа хийн "Солонгос улсын хөгжлийн түвшин" гэсэн сэдэвтэй тайланг гаргасан байна. Гэтэл бусдад туслах, хандив тусламж өгөх гэх мэт нийгмийн удирдах давхаргын хүмүүсийн эдийн засгийн үйл ажиллагааны оролцоо, халамжийн талаар тодорхойлсон "Нийгмийн дээд давхаргын хүмүүсийн үүрэг хариуцлага" гэсэн сэдвээр судалгаанд оролцсон улсуудын дотроос хамгийн сүүлийн байранд байсан байна. Солонгос улс одоогийн байдлаар эд материалын хувьд хангалттай сайн болсон боловч нийгмийн хатуу ширүүн өрсөлдөөнөөс шалтгаалан нийгэмд бусдыг хайрлаж халамжлах, туслаж дэмжих тал дээр анхаардаг хүн бараг байхгүй болоод байгаа юм.

Гэтэл эсрэгээрээ Еврей хүмүүс баян байна уу ядуу байна уу хамаагүй бусдад хандив тусламж өгдөг зуршлыг амьдралдаа байнга хэрэгжүүлдэг. АНУ-ын бүх хандив тусламжийн мөнгөний 45 хувь нь Еврей хүмүүсийн хэтэвчнээс гардаг гэсэн судалгаа байдаг. Сүүлийн үед АНУ-д хэрэгжиж эхлээд байгаа "Бүх хөрөнгийнхөө талыг нийгэмд буцаан хандивлах хөдөлгөөн"-ийг удирдан явуулж байгаа хүмүүс дунд Еврей хүмүүс маш их байна. "Микрософт" компаний үндэслэгч Билл Гейтс болон дэлхийн нэр нөлөө бүхий хөрөнгө оруулагч Уоррен Баббет нар 2009 оны 05-р сард Нью-Йорк хотод болсон АНУ-ын тэрбумтнуудын оройн зоогон дээр "Хандивын андгай тангараг /Giving Pledge/" гэсэн нэртэй бүх хөрөнгийнхөө талыг нийгэмд буцаан хандивлах хөдөлгөөнийг эхлүүлсэн юм. Энэхүү уулзалтыг Еврей гаралтай тэрбумтан болох Рокфеллерийн гэр бүлийн захирал Дэвид Рокфеллер удирдан явуулсан бөгөөд энэхүү арга хэмжээнд мөн Еврей хүн Нью-Йорк хотын захирагч Майкл Блүмбэрг, Соросийн сангийн тэргүүн Жорж Сорос зэрэг хүмүүс оролцсон.

Тэд бүх хөрөнгө нь 1 тэрбум доллар /яг 1 тэрбум 200 сая вон/ давсан АНУ-ын 400 орчим баян хүмүүсийг оролцуулан багаар бодоход бүх хөрөнгийнхөө 50 хувийг ямар нэгэн хандив тусламжийн байгууллагад хандивлана гэсэн амлалтыг авсан байна. Эхлээд 5 тэрбум 700 сая долларын хөрөнгө бүхий үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгч Эли Броад (Eli Broad) болон түүний гэр бүл бүх хөрөнгийнхөө 75 хувийг хандивлан мөн цаашид ч гэсэн хандив тусламжийг тасралтгүй өгсөөр байх болно гэснээр дараа дараагийн хүмүүсийн хандив тусламжийн амлалт үргэлжилсэн байна. 2010 оны 08-р сард Уоррен Баббет /бүх хөрөнгийнхөө 99 хувийг хандивлахаар амлалт өгсөн/ болон тэрбумтан 40 хүн тус бүр 15,000,000 доллар /яг 175 тэрбум вон/-ыг бусдад хандивлана гэж амласан байна.

"Баян хөрөнгө мөнгөтэй байж байгаад үхэх нь атаархмаар зүйл" гэсэн үгтэй санал нэг байна. Хандив тусламж нь итгэмээргүй хариу болон буцаж ирдэг. (Эли Броадийн гэр бүл)

"Тодорхой хэмжээнээс илүү их хэмжээний хөрөнгө мөнгөтэй хүн өөрөө бүх хөрөнгө мөнгөө үрж чадахгүй. Хамгийн сайн арга бол тэрхүү хөрөнгө мөнгөө үр удамдаа өвлүүлэн үлдээх биш үр хүүхдийнхээ төлөө илүү сайхан хорвоо ертөнцийг бий болгохын тулд зарцуулах юм. (Майкл Блүмбэрг Нью-Йорк хотын захирагч)

"Бизнес эрхлэгчид болон санхүүгийн салбарын ажилчдыг зөвхөн өөрийнхөө ашгийн араас

хөөцөлдсөн муу хүмүүс мэт ойлголт нийгэмд тархаад байна. Гэтэл бизнес эрхлэгчид өөрийнхөө болон өөрийн гэр бүлийнхээ төлөө хөлс хүчээ урсган ажиллаж байгаа хүмүүс төдийгүй өөрийн харъяалах нийгэмд ч томоохон хариуцлага хүлээж байгаа хүмүүс. (Thomas Steyr-Томас Стэйр Hedge сангийн хөрөнгө оруулагч)

“Манай гэр бүл улс орныхоо эдийн засгийн хүчээр олсон ашгаа нийгэмд дахин буцаан өгөх үүрэгтэй гэсэн бодлоор өнөөг хүртэл амьдарсаар ирсэн. (Дэвид Рокфеллер)

Бусдад хандив тусламж үзүүлэх байдлыг сурагчийг сонгон шалгаруулахад ч ашигладаг болж байна. АНУ-ын Бостоний нэр хүндтэй хувийн сургууль болох “Phillips Academy Andover” нь АНУ-ын өмнөх ерөнхийлөгч Жорж Буш гэх мэт нэр хүндтэй хүмүүс суралцаж байснаараа алдартай. Энэ сургуульд хамгийн чухалд тооцон онцолдог зүйл бол “Нийгэмд хувь нэмэр оруулах” юм. Сурагчийг сонгон шалгаруулахад сайн дурын үйл ажиллагаа хамгийн чухал үзүүлэлт болдог. Энэ сургуулийн элсэлт хариуцсан ажилтан “Сурлагын дүн сайтай ухаантай хүнийг олох бол амархан ажил. Харин бид сурагчид өөрийнхөө чадварыг ашиглан бусад хүмүүст хэрхэн тус болж байгааг нь анхаардаг. Бусдыг удирдаж манлайлах хүн бол нийгэмд сайн үйл хийж чаддаг байх хэрэгтэй” гэж хэлсэн байна.

Еврей хүмүүсийн хувьд бусдад хандив тусламж өгөх нь бусад хүмүүст харуулан өөрөөрөө бахархан бусдаас нэр хүнд олох гэсэндээ хийдэг зүйл биш хийх ёстой ажлуудынх нь нэг юм. Тэд бусдыг хайрлаж халамжлах нь Бурханаас өгсөн үүрэг гэж боддог учраас юм. Еврей хүмүүс хүн төрөлхтөнд байгаа бүх зүйл хүн төрөлхтнийх биш бүгд Бурханых гэж боддог. Хүн амьдрах богинохон хугацаандаа хэрэглэх хэрэгцээ төдий зүйл гэж итгэдэг. “Тора” номонд “Ах дүү нарын чинь дунд ямар нэгэн зүйл хэрэгтэй хүн байвал тэр хүнд хэрэгтэй зүйлийг нь өгөх хэрэгтэй” гэж бие биендээ туслах хэрэгтэй талаар онцлон бичсэн байдаг. Еврей хэлэнд “Сайн үйлс /charity/ гэсэн үгтэй хамгийн төстэй утгатай үгийг “Tzedakah” гэдэг бөгөөд үүнийг нарийвчлан орчуулвал “Хүний зайлшгүй хийх хэрэгтэй зүйл” гэсэн утгатай үг юм. Еврей хүмүүсийн хувьд бол бусдад хандив тусламж өгөн туслаж дэмжих нь сонголт биш тэдний үүрэг юм.

Дундад зууны үеийн нэр хүндтэй шашны багш, эмч байсан Испани гаралтай Маймунидэс /1135-1204/ гэдэг хүн амаар уламжлагдан дамжин ирсэн Еврейн шашны хуулийг эмхэлж цэгцэлсэн “Мишүи болон Тора” номыг судлан сайн үйлс хийх аргыг 8-н үе шат болгон ангилсан байна.

1- р шат. Хамгийн эрхэм дээдэд тооцогдох сайн үйлс бол нөгөө хүн өөрөө өөрийгөө авч явж чаддаг болтол нь туслах юм. Мөнгө өгөх юмуу хамтран ажиллах, ажлын байр бэлдэж өгөх гэх мэт үйлдэл энэ шатанд хамаарна.

2- р шат. Тусалж байгаа хүн болон тусламж авч байгаа хүн хэн хэнийгээ мэдэхгүй байх

3- р шат. Тусалж байгаа хүн нь тусламж авч байгаа хүн хэн болохыг мэдэж байгаа ч тусламж авч байгаа хүн нь туслаж байгаа хүнээ хэн болохыг мэдэхгүй байх

4- р шат. Тусламж авч байгаа хүн хэнээс тусламж авч байгаагаа мэдэж байгаа боловч тусламж өгч байгаа хүн хэн тусламж авч байгааг мэдэхгүй байх.

5- р шат. Тусламж хүсэхээс нь өмнө ядуу хүнд туслах

6- р шат. Тусламж гуйсных нь дараа ядуу хүнд туслах

7- р шат. Хэрэгтэй байгаа мөнгийг бүгдийг нь өгөхөөс илүүтэйгээр бага мөнгийг баяр хөөртэйгээр өгөх.

8- р шат. Дургүй ч хүчээр хийж байгаа сайн үйлс. Ийм сайн үйлсийг анхнаасаа хийхгүй байсан нь дээр. Энэ бол бусдаас магтаал хүндэтгэл сонсон бусдад таалагдахын тулд хийж байгаа үйлдлээс цаашгүй юм.

Маймунидэс “Хэдийгээр 8-р шатанд хамаарах сайн үйлсийг энд оруулсан ч юу ч хийхгүй байснаас дээр” гэж хэлсэн байна. Сөүлийн Итэвоний цэцэрлэгт “Хэчон” нэртэй Чонбуг загасны хоолны газар ажиллуулдаг тогооч Чэ Сон Тэ нь амралтын өдөр болгон “Хайрын хоол түгээдэг явуулын машин“ гэсэн нэртэй буяны ажил хийдэг цуглааны гишүүдтэй хамтран нийгмийн эмзэг бүлгийн хүмүүс дээр очин тэднийг хооллодог. Ганц ч удаа гадуур хооллож үзээгүй эдгээр хүмүүст гахайн татсан мах, тахиан мах, далайн бүтээгдэхүүний шөл гэх мэт хоолыг хийж өгдөг байна. Тэрээр буяны үйл ажиллагаанд оролцон мэдэрсэн зүйлийнхээ талаар “Үнэнийг хэлэхэд би эхэндээ бусад хүмүүст их ухаантай хүн болж харагдахыг хичээж байсан ч энэ үйл ажиллагаанд оролцсоор байгаад нэг мэдэхэд ухаантай хүн болж чадсан байсан” гэж ярьсан байна.

Еврей хүмүүс бусдад мэдэгдэхгүйгээр хийсэн сайн үйлсийг хамгийн өндөр үнэлдэг. Бусдад туслахдаа хүмүүст таалагдахын тулд биш нууцаар хийх хэрэгтэй бөгөөд өөрийнх нь тусалсан хүн өөрөө биеэ даан бусдад туслаж чадахаар болсон байвал үүнийг хамгийн үр дүнтэй ажил гэдэг. Өөрөөр хэлвэл туслаж байгаа хүндээ загас барьж өгөхөөс илүү загас барих аргыг зааж өгнө гэсэн үг юм.

“Өвчтөнийг эмнэлэгт эргэн очвол тэр өвчтөний өвчний 60/1 орчим хувь нь сайжирдаг гэсэн үг байдаг. Гэвч 60 хүн нэг дор эргэн очвол өвчтөний өвчин хоромхон зуур бүрэн эдгэрнэ гэсэн үг биш юм. Нас барсан хүний булшин дээр очих нь хамгийн хэцүү зүйл. Эмнэлэгт хүн эргэж очсон хүн өвчтний биеийн байдал сайжирвал түүний амнаас талархлын үг сонсдог бол нас барсан хүнээс ямар ч зүйл сонсож чаддаггүй. Тийм болохоор бусдаас талархал хүсэхгүйгээр бусдыг хайрлаж халамжлах нь хамгийн сайн юм. (Талмуд номны хэсгээс)

Нэгэн сайхан сэтгэлтэй хүн явж байтал ядарч туйлдан өлссөн жижигхэн охинтой таарсан байна. Нөгөө хүн тэр охиныг дагуулан гэртээ аваачин хооллож ундлан хувцаслаж сургуульд хүртэл явуулж гэнэ. Охин том болон нас биенд хүрсэн үед хийх ажлыг нь олж өгөн амьдрах гэрийг нь хүртэл бэлдэж өгсөн байна. Өнөөх эмэгтэй хичээнгүй ажиллаж хөдөлмөрлөсөөр маш баян чинээлэг хүн болжээ. Харин охиныг өсгөсөн нөгөө хүн бүх хөрөнгө мөнгөө алдан ядуу гуйлгачин болсон байв. Тэрээр охин дээр ирэн тусламж гуйсан байна. Бага байхаас нь эхлэн хайрлаж халамжлан өсгөсөн болохоор тэр эмэгтэйг туслана гэдэгт тэр бат итгэлтэй байв. Ингээд тэрээр нөгөө эмэгтэй дээр очин бүх хөрөнгө мөнгөө алдан идэж уух юм ч байхгүй болон амьдрал нь маш хүнд хэцүү байна гэж хамаг зовлонгоо тоочсон байна. Баян залуу эмэгтэй өөрийг нь өсгөсөн буянтныг тайтгаруулангаа дотроо бодов. “Энэ хүн надаас ичихгүй байхаар туслах арга надад байгаа болов уу?” гэж. Ингэж бодсоныхоо дараа

тэрээр буянтанд "Миний байдал ч гэсэн сүүлийн үед маш хүнд хэцүү байгаа болохоор туслаж чадахгүй нь" гээд гар хоосон буцаав.

Үүний дараа нэг зарцаа дуудан маш үнэтэй сувд өгөн буянтны гэр лүү явуулав. Зарц буянтан дээр очин "Маш үнэтэй сувдаа хямдхан үнээр зарна" гээд гартаа байгаа сувдаа үзүүлсэн байна. Буянтан буцаагаад зарвал мөнгө олж чадна гэж бодоод өөрт байсан мөнгө болох 1 дэнараа өгөн сувдыг худалдан авсан байна. Эмэгтэй хэд хоногийн дараа өөр нэгэн зарцаа буянтны гэрлүү явуулав. Энэ удаа очсон зарц "Би танаас сувд худалдан авахаар явж байгаа хүн байна. Танд гайхалтай сайхан сувд байгаа гэж сонсоод ирлээ. Надад зарахгүй биз" гэж асуув. Буянтан хэд хоногийн өмнө 1 денараар авсан сувдаа гаргаж ирэн түүнд үзүүлтэл зарц "Яг миний хайж байсан сувд мөн байна 1000 денараар худалдаж авъя гэсэнд буянтан түүнд сувдаа зарав. Мөнгөтэй болсон буянтан нөгөө эмэгтэй дээр буцаж ирээд "Одоо надад туслахгүй байсан ч болно" гэж хэлээд хамтдаа инээсэн гэдэг. (Талмуд номны хэсгээс)

Еврей шашны сүмүүд ч гэсэн хандив тусламжинд ихээхэн анхаарал хандуулдаг. Сүмд нь өргөл барьц ихээр орж ирвэл нэн түрүүнд сүмийн шинэ барилга байгууламж барихаас илүү ядуу зүдүү амьдралтай хүмүүст туслахад хэрэглэдэг. Еврей шашны танхим болох Синагогт байнга өргөлийн хайрцгийг байрлуулсан байдаг. Энэхүү өргөлийн хайрцагнаас ядуу зүдүү амьдралтай Еврей хүн хэн ч байсан хамаагүй 2 долоо хоногийн амжиргааны мөнгөө авч болдог. Энэ нь "Ах дүү нартаа туслаарай" гэсэн шашны хуулийнх нь үзэл баримтлал юм. Гэтэл Солонгосын шашны сүм хийдийн хувьд байдал эсрэгээрээ байдаг. Гоёмсог сүм дуганы барилга байгууламж барихыг нэн түрүүнд тавьдаг. Нийгмийн янз бүрийн хүчин зүйлээс шалтгаалан хүмүүсийн эдийн засгийн байдал муудан ядуу айл өрхийн тоо нэмэгдсээр байхад сүм дуганы барилга байшингийн тоог нэмэгдүүлэхийн тулд хичээдэг.

Бусдад хандив тусламж өгөх нь суралцах байдлаар дамжуулан улам сайжирдаг зуршил юм. Хүн бага наснаасаа эхлэн бусдад туслаж хандив тусламж өгөхийг сайн суралцвал бүхий л амьдралынхаа турш бусдад туслаж бусдыг халамжилж чаддаг халуун сэтгэлтэй хүн болж чаддаг. "Үзэсгэлэнт сан"-гийн гүйцэтгэх захирал Пак Вон Сүн өмгөөлөгч хүүхэд наснаасаа эхлэн бусадтай бүх зүйлээ хуваалцахыг сурах хэрэгтэй гэж хэлсэн байдаг. Сөүл их сургуулийн хуулийн сургуулийн Ан Гён Хуан багшийн хоёр хүүхэд 4 настайгаасаа эхлэн мөнгөний гахайндаа мөнгө цуглуулан түүнийгээ "Үзэсгэлэнт сан"-д хандивладаг байсан бөгөөд энэхүү зуршлаа сургуульд орсныхоо дараа ч үргэлжлүүлсээр байгаа юм.

Хүүхдээ бусдад туслаж хандив тусламж үзүүлэх сэтгэлтэй, зуршилтай болгоё гэвэл эцэг эхчүүд өөрсдөө эхлээд иймэрхүү арга хэмжээнд оролцон идэвхитэй байх хэрэгтэй. Хүүхдээ 3-4 нас хүрэх үеэс нь эхлэн хөөр баяртайгаар бусдад туслах, хандив тусламж өгөхийг заах хэрэгтэй. Харин бид хандив тусламж өгснийхөө дараа тэрхүү мөнгө юунд хэрхэн зарцуулагдаж байгаад анхаарал хандуулах хэрэгтэй. Мөн эцэг эх хүүхэдтэйгээ хамт ямар нэгэн буяны үйл ажиллагаанд оролцвол хүүхдийн цаашдын амьдралын хандлагыг өөрчлөгдөхөд ихээхэн тус нэмэр болдог.

Хүүхдэд эдийн засгийн боловсролыг эрт заах тусам сайн

Сурагчид багшаасаа асуусан байна. "Баян хүн болон цэцэн мэргэн хүний аль нь агуу вэ?"гэж. Багш нь "Мэдээж цэцэн мэргэн хүн" гэж хариулав. Гэтэл нэг сурагч "Тэгвэл баян хүний гэрт эрдэмтэн мэргэд очдог байхад цэцэн мэргэн хүний гэрт яагаад баян хүн очдоггүй юм бэ?" гэж асуув. Багш хариуд нь "Цэцэн мэргэн хүн ухаантай болохоор мөнгө гэдэг зүйл амьдралд тодорхой хэмжээгээр хэрэгтэй гэдэг бодит үнэнийг мэддэг. Харин баян хүн мөнгө ихтэй ч мэргэн хүнээс ухаан сурах хэрэгтэй гэдгийг мэддэггүй учраас юм" гэж хариулжээ. (Талмуд номны хэсгээс)

Еврей хүмүүс эдийн засгийн боловсролыг маш эрт сурч эхэлдэг. Тиймээс мөнгийг хэтэрхий их шүтэж хайрлахгүй бас хэтэрхий их үрэн таран хийхгүй хэрэглэж чадахуйцаар эдийн засгийн боловсролтой болсон байдаг.

· Үйл хөдлөл чинь аль хэдийн том амжилтанд хүрсэн хүн шиг болох хэрэгтэй. Тэгвэл чи өөрөө ч мэдэхгүй амжилтанд хүрнэ.

· Бусдын нөлөөгөөр буруу зүйл битгий хий. Энэ бол боол болох хамгийн дөт зам.

· Мэдээлэл бол мөнгө. Мэдээлэл цуглуулах чадвараа сайжруулаарай.

· Хүмүүс хоорондын харилцаа холбоо бол асар том хүч. Олон хүмүүстэй танилцаж танилын цар хүрээгээ нэмэгдүүлээрэй.

· Бусад хүнийг хайрла. Тэгж байж чи ч гэсэн бусдад хайрлагдана.

· Эрсдэл бол боломж. Эдийн засгийн хямралтай үед мөнгө олдох боломж жирийн үеийнхээс 10 дахин их байдаг.

· Багаар ажиллах шиг чухал зүйл байхгүй. Зохион байгуулалттай байхад маш их анхаарах хэрэгтэй.

· Боловсролдоо хөрөнгө оруулалт сайн хийх хэрэгтэй.

· Амжилтанд хүрсэн хүнтэй найзалж нөхөрлөөрэй. Гайхалтай хүч чадлыг мэдрэх болно.

· Хийх итгэлгүй байгаа зүйлээ анхнаас нь хийх хэрэггүй.

Дээр дурьдсан эдгээр зарчим бол бусдад хандив тусламжийг харамгүй өгдөг Ротшильдийн гэр бүлийн эдийн засгийн боловсролын 10 зарчим юм. Шашны багш Марвин Токаер ч "Мөнгө бол хүнд хайр энэрэлгүй эзэн ч болдог мөн дуулгавартай үйлчилдэг зарц ч болдог" гэсэн Еврей зүйр үг байдаг. Еврей хүмүүс мөнгийг хайрладаггүй ч бас хамаагүй үрэлгэн байдаггүй. Мөнгө гэдэг зүйл бол маш муу зүйл ч биш, бас маш сайн зүйл ч биш зүгээр хүний амьдралд хэрэгтэй зүйл бөгөөд боломж байвал их мөнгөтэй байх тусам сайн. Тэгэхдээ мөнгийг хэтэрхий хайрлаж шүтэх нь буруу юм. Мөнгийг хэтэрхий хайрлаж байгаа хүн өрөвдөлтэй харагддаг учир шалтгаан нь зүгээр л нэг эд зүйлийг хайрлаж байгаа учраас юм. Мөнгөний

сайн муу тал нь мөнгийг эзэмшиж буй хүн юунд хэрхэн зарцуулж байгаагаас шалтгаална” гэж хэлсэн байна.

Ийнхүү эдийн засгийн боловсролын талаар эрт ойлголттой болдог Еврей хүмүүсийн хүч чадал бодит амьдрал дээр илэрч байгаа юм. АНУ-ын нийт хүн амын хоёрхон хувийг Еврей хүмүүс эзэлдэг (8,000,000 хүн) ч АНУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүний 20 хувийг Еврей хүмүүс бүрдүүлдэг байна. Энэ нь АНУ-ын бусад үндэстнээс 10 дахин их үзүүлэлт юм.

Еврей хүмүүс бага наснаас нь эхлэн хүүхэддээ мөнгөний үнэ цэнэ, чухал чанарын талаар зааж сурган эдийн засгийн анхан шатны боловсролыг олгодог. Аавууд бизнес эрхэлж байгаа бол хүүхдээ ажлын байран дээрээ дагуулж ирэн үйлчлүүлэгчтэй хэрхэн харьцах, хэрхэн бизнес хийх, хөрөнгө мөнгөө хэрхэн зохицуулах арга барилын талаар зааж өгдөг. Аав нь ямар ажил хийж мөнгө олж байгаа, хэдий хэрийн орлого олж байгаа зэргийг хүүхэддээ харуулж ойлгуулдаг. Хүүхдүүд эцэг эх нь хичнээн их хөдөлмөрлөн мөнгө олж байгааг харсан болохоор мөнгөө хайр гамгүй үрнэ гэсэн ойлголт байдаггүй.

Күнзийн сургаалийн үзэл баримтлалын үндэс суурь гүнзгий дорно дахинд, мөн өрнө дахины улс орнуудын Христийн шашинд мөнгийг бохир муу зүйл гэж үздэг хандлага байдаг. Харин Еврей хүмүүс мөнгийг огтхон ч бохир заваан зүйл мэтээр үздэггүй. Харин мөнгө хүний амьдралд хэрэгтэй зүйл учраас мөнгө олохын тулд хичээх хэрэгтэй гэж үздэг. Гэхдээ мөнгөний тал дээр ухаалаг байх хэрэгтэй. Тийм болоод ч тэрүү Еврей сургааль үгэнд мөнгө бол амьдралыг хангалуун болгон хүнд янз бүрийн гайхалтай боломжуудыг бий болгож өгдөг гэсэн агуулга бүхий үгнүүд их байдаг.

“Мөнгө боломжийг бий болгодог”

“Мөнгө бол хараал хүртэх ёстой муу ёрын үр биш. Мөнгө бол хүнийг ерөөдөг зүйл”

“Хөрөнгө мөнгө ихтэй бол тэр хэмжээгээр санаа зовох зүйл их байдаг ч хөрөнгө мөнгө байхгүй бол санаа зовох зүйл бүр их байдаг”

“Ядуурал гэдэг бол тоон үзүүлэлт биш. Мөн нэр хүндийн асуудал ч гэж бодох хэрэггүй”

“Мөнгө бүх зүйлийг сайхан болгож чадахгүй. Тэглээ гээд бас бүх зүйлийг ч муутгадаггүй.”

“Зөвхөн мөнгөтэй л байвал бүх зүйл сайхан болно гэж бодон мөнгөний араас үхэн хатан хөөцөлддөг хүмүүс мөнгөний муу талыг нэг бодоод үзэхэд илүүдэхгүй”

“Мөнгө нь ухаантай хүнд гоё бэлэг өгөн ухаан муутай хүнд муухай бэлэг өгдөг.”

“Мөнгө олох заримдаа амархан ч зөв зүйтэй зарцуулах нь маш хэцүү”

“Мөнгө бол хувцаснаас ялгаагүй зүйл бөгөөд хүнд үйлчлэхээс өөр зүйл хийж чадахгүй”

“Баян хүнд хүүхэд гэж байхгүй. Зөвхөн өв залгамжлагч л гэж байдаг”

Мөнгө хүний амьдралд сайхан боломжийг бий болгож өгдөг талаарх бодит жишээг Еврей

эцэг эхчүүд хүүхэддээ ярьж өгдөг. Энэ бол мөнгө төлөн нэрээ худалдаж авч байсан өвөг дээдсийнх нь зүрх өвтгөм түүх юм. Еврей хүмүүс 18-р зуунаас өмнө ямар нэгэн нэргүй байсан байна. Австри болон Францийн засгийн газар Еврей хүмүүсийн бүртгэл хөтлөсөн бөгөөд Еврей хүмүүсээс мөнгө аван тэдэнд нэрийг нь зарсан байна. Мөнгө ихтэй хүний тухайд их мөнгө төлөн Росентал /сарнай/, алтан цэцэг гэх мэт гоё нэр авч байсан бол мөнгө төгрөгний боломжгүй хүн үнэг гэх мэт хачин нэр авч байв. Энэхүү түүх нь мөнгийг хэтэрхий их хайрлавал муу үр дагавар бий болдог ч бас мөнгийг үл тоомсорлож болохгүй гэдгийг зааж өгч байгаа юм.

Мөнгөний талаар ийм төвийг сахисан бодолтой болоод ч тэр үү Еврей хүмүүс хүүхдээ төрөөд 8 сар болсны дараа алхаж эхлэхээс нь өмнө хүүхэддээ зоосон мөнгө атгуулан өглөө оройны хоолны өмнө мөнгөний савруу хийлгэдэг бөгөөд энэ нь эдийн засгийн боловсролыг зааж эхэлж байгаа нэг хэлбэр юм. Мөнгөний талаар ойлголттой болж эхэлвэл хүүхэддээ ойр зуурын хэрэгцээнийх нь мөнгийг өгдөг. Хүүхдээ сургуульд орохоос өмнө буюу 5 нас хүрвэл хэрэгцээнийх нь мөнгийг өгч эхэлдэг. Тэгэхдээ хүүхэддээ хэрэглүүлэх зорилгоор ийм эрт мөнгө өгдөггүй байна. Зорилго нь хадгаламж үүсгэх юм. Хүүхэддээ мөнгөний үнэ цэнэ болон хадгаламжийн ач тусыг мэдүүлэхийн тулд юм. Еврей хүмүүсийг харвал их харамч хүмүүс юм шиг харагддаг учир шалтгаан нь мөнгөө хамаагүй үрэн таран хийлгүй хуримтлал үүсгэхэд анхаардаг хандлагаас нь болдог байж болох юм. Удаан хугацаагаар энд тэнд цагаачийн амьдралаар хүнд дарамт шахалтан доор амьдрахдаа Еврей хүмүүс “Бидний хуримтлуулсан мөнгө биднийг хамгаалж чадна” гэсэн бодолтой болсон байдаг.

Бага наснаасаа эхлэн мөнгөө хадгалж хуримтлуулах зуршлыг сурвал бүхий л амьдралынхаа турш хэрэгжүүлж чаддаг. “3 насны зуршил 80 нас хүртэл явдаг” гэсэн Солонгос улсын зүйр үг байдаг. Өөрийн хүчээр амьдралаа авч яван орон гэртэй болон амьдарч байгаа хүнээс хайр гамгүй мөнгөө үрж байгаа дүр төрхийг олж харахад хэцүү юм. Мөн их хэмжээний хөрөнгө мөнгө өвлөн авсан ч 2-3 жил тансаглан үрэн таран хийж байгаад ядуурч хоосроно гэж байдаггүй. Бага наснаасаа эхлэн мөнгө хуримтлуулан хураах зуршлыг сурсан хүн мөнгөнд үрэлгэн байна гэж байдаггүй. Мөнгөө хадгалж хуримтлуулж чаддаг хүн мөнгөө ухаалаг зарцуулж үрж чаддаг. Хүүхэддээ хэрэглээний мөнгө өгөн хадгалуулах зуршилтай болгож байгаа нь мөн мөнгийг ухаалаг зарцуулах аргыг давхар зааж байгаа бөгөөд нэг сумаар хоёр туулай буудаж байгаа юм.

Хүүхдэд эдийн засгийн боловсролыг эрт заах тусам сайн. АНУ-ын холбооны нөөцийн ситемийн удирдах зөвлөл (FRB)-ийн даргын албан тушаалд 5 удаа сонгогдон “АНУ-ын эдийн засгийн ерөнхийлөгч” хэмээн нэрлэгддэг Элан Грийнспэн(Alan Greenspan) ямар ч үед эдийн засгийн боловсролын талаар чухалчлан ярьдаг. Грийнспэний эцэг Еврей хүн байсан бөгөөд хувьцааны зуучлагчийн мэргэжилтэй нэгэн байв. Тэрээр 5 настайгаасаа эхлэн эцгээсээ хувьцаа болон авлага гэж юу болох талаар суралцан эдийн засгийн талаар мэдлэгтэй болсон байна. Еврей хүмүүс хүүхдээ бага сургуульд оронгуут хүүхдийн хандивын сангийн үйл ажиллагаанд элсүүлэн хэрэглээнийх нь мөнгөөр тухайн санд хөрөнгө оруулалт хийлгэдэг бөгөөд эдийн засгийн талаарх ойлголтыг хүүхэддээ сайн зааж өгдөг. Мэдээж хөрөнгө оруулсан сангийн хувьд зарим тохиолдолд оруулсан хөрөнгийг үрэн таран хийх тохиолдол гардаг. Гэвч эрсдэл үүсэх нь ч гэсэн нэг талаар сайн туршлага болдог. Хөрөнгө оруулалтанд эрсдэл гэж зүйл байдаг мөн тэвчээр шаардлагатай гэдгийг сурах боломжтой юм.

Хөрөнгө оруулалтын салбарт гайхалтай амжилт гарган дэлхийн хамгийн баян хүмүүсийн жагсаалтын 2-т бичигдэж чадсан Уоррен Баббетийн эцэг хүүхдүүддээ эдийн засгийн анхан шатны боловсролыг маш сайн заадаг байсан байна. Түүний боловсролын арга нь ихэвчлэн ном унших байсан. Тэрээр хүүхдүүддээ хувьцаа болон бизнесийн холбогдолтой ном сонинг байнга уншиж өгдөг байсан бөгөөд хүүхдүүд нь үүнээс шалтгаалан эдийн засгийн боловсролыг эрт суралцсан байна.

Хүүхдийг эдийн засгийн тал дээр маш ухаалаг болгож өсгөн хүмүүжүүлье гэвэл бага наснаас нь мөнгө гэж чухам юу болох, яагаад чухал болохыг энгийнээр тайлбарлаж ойлгуулах чухал юм. Мэргэжилтнүүд хүүхдэд эдийн засгийн боловсролыг эрт заах тусам сайн гэж үздэг. Бага наснаасаа эхлэн мөнгө гэж чухам юу болох, ямар үед хэрхэн зөв зүйтэй зарцуулах вэ гэдгийг мэдэж авах нь аз жаргалтай амьдралыг бий болгохын тулд заавал хийх ёстой зүйлсийн нэг юм. Хүүхдээ эдийн засаг, мөнгөний талаар зөв ойлголттой болгоё гэвэл эцэг эхчүүд өөрсдөө ч гэсэн энэ талаарх ойлголт сайн байх шаардлагатай. Тиймээс өдөр тутмын сонины эдийн засгийн булан юмуу эдийн засаг, санхүүтэй холбогдолтой ном сэтгүүлийг тогтмол уншин эдийн засгийн талаарх мэдлэгээ сайжруулах хэрэгтэй.

Эдийн засгийн боловсролын гол зорилго нь хүүхдийг өөртөө хадгаламж бий болгон хуримтлал үүсгэх зуршилтай болон мөнгийг зөв зүйтэй зарцуулдаг болгох юм. Ингэхийн тулд хүүхэддээ тогтмол хэрэглээний мөнгө өгч байх нь сайн юм. Гэхдээ энэхүү мөнгөнөөсөө 30-50 орчим хувийг хадгаламжинд хийх хэрэгтэй гэдгийг хүүхэддээ анхнаас нь сайн ойлгуулах хэрэгтэй. Хэрэглээний мөнгийг хүүхдийн насыг харгалзалгүй эрт өгч эхлэвэл маш сайн. Хүүхдээ хэрэглээний мөнгөө авбал юуны түрүүнд хадгаламжиндаа тодорхой хувийг хийгээд үлдсэн мөнгийг өөртөө хэрэгтэй зүйлд зарцуулдаг зуршилтай болгох хэрэгтэй. Ийм зуршилтай болсноор насанд хүрэн ажилд ороод цалин авсан ч тодорхой хувийг хадгаламжиндаа хийн үлдсэнийг нь хэрэглээндээ зарцуулдаг болж чадна. Хэрэв ямар нэгэн шалтгаанаар хүүхдээ загнаж зэмлэсэн бол дараа нь жаахан эрхлүүлэх хандлагаар хэрэглээний мөнгийг нь нэмж өгөх юмуу бэлэг авч өгөх зэрэг нь маш буруу зүйл. Хүүхэд буруу юм хийсэн ч мөнгө нэмж өгч байна гэж ойлгодог учраас эдийн засгийн үндсэн зарчимтай нийцэхгүй ийм үйлдлийг эцэг эхчүүд хийхгүй байх хэрэгтэй.

Хүүхдүүдтэйгээ хамт дэлгүүр хэсэх үедээ нэн түрүүнд хамгийн хэрэгтэй байгаа зүйлээ худалдан авдаг зуршлыг сургах бас чухал. Хүүхэд идэхийг хүсэж байгаа жигнэмэг юмуу авахыг хүсэж байгаа тоглоомоо авахыг хүсэн зөрүүдлэх үед хатуу байр суурьнаас хандах хэрэгтэй бөгөөд хүссэн бүхнийг нь авч өгөн хүүхдээ буруу эрхлүүлж болохгүй. Мэдээж ингэхдээ хамаагүй уурлаж уцаарлан хүүхдийнхээ сэтгэлийг шархлуулж болохгүй. Харин “Чиний үүнийг авахыг хүсэж байгааг чинь аав ээж хоёр нь сайн ойлгож байна. Гэхдээ энэ зүйл хүний эрүүл мэндэд муу, хэрэгтэй зүйл биш учраас авч өгөхийг хүсэхгүй байна” гэх маягаар хүүхэддээ сайн тайлбарлаж ойлгуулах хэрэгтэй. Хэрэгцээгээ хойшлуулах зуршлыг сургах нь ч гэсэн маш чухал юм. Яг одоо нэн даруй худалдан авах хэрэгтэй зүйл биш бол дараа худалдан авахаар хэрэгцээгээ хойшлуулах аргыг сургах нь зөв хэрэглээний зуршлын эхлэл юм.

Найз нөхдөө зөв таньж сонгон дотно нөхөрлөх талаар зааж ойлгуулах

“Талмуд” номонд найз нөхөдтэй холбогдолтой сургааль үг маш их байдаг. “Ухаантай найз хүнийг ухаантай болгодог бол мунхаг найз хүнийг мунхаг болгодог”, “Нэг хүний удаан найзалсан найз 10 хүний шинэ найзаас илүү”, “Хичнээн дотно анд нөхөр байсан ч хэтэрхий их ойртох хэрэггүй”, “Найздаа мөнгө зээлдэггүй хүн найзыгаа алдахгүй”, “Найз нөхдийнхөө дутагдалтай талыг хайдаг хүн найз нөхдөөсөө тусламж авч чадахгүй”, “Зөгийн баланд хүрээд үзвэл бага ч гэсэн зөгийн балны амтыг мэдэрч чадна”, “Үнэртэй усны дэлгүүрт ойрхон очвол үнэртэй усны үнэр үнэртэнэ”. Хүн гэдэг амьтан эргэн тойрноосоо байнга нөлөө авч байдаг. Хүүхдийг харвал түүний эцэг эх нь ямар хүн болохыг мэдэж, хүний найзалж нөхөрлөж байгаа хүнийг харвал тэр хүнийг ямар хүн болохыг мэдэж болно. Тиймээс хэн нэгэнтэй найзалж нөхөрлөхдөө тухайн хүний байдлыг сайтар ажиглах хэрэгтэй. Хүний амьдралын хамгийн үнэтэй хөрөнгийн нэг бол яахын аргагүй найз нөхөд юм. Хэрвээ хүнд үнэхээр дотно найз нөхөд байхгүй бол энэ нийгэмд амьдрах үнэхээр хэцүү. (Талмуд номны хэсгээс)

Сайн найз нөхөд гэдэг хүний амьдралд маш үнэ цэнэтэй байр суурийг эзэлдэг учраас хүнд маш том нөлөө үзүүлдэг. Хүн залуу насандаа найз нөхдийн нөлөөг хамгийн ихээр авдаг. Өөрөө ч мэдээгүй байхдаа хэн нэгэнтэй үзэл бодол, үйл хөдлөлийн хувьд ижил төстэй болон бусадтай найзалж нөхөрлөхөөр болдог. Солонгос улсын дунд сургуулийн 1-р ангид үздэг “Ачлал” хэмээх нэртэй сурах бичигт ийм үг гардаг. Күнз ч гэсэн найз нөхдийг “Сайн найз” болон “Муу найз” гэж ангилан найзалж нөхөрлөх хүнээ сонгохдоо анхаарах хэрэгтэйг онцолсон байдаг. Күнзийн тодорхойлсноор бол үнэнч шударга, итгэл даахуйц хүнийг сайн найз нөхөр, хуурамч дүр исгэсэн ноён нуруугүй, үг болон үйл хөдлөл нь хоорондоо таардаггүй хүнийг муу найз нөхөр гэнэ.

Үр хүүхэддээ бусадтай найзалж нөхөрлөхийн чухал чанарын талаар хэлж ярьдаггүй эцэг эх гэж бараг байхгүй. Энэ бол ямар ч үндэстэнд байдаг нийтлэг зүйл. Испани сургааль үгэнд “Найзыг нь харвал тэр хүнийг ямар хүн болохыг мэднэ” гэсэн үг байдаг. Энэ нь ойр дотно нөхөрлөдөг найз нөхдийг нь харвал тэр хүний мөн чанарыг мэдэж болно. “A Feathers get together” гэсэн Англи зүйр үг байдаг. Үүнийг орчуулвал дугуй дугуйгаа олно гэсэн утгатай үг юм.

“Бусадтай найзалж нөхөрлөхдөө өөрөөсөө нэг шат илүү түвшний хүнтэй найзалж нөхөрлөх хэрэгтэй” (Талмуд номын хэсгээс)

“Талмуд” номонд хүн хэн нэгэнтэй найзалж нөхөрлөхдөө өөрөөсөө нэг шат илүү хүнтэй найзалж нөхөрлөх хэрэгтэй гэсэн үг байдаг. Гэхдээ тэр нэг шат илүү хүн гэж зөвхөн толгой сайтай хичээл ном сайн хийдэг хүнийг хэлж байгаа юм биш. Хүн өөрийгөө нэг шат ахиулахад тус болох хүнтэй найзалж нөхөрлөх хэрэгтэй гэсэн утга юм. Тиймээс мэдлэг болон амьдралын ухаан, хүн чанарын хувьд сайн ямар ч байсан бусад хүний амьдралд нөлөөлөн амьдрах урам зориг өгч чаддаг, нэг ч гэсэн сайн чанарыг суралцаж чадах хүнтэй найзалж нөхөрлөх хэрэгтэй гэсэн үг юм.

Еврей хүмүүс хүүхэддээ өөрөөсөө нэг шат илүү хүнтэй найзалж нөхөрлөх хэрэгтэй гэж

байнга хэлж зөвлөдөг. Хүүхэд нь анх удаа найз нөхөдтэй болвол төрсөн өдрийн үдэшлэг юмуу оройн хоолон дээр хүүхдийнхээ найзыг урьдаг. Ингэж байгаа нь хүүхдийнхээ найзалж нөхөрлөж байгаа хүн ямар хүн болохыг шалгаж байгаа нэг төрлийн урьдчилсан хяналт шалгалт юм. Хэрвээ хүүхдийнх нь найзалж нөхөрлөж байгаа хүн хүүхдэд нь муу нөлөө үзүүлнэ гэж эцэг эх дүгнэсэн бол хүүхэддээ бодит үнэнийг шууд хэлэн “Найз нөхөрлөлийн харилцаагаа дахин нэг сайн тунгаан бодоод” үзээрэй гэж зөвлөдөг.

“Тодорхой бус найз нөхөд болж байснаас тодорхой дайснууд болсон нь дээр” (Талмуд номны хэсгээс)

Хүн хэн нэгэнтэй үнэхээр найзалж нөхөрлөж эхэлсэн бол энэ харилцаагаа үүрд хадгалж хэвээр байлгах хэрэгтэй гэж хүүхэддээ зөвлөдөг. Ямар ч байсан найз нөхөд болсон бол өнгөцхөн харилцаатай биш гүнзгий дотно харилцаатай болох хэрэгтэй гэсэн утга юм. Ийм үзэл бодолтой учраас Еврей хүмүүсийн хүмүүстэй харилцах харилцаа маш олон хүмүүстэй өнгөцхөн найзалж нөхөрлөдөг өрнө дахины хүмүүсээс өөр байдаг. Эсрэгээрээ олон биш ч гэсэн цөөхөн хэдэн хүнтэй дотно сайн найзалж нөхөрлөдөг дорно дахины хүмүүстэй төстэй байдаг.

Хамгийн анхны өрсөлдөгч болох ах, эгч, дүү нарын харилцааны талаар зааж сургах

Израильд ажилч хичээнгүй ах дүү 2 тариачин амьдарч байжээ. Ах нь хуримаа хийж хүнтэй суун эхнэр хүүхэдтэй болон харин дүү нь хүнтэй суугаагүй байна. Эцэг эхээ нас барсны дараа бүх хөрөнгөө 2 тэнцүү хувааж авав. Газар тариалан эрхлэн хураасан алим болон эрдэнэ шиш зэргээ яг тэнцүү хуваан өөр өөрийн эзэмшлийн газарт хадгалсан байна. Нэг шөнө дүү нь “Ах маань эхнэр хүүхэд, үеэлүүд гээд олон хүн тэжээж байгаа болохоор амьдрал нь хэцүү байгаа байх. Тийм болохоор өөрийнхөө хураасан зүйлээ ахдаа өгөх хэрэгтэй” гэж бодон мэдэгдэлгүйгээр ахынхаа алим эрдэнэ шишээ хураасан газар өөрийнхөө алим эрдэнэ шишнээс аваачиж тавьсан байна. Дараа өдрийн өглөө юм хадгалсан газраа очсон ах дүү хоёр яг тэнцүү хуваасан хэмжээгээр тариалангийн бүтээгдэхүүн нь хэвэндээ байхыг хараад маш их гайхсан байна. Түүний дараа өдөр ч гэсэн яг үүнтэй адилхан зүйл давтагдав. Ингээд дөрөвдөх өдрийн шөнө нэг нэгнийхээ тариа будаа хадгалах байр луу алим, эрдэнэ шиш зөөж байсан ах дүү хоёр тааралдсан байна. Ах дүү 2 бие биенээ хараад тэврэлдэн уйлалдсан байна. Тиймээс тэр газар одоо ч гэсэн Иерусалимд хамгийн эрхэм нандин газраар нэрлэгдсээр байгаа юм.

Гэр бүлд ах дүү эгч дүүсийн хооронд ямар нэгэн өрсөлдөөн үүсдэг нь мэдээж зүйл юм. Мэдээж өсөж том болох явцдаа зодолдож хэрэлдэх, муудалцах тохиолдол бишгүй л олон байдаг. Библи номонд гардаг Адам, Ева хоёр гэрлэн дундаас нь гарсан хүн төрөлхтний хамгийн анхны ах дүү болох Кайн болон Абелийг жишээ аваад үзье. Кайн Бурхан өөрийнх нь дүү Абелд сайн хандаж байгаад атаархан Абелийг алснаар хүн төрөлхтний хамгийн анхны алуурчин болсон байдаг. Ах дүүс бие биенээ алсан явдал цаг хугацаа ялгалгүй болж байсан тохиолдол их байдаг. Солонгос улсын түүхэнд ч Тэжугийн И Сон Гегийн хүүхдүүд ч гэсэн мөн хаан ширээний төлөө тэмцэлдэн цуст аллага үйлдсэн гэсэн түүх байдаг.

Ихэнхи улс орны түүхэнд иймэрхүү нэг гэр бүлийн ах дүү, эгч дүү хооронд өрсөлдөж тэмцэлдэж байсан тохиолдол их гарч байсан болоод ч тэр юмуу улс үндэстэн ах дүү, эгч дүү гэх мэт гэр бүлийн гишүүд хоорондын харилцааны талаар ихээхэн онцолсон байдаг. Хятадын Сан улсын үед газрын эзний байр сууриа бие биендээ өгсөн Пэг И болон Сүг Жэ, цөллөгдөн зовж тарчлан хүнд хэцүү орчинд амьдарч байсан ч ах дүүгийн хайр халамжаар бие биедээ туслан амьдарч байсан Жон Яг Жон болон Жон Яг Юн ах дүү нарын түүхийн талаар олон хүмүүс мэддэг.

Солонгос улс төдийгүй дорно дахины улс орны нийгэмд эцэг эхчүүд төрсөн ах дүү, эгч дүү хоорондын харилцааг өөрсдийн үзэмжээр шийдвэрлэн тулган шаардах хандлага их байдаг. Жишээлбэл ах дүү юмуу эгч дүү хоёр хоорондоо зодолдож хэрэлдэх үед “Чи ах нь учраас бууж өгөх хэрэгтэй” “Чи насаар ах учраас тэвчих хэрэгтэй” гэх мэтээр тулган шаардан хүүхдүүдэд буруу ойлголт төрүүлдэг. Шударгаар хэн буруу зүйл хийсэн хэн буруугүй болохыг хүүхдүүддээ тайлбарлаж ойлгуулахын оронд насаар ах учраас дүүгээ тэвчих хэрэгтэй гэх маягаар хүүхдүүддээ буруу зүйл заадаг болохоор хүүхэд шударгаар ялж ялагдахыг суран хэн буруу зүйл хийсэн, хэн буруугүй болохыг ойлгож ухаарч чаддаггүй.

Харин Еврей хүмүүсийн хүүхдүүдийнхээ хоорондын хэрүүл маргаан, зодооныг зохицуулж шийдвэрлэх арга барил маш өвөрмөц байдаг. Эхлээд хэрүүл маргаанд оролцсон

хүүхдүүдийнхээ яриаг нэг бүрчлэн анхааралтай сонсон өөрсдийн санал бодлоо хэлэх боломжоор хангадаг. Ингээд хүүхдүүдийнхээ яриаг сонссоны дараа эцэг эх хоёр шийдвэрлэх байр суурьнаас хэн нь буруу зүйл хийснийг хүүхдүүддээ тайлбарлаж ойлгуулдаг. Эцэг эхийн шийдвэр нэг гарсан л бол дахиад энэ асуудалтай холбоотой хэрүүл маргаан гаргахгүй байхыг хүүхдүүддээ заадаг.

АНУ-ын гадаад харилцааны сайдын албан тушаалыг хашдаг Еврей хүн Хэнри Киссинжерийн дүү Уолтер Киссинжер өнөөдрийг хүртэл ахтайгаа өрсөлдсөөр ирсэн гэж ярьдаг. Ахынхаа ард орж болохгүй гэсэн бодол түүнийг шамдуулан том амжилтанд хүргэсэн байна. Тэрээр “Хүүхэд наснаасаа эхлэн бид байнга өрсөлдөгчид байсаар ирсэн. Харин бид хэзээ ч буруу хандлагаар өрсөлдөж байгаагүй. Учир нь бидний хийдэг ажил, сонирхол, зан чанар өөр өөр байсан учраас юм” гэж ярьжээ. Уолтер Киссинжер дэлхийн нэр хүндтэй дипломатч байсан ахдаа өөрийн амжилтаа харуулахын тулд хичээнгүйлэн ажилласаар цахилгаан, эрчим хүчний компани байгуулан захирлаар нь ажиллан ахаасаа өндөр үнэлгээ авч чадсан байна. Уолтер Киссинжер “Одоо ч гэсэн миний сонины газар Хэнригийн хойноос явж байгаа. Миний амжилт гаргасан нууцад судлаж үзүүштэй үнэ цэнэ байгаа” гэж хэлэн өрсөлдөхийн чухал чанарыг онцолсон байдаг.

Ийнхүү Еврей эцэг эхчүүд төрсөн ах дүү, эгч дүүсийг хооронд нь өрсөлдүүлдэг ч зөв хандлагаар өрсөлдөн бие биеэсээ суралцан нэг нэгнээ хайрлаж халамжлах хэрэгтэйг хүүхдүүддээ зааж сургадаг. Бусадтай зөв арга барилаар өрсөлдөхийг чухалчлан ямар ч үед бие биедээ туслан зөв хандлагаар, зөв арга барилаар өрсөлдөхийг хүүхдүүддээ заадаг. Боловсролын талаас нь аваад үзвэл хүүхэд бусадтай хамтран ажиллах юмуу зөв хандлагаар өрсөлдөх байдлаар суралцвал маш үр дүнтэй. Тэгэж байж л ямар нэгэн зүйлд хүсэл сонирхол дүүрэн өөртөө итгэлтэй хүн болон өсч чадах бөгөөд хувиа хичээсэн зан чанараас ангижран бусад хүнтэй сайн зохицож харилцан бие биедээ туслах талаар суралцаж ийм зан чанарыг өөртөө бий болгодог.

Солонгос хүмүүсийн тухайд хүүхдүүдээ хооронд нь байнга харьцуулдаг. “Ах чинь хичээлдээ ийм сайн байхад чи яагаад ийм муу байгаа юм бэ?” гэх маягаар хүүхдээ загнаж шүүмжлэх хандлагатай байдаг. Гэтэл Еврей хүмүүс хүүхдүүдээ чадвар мэдлэгээр нь огтхон ч харьцуулдаггүй. Хүүхдийн мэдлэг чадварыг харьцууллаа гээд хичээлдээ муу хүүхэд сайжирдаг юм биш. Харин эсрэгээрээ өөрийгөө бүр голон сэтгэл санаагаар унан буруу тийшээ явах магадлал өндөр байдаг. “Хүүхдүүдийнхээ мэдлэг чадварыг хооронд нь харьцуулалгүй хувийн зан чанарыг нь харьцуулах хэрэгтэй” гэсэн Еврей сургааль үг байдаг. Энэ үгний дагуу бол хүүхэд нэг бүрийн авъяас хувийн зан чанарыг сайжруулан хооронд нь зөв арга барилаар өрсөлдүүлж байгаа нь Еврей хүмүүсийн боловсролын нууц арга барилуудын нэг юм.

Еврей хүмүүс хүүхдээ найзынхаа гэрт тоглохоор явах үед ах дүү, эгч дүү хоёрыг хамт явуулдаггүй. Учир нь энэ бол хүүхдүүдийнхээ хувийн зан чанарыг сайжруулах нэг арга юм. Хэдийгээр төрсөн ах дүү, эгч дүү боловч зан чанар, сонирхлын хувьд өөр өөр байдаг учраас нэг газар очоод хоорондоо таарч тохирох гэж хичээснээс илүү тус бүр өөрийнхөө найзын гэрт очин өөр орчноос шинэ зүйл суралцах нь илүү дээр гэж үздэг. Еврей хүмүүс нэг эцэг эхээс төрсөн ч хүүхэд тус бүрт онцгой авъяас хувийн зан чанар байдаг бөгөөд үүнийг сайжруулж

хөгжүүлэх нь эцэг эхчүүдийн үүрэг гэж боддог.

Үнэнч шударга байдал хамгийн шилдэг зэвсэг болохыг хүүхэддээ ойлгуулах

Уулнаас мод бэлтгэн зарж олсон мөнгөөрөө амь зуудаг нэгэн багш байсан байна. Тэрээр бэлтгэсэн модоо ачихдаа хэрэглэх гэж нэг илжиг худалдан авав. Худалдаж авсан илжгээ хотын захад авчран цэвэрлэж байтал хүзүүнийх нь оосорноос нэг очир алмааз унаад ирэв. Үүнийг мэдсэн шавь нар нь багшийгаа одоо л нэг баян чинээлэг болон түлээ мод бэлтгээд байхгүй сурагчидтайгаа хамт суралцах цаг ихтэй болох нь гэж ихэд баярласан байна. Гэтэл багш худалдаачин дээр буцаж очин алмаазыг буцаан өгөөд "Би танаас зөвхөн илжиг л худалдан авсан. Очир алмааз худалдаж аваагүй" гэж хэлсэн байна. Өөрийн эзэмшлийн биш зүйлийг авахгүй байх Еврей хүмүүсийн амьдралын бас нэг чухал зарчим юм. (Талмуд номны хэсгээс)

Нью-Йоркийн Queens юмуу Brooklyn дүүрэгт очвол хүн түрээслэн амьдрах 6 давхар түрээсийн байр хаа сайгүй ярайсан байдаг. Гадна талын ханыг нь улаан өнгөөр будсан энэхүү түрээсийн байрнуудад амьдарч байгаа гэр бүлийн тоо бараг 60,000-д хүрнэ. Эдгээр бүх орон сууцнууд Нью-Йорк хотын үл хөдлөх хөрөнгийн бизнесийн эцэг гэгддэг Еврей хүн Лифрак (Lefrak)-ийн гэр бүлийн эзэмшил юм. 4 үе дамжин ирсэн гэр бүлийн удирдлагын ухаанаараа дамжуулан олон тэрбум долларын хөрөнгө мөнгийг цуглуулахад хамгийн гол нөлөө үзүүлсэн хүн бол Самуэл Лифрак (Samuel Lefrak) юм. 1905 онд хувийн бизнесээ эхэлж байсан түүний эцэг Самуэлийг 8 настай байхаас эхлэн ажлын газраа дагуулан очин үл хөдлөх хөрөнгийн бизнесийн талаар зааж өгсөн байна. Хүүхэддээ зааж зөвлөж байхдаа эцгийнх нь байнга чухалчилдаг байсан зүйл бол "Ямар ч зүйлд үнэнч шударга байх хэрэгтэй" гэсэн зүйл байсан юм.

Үл хөдлөх хөрөнгийн бизнес бол байнгын хөдөлгөөнтэй эргэлдэж байдаг бизнес. Аливаа бизнесд хамтран ажиллаж байгаа хүмүүс их байх тусам хүмүүс хоорондын итгэлцэл, харилцаа юу юунаас илүү чухал юм. Жаахан илүү ашиг олох гэсэн бодлоор үнэнч шударга байдлыг алдах нь бизнесийн үйл ажиллагаа хэвийн явахад асуудал үүсгэн ашиг олох нь байтугай хохирол амсуулах хэмжээний аюултай түвшинд ч аваачдаг. Самуэлийн хувьд ч гэсэн нас барах хүртлээ өдөр бүр хүү болон 2 ачтайгаа хамт өдрийн хоол идэнгээ тэдэнд үнэнч шударга байдлын талаар маш их зүйл зааж сургаж байсан гэдэг.

2008 онд болсон АНУ-ын хамгийн том санхүүгийн залилангийн хэргээс болон Еврей хүмүүс ихээхэн цочролд орсон юм. 50 тэрбум долларын томоохон санхүүгийн залилангийн хэргийг Насдакийн хөрөнгийн биржийн хувь нийлүүлэгчдийн тэргүүн Еврей хүн Бернард Мэдофф (Bernard Lawrence Madoff- тухайн үед 70 настай байсан) гэдэг хүн үйлдсэн байсан учраас юм. Хохирлын хэмжээ асуудал биш ч өнөөг хүртэл "Үнэнч шударга байдал"-ыг чухалчлан амьдарсаар ирсэн Еврей хүмүүсийн амьдралд хар толбо үлдээгээд зогсохгүй олон арван жилийн турш залилан хийж мөнгө идэж байсан гэдэг нь тогтоогдсоноор Еврей хүмүүсийг маш том цочролд оруулсан юм.

Мэдоффийн залилангийн хэргийн хохирогчид дотор алдарт кино найруулагч Стивен Сбилберг, Нобелийн энх тайвны шагналтан Эли Вижл (Elie Wiesel) гэх мэт нэр алдартай Еврей хүмүүс цөөнгүй байсан байна. Хүмүүс хоорондын итгэлцэл, үнэнч шударга амьдрахын үнэ цэнэтэй байдлын талаар хүүхэд наснаасаа л суралцан зөв хүмүүжлээр хүмүүждэг Еврей

хүний хувьд залилангийн хэрэг хийнэ гэдэг бол зүүдэнд ч ормооргүй зүйл юм. “Талмуд” номноос иш татсан Нью-Йорк таймс сонины нэгэн нийтлэлд “Еврей хүмүүс нас барсныхаа дараа Бурханы өмнө очихдоо хамгийн эхлээд “Чи худалдаа наймаа эрхлэхдээ хүн чанарынхаа дагуу үнэнч шударга байж чадсан уу?” гэсэн асуултанд хариулахад бэлэн байх хэмжээгээр бага наснаасаа эхлэн үнэнч шударга байдлын талаар суралцдаг. Мэдоффийн хувьд Еврей гэр бүлд өссөн ч хийж боломгүй муу зүйл хийсэн” гэж бичсэн байна.

Еврей хүмүүс хүүхэд наснаасаа эхлэн үнэнч шударгаар амьдрах талаар сайтар ойлгож суралцсан байдаг. Жишээ нь хичээлийн цаг дээр шалгалт өгөхдөө хажууд нь хяналт тавих хүн байхгүй байсан ч сурагчид нэг нэгнээсээ хуулах гэх мэт бусдыг хуурсан буруу үйлдэл огтхон ч хийдэггүй. Худалдаа наймаа хийхдээ ч гэсэн байгуулсан гэрээ, хэлцлээ хатуу дагаж мөрддөг. Гэрээ хэрэгжин дуусгавар болох хүртэл үнэнч шударга байдаг. Шугамаар хэмжих юмуу жинлүүрээр жинлэх үедээ ч бусдыг хуурдаггүй. Баталгаатай хэмжигч, жин хэмжүүрийг хэрэглэх хэрэгтэйг сурсан байдаг учраас юм. Үнэнч шударгаар худалдаа наймаа эрхлэвэл эцэст нь мөнгө олж чадна гэсэн итгэлтэй байдаг. Үнэнч шударга байдал бол Еврей хүмүүсийн бас нэгэн том хөрөнгө бөгөөд хөрөнгийн эх үүсвэр юм.

Мэдээж бас бусдад худлаа ярьж болохгүй гэж хүүхдүүддээ заадаг. “Талмуд” номонд бичсэнээр зөвхөн дараах 2 тохиолдолд л худлаа ярихыг зөвшөөрсөн байдаг. Энэ нь нэг ёсондоо “Уучлагдах боломжтой худлаа ярилт” гэсэн үг юм. 1-рт. Хэн нэгэн чамд худалдан авсан бараагаа сонирхуулан чиний бодол санааг асууж сонирхох үед хэдийгээр тэр нь чиний сэтгэлд таалагдаагүй байсан ч гоё байна” гэж худлаа ярих. 2-рт хуримаа хийсэн найзын чинь эхнэр царай муутай байсан ч “Эхнэр чинь үнэхээр үзэсгэлэнтэй юм. Аз жаргалтай сайхан амьдраарай” гэж худлаа ярих юм.

Байнга талархалтайгаар амьдрах зуршлыг сургах

Дэлхийд хамгийн анх хүн нэг талх барьж идэхийн тулд талбай хагалах, үр цацах, түүнийгээ арчилж тордох, хураах, тээрэмдэх, зуурах, жигнэх гэх мэт 15-16 шат дамжлага дамжуулж байж талхаа хийж иддэг байв. Харин орчин үед мөнгө байвал талх зардаг газарт очин хүссэн талхаа худалдан авч идэж байна. Дээр үед бараг ганцаараа хийдэг байсан энэ бүх ажлуудыг одоо олон хүн хуваан хийж байгаа учраас талх идэхдээ олон хүмүүст талархахаа мартаж болохгүй. Хувцас өмсөхдөө ч мөн адил. Дээр үед мөн л өөртөө таарсан хувцас хийж өмсөхийн тулд маш их хөдөлмөрлөдөг байсан бол одоо тэр ажлыг олон хүн хуваан авч бидний хүссэн хувцасыг хийж байгаа болохоор хувцас өмсөх үедээ ч гэсэн хүмүүст талархаж байх хэрэгтэй. (Талмуд номны хэсгээс)

“Талархал бол гэр бүл юмуу ажил төрлийн талаарх сэтгэл ханамж, баяр баясгаланг нэмэгдүүлэн хүмүүс хоорондын харилцааг улам сайжруулан хайраар бялхаадаг бөгөөд зөрчил тэмцлийг үгүй болгон хамтран ажиллах таатай нөхцлийг бүрдүүлдэг. Хүн ямар ч нөхцөл байдалд чин сэтгэлээсээ талархахыг сурвал хичнээн тэсвэрлэхэд хэцүү нөхцөл байдал тулгарсан ч нөхцөл байдалд ухаалаг хандаж чаддаг болдог. Түүнчлэн амьдралыг гэгээлгээр харан өөдрөг үзэл бодолтой болдог. Яг л ид шид юм шиг боломжгүй зүйлийг боломжтой болгодог. (Хүний оюун санааны эмчилгээний мэргэжилтэн Ноелли Нэлсон (Noelle Nelson)-ий “Хүсэл мөрөөдлийг бий болгодог талархлын хүч”)

“Удирдлагын баатар” хэмээн нэрлэгддэг Японы бизнесмэн Машида Кунускэ “Шорон болон сүм дуган дэлхий ертөнцөөс тусгаарлагдмал байдгаараа хоёулаа төстэй газар. Хоорондоо ялгаатай гэж бодож байгаа бол гомдоллож ч болно талархаж ч болно. Хүн шоронд байлаа ч талархалтай байдлаар хандвал шоронг сүм дуган мэт бодож чадна” гэж хэлсэн байдаг. Тэгвэл талархах сэтгэлээр бүх зүйлд хандан амьдарч байсан Гүидугийн хувьд тамлан зовоон хорих газар нь шорон биш сүм дуган шиг байсан гэж үү? Италийн “Амьдрал бол гайхалтай (Life is Beautiful)” гэдэг киноны гол дүр болох Гүиду гэдэг хүн бусдаас өвөрмөц Еврей хүн биш юм. “Амьдрал түүнд хатуу хандсан ч ”Бурханд итгэн тэвчиж аливаа асуудалд ухаалаг хандаж чадвал гайхалтай сайхан амьдрал өөрт нь ирнэ гэсэн итгэлээ алдаагүй Еврей хүн байсан юм.

Еврей хүмүүс бол 2000 жилийн турш маш хүнд хэцүү хавчлага дарамтанд амьдарч байсан үндэстэн. Дэлхийн 2-р дайны үед бараг бүх Еврей хүмүүсийн талыг нь устгах хэмжээний томоохон аллага болж байсан. Ийм удаан хугацааны турш хүнд хэцүү зовлон бэрхшээл дунд амьдарч байсан ч Еврей хүмүүс өөрсдийн шүтдэг Бурхандаа талархан итгэл найдвараа алдаагүй юм. Нацист Германы шоронд хүч чадал нь барагдан хүүхэд хөгшидгүй үхэж байсан ч Бурхандаа хандан талархалтайгаар гуйсаар байсан юм.

Еврей хүмүүсийн энэхүү аливаа зүйлд талархалтайгаар ханддаг хандлага нь шашны үзэл сурталтай нь холбоотой. 16-р зууны үед амьдарч байсан шидтэн Исаак Рүриа гэдэг Еврей хүн “Хүн амьдралынхаа бүхий л явцаас баяр хөөр, аз жаргалыг мэдэрч амьдрах хэрэгтэй” гэж хэлсэн байна. Мөн Мэнахэм Шюүнэрсон гэдэг шашны багш “Бүх зүйлийг сайнаар бод. Тэгвэл бүх зүйл сайхан болно” гэж хэлсэн байна. “Талмуд” номонд Хиллэри гэдэг шашны багш “Өөрийг чинь хүнд байдал оруулах зүйлийг бусдад битгий хийгээрэй. Еврейн шашны сургааль бараг энэ сургаальд үндэслэсэн байдаг бөгөөд бусад бүх зүйлийг бараг үүний

тайлбар гэж хэлж болно” гэж хэлсэн байдаг.

Энэхүү хандлага хүүхдийнх нь боловсролд хүртэл илэрдэг. Еврей хүмүүс хүүхэддээ бага наснаас нь эхлэн бага том гэлтгүй ямар ч зүйлд талархаж баяртайгаар ханддаг хүн болох хэрэгтэй гэж зааж сургадаг. Бурханд талархах байдлаар суралцан энэхүү хандлага нь эцэг эх, эх орондоо талархах хандлагаар үргэлжилдэг. Хоол идэхдээ ч хоолонд орсон хүнсний бүтээгдэхүүнийг хийж буй хүмүүст талархан, унтахын өмнө өөрийг нь хайрлаж халамжлан өсгөж байгаа эцэг эх, багшдаа ч талархахыг заадаг. Бүх зүйлд талархаж сурснаар хүүхэд аяндаа бусдыг хайрлаж халамжлах сэтгэлтэй бие хүн болон төлөвшдөг.

Гэтэл эсрэгээрээ сүүлийн үед Солонгос хүмүүс бүх ажил төрөл нь бүтэмжтэй сайн байвал өөрөөс нь шалтгаалсан гэж үзэн бүтэмжгүй байвал бусад хүнээс болсон гэсэн үзэл бодолтой болж өөрчлөгдөж байна. Энд тэндхийн шашны уулзалт цуглаанаас Бурханаас гуйж залбирч байгаа дүр төрхтэй хүмүүсийг олноор харж болох ч сүсэг бишрэлгүй худлаа зөвхөн хэрэгцээнийхээ дагуу Бурханаас гуйж залбирч байгаа хүмүүс ихэнхи хувийг эзэлж байна. Ихэнхи хүмүүс итгэж шүтдэг шашныхаа Бурханаас гэр бүлийн гишүүдийнхээ эрүүл мэнд, бизнес нь амжилттай болон мөнгө их олох, хүүхдүүдээ сайн их сургуульд оруулах, ажилдаа амжилт гаргах гэх мэт зүйлийн талаар гуйдаг хандлагатай болсон байна. Хүнд хэцүү амьдралтай байгаа хүмүүс юмуу улс орныхоо сайн сайхан нийгмийн төлөө гуйдаг хүн бараг байдаггүй. “Орчин үеийн хүмүүс насанд хүрсэн байна уу хүүхэд байна уу хамаагүй аливаа зүйлд талархахыг огт мэдэхгүй ихэнхидээ гомдоллох хандлагатай болж байна. Бурханд итгэн сүсэг бишрэлээр амьдардаг хүмүүсийн хувьд ч Бурханаас гуйж байгаа зүйл нь цаг хугацаа өнгөрөх тусам ямар нэгэн материаллаг зүйл хүссэн хандлагатай болон өөрчлөгдөж байна” гэж нэгэн шашны алба эрхлэгч хэлсэн байна.

Цаг хугацааны үнэ цэнийг ойлгодог болгох

Соломон хаан хивсэн дээр суун тэнгэрээр нисэж байгаад нэгэн цайзад тулж иртэл хаалган дээр нь "Та хичнээн их хичээсэн ч цаг хугацаа таныг хүлээхгүй. Хэзээ нэгэн цагт та хөгшрөн ядарч туйлдан өөрийн байр суурийг өөр хэн нэгэнд өгөх хэрэгтэй болох бөгөөд эцэст нь та энэ дэлхийд ирсэн шигээ буцах болно. Цаг хугацаа урсан өнгөрч өөрчлөгдсөн ч бүү санаа зов. Цаг хугацаа гэдэг урсан өнгөрч хувьсан өөрчлөгдөх нь ч мэдээж зүйл юм" гэсэн үг бичээстэй байв. Таны энэ хорвоо ертөнцөд амьдрах хугацаа хязгаартай учраас хийхийг хүсэж байгаа бүхнээ хийн зогсолтгүй давшаарай. (Талмуд номны хэсгээс)

Унгар улсын сонины сэтгүүлч байсан Разиль Биру гэдэг Еврей хүн үзгээр нийтлэл бичих болгондоо уур нь хүрдэг байсан байна. Түүнд байсхийгээд үзгэндээ бэх дүүргэн бичих ядаргаатай байсан төдийгүй түүнд зарцуулж буй цаг хугацаа нь маш харамсалтай санагдаж байсан учраас юм. Бэх гар юмуу бичиж буй цаасыг нь заваарууулах тохиолдол ч бишгүй их байсан бөгөөд үзэгний хурц хушуунд бичиж буй цаас нь урагдах тохиолдол ч гарч байв. Тэрээр сонины хэвлэлтэнд ашигладаг бэх цаасанд хурдан шингэж хатан уусаж тархдаггүй болохыг ажигласан байна. Тэрээр сонины хэвлэлтэнд ашигладаг бэхийг үзгэндээ хийн ашиглаж үзтэл бэхийн найрлага хэтэрхий өтгөн байсан болохоор үзэгний хошуугаар урсаж гарч ирэхгүй байв. Тэрээр химич дүү Гэулигийн тусламжтайгаар үзэгний хошууны үзүүрт жижигхэн бөмбөг бүхий үзгэн балыг зохион бүтээсэн байна.

Үзэгний хошууны төгсгөлд жижигхэн төмрөн өндөг хэлбэрийн бөмбөгийг хийж өгвөл энэ нь үзэгний хөдөлгөөнийг даган өнхөрч тосон бэх урсан гарч ирэн цаасан дээр буудаг гэсэн санааг анх бодож олсон хүн бол 17-р зуунд амьдарч байсан Галлилэу Галлилэй гэдэг хүн байсан юм. Ингээд бодитоор үзгэн балыг зохион бүтээх гэж оролдлого хийсэн хүн бол 19-р зууны үед амьдарч байсан Английн арьс шир боловсруулах үйлдвэрийн эзэн Жон Рауд гэдэг хүн байв. Тэрээр ган төмрөн бөмбөлөг болон бөмбөлөг ордог хонхор хэсгийн талаар санаа дэвшүүлэн 1888 онд тусгай зөвшөөрөл хүртэл авсан боловч бэхээ тогтоож чадалгүй асгаснаас болоод бүтээгдэхүүн болох нь бүтэлгүйтсэн байна. Ийнхүү явсаар үзгэн бал 50 жилийн дараа буюу 1938 онд Бируугээр бүтээгдэн дэлхийд анхныхаа хэлбэр дүрсийг олсон юм. Энэхүү бүтээл цаг хугацааын үнэ цэнийг эрхэм чухалд тооцсон нэгэн Еврей хүний судалгааны үр дүнд бий болсон юм.

Русвэлт ерөнхийлөгчийн эхнэр Элианор Ёсо "Өчигдөр бол түүх, маргааш бол оньсого, өнөөдөр бол бэлэг /Yesterday is history, tomorrow is mystery, today is gift/ гэж хэлсэн байдаг. Еврей хүмүүс ямар ч үндэстнээс илүү цаг хугацааны үнэ цэнийг сайн ойлгодог. Тэд эртний Египетийн үеэс эхлэн 430 жилийн турш боолын амьдралаар амьдарсаар ирсэн. Тухайн үед өглөөнөөс эхлэн шөнө болтол хүнд хэцүү боолын хөдөлмөр эрхлэн амьдарч байсан учраас цаг хугацааны талаар ойлголтгүй байсан.

Еврей хүмүүс Египетээс чөлөөлөгдөн чөлөөт хүмүүс болсон тэр үеэс эхлэн удирдагчид нь цаг хугацааны ойлголтын талаар зааж эхэлсэн. "Өнөөдөр ямар ажил хийсэн бэ?" "Цагаа хий дэмий өнгөрөөгөөгүй биз дээ?" гэх мэтээр асуулт тавин цаг хугацааг сайн ашигладаг болтол хүмүүст зааж сургасан байна. Еврей хүмүүс ямар ч үндэстнээс илүү цаг хугацааны чухал чанарыг ойлгон онцлохдоо түүхийнхээ талаар их ярьдаг.

Мөн Еврей хүмүүс мөнгөний үнэ цэнийг маш сайн мэддэг үндэстэн. Тиймээс бага наснаас нь эхлэн хүүхэддээ хэрэглээний мөнгө өгөн өөртөө хуримтлал үүсгэх арга барил зуршлыг зааж сурган мөнгөний талаар ойлголттой болгодог. Гэвч мөнгөнөөс илүү эрхэм чухалд тооцдог зүйл нь мэдээж цаг хугацаа юм. Мөнгийг цаг хугацааг чөлөөтэй болгодог хэрэгслээс цаашгүй зүйл гэж тооцдог. “Талмуд” номонд “Хүн мөнгийг цаг хугацаанаас илүү эрхэмд тооцдог боловч мөнгөнөөс болон алдсан цаг хугацааг мөнгөөр худалдан авч чадахгүй” гэсэн үг гардаг. Мөнгийг хүн хичээвэл хэзээ ч олж болдог зүйл, мөн эрүүл мэнд муудсан ч сайн амарч хичээнгүй дасгал сургууль хийн хоол унд сайн идвэл дахин сайжруулж болдог зүйл боловч нэгэнт өнгөрсөн цаг хугацааг хэн ч буцааж чадахгүй.

Тиймээс Еврей хүмүүс 2000 жилийн өмнө өвөг дээдэс нь хүүхдүүддээ зааж байсан шиг одоо ч гэсэн хүүхдүүддээ цаг хугацааны үнэ цэнийн талаар сайн зааж ойлгуулдаг. Еврей хүүхдүүд аливаа зүйлд төлөвлөгөөтэй ханддаг учир шалтгаан нь энэхүү боловсролын нөлөө юм. Өглөө босоод орой орондоо орох хүртлээ 1 минут 1 секундыг ч дэмий зүйлд зарцуулдаггүй. Сайтар төлөвлөсөн цагийн хувиарынхаа дагуу амьдрах зуршлыг биедээ шингээсэн байдаг. Насанд хүрсэн хүмүүсийн хувьд ч гэсэн мөн ялгаагүй байдаг. Ажлаа сайтар төлөвлөн цаг хугацааг хий хоосон өнгөрөөдөггүй.

Төлөвлөсөн цагийн хувиарынхаа дагуу эмх цэгцтэй амьдарвал төлөвлөсөн ажлууд тогтсон цаг хугацаандаа дуусдаг. Хийж байсан ажлаа дундаас нь орхих юмуу дараагийн өдөр лүү шилжүүлэхгүйгээр төлөвлөсөн цаг хугацаандаа дуусгах хэрэгтэй гэсэн бодолтой байдаг учраас тэр хэмжээгээр ажилдаа сайн төвлөрөн үр дүн амжилт гаргах хувь нь ч өндөр байдаг.

Ийнхүү хүүхдэд цаг хугацааны үнэ цэнийн талаар ойлгуулан цаг хугацааг төлөвлөгөөтэйгээр үр дүнтэй ашиглах зуршилтай болгоё гэвэл цаг хугацааны талаарх ойлголтыг сайн ойлгуулах хэрэгтэй. Бүх хүнд цаг хугацаа адилхан оногддог объектив зүйл боловч хүмүүсийн мэдэрч буй цаг хугацааны тухайд субъектив зүйл юм. Ялангуяа хүүхдийн цаг ашиглалт эцэг эх, найз нөхөд, цэцэрлэгийн багш гэх мэт өөртэй нь харилцан хамаарал бүхий хүмүүсийн үйл ажиллагаанаас шалтгаалан өөрчлөгдөн байнга хөдөлгөөнтэй байдаг.

Хүүхдэд цаг хугацааг өөрөө дур мэдэн ашиглах чадвар хараахан байдаггүй. Тиймээс эцэг эхчүүд хүүхдээ цаг хугацааны талаар зөв ойлголттой болоход нь туслах хэрэгтэй. Хүүхэд нэг өдөр, 1 долоо хоног, амралтын өдөр зэргийг ялгаж чаддаггүй. Хүүхэд маргааш 1 дэх өдөр гэдгийг өөрөө ухамсраараа ойлгож чаддаггүй учраас “Маргааш цэцэрлэгтээ явах өдөр учраас эрт унтах хэрэгтэй” гэх маягаар ойлгуулж хэлж өгч байх хэрэгтэй. Хүүхэддээ ийнхүү цаг хугацааны талаар ойлголттой болоход нь байнга тусалж дэмжсэнээр цаашид цаг хугацааны үнэ цэнийг ойлгон үр дүнтэйгээр ашиглах чадвар нь сайжирдаг.

Эгэл жирийн даруу амьдрал хамгийн сайхан амьдрал болохыг ойлгуулах

“Муухай вааран дотор үнэтэй архи байдаг” гэсэн Еврей сургааль үг байдаг. Энэ бол хүнийг гадаад үзэмж юмуу хөрөнгө чинээгээр нь үнэлж дүгнэж болохгүй гэсэн утгыг агуулж байгаа юм. Мөн “Илжиг Иерусалимд очсон ч илжиг хэвээрээ л байна” гэсэн үг байдаг. Энэ нь илжгэнд гоё сайхан хувцас өмсгөн одон медал зүүсэн ч илжиг хэвээрээ л байна гэсэн утгатай юм. Гэтэл үнэтэй эд зүйлээр биеэ гоёж чимэн өндөр албан тушаалтай баян чинээлэг болсон гээд бусад хүнийг юу ч биш юм шиг бодож харьцдаг хүмүүс байдаг. Мөнгөний авдар гаднаасаа хичнээн сайхан харагддаг ч доторх нь байнга хоосон болдоггүй гэж үү. (Марвин Токаер)

Мөнгө жин нь хүнд байх тусам сайн. Гаднаасаа хүнд юм шиг харагдсан ч хөнгөхөн байж болохгүй. Энэ бол Нью-Йорк хотын Еврей гаралтай баян айл болох Филип Гүддод (Philip Good Dodd)-ийн эхнэрийн амьдрах ухаан юм. Алт юмуу мөнгө, эрдэнэсийн чулуутай ижил төстэй үнэт эдлэл жин нь хүнд байх тусам сайн. Харин харахад хүнд юм шиг боловч хөнгөхөн байвал энэ нь ямар ч үнэ цэнэгүй хэрэгтгүй зүйл юм.

Гүддодийн эхнэрийн тухайд үнэндээ хамгийн шилдэг дизайнерийн хамгийн сайн чанарын материалаар хийсэн хувцсыг өмсдөг боловч хэтэрхий гоёмсог хурц тод өнгө юм уу сүүлийн үеийн моод зэргээс зайлсхийдэг. 40 нас хүрэхээсээ өмнө усны булганы арьс гэх мэт янз бүрийн тансаг зэрэглэлийн материалаар хийсэн үнэтэй хувцас өмсөж байгаагүй бөгөөд хэтэрхий их тансаг чамин зүйлээр өөрийгөө гоёдоггүй байна. Гэрийнхээ хананд гоё сайхан зураг өлгөсөн ч хүмүүст анзаарагдах газар байрлуулдаггүй. Энэ нь хэдийгээр үнэтэй сайхан зүйл хэрэглэж байгаа ч түүнийгээ зөв зүйтэй ашиглан бусдад гайхуулж баярхан хүмүүсийн дургүйг хүргэхгүй байхын тулд хийж буй түүний үйлдэл юм.

Унгар гаралтай Еврей хүн Эндрю Гроув нь 1987 оноос 1998 он хүртэл Интел компаний захирлын албан тушаалыг хашиж байсан бөгөөд энэ хугацаанд компанийхаа хөрөнгийг 4,300,000,000 доллараас 197,600,000,000 доллар болтол өсгөж чадсан гайхалтай удирдагч хүн юм. Тухайн үед уг компаний эдийн засгийн өсөлт жилд дунджаар 42 хувь өсөн гайхамшгийг бий болгож байсан бөгөөд “Цахиурт хөндийн хаан” хэмээн нэрлэгдэж байв. Тэрээр хувьдаа ч гэсэн гайхамшигтай их хөрөнгө мөнгийг хурааж чадсан нэгэн юм. Харин нэг хачирхалтай зүйл нь тэрээр бусад томоохон компаний захирлууд шиг баян тансаг амьдралаар амьдардаггүй нэгэн юм. Түүнд хувийн жолооч гэж байхгүй өөрөө машинаа барьдаг байсан бөгөөд компанийх нь гадаа түүнд зориулсан машины тусгай зогсоол ч байдаггүй байв. Түүний ажлын өрөө зүгээр л нэг тасалгаа болгон зассан жижиг өрөө байсан бөгөөд хаалган дээр нь ямар нэгэн албан тушаалын хаяг байхгүй нэгэн байв. Ажлын өрөө нь 4.75 метр хэмжээтэй жирийн нэг ажилчны өрөө шиг байсан байна.

Еврей хүмүүс маш энгийн даруухан амьдарлаар амьдардаг. “Ваарны гадна талаас илүү дотор талыг харах хэрэгтэй” гэсэн Еврей сургааль үг байдаг. Тийм болохоор хувцаслалт гэх мэт гадаад үзэмжиндээ нэг их анхаараад байдаггүй. Олон арван тэрбумын хөрөнгө мөнгөтэй ч үнэтэй хувцас юмуу эрдэнэсийн зүйлээр өөрийгөө чимж гоёсон Еврей хүнийг олж харна гэдэг маш хэцүү. Бага наснаасаа эхлэн энгийн даруу амьдрахыг сурсан байдаг учраас бусдын нүдэнд өртөхүйц хувцаслах юмуу бусдад баярхаж сайрхах байдлыг эсрэгээрээ төвөгтэй зүйл

гэж үздэг. Мэдээж хүүхдүүдээ ч гэсэн энгийн даруухан хувцасладаг.

Хоол ундны тал дээр ч гэсэн энгийн байдаг. Үүнийг бас шашны зан үйлтэй нь холбоотой гэж хэлж болно. Еврей хүмүүс гахайны мах болон хайрсгүй загас хүнсэндээ хэрэглэдэггүй. Цус нь бүрэн цэвэрлэгдээгүй үхрийн мах юмуу хонины махыг иддэггүй. Чөлөөлөгдсөн баярын өдрүүдээрээ (Манай эриний өмнөх 13-р зуунд Египетээс гарсныг бэлгэдэн тэмдэглэдэг болсон Еврейчүүдийн баярын өдөр) 7 хоногийн турш "Цэвэр талх" гэж нэрлэдэг хөрөнгөгүй барьж хийсэн талхыг иддэг. Еврей хүмүүс "Гаднах байдлаас илүү доторх байдал хүчтэй байх хэрэгтэйг чухалчилдаг" шашны болон соёлын уламжлалаа сайн мэддэг учраас хооллолтын тал дээр ч гэсэн энгийн байдаг. Тийм болохоор Солонгос улс шиг ширээн дээр ийм тийм хачир байхгүй байна гэж гомдоллодог хүн бараг байдаггүй.

Дотоод сэтгэлийн хувьд бат бөх хүн дотоод мөн чанартай тулгуурласан хүн юм. Гадаад үзэмжийн хувьд тийм ч гоё ганган биш, идэж ууж байгаа зүйл нь энгийн боловч толгой нь ухаанаар дүүрэн хүн ядуу зүдүү, хүнд хэцүү амьдралтай хүмүүсийг ойлгон тэдэнд тусалж чаддаг. Еврей хүмүүс бусдын хавчлага дарамтан доор олон арван жил амьдарч байсан болохоор хэдийгээр асар их хөрөнгө мөнгө байсан ч эгэл жирийн даруу амьдран өөрсдийгөө амар тайван байлгаж чаддаг нь тэдний амьдралыг даруу төлөв энгийн болгож буй гол хүчин зүйл юм.

Гэтэл Солонгос хүмүүсийн тухайд ямар вэ? Гадаад дүр төрх, эд хөрөнгөнд маш их анхаарал хандуулдаг. Хүмүүс өөрийн дотоод байдлаа сайн болгохоосоо илүүтэйгээр бусдын хараанд өртөхийн тулд гадаад үзэмжиндээ маш их анхаарал хандуулж байна. Гадаад дүр төрх гол өрсөлдөх чадвар гэж ойлгодог учраас гоо сайхны мэс засал хийлгэх бол энгийн үзэгдэл болж байгаа бөгөөд бусдад байгаа зүйлийг өөртөө авахын тулд өр зээл тавиад ч хамаагүй худалдан авдаг. Өөрийн гэсэн гэр орон байхгүй ч гэсэн үнэтэй машин сүүлийн үеийн гар утас зэрэг хэрэглэн жилд ядаж 1 удаа гадны өөр нэгэн улс орон руу явахыг хичээдэг.

"Wall Street" сэтгүүлийн 2010 оны 07-р сарын дугаарт "Солонгос улсыг дэлхийд хамгийн их үнэтэй бараа бүтээгдэхүүн сонирхдог улс" гэж нийтэлсэн байдаг. Солонгос улсын үнэтэй бараа бүтээгдэхүүний хэрэглээ өнгөрсөн 1 жилд 46 хувиар огцом өссөн бөгөөд өндөр үнэтэй брэндийн бараа бүтээгдэхүүн худалдан аван түүнээсээ таашаал авсан хүмүүс харин 5 хувьд ч хүрээгүй байна. Орлогын түвшин ямар байх нь хамаагүй бүгд л "Louis Vuitton" зэрэг янз бүрийн үнэтэй брэндийн бараа бүтээгдэхүүн хэрэглэх гэж хээнцэрхдэг болсон нийгмийн уур амьсгал бусдад өөрийгөө зохицуулан бусдыг дуурайж байгаа хэлбэр бөгөөд үнэтэй брэндийн бараа бүтээгдэхүүнээр дотоод сэтгэлийнхээ хоосон орон зайг нөхөх гэсэн харц ардын хөрөнгөтний үзлийн нэг хэсэг юм.

Хүүхдүүдийн хувьд ч гэсэн томчуудаас ялгараад байхаар зүйлгүй болсон байна. Хүүхдийн сан 2010 оны 02-р сард Сөүл, Кёнгигийн бүс нутгийн бага сургуулийн 322 сурагчийг оролцуулан "Хүүхдүүдийн ихэвчлэн худлаа ярьдаг зүйл юу болох" талаар судалгаа хийсэн байна. Гэрийн даалгавар болон хичээл номтой холбогдолтойгоор худлаа ярих нь хамгийн их байсан боловч гэр бүлийн орчин юмуу эдийн засгийн байдалтай холбогдолтойгоор худлаа ярих үзэгдэл нь ч гэсэн нилээд ихэссэн байна. Жишээ нь судалгаанд оролцсон сурагчдаас "Гэрт нь ирэх гэж байгаа найздаа өөр ажил гарлаа" гэж /59 хүн 18.3 хувь/, "Гэртээ байхгүй үнэтэй зүйлийг байгаа" гэж /53хүн/, "Найзтайгаа өөрийгөө харьцуулан явах дургүй

дугуйландаа явж байгаа” гэж /50хүн/, “Эцэг эхийнхээ ажил мэргэжлээс ичээд өөр ажил хийдэг” /34хүн/ гэх мэтээр худлаа ярьдаг гэсэн байна. Энэ бол Солонгос улсын нийгэмд тархаад буй материаллаг зүйлсэд хэтэрхий их анхаарал хандуулж буй хүмүүсийн үзэл санааны нэг тод томруун илэрхийлэл юм.

Хүүхдээ бүх зүйлд дасан зохицож чадахуйц амьдралын чиг хандлагатай болгох

“Хайр гэдэг жимсний чанамал шиг чихэрлэг зүйл боловч талхгүйгээр байнга жимсний чанамал идэж амьдарч чадахгүй” гэсэн Еврей сургааль үг байдаг. Хүн зөвхөн жимсний чанамал идэн амьдарч чадах болов уу? Мөн зөвхөн талх идээд байвал бас амтгүй. Хүний амьдрал яг үүнтэй адилхан олон янзын зүйл холилдож байж тэнцвэртэй утга учиртай болдог. “Хүн нэг л амьдарч байж зөвхөн уйлаад эсвэл зөвхөн инээгээд байж болохгүй” гэсэн сургааль үг ч байдаг бөгөөд энэ нь мөн л аливаа зүйл тэнцвэртэй байх ёстой гэдгийг хэлж байгаа юм. Бурхан хүн төрөлхтнийг баруун зүүн тэгш хэмтэйгээр бүтээсэн. Амьтад ч гэсэн баруун зүүн тэгш хэмтэй. “Талмуд” номонд бичсэнээр бол хүн төрөлхтний тал нь тэнгэрт тал нь газарт харъяалагдаж байгаа юм. Хүний мөн чанарт төрөлхийн зан чанар болон арааТны зан чанар байдаг. Мөн хүн гэдэг амьтан баяр гуниг 2-ланг нь мэдэрдэг. Харин эдгээр зүйлээс аль нэг нь хэтэрхий их байх буруу юм. Хүний амьдралд бүх зүйл тэнцвэртэй байх хэрэгтэй. Цаг ямагт зөвхөн уйлах юмуу уурлах, инээгээд байж болохгүй. (Марвин Токаер)

“Талмуд” номонд тэнцвэртэй амьдралын талаар олон арван тайлбарууд гардаг. Мөнгөний үнэ цэнийг сайн мэдэн амьдралд хэрэгтэй зүйл гэж хүлээн зөвшөөрдөг ч мөнгөний боол болдоггүй, хэзээ нэгэн өдөр Бурханыг энэ дэлхий ертөнцөд ирнэ гэж итгэн хүсэн хүлээж байгаа ч амьдралаа хий хоосон зүйлд үрдэггүй Еврей хүмүүсийн амьдралд хандах хандлагын талаар маш их зүйл энэ номонд гардаг.

Еврей хүмүүс боловсролын тал дээр ч тэнцвэртэй байдлыг маш их чухалчилдаг. Тиймээс мэдлэгийн боловсрол болон хүн чанарын боловсролыг хослуулан суралцдаг. Мэдлэг юмуу хүн чанарын аль нэг талд анхаарсан боловсрол бол тийм сайн зүйл биш юм. Хүүхэд нийгмийн нэг бүрэлдэхүүн хэсэг болж өсч бойжиход шаардлагатай бүхий л элементүүдийг тэнцвэртэйгээр хөгжүүлдэг Еврей хүмүүсийн “Тэнцвэрт боловсрол” бол боловсролынх нь гол чиг хандлага юм. Энэ нь боловсролын онолд ч сайн зохицож чаддаг. Хүүхдийг зөв хүн болгон өсгөж хүмүүжүүлье гэвэл мэдлэг, шударга ёс, хүн чанар, авъяас чадвар зэрэг бүх талыг нь тэнцвэртэйгээр хөгжүүлэх хэрэгтэй. Хүн суух, босох, алхах зэрэг үйлдлийг бүгдийг тэнцвэртэйгээр хийдэг шиг бүх зүйл тэнцвэртэй байх хэрэгтэй.

Солонгос улсын боловсролын тухайд хүн чанар болон нинжин сэтгэлийг ихээхэн онцолсоор ирсэн. Нэг үе Еврейчүүдийн шашны нөлөөгөөр нийгмийн халамж болон бусдыг хайрлаж халамжлах гэх мэт хүний хувьд байх ёстой ёс жудаг, биеэ авч явах байдал, ёс журам гэх зэрэг зүйлийг чухалчилдаг болсон. Гэтэл сүүлийн үед аливаа улс орны нийгэм маш ширүүн өрсөлдөөнт нийгэм болон өөрчлөгдөн хүн чанар болон өгөөмөр зан чанарын оронд зөвхөн оюун ухаан, мэдлэгийг чухалчилсан боловсролын тогтолцоотой болж байна. Сурагчид гэртээ байна уу сургууль дээр байна уу хамаагүй бүгд л зөвхөн хүмүүсийн сайн гэж нэрлээд байгаа их сургуульд элсэн суралцахын төлөө шаргуу хичээллэн хичээлээс гадуурх курс дамжаанд ихээр хамрагдаж байна. Хүн ажилд орохын тулд өөрийн зан чанараас илүү сурлагын дүн, гадаад хэлний чадвар гэх мэт зүйлдээ анхаарал хандуулдаг болж байна. Ийм нөхцөл байдалд суралцаж байгаа хүн хүнлэг сэтгэлтэй энэрэнгүй, өгөөмөр зан чанартай бүх талын тэнцвэртэй хүн болно гэдэг бараг боломжгүй юм. Зүгээр л толгой нь баахан мэдлэгээр дүүрсэн зүрх сэтгэлгүй нэгэн болохоос цаашгүй. Зөвхөн мэдлэгийг өөртөө хуримтлуулах арга

барилаар суралцсан хүн нийгэмших чанар, бүтээлч чанарын хувьд муу байдаг учраас нийгэмд хөл тавьбал эсрэгээрээ өрсөлдөх чадвар муутай болдог.

Солонгосын шинжлэх ухаан технологийн хорооны (KAIST) удирдлагын ухааны сургуулийн Ан Чол Сү багш “Мэдлэг бол хязгаарлагдмал зүйл харин хатуу ширүүн нийгмийн харилцаанд бусадтай харилцахад зайлшгүй шаардлагатай зүйл болох хүн чанар нь хүний амьдралыг удирдан чиглүүлдэг гол зүйл бөгөөд бүр цаашлаад ирээдүйг ч удирддаг” гэж хэлсэн байдаг. Сурлагын дүн болон гадаад хэлний чадвар гайхалтай сайн байлаа ч хүн чанаргүй хүн бусдад болон нийгэмд буруу муу нөлөө үзүүлдэг байхад эсрэгээрээ хүн чанартай хүн боловсролоор дамжуулан бусад хүмүүс болон нийгэмд тус нэмэр болохуйц чадварыг хэзээ ч өөртөө бий болгож чаддаг.

Хамгийн сайн боловсрол гэвэл мэдлэг болон хүн чанарыг хоёуланг нь давхар суралцаж буй тэнцвэрт боловсрол юм. Харин энэ 2 зүйлээс зөвхөн нэгийг нь сонгох шаардлагатай гэвэл бусдыг халамжилж хайрлах хүн чанарын боловсролыг илүүд үзэх нь зүйтэй юм.

Бусдыг хайрлаж халамжлах, буруу зүйл хийсэн бол уучлал гуйхыг мэддэг нийгмийн харилцааны талаар хүүхэддээ зааж сургах

Нэгэн нэр хүндтэй шашны багш байсан байна. Түүний хийж байгаа бүхэн цэвэр ариун сайн байсан учир бүх хүн түүнийг хайрлаж хүндэтгэдэг байв. Тэрээр 80 нас хүрсэн бөгөөд нэг өдөр бие муудан өөрийн үхэх цаг нь болсныг мэдэв. Шавь нараа хажуудаа дуудаж авчирсны дараа тэрээр гэнэт уйлж эхлэв. "Багш аа та яагаад гэнэт уйлаад байгаа юм бэ?" гэж шавь нар асуутал багш нь "Би та нарт юм заагаагүй өдөр, буян хийгээгүй өдөр нэг ч байхгүй. Би өөрийгөө энэ улс оронд хамгийн их хүндэтгэл хүлээхээр амьдарсан хүн гэж хэлж чадна. Бурхан надаас сайн суралцсан уу? Сайн үйлс их хийсэн үү? Зөв амьдарсан уу? гэж асуувал эргэлзэлгүйгээр тийм гэж хариулж чадна. Харин бусад хүнтэй зохицож нийцэж амьдарч чадсан уу? гэж асуувал чадаагүй гэж хариулахаас өөр зүйл хэлж чадахгүй. Тийм болохоор л би уйлж байна" гэж хэлсэн байна. Хэрвээ хэн нэгэн Еврей хүн хорвоо ертөнцөөс өөрийгөө тусгаарлан 10 жилийн турш зөвхөн суралцахад анхаарал хандуулсан бол 10 жилийн дараа Бурханд өргөл өргөж уучлал гуйх хэрэгтэй. Учир нь хичнээн гайхалтай сайн сурлаа гээд нийгмээс өөрийгөө тусгаарлавал үүнийг бараг нүгэл гэж тооцдог учраас юм. Тиймээс Еврей хүмүүсийн нийгмээс ганцаараа бусдаас нуугдмал амьдардаг хүнийг олно гэдэг бараг боломжгүй зүйл байдаг. (Марвин Токаер)

Ким Мин Чол /38 нас/ бол жирийн нэгэн компаний ажилтан юм. Тэрээр хүүхдүүдтэйгээ хамт тоглохыг хүсдэг ч хэрхэн тоглох аргаа мэддэггүй учраас гэртээ байх үедээ телевиз үзэн цаг өнгөрөөдөг байна. Түүний ийм байдлаас болон цэцэрлэгт явдаг том охин нь өөрийг нь ажлаа тараад ирсэн ч нэг их тоосон янзгүй зөвхөн ээжтэйгээ хамт тоглодог байна. Нэг удаа түүний эхнэр хүүхэд чинь цэцэрлэгт найз нөхөдтэйгээ сайн таарч тохирохгүй хэтэрхий дотогшоо зан чанартай байгаа болохоор охинтойгоо бага багаар тоглож байгаач гэж хэлсэн байна. Эцэг эхтэйгээ сайн тоглодог хүүхдийн нийгмийн оролцоо сайн байдаг.

Эхнэр нь ингэж хэлсэн болохоор тэрээр удаан хугацааны турш охиныхоо асуудлыг эхнэртээ даатгаж байсан болоод ч тэр үү хүүхэдтэйгээ хэрхэн харилцахаа мэдэхгүй байсан ч өдөр бүр багадаа 10 минут орчим хамт байхаар шийдсэн байна. Хүүхэддээ үлгэрийн ном уншиж өгөн, айл гэр болж тоглож эхэлсэн бөгөөд энэ байдлаар дамжуулан бие биенээ сайн ойлгодог болов. Ингээд нэг сар ч хүрэхгүй хугацаа өнгөртөл хүүхдийнх нь зан чанар гайхалтай сайжирч чадсан байна.

Ихэнхи Еврей хүмүүс эхнэр нөхөр хоёулаа ажил хийдэг учраас хүүхдээ төрүүлээд 3 сар орчим болсны дараа хүүхдийн цэцэрлэгт даатгадаг. Ингэх нь мэдээж бага наснаас нь эхлэн нийгмийн харилцааны талаар хүүхэддээ ойлгуулахад тус болдог. Еврей хүмүүс олон зуун жилийн турш бусад улс оронд тархан амьдарч байсан учраас нийгмийн чанарыг хүүхдэд бага наснаас нь заахыг хүүхдийн боловсролын бас нэг гол цөм гэж үздэг. Хүүхэддээ бага наснаасаа эхлэн бусад найз нөхөдтэйгээ таарч тохирон хамт тоглох нөхцөл боломжийг бий болгож өгдөг бөгөөд энэ бол нийгмийн боловсролынх нь нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Зарим эцэг эхчүүд хүүхэд нь муу найз нөхөдтэй болон бусад хүүхдүүдээс муу нөлөө авах вий гэж хэтэрхий болгоомжлон хүүхдээ зөвхөн гэртээ өсгөж хүмүүжүүлэх тохиолдол байдаг бөгөөд энэ нь хүүхдийн нийгмийн оролцоог муутгаж эрэмдэг хүн болгодог муу талтай. Бага насны

хүүхдийн боловсролын мэргэжилтнүүдийн хийсэн бодит судалгаанаас харвал бага насандаа нийгмийн харилцааны талаар суралцаагүй хүүхэд хэтэрхий өөрийгөө төвд тавин өсөж том болсон ч хүмүүстэй харилцах тал дээр муу байдаг нь батлагдсан байна.

Еврей хүмүүс хүүхэддээ нийгмийн харилцааны талаар зааж сургахдаа хамгийн их чухалчилдаг зүйл бол “өрсөлдөөн” болон “хамтын хүч” юм. Бусадтай өрсөлдөнө гэхээр зөвхөн өөрийгөө бодно гэсэн үг биш юм. Харин ямар нэгэн зорилгоо биелүүлэхийн тулд заавал төлөх ёстой үнэ гэж хэлж болно. Тийм учраас Еврей хүмүүс хүүхэддээ багаас нь эхлэн өрсөлдөөнийг амьдралын нэг хэсэг гэж ойлгуулан зааж сургадаг. Мэдээж өрсөлдөж байгаа учраас ялахын чухал чанарыг ч давхар заадаг. Гэвч ямар нэгэн өрсөлдөөнд ялах ялагдах үе байгаа гэдгийг заан ялах юмуу ялагдах үед шалтгаан нь юу болохыг тунгаан бодож бусдад ялагдсан ч тэр байдлаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг зааж сургадаг.

Еврей хүмүүс өөрсдийн сонирхож байгаа зүйлээ нэг төрлийн өрсөлдөөнтэй тоглоом гэж бодон бусадтай зөв арга барилаар өрсөлдөх байдлаар дамжуулан өөрийгөө хөгжүүлдэг. Еврей хүмүүс хүүхэд наснаасаа эхлэн ялах, ялагдах тоглоом ихээр тоглодог. Еврей хүмүүсийн сургалтын хэрэгслээр ашигладаг алдартай “ORDA (Puzzle-хэлбэрийн оюун ухааны тоглоом)” тоглоом нь тоглох агуулгын хувьд маш олон төрөл зүйлтэй байдаг. Эцэг эх болон багш нар энэхүү тоглоомоор дамжуулан хүүхдийн өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд тоглуулдаг. Мэдээж зөвхөн бусдаас илүү байх хэрэгтэй гэсэн ойлголтыг хүүхдийн толгойд суулгах биш бусадтай өрсөлдөх байдлаар дамжуулан бусдаас өөр болох хэрэгтэйг нь заадаг. Бас өрсөлдөөнд ялагдсан нөгөө өрсөлдөгчөө хайрлаж халамжлах хэрэгтэй гэсэн ойлголтыг ч хүүхдэд суулгаж өгдөг. Еврей хүүхдүүд эхээс мэндэлснээсээ хойш 3 сарын дараагаас эхлэн хүүхдийн цэцэрлэгт хүмүүжиж эхэлдэг учраас цэцэрлэгтээ 4-5-уулаа хамтрах юмуу аливаа зүйлийг олуулаа хамтран хийхийг суралцдаг.

Хүүхэд эцэг эхтэйгээ харилцах байдлаар дамжуулан энэ ертөнцөд амьдрах арга барилыг суралцаж байдаг. Эцэг эхийн хайр халамж сайн өссөн хүүхэд бусад хүнийг хайрлаж халамжлах тал дээр ч гэсэн сайн байдаг. Хүүхдийнхээ нийгмийн харилцааг сайжруулах сайн аргуудын нэг бол эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамт тоглох юм. Хүүхэд эцэг эхтэйгээ бие мах бодиороо харилцах нь хүүхдийн сэтгэл зүй, бие мах бодь, сурах чиг хандлагад маш том нөлөө үзүүлдэг бөгөөд нийгмийн үндэс сууриа тавихад ихээхэн тус болдог. Мэргэжилтнүүд хүүхдийн шилжилтийн нас болохоос өмнөх үе болох цэцэрлэг, бага сургуулийн үед бие мах бодиороо хүүхэдтэйгээ байнга харилцаж байх нь маш үр дүнтэй гэж зөвлөж байна. Өдөрт ядаж 10 минут орчим хүүхдээ өвөр дээрээ суулган гар хөлийг нь атгаж өгөх, тэврэх гэх мэт хүүхдийнхээ дуртай зүйлийг хийж өгөн эцэг эхийн хайр халамжийг мэдрүүлснээр хүүхдийн нийгмийн хандлага сайжирдаг.

Хүүхдүүд 3-4 наснаасаа эхлэн үеийнхээ хүүхдүүдтэй тоглож наадаж эхэлдэг. Гэвч бусадтай нийцэх тал дээр муу өөрийгөө төвд тавьсан хандлагатай хүүхэд өөрийнх нь хүссэнээр болохгүй бол найзыгаа зодох юмуу эд зүйл шидэх гэх мэт үйлдэл хийх хандлага ажиглагддаг. Хэрэв таны хүүхэд бусад хүүхдүүдтэй тоглож байгаад ийм үйлдэл хийвэл хүүхдээ зэмлэж шийтгэн буруу зүйл хийснийг нь ойлгуулсны дараагаар найзаасаа “Уучлал гуйх” хэрэгтэйг сайн зааж өгөх хэрэгтэй. Учир зүггүй загнах юмуу хүчлэх байдлаар хүүхэддээ хандалгүйгээр буруу хийсэн зүйлийг нь сайн тайлбарлаж ойлгуулан бусадтай зөв харилцдаг болтол нь сайн

зааж зааварлах хэрэгтэй.

Хүүхдээ алдаа гаргасан үед нь туслаж дэмжин нэг алдаагаа дахин давтсаар байвал загнаж зэмлэх

“Талмуд” номонд “Нэгэнт хийсэн зүйлдээ харамсахаасаа илүү заавал хийхийг хүсэж байсан ч хийж чадаагүй зүйлдээ харамс” гэсэн үг гардаг. Хүн гэдэг амьтан алдаа гаргасан ч түүгээрээ дамжуулан их зүйл сурж байдаг. Харин хийхийг хүсэж байсан ч хийгээгүй зүйлээсээ их зүйл сурна гэж бараг байдаггүй. Хүний бүх ахиц дэвшил боломжид итгэдэг өөдрөг үзэл бодлоор бий болж байдаг. Алдаа гаргах нь хүнд туршлага болон амжилт гаргах үндэс суурь ч болдог зүйл. Хүн алдаа гаргасандаа харамсдаг ч үүгээр дамжуулан их зүйлийг суран туршлага хуриМтлуулан сургамж авснаа мэддэг учраас боломжийг алдсанаас илүү харамсаад байх зүйл нэг их байдаггүй. Алдаа амжилтын үндэс суурийг бий болгоход ашиглагддаг зүйл бол, хийгээгүй зүйл нь боломж гэсэн зүйлийн үндэс суурийг үгүй болгож байгаа зүйл юм. Алдаа гаргахаас хэтэрхий их айх нь алдаа гаргахаас муу зүйл. (Марвин Токаер)

АНУ-д хорин настайдаа ганцаархнаа дүрвэн ирж “Интел” компаний захирлын албан тушаалд очтолоо гайхалтай амжилтыг гаргаж чадсан Унгар гаралтай Эндрю Гроув алдааг хүлээн зөвшөөрөх ёстой гэж боддог удирдагч юм. 1994 онд нэгэн тооны багш Intel Pentium чип-ийн тооцоолох төхөөрөмжинд асуудал байгааг хэлсэн байна. Тухайн үед “Intel Inside”-ийн лого бүхий компьютер бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад 10 хувиар илүү үнэтэй зарагддаг байв. “Интел” компаний техникийн хэсэг тооны багшийн хэлсэн тооцоолох төхөөрөмжийн алдаа дутагдлыг нэг их сүртэй зүйл биш гэж үзэн тоохгүй орхисон байна. Учир нь энэ гэмтэл есөн зуун саяд 1 удаа тохиолддог гэмтэл бөгөөд компьютер хэрэглэгчдэд 27000 жилд нэг удаа тохиолддог гэмтэл байсан юм.

Гэвч Эндрю Гроув үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг олохын тулд хичнээн аар саар жижигхэн алдаа дутагдал байсан ч түүнийг орхиж болохгүй гэсэн бодолтой нэгэн байв. “Хэн ч алдаа гаргаж болно гэвч нэг чухал зүйл гэвэл алдаа дутагдал гаргасан бол түүнийгээ хүлээн зөвшөөрөн дахин адилхан алдаа гаргахгүй байхын тулд хичээх хэрэгтэй” гэдэг нь түүний үзэл баримтлал байсан юм. Гроув “Компаний зүгээс нөхөн төлбөр хийх” шийдвэрийг гаргасан бөгөөд үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг буцаан олохын тулд 475,000,000 долларыг зарцуулсан байна. Үүнээс хойш “Интел” компани компьютерийн CPU үйлдвэрлэлээрээ дэлхийд хамгийн шилдэг нь болж чадсан юм.

Шорооны уутгүй тоос сорогч, далавчгүй сэнс зэргийг зохион бүтээн “Английн Стив Жобс” хэмээн нэрлэгдээд байгаа Жэймс Дайсон (James Dyson) ажилчдаа алдаа гаргавал ажлаа илүү хурдан сурна гэж бодон эсрэгээрээ алдаа гаргахыг дэмждэг байна. Тэрээр “Амжилтын 99 хувь нь алдаанаас бий болдог” гэж итгэдэг нэгэн юм. Тэрээр өөрөө 40-н жилээс ч дээш хугацаагаар янз бүрийн зүйл хийж оролдож алдаж онож явсаар эцэст нь бусдын бодож байгаагүй шинэлэг бараа бүтээгдэхүүнийг зохион бүтээж чадсан юм. Үүнээс шалтгаалаад ч тэр юмуу Дайсоний зохион бүтээсэн бүтээлд маш их хугацаа зарцуулагдсан байна. Шорооны уутгүй тоос сорогчийг 5 жил, далавчгүй сэнсийг 4 жилийн хугацаанд зохион бүтээсэн байна. Инженер юмуу эрдэмтэн хүний амьдралд алдаа гэдэг зүйл байнга сүүдэр шиг дагалдаж байдаг. Эдгээр хүмүүсийн амьдралд эсрэгээрээ амжилт гэдэг зүйл маш цөөхөн байдаг.

Хүмүүсийн нэг мэдэх ёстой бодит үнэн бол зөвхөн хүн өөрөө алдаа гаргадаг биш бусад хүн ч гэсэн бүгд л алдаа гаргаж байдаг зүйл юм.

“Алдаа гаргадаггүй хүн бол зүгээр л бусдын хий гэснийг хийж буй боолоос цаашгүй юм. Ямар нэгэн зүйл хийх гэж хичээж байгаад алдаа гаргасан хүнийг хэзээ ч загнан зэмлэн сэтгэл санаагаар унагааж болохгүй. Судалгааны ажил гэдэг бол 99 хувийн алдааг ойлгож ухаарахгүй бол бүтэхгүй бүтээлийн явц юм”. Энэ бол Японы Хонда автомашины компанийг үндэслэгч Хонда Соичиро (Honda Soichiro)-гийн удирдлагын гүн ухаан юм. “Хонда” компани ажилчдынхаа дунд “Энэ жилийн алдааны хаан” гэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Жил болгон судалгааны ажилчид дотроос хамгийн их алдаа гаргасан хүнийг сонгон 1,000,000 иений шагнал олгодог. Ажилчид өөрсдийн ажил, зорилгоо биелүүлэхийн тулд хичээнгүйгээр ажиллаж байхдаа ямар нэгэн алдаа гаргавал шүүмжлэх биш эсрэгээр нь урамшуулж байх хэрэгтэй гэж үздэг бөгөөд энэ бол “Хонда” компаний гол баримталдаг зарчим юм.

“Хамгийн том алдаа бол алдаанаасаа суралцаагүй алдаа”

Еврей хүмүүс алдаа гаргахаас айдаггүй. Яагаад гэвэл хүн ямар нэгэн шинэлэг зүйлийг алдаанаасаа суралцах байдлаар бий болгож чаддаг гэсэн бодит үнэнийг сайн мэддэг учраас юм. Тиймээс хүүхдүүддээ багаас нь эхлэн “Алдаа гаргахаас айх хэрэггүй” гэж заадаг. Бүхий л хүчээ дайчлан ажиллаж байгаад алдаа гаргавал энэ нь хүлээн зөвшөөрөгдөх нь мэдээж зүйл юм. Хийж буй зүйлийнх нь зөвхөн үр дүнг тооцоолоод байвал хүүхдүүд алдаа гаргахаас айн хийж буй ажлаасаа ухрах аюултай байдаг учраас ирээдүйд том амжилт гаргана гэж итгэн одоо гаргаж байгаа аар саар алдаа дутагдалд нь анхаарал хандуулан зууралдаад байлгүй хүүхдийнхээ хийж буй зүйлд сайн туслаж дэмжих хэрэгтэй гэж Еврей хүмүүс боддог.

Гэтэл Солонгос улсын нийгэм яг үүний эсрэг байна. Аливаа зүйлийн явцыг харалгүй зөвхөн үр дүнг нь чухалчилдаг учраас алдаа дутагдал гаргахыг огтхон ч хүлээн зөвшөөрдөггүй. Тийм болохоор ямар ч арга хэрэглэсэн хамаагүй бүгд амжилт гаргахын тулд улайран зүтгэдэг. Шалгалтаа 10-н удаа онц өгсөн сурагч 1 удаа алдаа гарган муу өглөө гэхэд хүүхдээ ойлгон уучилж энэ байдлыг нь хүлээн зөвшөөрдөггүй эцэг эхчүүд маш олон байх жишээтэй.

Компаний хувьд ч мөн адил ялгаагүй. Солонгос улсын удирдах албаны хүмүүс өөрсдөө шинээр аль нэг газар хөрөнгө оруулалт хийхээс татгалздаг. Цаг хугацааг тоолон шийдвэр гарахыг хүлээдэг. Яагаад гэвэл 10-н газар хөрөнгө оруулалт хийлээ гэхэд 7-8-д нь амжилтгүй болох тохиолдол хэвийн үзэгдэл бөгөөд 9 нь амжилттай болон 1 нь амжилтгүй болсон ч хүнд хэцүү асуудал болгон хүлээн авдаг учраас юм. “Амжилтын араас улайран хөөцөлдөж буй Солонгос улсын компаниудын ажилчид шинэ бүтээл, шинэлэг санааг бий болгоё гэж хичээхээсээ илүү хариуцлага хүлээх ажилд огтхон ч ороцолдохгүй гэж болгоомжилсон байр суурьнаас ажилдаа ханддаг.

3-н ч шашны багшийг төрүүлэн гаргасан үнэнч шударга Еврейн шашны гэр бүлээс гаралтай дэлхийн загварын брэнд “GUESS”-ийн үндэслэгч Паул Марсиано (Paul Marciano) захирал “Бизнес гэдэг бол удаан хугацаагаар үргэлжлэх дайн. Тийм учраас аюулыг багасган тэмцэх хэрэгтэй. Мэдээж алдаа гаргах уе гарна. Харин миний ажигласнаар Солонгос хүмүүс алдаа дутагдлыг хүлээн зөвшөөрөх тал дээр ойлголт байдаггүй юм шиг санагдаж байна” хэлсэн байна.

Алдааг хүлээн зөвшөөрдөггүй энэ байдал томоохон компаний удирдлагуудад “Хаант засаглал”-ыг бий болгох боломжийг бүрдүүлж өгдөг. Компаний удирдлагууд буруу шийдвэр гаргавал компанийг сүйрүүлэх нь мэдээж зүйл. Гэтэл компаний удирдлагынхаа буруу шийдвэр гаргаж буйг мэдсээр байж энэ байдлыг эсэргүүцэн бодит үнэнийг нь хэлж чадах хүнийг Солонгос улсын компаниудад ажиллаж буй ажилчдаас олж харахад үнэхээр хэцүү. Энэ бол удирдлагуудынхаа хийж байгаа зүйл буруу гэдгийг мэдэж байгаа ч үг дуугүй дагадаг Солонгос улсын компаниудын ажилчдын өнөөгийн бодит дүр төрх юм.

Еврей хүмүүсийн байгуулсан компаний тухайд компаний удирдлагыг тодорхой хэсгүүдэд хуваадаг. Үүнийг өндөр хөгжилтэй орнуудын энгийн загвар ч гэж нэрлэдэг. Жэймс Дайсоний тухайд өөрөө тэргүүлэх зэрэглэлийн инженер байсан болохоор зөвхөн бараа бүтээгдэхүүнийг хөгжүүлж сайжруулах ажилд анхаарлаа хандуулан компаний удирдлагыг дадлага туршлага бүхий өөр хэн нэгэнд даатгасан байдаг. Хонда Соичиро ч гэсэн үйлдвэрлэл болон судалгааны ажлаа өөрөө хариуцан компанийхаа бусад ажлыг удирдлагын тал дээр туршлагатай шилдэг ажилчиндаа даатгасан байдаг. Соичиро нь ажлаа хүлээлгэн өгөхдөө өөрийн эзэмшдэг компанийхаа ихэнхи хувьцааг компанидаа үнэгүй бэлэглэсэн бөгөөд “Хонда” компаний удирдах зөвлөлд “Хонда” компаний нэрэмжит шагналыг авсан хүн нэг ч байдаггүй байна. Удирдлагын хороо нь дангаараа компаний эзэний саналыг сонсолгүйгээр компанийхаа захирлыг сонгодог байна.

Хүүхдээ аливаа зүйлийг сайтар сонссоныхоо дараа бодож тунгаан зөв ярьдаг хүн болгон төлөвшүүлэх

Нэгэн худалдаачин "Сайхан амьдралыг бий болгох нууцыг зарна" гэж хашхирсан байна. Гэтэл хоромхон зуур маш олон хүн цугларав. Тэдгээр хүмүүсийн дунд шашны багш нар ч байсан байна. Хүмүүс бүгд надад тэр нууцаа зараач гэж худалдаачнаас гуйн хоорондоо би чи авна гэж маргалдаж эхэлтэл худалдаачин ингэж хэлэв. "Сайхан амьдралыг бий болгох нууц гээд байгаа зүйл бол үг яриандаа анхааран болгоомжтой байхыг хэлж байгаа юм. Бусдыг муулах нь бусдыг алахаас ч илүү аюултай зүйл. Аллага зөвхөн нэг хүнд хор хүргэдэг бол муу үг яриа 3 хүнд хор хүргэж байдаг. Энэ 3 хүн бол бусдыг муулж байгаа хүн өөрөө, түүнийг сонсож байгаа хүн, ярианы гол сэдэв болж байгаа хүн юм. (Талмуд номны хэсгээс)

Австри гаралтай хэл, задлан шинжлэлийн гүн ухаантан болох Лудвик Витгэнштин (Ludwig Wittgenstein) "Хүн чанар хүний үгнээс илэрдэг" гэж хэлсэн байдаг. Үг гэдэг зүйл тухайн хүний хүн чанар, боловсролын түвшинг илэрхийлдэг. Еврей хүмүүс санамсаргүй хэлсэн нэг үг маш чухал бизнесийн хэлэлцээрийг сүйтгэн уурлаж уцаарлан түр зуурын сэтгэл хөдлөлөөр хэлсэн нэг үг хүүхдийн зүрх сэтгэлээс насан туршид нь арчигдахааргүй шархыг үлдээдэг гэдгийг сайн мэддэг хүмүүс.

Тийм болоод ч тэр үү Еврей зүйр үгэнд үг хэлний аюултай байдлын талаар анхааруулсан агуулга бүхий үгнүүд их байдаг. Жишээ нь "Үүрнээсээ зугтсан шувууг барьж болох боловч амнаас гарсан үгийг барьж болдоггүй", "Илжиг урт чихээрээ танигддаг бол мунхаг хүн үг яриагаараа танигддаг", "Чиний хэлэнд яс байхгүй гэдгийг байнга санаж явах хэрэгтэй", "Хүүхэд шиг бодож сэтгэх нь гашуудаж буй хүмүүсийн гэрт хөгжилтэй дуу дуулахтай адилхан", "Энэ хорвоо ертөнцөд хүн болж мэндэлсэн бол ярьж сурдаг нь мэдээж зүйл боловч хэл амаа хязгаарлахыг сурах нилээд хэцүү байдаг"

Өвөг дээдсээсээ үг яриандаа анхаарахын чухал чанарын талаар их сургааль сонссон байдаг болоод ч тэр үү Еврей хүмүүс ярихаасаа өмнө бусдын яриаг сайтар сонсдог. "Хэл амаа хязгаарлахыг мэддэггүй хүн хаалгаа хаагаагүй гэртэй адилхан" гэсэн сургааль үгийг сайн мэддэг ч Еврей хүмүүсийн бусадтай яриа хэлэлцээр хийхдээ гарамгай байдаг нь энэхүү уламжлалтай нь хамааралгүй. Ер нь хүмүүс хоорондоо ярилцаж байх үед их ярьж байгаа хүн эрсдэлд орох магадлал хамгийн өндөр байдаг. Хэтэрхий хөөрч догдлох юмуу сэтгэл хөдлөлөөр хандан хохирол амсдаг тал нь их зүйл ярьж байгаа тал байдаг. Хүн өөрөө их ярихаасаа илүү нөгөө хүнийхээ ярьж буй зүйлийг анхааралтай сонсон хааяа асуулт тавих маягаар ярилцвал нөгөө хүнийхээ хүсэж байгаа зүйл юу болохыг мэдэн хэрэгтэй мэдээллийг олж чаддаг. Ингэж ярилцвал ярилцлагын ялагч хэн болох нь тодорхой юм.

Нэгэн шашны удирдагч багш шавь нартаа зориулан оройн зоог барьсан байна. Үхрийн хэл болон хонины хэлээр амттай хоол бэлтгэсэн байна. Тэр дунд хатуу, зөөлөн янз бүрийн хэл байв. Шавь нар зөөлөн хэлээр хийсэн хоолыг идэх гэж булаацалдаж байв. Үүнийг харсан багш шавь нартаа хандан "Та нар ч гэсэн хэлээ хэзээ нэгэн цагт зөөлөн юмуу хатуу болгоно. Хатуу хэлтэй хүн бусдыг уурлуулан эвгүй харилцаа үүсгэх нь мэдээж юм" гэж хэлсэн байна. (Талмуд номны хэсгээс)

Үг хэлэндээ анхаарах талаар хүүхдийнхээ боловсролд ч тусгасан байдаг. Боловсрол судлаач Бенжамин Блүм (Benjamin Bloom) гэдэг Еврей хүн хүүхдэд материаллаг орчноос илүү сайн хэл ярианы орчинг бүрдүүлж өгөх нь илүү чухал гэж хэлсэн байна. Сайн хэл ярианы орчинг бүрдүүлэхийн тулд хүүхдийнхээ үг яриаг анхааралтай сонсон бусдад өөрийгөө тодорхой илэрхийлж чаддаг болгох хэрэгтэй. Еврей хүмүүс цаг зав гарган хүүхдийнхээ яриаг анхааралтай сайн сонсдог. Хүүхдээ эсэргүүцэлгүй хэлэхийг хүсэж байгаа зүйлийг бүгдийг сайн анхаарч сонсдог. Ийнхүү эцэг эхээсээ зөвлөгөө аван хүүхэд өөрөө шийдвэр гаргаж чаддаг болоход нь тусладаг.

Хүүхдээ загнаж зэмлэх үедээ ч гэсэн муухай хараалын үг хэллэг огтхон ч хэрэглэдэггүй. “Хүүхдийг огтхон ч айлгаж сүрдүүлж болохгүй. Шийтгэх юмуу уучлахын аль нэгийг сонгох хэрэгтэй” гэсэн Еврей сургааль үг байдаг. Тийм болохоор хүүхдэд огтхон ч айлгаж сүрдүүлсэн янзтай үг хэлдэггүй. Гэтэл эсрэгээрээ Солонгос хүмүүс бараг өдөр болгон хүүхдээ сүрдүүлж заналхийлж байна. Жишээ нь “Чамайг ээжийнхээ үгэнд орохгүй бол аавд чинь хэлнэ дээ”, “Гэрийн даалгавраа хурдан хийхгүй бол телевиз үзүүлэхгүй”, “Янз бүрийн амттай хачир нэхээд эрхлээд байвал чамд хоол өгөхгүй”, “Дахиад нэг л удаа дүүтэйгээ зодолдох юм бол саваагаар зодож шийтгэнэ шүү” гэх мэт энгийн сонсогдож байгаа юм шиг боловч цаанаа дарамталж сүрдүүлсэн өнгө аястай үл хэллэг хэрэглэн хүүхэдтэйгээ буруу харьцдаг. Ингэж харьцах нь хүүхдийг айлгаад зогсохгүй хүүхдийг эцэг эхдээ өширхөхөөр болгодог.

Еврей хүмүүс хүүхдээ бусадтай харьцуулан ярихдаа ч маш зөв хандлагаар харьцдаг. Жишээ нь “Эгч чинь англи хэлнийхээ хичээл дээр 100 оноо авсан байна. Харин чи 70 оноотой байна. Хэзээ нэгэн цагт 100 оноо заавал авааарай”, “Чи ах нь байж дүүдээ сайн анхаарал хандуулахгүй яагаад өдөр болгон гадуур яваад байна?”, “Хажуу айлын Мин Сү-гээс үлгэр жишээ авааарай. Мин Сү хичээлдээ ч сайн спортондоо ч сайн байна. Харин чи өдөр болгон зөвхөн тоглоом тоглосоор байна. Цаашид энэ байдлаа яавал дээр гэж бодож байна” гэх мэтээр хүүхэдтэйгээ эелдэг харьцан зөв арга барилаар ярилцдаг. Хэтэрхий үйл хөдлөл юмуу сурлагын дүнг нь жишээ татан ах дүү, эгч дүүсийг хооронд нь харьцуулалт хийвэл хэн нэгнийг доош нь хийн тэр хүний бусад нөөц боломжийг үгүй хийх муу үр дагавартай байдаг.

Еврей хүмүүс шиг хүүхэдтэйгээ илэн далангүй сайн ярилцдаг болъё гэвэл эхлээд эцэг эхчүүд өөрсдөө хүүхдийнхээ өмнө илэн далангүй байж сурах хэрэгтэй. Хүүхдийнхээ зарим нэгэн дутагдалтай талыг нь ажиглан жаахан сэтгэл дундуур байсан ч сэтгэл хөдлөлөө барин хүүхдээ шүүмжилж доромжилж гутаасан зүйл ярихгүй байх хэрэгтэй. Эцэг эхчүүд өөрсдийн бодол санааг хүүхэддээ дамжуулахдаа “чи” гэсэн үгээр биш “би” гэсэн үгээр эхлэсэн үгийг ашиглан зөвхөн өөрсдийн байр суурьнаас яриад байх биш хүүхдийнхээ санаа бодлыг сонссоныхоо дараа хүүхэддээ зөвлөж тусладаг зуршилтай болох хэрэгтэй.

Хүүхдээ бусдад хамаагүй амлалт өгдөггүй, хэрвээ амласан бол амлалтаа заавал биелүүлдэг хүн болгон төлөвшүүлэх

Нэгэн эмэгтэй аялалаар явж байтал замд нь нэг худаг тааралдсан байна. Эмэгтэй уяа ашиглан доош бууж худгийн уснаас уув. Тэгээд буцаад худгаасаа гарах гэтэл гарч чадахаа байсан байна. Тэрээр чангаар уйлан туслamж гуйн хашхирав. Дэргэдүүр нь өнгөрч явсан нэг залуу түүний дууг сонсон хүрч ирээд түүнийг худгаас гарган аварсан бөгөөд тэд хоорондоо хайрын андгай тангараг тавьсан байна. Залуу хол газарт аялалаар явахаар болсон бөгөөд хоёулаа хаана ч байсан хайр дурлалаа үнэнчээр хадгална гэж бие биедээ амлав. Яг энэ үед нэг үен тэдний дэргэдүүр өнгөрөн явсан бөгөөд эмэгтэй "Энэ үен болон тэр худаг бид хоёрын гэрч шүү" гэж хэлжээ. Ингээд үүнээс хойш нилээн цаг хугацаа өнгөрөв. Нөгөө залуу өөр газар өөр эмэгтэйтэй гэрлэн хурим найраа хийн хүүхэдтэй болсон байна. Нэг өдөр түүний хүүхэд гадаа өвсний талбайд тоглож байгаад унтсан бөгөөд энэ үед нэг үен хүүхдийнх нь хоолойноос хазан хүүхдийг нь алсан байна. Удалгүй дахин нэг хүүхэдтэй болсон ч мөн л худаг дээр тоглож байгаад доош унан нас барав. Залуу энэ үед дээр амласан амлалтаа санан эхнэртээ учир явдлаа тайлбарлан эхнэрээсээ салсан байна. Ингээд нөгөө залуу амлалт өгсөн эмэгтэйн амьдардаг тосгонд ирэн тэр үеийг хүртэл амлалтаа сахин хүлээж байсан нөгөө эмэгтэйтэйгээ хайж олон гэрлэсэн гэдэг. (Талмуд номны хэсгээс)

Роберт Кеннеди /Жон Кеннедигийн дүү/-г 22 настай байхад болсон явдал юм. Найзтайгаа хамт дарвуулт усан онгоц унан далайд гарсан байна. Гэтэл цайны цаг дөхмөгц завиа гэнэт эрэг рүү эргүүлж эхлэв. Усан онгоц эрэг рүү ойртож эхлэх үед Роберт найздаа дарвуулт завиа зогсоолд тавиарай гэж хэлээд өөрөө усруу үсрэн ороод сэлсээр эрэгт хүрч очив. Тэгээд гэрлүүгээ гүйсэн байна. Учир нь тэрээр өдрийн хоолныхоо цагаас хоцрохгүй гэсэндээ ингэж их яарсан байна. Завиа зогсоолд тавиад гэр лүүгээ явбал хоцроно гэж бодсон учраас ус руу үсрэн орсон юм. Кеннедигийн ээж Рөүз Ёсо хоолны цагаа бариагүй хүүхэддээ огтхон ч хоол өгдөггүй хүн байсан юм. Ингэж байгаа нь амлалтын чухал чанарыг хүүхдүүддээ ойлгуулахын тулд юм.

Еврей хүмүүсийг "Гэрээний хүмүүс" ч гэж нэрлэдэг. Учир нь Еврей хүмүүс бага наснаасаа эхлэн амласан бол заавал амлалтаа биелүүлэх ёстой гэдгийг боловсролоороо дамжуулан маш сайн сурсан байдаг. Шекспирийн жүжиг болох "Венецийн худалдаачин" жүжигт мөнгө хүүлэгч Шяаллу гэдэг хүний талаар гардаг. Өр зээлээ төлж барагдуулж чадахгүй бол 1 паундын хэмжээтэй махаа таслаж өгнө гэсэн гэрээ байгуулсан түүнээс мөнгөнд хэт шунасан Еврей хүний хар бараан дүр төрхийг харж болох ч нөгөө талаараа амласан амлалтаа заавал биелүүлдэг Еврей хүний онцлогийг ч харж болох юм.

"Библийн хуучин гэрээ" ном нь Бурхан Израйлийн ард түмэнд өгсөн авралын амлалтыг илэрхийлдэг. Бурханы амлалтанд итгэн дагадаг шигээ хүмүүс хоорондын амлалтыг ч гэсэн эрхэмд тооцон хэн нэгэнд амласан бол заавал амлалтаа биелүүлэх хэрэгтэй гэж Еврей хүмүүс үздэг. Тиймээс Еврей хүмүүс нэг л удаа амлалтаа биелүүлэхгүй бол тэр хүнд итгэх итгэл нь муудаж эхэлдэг. Учир нь Еврей хүмүүс амлалтаа биелүүлэхгүй байх нь бусад хүний цагийг хий дэмий үрэн тэр хүний амьдралын үнэ цэнэтэй хэсгээс булааж байгаатай ялгаагүй зүйл гэж үздэг. Тиймээс амлалт гэдэг зүйл Еврей хүмүүсийн амьдралд бас томоохон байр

суурь эзэлдэг. Амласан л бол амлалтаа заавал биелүүлдэг Еврей хүмүүсийн онцлог бизнесийн салбарт “Итгэл дааж хамтран ажиллаж болохуйц түнш” гэсэн ойлголтыг бусад хүмүүст суулгаж өгдөг бөгөөд энэ нь амжилт гаргах үндэс суурь нь болдог.

Тэгвэл хүүхдээ амлалтандаа хүрдэг хүн болгон өсгөж хүмүүжүүлье гэвэл юу хийх хэрэгтэй вэ? Эцэг эхчүүд өөрсдөө хүүхэддээ амласан амлалтаа биелүүлэхээс эхлэх хэрэгтэй. Эхнэр нөхөр хоёулаа ажиллаж хөдөлмөрлөн ядарсан үед хүүхэд нь ирээд үлгэрийн ном уншаад өг гэвэл төвөгтэй санагдах үе мэдээж байдаг. Ийм үед эцэг эхчүүд “Маргааш уншаад өгье” гэж хэлэн хойшлуулдаг. Маргааш болвол дахиад л маргааш гэх маягаар хойшлуулсаар байдаг. Түр зуур төвөгшөөж ядаргаатай санагдсан үедээ хүүхэддээ худлаа амлалт өгөн дараа нь амлалтаа биелүүлэхгүй байвал хүүхдийн тархинд “худалч аав, ээж” гэсэн ойлголт суудаг. Хэрвээ хүүхэд биелүүлэх боломжгүй зүйл шаардвал шууд татгалзах юмуу учир шалтгааныг нь тайлбарлаж өгөх илүү дээр юм. Амлалт том, жижиг байна уу хамаагүй чухал зүйл учраас бусдад амласан л бол амлалтаа заавал биелүүлж байхыг хүүхэддээ багаас нь сайн ойлгуулах хэрэгтэй.

Хүүхэддээ эмх цэгцтэй байдал болон ёс зүйн талаар зааж сургах

Нэгэн тосгонд сүшиг бишрэлтэй юм шиг дүр эсгэн цуглаанд явдаг ааш зан муутай эрэгтэй байсан байна. Нэг өдөр багш нь түүнийг дуудан өөрийн байгаа байдлаа жаахан засахыг зөвлөв. Гэтэл тэр эрэгтэй "Би бол тогтсон өдөр болгон цуглаанд тасралтгүй ирдэг сүсэгтэй хүн" гэж хэлсэн байна. Гэтэл багш нь "Чи сайн бодоод үз. Хүн амьтны хүрээлэн рүү өдөр болгон явлаа гээд амьтан болдоггүй биз дээ" гэж загнасан гэдэг. (Талмуд номны хэсгээс)

Нью-Йорк хотод амьдарч байхад миний амьдарч байсан тосгонд Еврей хүмүүс ихээр амьдардаг байв. Хүүхдүүдийн маань сурч байсан бага сургуульд хар арьстай юмуу Ази гаралтай хүмүүс маш цөөхөн байсан бөгөөд цагаан арьстан Еврей хүмүүс их байв. Нью-Йорк хотын бага сургууль хичээлийн шинэ улиралд бага сургуулийн сурагчдын эцэг эхчүүдийг урин "Сургалтын хөтөлбөрийн талаарх уулзалт /Curriculum conference/"-ыг зохион байгуулдаг. Энэхүү уулзалтанд оролцохоор хүүхдийнхээ ангид очтол самбарынх нь дээд хэсэгт манай Солонгос улсын бага сургуулийн хичээлийн танхимд өлгөөтэй байдаг зүйлтэй төстэй "Бидний амлалт/Our promise/" гэсэн агуулга бүхий бичиг өлгөөтэй байв.

Тэрхүү зүйлийн агуулгад 1-д онцолж байгаа зүйл нь "ёс зүй" байсан бөгөөд үлдсэн бусад хэсэг нь эмх цэгцтэй байдалтай холбогдолтой агуулга байв. "Соёлч боловсон еелдэг байх /Be polite/", "Дуу чимээ гаргаж бусдад саад болохгүй байх /Sit Quietly/", "Гараа өргөн хариулах /Raise Hands/", "Бусдын яриаг анхааралтай сонсох /Listen Carefully/", "Багшийнхаа зааж байгаа зүйлийг дагаж хийх /Follow Directions/", "Бүх хүчээ дайчлах /Do your Best/" гэх мэт.

АНУ-ын бага сургуулийн онцлогийг цөөн хэдэн үгээр илэрхийл гэвэл би эргэлзэлгүйгээр "Эмх цэгцтэй байдлыг чухалчлах" гэж хариулна. Манай хүү 15 хоногт нэг удаа сургуулиасаа багшийнхаа "Анхааруулгын захидал"-ыг авчирдаг (сургуулийн зүгээс нилээн хэдэн удаа утсаар ярьсан) байв. Тэрхүү захианд бичсэн зүйлийг уншиж үзвэл тийм ч сүртэй зүйл байдаггүй байсан. Өдрийн хоолны цаг дээр гуанзанд гүйсэн, хичээлийн танхимд гүйсэн, үеийнхээ хүүхдүүдтэй маргалдсан" зэрэг зүйлийн талаар бичсэн байв. Солонгос улсад байсан бол эрэгтэй хүүхдийн хувьд байх л ёстой жирийн үйлдэл гэж үзэн зүгээр өнгөрөх зүйл ч Нью-Йорк хотын бага сургуулийн хувьд бол том асуудал юм.

2-3 удаа эцэг эхэд нь захидал явуулах юмуу утсаар ярилцсан ч хүүхэд алдаагаа засахгүй бол эцэг эхийг нь сургууль руу дуудаг. Сургууль дээр дуудагдсан эцэг эхчүүд гэр бүлдээ жаахан анхаарал хандуулаарай гэсэн үгийг сургуулийн зүгээс сонсдог байна. Хүүхдийн маань явдаг сургуулийн захирал нилээн хэдэн удаа намайг дуудсан. Нэг удаа "4-р ангийн сурагчид лекцийн танхимд хөгжмийн тоглолт хийж байх үед Вон Сог И нь ангийнхаа найзтай муудалцаж зодолдон хамаг юм сүйтгэж орхисон" шалтгаанаар сургууль дээр нь очсон удаа бий.

Би үүнийг сонсоод маш их айж түгшсэн байдалтайгаар сургууль дээр нь очив. Гэтэл сургуулийн захирал "Танай хүү Вон Сог И улс орны соёлын ялгаанаас болоод асуудал үүсгээд байгааг сайн ойлгож байна. Хүүхэддээ сайн анхаарч сургуулийн амьдралдаа хурдан дасан зохицоход нь туслаарай" гэж еелдэг сайхан ярьсан юм. Энэ үед АНУ ийм богинохон

хугацаанд дэлхийн тэргүүлэх хүчирхэг улс гүрэн болж чадсан нь хүүхэддээ бага наснаас нь эхлэн эмх цэгцтэй, дүрэм журамтай байхыг сайн зааж сургасан байдаг бага сургуулийн боловсролын системийн нөлөөнөөс болсон байх гэсэн бодол төрөв.

Еврей хүмүүс хүүхдээ өгсөж хүмүүжүүлэхдээ эмх цэгцтэй байдал болон ёс журамтай байдлыг маш их чухалчилдаг. Хүний ярьж байгааг хараахан ойлгох болоогүй хүүхдийг гадагшаа хоолонд орохдоо огтхон ч дагуулж явдаггүй. Мэдээж хүүхэд гадуур хооллож байгаа утга учрыг ойлгохгүй төдийгүй янз бүрийн муухай үйлдэл үзүүлэх, уйлах гэх мэтээр бусад хүмүүсийг хооллож байхад саад болох аюултай учраас юм. Хоол ундаа асган орчин тойрноо бохирдуулдаг учраас үнэндээ хоолны газрын хүмүүс ч хүлээн авах дургүй байдаг. Тийм болохоор хоол идэх үедээ дагаж мөрдөх ёс журам болон утга учрыг ойлгодог болох үе хүртэл нь хүүхдээ гадуур хооллохдоо огтхон ч дагуулж явдаггүй.

Еврей хүмүүс бусадтай харилцахдаа биеэ цэвэр цэмцгэр, боловсон авч явахыг маш том хариуцлага гэж боддог. Тиймээс хүүхэддээ хоол идэхээс өмнө гараа угааж цэвэрлэн зөв зохистой хувцаслах ёс журмыг зааж дагаж мөрдүүлдэг.

Солонгос хүмүүс цэцэрлэг юмуу бага сургуульдаа нэг хэвийн ёс журмаар боловсрол авдаг учраас сэтгэлээсээ урган гарч байгаа ёс журмыг бусдад илэрхийлэхдээ муу байдаг. Цэцэрлэгийн багш нар хүүхэд буруу зүйл хийвэл найздаа “Уучлаарай” гэж хэл гэж шаардан хүчээр хийлгэдэг. Ийнхүү хүчээр хийлгэж буй үйлдэл зуршил болвол хүүхэд бусдаас сэтгэлээсээ уучлал гуйхыг мэддэггүй зүгээр л “уучлаарай” гэсэн үгийг зуршил болсон зүйл мэт амнаасаа урсан гаргадаг болдог.

Тиймээс хүн бусад хүний байр суурьнаас бодон нөгөө хүнийхээ сэтгэл хөдлөлийг ойлгож чаддаг чадвартай болох нь чухал юм. Хүүхэд гуанз юмуу кино театрт гэх мэт олон нийтийн газар гүйх, хашхирах зэрэг үйлдэл хийн бусдад төвөг учруулах үед нь “боль” гэж утга учиргүй загнаж зэмлэхээс илүү “Чамайг ингээд орилж чарлаад гүйгээд байвал бусад хүнд ямар хэцүү байх вэ?” гэх маягаар асуулт тавин хүүхдэд дотроо бодож тунгаах боломжийг өгөх нь сайн юм. Мөн хүүхэд зөв үйлдэл хийх үед байнга магтаж урамшуулж байх хэрэгтэй. Жишээ нь “Миний хүү ахмад хүнийг хүндэтгэж харьцаж байгаа учраас ээжийнх нь сэтгэл үнэхээр сайхан байна” гэх мэтээр магтаж урамшуулж байх нь маш сайн юм.

Ирээдүйн амьдралын зөвлөгөө

Мөрөөдлөөр дүүрэн амьдрал

Бодит байдал дотор мөрөөдүүлэх

- Хүүхдээ итгэл найдвараа алдахгүйгээр амьдралд тохиолдож буй хүнд хэцүү зовлон бэрхшээлийг гайхалтай боломжоор хүлээн авч чаддаг болгох -

- Амьдралд илүү том зүйлийг мөрөөдье гэвэл одоогийн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг хүүхэддээ ойлгуулах -

- Хүүхдээ бусдын яваагүй замаар явуулах -

- Янз бүрийн улс үндэстний соёлын олон талт чанарыг эрт зааж сурган эзэмшүүлэх -

- Хүмүүс хоорондын нөхөрлөлийн чухал чанарыг хүүхэддээ ойлгуулах -

Хүүхдээ итгэл найдвараа алдахгүйгээр амьдралд тохиолдож буй хүнд хэцүү зовлон бэрхшээлийг гайхалтай боломжоор хүлээн авч чаддаг болгох

Цаазаар авахуулах ял авсан нэгэн эр үхэхийн өмнө хаанд хандан хүсэлт гаргасан байна. Хүсэлтийнх нь агуулгад "Намайг цаазлалгүй 1 жилийн хугацаанд амьд байлгавал хааны хамгийн хайртай морийг нисдэг морь болгоно. Хэрвээ амлалтаа биелүүлж чадахгүй бол тэр үед намайг цаазаар авна уу" гэсэн байв. Хаан үүнийг уншаад ингэж хариулав. "Болж байна. Хэрвээ амлалтаа биелүүлж чадахгүй бол тэр үед шууд цаазаар авах болно" гэв. Ингээд нөгөөх эрэгтэй цаазаар авахуулах ялаас мултран шорон руугаа буцан ирэв. Бусад хоригдлууд түүнээс "Морийг яаж нисдэг болгох гэж байгаа юм бэ?" гэж асуув. Гэтэл өнөөх эрэгтэй "Мэдээж морь тэнгэрт ниснэ гэдэг боломжгүй зүйл. Гэвч 1 жилийн хугацаанд хаан ч үхэж магадгүй би ч үхэж магадгүй. Ирээдүйд юу болохыг хэн мэдэх билээ. 1 жилийн хугацаа өнгөрөхөд морь өөрөө тэнгэрт нисэж чаддаг болох ч юм билүү" гэж хариулсан гэдэг. (Талмуд номны хэсгээс)

Сохор зоосчгүй Унгарын цагаач байсан Эндрю Гроув (Andrew Grove) хүнд хэцүү нөхцөл байдалд амьдарч байсан ч энэ бүхнийг даван туулан "Интел" компанийг дэлхийн шилдэг компаниудын нэг болгож чадсан хүн юм. Тэрээр Еврей хүн байсан боловч хуурамч иргэний үнэмлэх үйлдэн Гитлерийн Еврей хүмүүсийг алж байсан аллагаас амьд үлдэж чадсан юм. Дэлхийн 2-р дайн дууссаны дараа дахин гэр бүл нь "хөрөнгөтөн" болох ферм эрхлэгч гэсэн шалтгаанаар Оросын холбооны улсын дарамт шахалт аван үхэхийн даваан дээр Австрийн хилийг давсан бөгөөд тэрээр 1957 онд ганцаараа АНУ-д дүрвэн ирсэн байна.

Тэрээр дайны олзлогсдыг хорьж цагддаг байсан АНУ-ын "New Jersey"-гийн Килмо гэдэг шоронд түр зуур байрлаж байгаад аз тааран авга ахтайгаа холбоо тогтоон тэрхүү газраас гарч чадсан гэдэг. Их сургуульд сурахыг хүсэж байсан боловч өөрт нь мөнгө гээд байх юм байхгүй мөн авга ах нь ч гэсэн эдийн засгийн хувьд хүнд байдалтай байсан байна. Тиймээс сургалтын төлбөргүй Нью-Йорк хотын коллежед бүртгүүлэн өдөр нь ажиллан шөнө нь суралцаж эхэлсэн байна. Хоолны газарт үйлчлэгчээр ажиллан уул овоо шиг олон таваг угаан заримдаа алдаж унагааж хагалаад эзэнд нь загнуулан бусдад мэдэгдэхгүйгээр уйлж байсан удаа түүнд цөөнгүй байсан гэдэг.

Гэвч үхэлтэй хэд хэдэн удаа нүүр тулгарч байсан түүнд айдас гэсэн зүйл огтхон ч байгаагүй юм. Түүний амьдрал ихэнхидээ маш хүнд хэцүү нөхцөлд өнгөрсөн юм. Гэвч тэр хэзээ ч бууж өгөлгүй энэ бүх хүнд хэцүүг тэвчин өдөр болгон бүх хүчээ дайчлан ажиллаж байсан юм. Англи хэл сайн мэдэхгүй байсан болохоор эхэндээ хичээлүүд дээрээ муу дүн авч байсан ч сүүлдээ хичээлдээ маш сайн болсон байна. Бага багаар сурлагын дүн нь сайжран онц үнэлгээ авч эхэлсэн бөгөөд эцэст нь инженерийн сургуулийг сурлагын хамгийн сайн дүнтэйгээр төгсөж чадсан юм. "Нью-Йорк Таймс" сонин Гроувийн сургуулийн төгсөлтийн талаар нийтлэл бичсэн байдаг. Энэхүү нийтлэлд түүний талаар "3-н жилийн өмнө АНУ-д ирэхдээ Англи хэлээр "хэвтээ" "босоо" гэсэн үгийг ч ялгаж чадахгүй байсан Унгар гаралтай ядуу залуу өдөр нь ажиллан шөнө нь Англи хэл суран тууштай хичээсний үр дүнд ойлгоход хэцүү инженерийн мэргэжлийн нэр томъёог ойлгож цээжлэн инженерийн сургуульдаа хамгийн шилдэг нь болж чадсан юм" гэж бичсэн байжээ.

Тэрээр эдийн засгийн өдөр тутмын “Forbes” сэтгүүлийн ярилцлаганд оролцох үедээ дэлхийд хамгийн шилдэг IT компанийг байгуулж чадсан миний хүч бол “айдас” юм гэж хэлсэн байдаг. “Амар тайван амьдралаас хүнийг холдуулдаг зүйл бол айдас юм. Айдас бол боломжгүй хүнд хэцүү зүйлийг боломжтой болгодог зүйл. Нэг үгээр хэлбэл бие мах бодиороо хүнд хэцүү зовлон бэрхшээл туулсан хүн эрүүл мэнддээ улам илүү анхаарахаар болдогтой адилхан зүйл юм” гэж тэрээр хэлсэн байдаг. Хоёр ч удаа үхэл амьдралын зааг дээр очин амьдралын хүнд хэцүүг туулсан түүний туршлага нь эсрэгээрээ түүнд амжилт гаргах боломжийг өгсөн гэсэн үг юм.

Еврей хүмүүс хүүхдээ “Сабра /Sabra/” гэж дууддаг. Хүүхдээ бага байхаас нь эхлэн “Аав шигээ Сабра болоорой” гэж байнга хэлдэг. “Сабра” гэдэг нь кактусны цэцгийн үр жимс юм. Энэхүү жимсийг гадна талаас нь харвал маш их өргөстэй боловч доторх нь улаан өнгөтэй чихэрлэг амттай байдаг. Ганц дусал ч бороо ордоггүй цөлийн тэр хүнд хэцүү нөхцөл байдлыг тэсвэрлэн цэцэг, үр жимсээ ургуулдаг “Сабра” шиг хүнд хэцүү нөхцөл байдлыг тэвчин даван туулж амьдрах хэрэгтэй гэсэн утга санаа үүнд агуулагдаж байгаа юм. Олон мянган жилийн турш амьдралын хүнд хэцүүг туулсаар ирсэн ч өөрсдийн онцлог, ёс заншлаа сахин хамгаалж үлдэж чадсан Еврей үндэстний хүч чадлыг илэрхийлж буй нэг үг ч гэж хэлж болно. Тэгвэл одоо шашны багш болох Марвин Токаерийн хэлсэн үгэнд анхаарлаа хандуулцгаая.

Тэрээр “Хичнээн хүнд хэцүү нөхцөл байдал тулгаран цөхөрсөн ч Еврей хүмүүсийн итгэл найдварын гал унтардаггүй. Хэзээ ч шантран бууж өгөхгүй гэсэн бодолтой байн өөртөө итгэх итгэлтэй байвал хүн манлайлагч болж чадна” гэж хэлсэн байна.

“Хүний амьдралд юу ч тохиолдсон амархан шантарч бууж өгч огтхон ч болохгүй. Амьдрал өөрөө янз бүрийн өөрчлөлтөөр дүүрэн байдаг бөгөөд хэдий хэр их өөрчлөгдөж байна тэр хэмжээгээр олон янзын боломж нөхцөл дагалдаж байдаг”

Солонгос улсынхаа иргэншлийг хэвээр хадгалан гадаадад сурч амьдарч байгаа Солонгос хүмүүсийн амьдрал ч гэсэн тийм их ялгаатай байдаггүй. Өмнөд Африкийн хөлбөмбөгийн тэмцээнд тоглосон “Нулимсны од” хэмээн нэрлэгддэг Жон Дэ Сэ нь ярилцлага өгөхдөө “Дэлхийн хөл бөмбөгийн тайзан дээр хөлбөмбөгийн ододтой мөр зэрэгцэн тоглосондоо баярлан уйлсан” гэж хэлсэн боловч түүний ээж И Жон Им /58 нас/ нь “Бидний нүдэнд харагдахгүй ялгаварлал болон хана хэрмийг тэсэж гаран дэлхийн хөлбөмбөгийн тэмцээнд оролцотлоо өсөж чадсан хөлбөмбөгийн амьдрал түүний амьдралыг агшин зуурт хувиргасан юм шиг болгосон учраас миний хүү уйлсан гэж” хэлсэн байна.

И хүүхдийнхээ амжилтын нууцыг нэг үгээр “Сул дорой хүмүүсийн өлсгөлөн оюун ухаан” гэж хэлсэн байна. Өөр орны газар нутаг дээр амьдарч байсан түүнийг бага буурай гэж нэрлэх нь зүйтэй бөгөөд тэрээр сайн сайхан амьдаръя гэвэл тохиолдож буй хүнд хэцүү зовлон бэрхшээлийг тэсвэрлэн юу ч байсан хичээнгүй хийхээс өөр аргагүй байсан” гэсэн утга юм.

Еврей үндэстэн ч гэсэн ялгаагүй юм. Еврей хүмүүс дэлхий даяар тархан янз бүрийн улс оронд амьдарч байхдаа байнга хүнд хэцүү зовлон бэрхшээлтэй тулгарч байсан бөгөөд үүнийг даван туулж чадсан хүч нь сул дорой цөөн хүмүүсийн хүчтэй оюун ухааны хүч байсан юм. Тэд “Тора” болон “Талмуд” номоор дамжуулан системчлэгдсэн мэдлэг болон ухааныг амьдралдаа ашиглаж чадсанаар тулгарч буй хүнд хэцүү зовлон бэрхшээлийг даван туулж

чадсан юм.

Амьдралд илүү том зүйлийг мөрөөдье гэвэл одоогийн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг хүүхэддээ ойлгуулах

Могойны сүүл толгойдоо удирдуулан толгойн явж буй зүг рүү даган явахдаа маш дургүй байдаг байв. Сүүл толгойд хандан “Яагаад би заавал чамайг даган явах ёстой юм бэ? Өөрийн явахыг хүссэн зүг рүүгээ намайг дагуулан дурааараа явж байгаа чинь надад үнэхээр шударга бус санагдаж байна” гэж хэлэв. Гэтэл толгой сүүлэндээ хандан “Чамд өмнөхөө харах нүд байхгүй, аюул ослыг сонсож чадах чих байхгүй, үйл хөдлөлөө удирдаж чадах тархи байхгүй шүү дээ. Би зөвхөн өөрийнхөө төлөө биш өөрсдийнхөө төлөө үүнийг хийдэг гэж” хэлсэн байна. Гэтэл сүүл “Наад үгийг чинь сонсохоос дургүй хүрч байна. Дарангуйлагч нар, харгис хаад ноёд ч өөрийн зарц албатуудаа чөлөөтэй сул тавьж явуулах үе байдаг шүү дээ” гэж уурлав. Тийм болохоор толгой сүүлийг тавьж явуулсан байна. Ингээд сүүл өмнө нь гаран явж байгаад нэг их удалгүй ухсан нүх рүү уначихав. Арай гэж нүхнээс гарч ирэн цааш явж байгаад дахин өргөстэй бутанд орооцолдон маш их гэмтэл авав. Өргөст бутнаас арай гэж салж чадсан ч энэ удаа халуун гал руу орон түлэгдэж үхсэн байна. (Талмуд номны хэсгээс)

Хувцас загварын алдарт Поло (Polo) брэндийг бий болгосон Ральф Лаурен (Ralph Lauren) бол “Хамгийн сайн Америк стиль”-ийг бий болгож чадсанаараа алдартай нэгэн юм. Ральф Лаурен Нью-Йоркийн Бронкс /New York, Bronx/ дүүргийн орос гаралтай ядуу амьдралтай Еврей гэр бүлд будагчны хүү болон мэндэлсэн юм. Тэрээр “Лаурен” гэсэн язгууртны нэртэй болсон нь “Рипсид” гэдэг Еврей гаралтай овог ашиглаж байсан аав нь хүүхдүүдийнхээ доог тохуу болж байгааг хараад овгийг нь сольсноос болсон юм.

Лаурен хүүхэд байхаасаа л аваасаа өвлөн авсан төрөлхийн өнгөний мэдрэмжийнхээ авъяасын ачаар хямдхан хувцсыг өнгө үзэмжийг нь тохируулан гоё хувцасладаг авъяастай нэгэн байв. Сургалтынхаа төлбөрийг төлж чадахгүй байсан учраас сургуулиа орхин бээлий хийдэг компанид ажилчнаар орсон тэрээр маш богинохон хугацаанд загварын талаар ойлголттой болон сайн суралцсан байна. Лаурен Америк хэв маягт тулгуурлан нийгмийн бүхий л хүрээний хүмүүсийн амьдралын хэв загварыг харуулсан хувцасны загварыг зохион бүтээсэн юм. АНУ-ын зүүн бүсийн /Ivy League/ шилдэг баг, шинжээчид, ард түмнийхээ хайр хүндэтгэлийг хүлээсэн бейсболын тамирчид гэх мэт нийгмийн янз бүрийн салбарын хэсэг бүлэг хүмүүсийн амьдралаас тэрээр санаа авсан байна. Поло брэнд нь “Түр зуурын моод биш Америк хүмүүсийн өдөр тутмын амьдралын брэнд” гэсэн үнэлгээ авсан бөгөөд “Wall Street”-ээс эхлээд Харлэм (Harlem) хүртэл Америк хүмүүсийн хүндэтгэлийг хүлээж чадсан юм.

Тэрээр “Би эхнэртээ зориулан хувцас хийснээр эмэгтэй хувцасны загвараа, 3 охиндоо зориулан хувцас хийснээр эмэгтэй хүүхдийн хувцасны загвараа, гэрээ тохижуулж янзлахаар оролдож байгаад гэрийн зохион байгуулалтын цогц загварыг бий болгож чадсан” гэж хэлсэн байдаг. Америк гэр бүлийн өдөр тутмын амьдралын хэв маягт тохируулан гаргасан түүний загварууд “АНУ-ын дүрэмт хувцас” шиг хүлээн зөвшөөрөгдөн цаг хугацаа өнгөрсөн ч хувиралгүйгээр улам сайжирч чадсан юм.

Бодит зүйлийг боддог хүн бол аливаа зүйлд оновчтой логик бодолтой байдаг. Ньюркид сурч байсан хүүхдүүдийнхээ сурлагын дэвтэрнээс барууны орнуудын хэв маягийг мэдэрдэг байв.

Анх сурлагын дэвтэр авсан үед агуулга нь хэтэрхий төвөгтэй хэсэгтээ сонин санагддаг байсан. Ньюркийн бага сургууль 1 жилд 4 сурлагын дэвтэр өгдөг. /1-р ангид нь 3 удаа өгдөг/ Зуны амралтын цагийг хасаад 2,5 сард нэг удаа сурлагын дэвтэр өгдөг гэсэн үг юм.

Ньюрк хот болон төрийн байгууллагаас тогтоосон стандарт (Performance Standards)-ын дагуу сурагчдын сурлагын амжилтыг 50 орчим төрлөөр ангилан нарийвчлан үнэлж 1-4 оноогоор дүгнэдэг. Тухайн ангийн шаардаж буй сурлагын түвшинг хангасан тохиолдолд 3 оноо, үүнээс илүү түвшинд байвал 4 оноо, муу байвал 1-2 оноо гэх мэт үнэлгээ өгдөг байна. (4-Exceeds grade level standards, 3-Meets grade level standards, 2-Approaches level standards, 1-Far below grade level standards)

Хичээлийн гол суралцах чадвар гэвэл мэдээж хичээлээ таслахгүй суух байдал, урлаг спортын чадвар, хувийн зан чанар, нийгмийн зан чанар, суралцаж буй хандлага гэх мэт зүйл юм. Тухайн үед 3-р ангид сурч байсан охиныхоо сурлагын дэвтрийг үзвэл унших (Reading), бичих (Written Language), сонсох/ярих (Listening/Speaking), математик (Mathematics), шинжлэх ухаан (Science), нийгэм судлал (Social Studies), ESL /Англи хэл эх хэл нь биш сурагчдад заадаг англи хэлний хичээл/, зураг (Art), хөгжим (Music), компьютер (Computer), эрүүл мэнд/биеийн тамир (Health/Physical Education), сурах хандлага (Work and Study Habits), зан чанар болон нийгмийн хөгжил (Personal and Social Development) гэх мэт 13 хичээлийн нэр байсан.

Эдгээр хичээлүүд дахин цааш маш олон нарийн хэсэг болон задардаг бөгөөд зөвхөн “бичих” гэхэд л цаашаа “хэлзүй болон ярианы чадвар”, “төлөвлөх болон бүрдүүлэх чадвар”, “учир шалтгааны уялдаа холбоо бүхий өгүүлбэрийн бүтэц”, “үгийн санг оновчтой ашиглах”, “зөв бичих /Spelling/”, “цэвэр бичих /Good Penmanship/” гэх мэт олон хэсэгт задран хуваагддаг.

Багш энэхүү олон хэсэг тус бүрийг үнэлэн сурагчдад 1-4 оноо өгдөг. Сурлагын дэвтрийг нь харвал хүүхдийнхээ Ньюрк хотын сургуулиас шаардаж байгаа сурлагын түвшинд хүрч байгаа эсэх, сурлагын дүн нь сайжирч байгаа эсэх, муудаж байгаа эсэх, ямар хичээлдээ тааруу байгаа эсэх зэргийг амархан мэддэг байв. Мөн сурагчдын сурлагын дэвтэрт анги удирдсан багш тухайн сурагчийн талаарх өөрийнхөө товчхон сэтгэгдлийг хавсаргадаг. Манай охины талаарх анги удирдсан багшийнх нь үнэлгээ үе үе өөрчлөгддөг байв. “Тооны хичээлдээ сайн. Унших тал дээр жаахан анхаарах хэрэгтэй”, “Унших чадвар гайхалтай сайжирсан”, “Танай гэр бүл хүүхэддээ сайн анхаарал тавьж байгаад тань талархаж байна”, “Тооны хичээлдээ маш сайн байгаа. Англи хэлний чадвар нь сайжирсан. Гэвч хичээлд идэвхитэй оролцох тал дээр жаахан муу байна. Зохион бичлэг хийх дасгал сайн хийх хэрэгтэй” гэх мэтээр бичсэн байдаг.

Харин Еврей хүмүүс үүнээс нэг алхам илүү явдаг. Тэдний хувьд үхсэний дараа очих дараагийн ертөнцөөс илүү амьдарч буй одоогийн ертөнцдөө өөрчлөлтийн нийгмийг бий болгоход маш их анхаардаг шашны чиг хандлага нь томоохон байр суурь эзэлдэг ч 2000-н жилийн турш хавчлага дарамт хүнд хэцүү нөхцөлд амьдарч байсан тэдний амьдралын түүх нь бодит байдалд үр цацсан сэтгэлгээнийх нь хэв маягийг сайжруулсан тал ч бий. Еврей хүмүүс бодит байдалтай нийцэхгүй байгаа оюун ухааныг ямар ч утга учиргүй зүйл гэж боддог. Тиймээс өөрийнхөө итгэхгүй байгаа болон бодит байдалтай нийцэхгүй байгаа зүйлийг хүүхэддээ огтхон ч заадаггүй. Жишээ нь тэд Санта Клаус байдаг гэх мэт хийсвэр зүйлийн талаар хүүхэддээ огтхон ч ярьдаггүй.

Сэтгэл судлаач Роберт Стэрнберг /Robert Sternberg/-ийн хэлснээр бол хүнд IQ-гаар хэмжигддэг задлан дүн шижилгээ хийх чадвар болон задарсан бусад төрлийн чадвар байдаг. Энэ бол төрөлхийн бус олдмол байдлаар суралцах хандлагаас хүн өөртөө бий болгож буй авьяас чадвар /practical intelligence/ бөгөөд бодит байдлыг зөв үнэлж дүгнэн өөрийнхөө хүсэж байгаа зүйлийг олоход шаардлагатай чадварыг хэлдэг.

Еврей хүмүүс хий хоосон мөрөөдөл юмуу зохиомол зүйлээр биш бодит байдлаас бий болон урган гарсан зүйл, бодит байх магадлал өндөртэй зүйлээр дамжуулан төсөөлөн бодох чадвараа сайжруулдаг. Ямар ч үндэслэл байхгүй хий хоосон ярианаас илүү бодитоор болсон үйл явдал нь хүүхдийн төсөөлөн бодох чадварыг маш сайн цочроон сайжруулдаг төдийгүй тэвчээртэй болоход нь маш их нөлөө үзүүлдэг.

Хүүхдээ бусдын яваагүй замаар явуулах

“Талмуд” номонд “Хамгийн азгүй хувь тавилантай хүн гэвэл өөртөө хэтэрхий их анхаарал хандуулдаг хүнийг хэлнэ” гэж бичсэн байдаг. Өөрийнх нь дутагдлыг бусад хүн байнга анзааран өөрийг нь басамжилж байгаа гэж боддог хүнд бусад хүмүүс байнга өөрийг нь ажиглаад байгаа юм шиг санагдан андуурдаг. Тиймээс өөрийгөө ямар байгаа бол гэж хэтэрхий анхаарал хандуулан ямар ч ажил хийж чаддаггүй. Гэтэл яг үнэндээ ихэнхи хүмүүс бусдад анхаарал хандуулах нь байтугай сонирхох ч цаг завгүй амьдардаг. Тийм болохоор хүн алдаа гаргачихлаа гээд харамсаад байх шаардлагагүй юм. Нэгэнт л Бурхан биш хүн учраас хэн ч байсан алдаа гаргадаг нь мэдээж зүйл юм. (Марвин Токаер)

1928 онд Английн Лондон хотын нэгэн ядуу гэр бүлд Видал Сэссүн /Vidal Sassoon/ төржээ. Тэрээр 14 настайдаа гэрийнхээ ойролцоох гоо сайхны газарт ажиллаж эхэлсэн бөгөөд гоо сайханч болохыг мөрөөдөж эхэлсэн байна. Гэвч тухайн үед эрэгтэй хүн гоо сайханчийн мэргэжилтэй болно гэдэг амар ажил биш байв. Хүмүүс янз бүрээр ярин дарамт шахалтан дунд байсан ч тэрээр эдгээр бүх зүйлийг тэвчин хүнд хэцүү орчинд ч сайтар суралцсаар байсан юм. Түүнийг дэмжиж урамшуулдаг хүмүүс гэвэл эцэг эхээс нь өөр хүн байгаагүй юм. Түүний эцэг эх хэдийгээр бие махбодийн хувьд жижигхэн боловч үнэнч шударга зан чанартай гар нь маш чадварлаг байсан хүүхэддээ итгэн хүсэл мөрөөдлөө орхихгүй байхад нь үргэлж тусалж дэмжин урамшуулж байсан байна.

Ингээд удалгүй Видал гоо сайхны үндсэн үйл ажиллагааны арга барилд хувьсал өөрчлөлтийг хийн гайхалтай амжилт гаргаж эхэлсэн юм. Түүний 1960 онд танилцуулсан “Боб Курт” нэг л хэвийн сэтгэдэг эмэгтэйчүүдийн толгойг чөлөөт болгосон бүтээлч загвар байсан юм. Хувь хүн тус бүрийн царайны ерөнхий хэлбэрийг харгалзан хүн тус бүрд өөр өөр дүр төрхийг бүрдүүлж өгсөн түүний үсний загвар дэлхий нийтийн загвар болж чадсан юм. Тэрээр Еврей хүмүүсийг ялгаварлан гадуурхаж байсан байдлыг үгүй хийн эрэгтэй хүний явж байгаагүй шинэ замаар яван “Видал Сэссүн”-ийг дэлхийн үс арчилгааны алдартай брэнд болгож чадсан юм.

Спортын брэнд бүтээгдэхүүний Пума (Puma) компани 1990 оны эхэн хүртэл санхүүгийн хувьд маш хүнд хэцүү байсан байна. Учир нь бүтээгдэхүүнийхээ зөвхөн чанар болон ашигтай чанарт хэт их анхаарал хандуулан загварыг үл тоомсорлож байгаад хэрэглэгчдээс муу үнэлгээ авсан юм. 1993 онд Герман улсын түүхэн дэхь хамгийн залуу /тухайн үед 30 настай байсан/ шилдэг удирдагч байсан нэг хүн “Пума” компаний “аврагч” болсон юм. Тэр хүн бол Jochen Zeitz /47 нас/ захирал юм. Тэрээр “Пума”-г дампуурлаас гарган дэлхийн спортын барааны брэнд болгож чадсан байна. Бусдын хийж үзээгүй шинэ шинэлэг зүйлд анхаарал хандуулсан нь түүний нууц байсан юм.

Спортын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ихэнхи компаниуд Tiger Woods болон Роналда гэх мэт алдартай тамирчдыг дэмжин бүтээгдэхүүнийхээ сурталчилгаанд тоглуулдаг. Энэ нь зар сурталчилгааны үр дүн сайн байдаг учраас юм. Гэвч “Пума” компани 16-17 насны нэр алдаргүй хөнгөн атлетикийн тамирчин Усайн Болт (Usain Bolt)-оор компанийхаа бараа бүтээгдэхүүнийг сурталчлуулсан байна. “Гэрэл гэгээтэй өөдөрлөг зан чанар, хурц шийдэмгий хувийн зан чанар нь Пуматай сайн зохицсон байдаг” бөгөөд бусдын яваагүй

замаар явж буй “Пума” компаний стратегийг илэрхийлж байдаг.

Дайсон /Dyson/ нь Битлз компани шиг нэр алдартай Английн нэг гэр бүлийн хүмүүс байгуулсан компани юм. Дэлхийд хамгийн анх тоосны уутгүй тоос сорогчийг бүтээн Битлз компаниас хойш АНУ болон Европын улс орнуудаас Англи улсын шилдэг бараа бүтээгдэхүүн гэсэн нэр хүндийг олж чадсан юм. 2009 онд бүтээсэн “Далавчгүй сэнс /барааны нэр Air multipliers/ нь долоо хоног тутмын “Тайм” сэтгүүлд “Тухайн оны шинэ бараа бүтээгдэхүүн”-ий нэгээр сонгогдсон байна.

“Дайсон” /Dyson/ компаний үүсгэн байгуулагч Жэймс Дайсонг 9 настай байхад багш мэргэжилтэй байсан аав нь хорт хавдраар нас барсан бөгөөд тэр цагаас эхлэн аливаа зүйлийг тэр бусдаас өөрөөр бодож сэтгэж эхэлсэн байна. 16 настайдаа сургуулийнхаа хөгжмийн сургалтаас сурахад хамгийн хэцүү үелэх бишгүүрийг сонгон суралцсан байна. Тэрээр 1882 онд бүтээгдэн 127 жилийн турш нэг хэв загвараар ашиглагдсаар ирсэн далавчтай сэнсний хэв загварыг халсан нь бусдаас өөрөөр сэтгэж байсан түүний сэтгэлгээний үр дүн байсан юм. Тэрээр “Сэнс яагаад заавал далавчтай байх ёстой гэж? Эргэлдэж байгаа далавчнаас шалтгаалан салхи нь дундаа үе үе тасалдан далавчийг нь цэвэрлэхэд ч хэцүү байдаг. Бас хүүхдүүд гараа хийн гэмтээх аюултай байдаг ш дээ” гэж хэлсэн юм.

Шорооны уутгүй тоос сорогч бүтээсэн нь ч гэсэн ялгаагүй юм. 1901 онд Английн зохион бүтээгч Бүс хамгийн анхлан орчин үеийн тоос сорогчийг зохион бүтээснээс хойш хэн ч тоос сорогчийн шорооны уутны талаар асуудал дэвшүүлж байгаагүй ч Дайсон бусдаас өөр бодолтой байсан юм. Тэр “Тоос сорогчинд байдаг хогны уутны жижигхэн нүхийг хог шороо таглан сорох чадвар нь мууддаг. Тоосны уутгүй тоос сорогч байвал зүгээр юм биш үү?” гэж бодсон байна.

Тэрээр судалгааны ажил хийхдээ ч бусдаас өөр арга барилыг ашиглан өөрөөр сэтгэн бодохыг илүүд үздэг нэгэн байсан юм. Тэр “Бид бусдаас өөр сэтгэж бусдаас өөр арга барилаар ажиллахыг хүсдэг” гэж хэлсэн байдаг. Компанидаа шинээр ажилчин сонгон шалгаруулж авахдаа ч бусдаас өөр арга барилыг ашигладаг. Аливаа салбарт мэргэшлийн мэдлэг болон туршлагатай хүнийг илүүд үздэг ч тэрээр туршлагагүй хүнийг илүүд үздэг. Дайсон “Ажлын дадлага туршлагагүй хүн тогтож хэвшсэн үзэл бодол байдаггүй. Тийм болохоор ямар нэгэн ажил даалгавал тэр ажлынхаа талаар олон янзаар дахин дахин боддог” гэж хэлсэн байна.

Янз бүрийн улс үндэстний соёлын олон талт чанарыг эрт зааж сурган эзэмшүүлэх

Нэг хаан хоньчинд хонинуудаа даатган маллуулдаг байжээ. Нэг өдөр хоньтой төстэй нэг амьтан хонины хашаанд нь ороод ирсэн байна. Түүнийг харсан хоньчин хаан дээр очин "Урьд нь нэг ч удаа харж байгаагүй нэг сонин амьтан хонины хашаанд ороод ирлээ яах ва?" гэж асуув. Гэтэл хаан "Тэр амьтанд онцгойлон сайн анхаарал хандуулаарай" гэв. Хоньчин гайхсан байдалтайгаар харахад хаан "Хонинууд анхнаасаа хонинууд дунд өсдөг. Харин тэр амьтан огт өөр орчинд өссөн ч хонинуудтай ингэж дасан зохицож чадаж байгаа болохоор гайхалтай хэрэг биш гэж үү?" гэж хэлсэн гэнэ. (Талмуд номны хэсгээс)

АНУ-д ирсэн Еврей хүмүүс дунд уламжлалт хэв маягаа хатуу чанд хадгалж буй хүн тийм ч их байдаггүй. Сахлаа урт ургуулан уламжлалт хоол хүнс болох Кошероо хүнсэндээ хэрэглэн зөвхөн Еврей хүмүүс хоорондоо гэрлэхэд ашигладаг уламжлалаа сахин амьдардаг Еврей хүмүүс тийм ч их байдаггүй. Дундад зууны үед ч ихэнхи Еврей хүмүүс илүү их эрх мэдэл, эрх чөлөөтэй болохын тулд хэд хэдэн уламжлалт ёс заншлаасаа татгалзаж байсан. Хэдийгээр ийм зүйл болж байсан ч үндэстнийхээ оюуны их өв хөрөнгөө хэзээ ч орхиогүй юм. Янз бүрийн үндэстэн, соёлын янз бүрийн чанарыг авч хэрэглэн олон талын соёлыг нэгтгэн хөгжүүлж ирсэн. Үүнийг янз бүрийн улс оронд очин амьдрахдаа тухайн оронд зохицон амьдрахын тулд уян хатан зохицох чадварыг өөрсдөндөө бий болгож байсан гэж хэлж болно.

2010 онд Өмнөд Африкийн хөлбөмбөгийн дэлхийн аваргын тэмцээнд хэдийгээр ялалт байгуулж чадаагүй ч хамгийн шилдэг тактиктай баг гэсэн үнэлгээ авч чадсан баг бол Герман улсын баг байсан юм. Энэ багийн тамирчид хүч чадал болон зохион байгуулалтын чадварыг түрүүнд тавьсан "хамгаалах хэлбэрийн тоглолт", техник болон дамжуулах чадварыг зэрэг бүрдүүлсэн "дайрах хэлбэрийн тоглолт"-ыг зэрэг үзүүлж чадсан учраас юм. Мэргэжилтнүүд "Янз бүрийн улс орны соёлын нэгдэл"-ийг энэ багийн гол нууц гэж дүгнэсэн байна. Герман улсын баг 1990 оны сүүл хүртэл зөвхөн Герман цустай хүнийг багийн гишүүнээр сонгон тоглуулдаг байв. Хичнээн чадвартай нэгэн байсан ч Герман улсын харъяалалтай Герман хүн биш байвал огтхон ч багтаа авдаггүй байсан байна.

Харин 2002 оны дэлхийн хөлбөмбөгийн аваргын тэмцээнээс эхлэн өөр орны харъяалалтай хэн ч байсан хамаагүй багт орон тоглож болохоор болсон. Ийнхүү янз бүрийн улс орны хүмүүсээс багаа бүрдүүлснээр Өмнөд Африкийн дэлхийн хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн дээр гайхамшгийг харуулж чадсан юм. 2002 онд хамтарч тоглосон Клос болон Подолски /Польш гаралтай/, Кака /Бразил/, Уичил /Турк/, Буатэн /Гана/ гэх мэт янз бүрийн улс орны хүмүүс багийн үндсэн бүрэлдэхүүн болох 23-н хүний бараг тал нь буюу 11 хүн болж байв. Нийтлэг бодол санаанд тулгаарлан үндэстэн, соёлын нээлттэй байдлаар дамжуулан дэлхийг эзэлсэн Ром улсын стратегийг тоглолтондоо ашигласан гэсэн үг юм.

Еврей үндэстэн 5000-н жилийн түүхтэй хүмүүс ч үүнээсээ 2000-н жилээс дээш хугацаагаар дэлхийн янз бүрийн улс оронд тархан амьдарсаар ирсэн. Олон янзын улс орноос дарамт шахалт аван байнгын аюултай нөхцөл байдалт амьдарч байсан. Олон арван улс оронд тархан амьдарч байсан болохоор Еврей хүмүүс хаана ч байсан хүн амын хувьд маш бага байсан. Одоогийн байдлаар хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг ардчилалын системтэй болоод 100-н жил ч болоогүй байгаа юм. Бусад улс оронд амьдарч байгаа жижиг үндэстэн оршин тогтнож

амьд үлдэе гэвэл нэн түрүүнд хийх шаардлагатай зүйл бол тухайн улсын соёлд дасан зохицох юм. Еврей хүмүүс янз бүрийн улс орны дарангуйлалаас зугтан өөр улс орон руу ихээр дүрвэдэг байсан бөгөөд энэ байдал нь тэдэнд өөр орчин нөхцөлд хурдан дасан зохицож чадах чадвартай болоход нь ихээхэн нөлөө үзүүлсэн юм.

Ямар нэгэн өөр улс оронд очин амьдарсны бас нэг сайн тал нь гэвэл шинэ үзэл санаа, хандлагыг суралцах боломж нэмэгддэг. Пэг Нам Сон /63 нас/ Конгүг их сургуулийн эмнэлгийн захирал Солонгос улсад хамгийн анх хөхний хорт хавдартай өвчтөний хөх нөхөн суулгах /хавдрын тархалтыг зогсоон хөхний байдлыг хэвээр нь хадгалдаг мэс засал/ мэс заслыг хийсэн мэс заслийн эмч юм. Тэрээр өөрийгөө “Дотооддоо хамгийн анх” хөхний мэс заслын төрөлд хүлээн зөвшөөрөгдсөн чадвартай эмч болж чадсаныгаа гадаадын олон улс орноор аялж туршлага хуримтлуулсны хүч гэж хэлсэн байна. “Суралцана уу, ажил хийнэ үү, аялалаар явна уу хамаагүй болж өгвөл гадаадын олон улс орноор аялаарай” гэж тэрээр зөвлөсөн байдаг.

Тэрээр өнгөрсөн хугацаанд АНУ-ын хорт хавдар судлалын холбоонд очих болгондоо хөхний хорт хавдар, уушгины хорт хавдрын талаар сайтар суралцан эх орондоо ирээд хөхний хорт хавдрын холбоог байгуулсан. Нэг үе Солонгос улсад хүмүүс хөхний хорт хавдар болон уушгины хорт хавдраар өвчлөх нь бага байсан боловч нэг их удахгүй яваандаа хорт хавдраар өвчлөх тохиолдол барууны улс орнуудынх шиг болно гэж тэрээр таамагласан байна. Пэг Нам Сон нь Итали улсын улсын хорт хавдрын төвийн эмчийн хөхний мэс заслыг ажигласны дараа 1986 онд дотооддоо анх удаа ийм төрлийн мэс засал хийсэн байна. Тухайн үед өөрөөс нь нас өндөр мэс заслын эмч нар “Ийм залуу хүн байж ийм хүнд мэс засал хийж болохгүй” хэмээн түүнийг буруушааж байсан боловч одоо бол түүний хийдэг хөх нөхөн суулгах мэс засал нь Солонгос улсдаа хөхний мэс ажилбарын гол арга болоод байгаа юм.

Еврей хүмүүс цагаачлалын бодлогын сайн талыг хэнээс ч илүү сайн мэддэг хүмүүс. Еврей гаралтай АНУ-н хэвлэл мэдээллийн ажилтан Томас Придмон гэдэг хүн “Ажилчин байна уу судалгааны ажилчин байна уу хамаагүй хууль ёсоор цагаачлагчдыг хүлээн зөвшөөрөх нь АНУ-н ирээдүйд ихээхэн нөлөө үзүүлнэ. Энэ бол АНУ-ыг үргэлж БНХАУ-н өмнө байлгах арга” гэж хэлсэн байдаг. Дэлхий ертөнц ингэж хурдацтай өөрчлөгдөж байгаа өнөө цагт байнга шинэ шинэлэг санааг ольё гэвэл улс орноо нээлттэй болгон дэлхийн янз бүрийн улс орны боловсон хүчнийг улс орондоо хүлээн авч байх хэрэгтэй.

Дэлхийн загварын алдартай брэнд болох “GUESS”-ийн үндэслэгч Еврей хүн Паул Марсиано захирал Морокод төрөн Франц улсад өссөн бөгөөд 10 настай байхаасаа Израйлд гэрийн тариалангийн талбай дээр тариалангийн ажил хийж байсан. Тэрээр 20-29 насныхаа үед АНУ-д ирэн 1981 онд Лос Анжелес хотод “GUESS”-ийг үндэслэн байгуулсан. Тэр бол дэлхийн янз бүрийн улс орны соёлыг биеэр туршиж үзсэн нэгэн байсан юм. Тэгвэл олон янзын улс орны соёл иргэншил түүнийг өсөж том болох явцад ямар нөлөө үзүүлсэн байдаг бол.

Тэрээр “Энд тэнд янз бүрийн улс оронд очиж амьдран янз бүрийн соёл иргэншилтэй танилцаж байсан маань надад бүх зүйлд дасан зохицож чадах чадварыг өгсөн. Ямар ч улс, ямар ч хотод очсон би амьдрах аргаа амархан олж чаддаг болсон. Өөртөө байгаа бүх зүйлийг алдсан ч маргааш нь дахиад бүхнийг шинээр эхэлж чаддаг болсон. Дахин ширээ арчих юмуу

аяга угаах хэрэг гарвал хийж чадна. Би нэгэн жижигхэн загасчны гэр бүлд төрсөн ч дэлхий ертөнцийг гайхалтай болгох ажлыг хийн дэлхий ертөнцөөр тойрон явах ерөөлийг авсан хүн" гэж хэлсэн байдаг.

Еврей зүйр цэцэн үгэнд "2 чихээ гадагш нь чиглүүлээрэй" гэсэн үг байдаг. Энэ нь хэтэрхий дотогшоо хандлагатай байснаас гадаад ертөнц рүү илүү их анхаарал хандуулвал олон зүйлийг ажиглаж чадах бөгөөд ямар нэгэн өөрчлөлт байгааг хараад аливаа зүйлийн талаар тодорхой сайн мэдэж чаддаг гэсэн утгатай юм. Олон янзын улс оронд амьдарч тухайн улс орны соёлд хурдан дасан зохицохыг суралцан бусдаас өмнө шинэ содон зүйлийг олж мэдэж чаддаг нь Еврей хүмүүсийн амжилтын бас нэгэн үндэс суурь юм.

Хүмүүс хооронд нөхөрлөлийн чухал чанарыг хүүхэддээ ойлгуулах

Еврей хүн өөрийн үндэстнээ нэг том гэр бүл гэж тооцдог нь бизнесийн томоохон амжилт гаргахад нь ихээхэн хүч болж өгдөг. Энэхүү ойлголт ухамсар дэлхийн янз бүрийн улс оронд амьдарч буй бүх Еврей хүмүүсийг холбож өгдөг учраас юм. Тэгэхээр Еврей хүмүүс Дорнын зарим нэгэн улс үндэстэн шиг 2 гэр бүлтэй гэсэн үг юм. Энэ бол өөрийнх нь гэр бүл болон үндэстэн нь гэсэн үг юм. (Марвин Токаер)

Англи хэлэнд Ротшильд шиг баян гэсэн өвөрмөц хэлц байдаг. Ротшильдийн гэр бүл бол "Мөнгө=Еврей хүн" гэсэн ойлголтыг дэлхий дахинд таниулсан баян Еврей хүмүүсийн гол төлөөлөл юм. Энэ гэр бүл Израйл улсыг санхүүгийн талаас нь дэмжиж байсан удаа ч бий. Энэ гэр бүлийг бий болгосон Маеэр Амсчил Ротшильд (Mayer Amschel Rothschild) нь 18-р зуунд Германы Франкфурт Гетто (Frankfurt Ghetto)-д валет арилжигчаар очсон байна.

Тухайн үед Франкфурт хотод Еврей хүн Христийн шашинтай хүнтэй гэрлэхийг хориглох хэмжээгээр Еврей хүмүүсийг ялгаварлан гадуурхаж байсан юм. Христийн шашинтай хүнтэй бэлгийн харьцаанд орсон Еврей хүнд эрэгтэй эмэгтэй хамаагүй дүүжилж алах ял оноож байв. Христийн шашныг шүтэхгүй бол мэдээж ажил олоход хэцүү байсан бөгөөд хичнээн авъяас чадвартай хүн, урлагийн хүн байлаа гээд ч ажил хийх боломжгүй байв. Христийн шашинтай хүмүүсийн хамгийн дургүй ажил болох "мөнгө хүүлэгчийн ажил" цорын ганц мөнгө олох арга байсан юм.

Маеэр Франкбурт хотын хамгийн эрх мэдэлтэй нэгэн байсан Билхэллэм ноёнтой санамсаргүй уулзсан бөгөөд түүний сонирхол мөнгөн дэвсгэрт цуглуулах болохыг мэдээд ховор зоосыг хямдхан үнээр олж өгөн сайн найз нөхөд болсон байна. Тэрээр энэ байдлаа ашиглан илүү том худалдаа наймаа хийхээр болсон байна. Францын хувьсгалаар дамжуулан эрх чөлөөтэй болсон Маеэр Европын эзэн хаадуудад хөрөнгө мөнгөний туслалцаа үзүүлэн санхүүгийн томоохон хүмүүсийн эгнээнд орсон байна. Тэрээр Парис, Лондон, Франкфурт, Вена, Напулли зэрэг хотуудад салбар байгуулан таван хүүхэддээ салбаруудаа хариуцуулсан байна.

Ротшильдийн гэр бүлийг амжилтанд хүргэсэн гол зүйл бол Англи болон Франц хоёр улсын дайн байсан юм. 1815 оны 06-р сарын 20-ны өдөр Лондонгийн хөрөнгийн бирж Франц Ватерлогийн дэргэдэх тулааны үр дүнг хүлээж байв. Энэ үед Лондон хотын салбарыг хариуцаж байсан Маеэрийн 3 дахь хүү Натан Ротшильд (Nathan Rothschild) Англи улсын бондыг зарж эхэлсэн. Гэтэл бондны үнэ агшин зуур буурсан байна. Ийм нөхцөл байдал үүсмэгц Натан дахин маш их хэмжээний бондыг худалдан авсан байна. Тухайн үед дайнд "Английн цэрэг ялна" гэсэн цуу яриа гарч байв.

Европын янз бүрийн улс оронд тархсан санхүүгийн сүлжээг үүсгэн байгуулж байсан Натаний ах дүү нар мэдээллийн сүлжээг ашиглан Английн цэргийн ялалтыг нэг шат урагшлуулсан гэсэн дүгнэлт гарсан байдаг. Гэр бүлийн гишүүдийн эв нэгдэлтэй байдал болон янз бүрийн улс орны дээд давхаргын хүмүүстэй нөхөрлөлийн сүлжээ үүсгэж чадсан нь Ротшильдийн гэр бүлийн амжилтыг бий болгосон нууц юм.

Еврей хүмүүс мэдээлэл мөнгө болдог гэсэн бодит үнэнийг хэнээс ч илүү сайн мэддэг. Тиймээс хааны гэр бүл, язгууртан, дээд давхаргын хүмүүс, хөрөнгөтний давхаргын хүмүүстэй харилцаа үүсгэхийн тулд бүх хүчээ дайчилдаг. Ротшильдийн гэр бүлийн түүхийг бий болгосон Маеэр нь Германы эрх мэдэлтэй нэгэн байсан Билхэллэм ноёнтой анд найз болохын тулд Билхэллим Напелеонд ялагдсан үед гарсан хохирлыг нь бүрэн төлсөн байдаг. Хүнд хэцүү нөхцөл байдалтай байсан Европын улс төрийн байдал дунд Ротшильдийн гэр бүл ихээхэн хэмжээний ашиг олж чадсан нь янз бүрийн улс орны хаад ноёд болон дээд давхаргын хүмүүстэй нөхөрлөлийн харилцааг бий болгож чадсан учраас юм.

Еврейн шашин бие биенээ хайрлаж халамжлахын чухал чанарыг чухалчилдаг. АНУ-д цагаачлан ирсэн ядуу Еврей хүмүүс бусад үндэстний хүмүүсийг бодвол илүү хурдан байр сууриа олон мөнгө олж чаддаг нь Еврей хүмүүс бие биедээ сайн туслан нөхөрлөлийн сүлжээ сайтай байдаг учраас юм. Одоо ч гэсэн Орос юмуу өмнөд Европ гэх мэт газарт Еврей хүн цагаачлан ирвэл Еврей хүмүүсийн холбооны сайн дурын ажилчид орон байр, ажил олж өгөх гэх мэт шинээр амьдралаа эхлэх хүртэл нь нэг нэгэндээ хөрөнгө мөнгөөр тусалдаг.

Солонгос улсын иргэд ч гэсэн гадаадын өөр улс оронд ихээр амьдарч байгаа бөгөөд одоогийн байдлаар энэ тоо 7 саяд хүрээд байна. Үүнийг “Эх орноосоо өөр улс оронд амьдарч буй цаг үе” гэж хэлж болох боловч Еврей хүмүүстэй харьцуулвал олон улсын улс төрийн байр суурь маш муу байдалтай байгаа юм. Барууны улс орны хүмүүс Солонгос хүнтэй уулзвал одоо ч гэсэн “Хятад хүн үү, Япон хүн үү” гэсэн асуултыг асуусаар байна. Ийнхүү “Солонгос” гэсэн улсын нэр хүмүүст сайн танигдаж чадахгүй байгаа шалтгаан нь гадаадын улс оронд амьдарч байгаа Солонгос хүмүүс хоорондын нөхөрлөлийн сүлжээ муу байгаа учраас юм.

Харин бүр эсрэгээрээ Солонгос хүмүүс бие биедээ туслахын оронд хоорондоо хэрүүл маргаан үүсгэн нэгнийгээ хүнд хэцүү байдалтай болгож буй тохиолдол их байна. Солонгос хүмүүс нийгмийн харилцааны тал дээр муу байгаа учраас хичнээн АНУ-н нэр хүндтэй их сургуулийг төгсөн Англи хэлэндээ сайн байсан ч нийгэмд дасан зохицох чадвар нь Еврей хүмүүстэй харьцуулахад маш муу байгаа юм. Солонгос хүмүүс янз бүрийн байдлаар бие биенээ хууран мэхлэх, муулах зэргээр нэг нэгэндээ хор хөнөөл учруулж байхад эсрэгээрээ Еврей хүмүүс ямар ч улс оронд амьдарч байсан нэг нэгнийгээ халамжлан тусалж дэмжин хоорондоо өрсөлдөж тэмцэлдэнэ гэж байдаггүй. Харин бие биендээ чадлаараа туслан бат бөх харилцаа холбоог бий болгож байдаг.

Table of Contents

Еврей хүмүүсийн боловсрол болон амжилтын нууц
Өмнөх үг
Оршил
“Талмуд” номын зохиолч, Марвин Токаер (Marvin Tokayer)-тай хийсэн ярилцлага
Израйль улсаас БНСУ-д улсад суугаа элчин сайд, Тувиа Израйль (Tuvia Israeli)-тай хийсэн ярилцлага
Гэр бүлийн боловсрол
Мэдлэг боловсролтой хүн хамгийн баян хүн болохыг хүүхэддээ ойлгуулах
Зочны өрөөндөө телевизийн оронд номын тавиур байрлуулах
Эх хүн бол гэр бүлийн амин сүнс
Гэрийн эзний суух сандлыг тусад нь байрлуулах
Хоолны ширээний ардах боловсролыг орхигдуулахгүй байх
Хүүхдээ баруун гараараа шийтгэн зүүн гараараа тэврэх
Нөхөр нь эхнэрээ хүндэтгэн хайрлаж халамжлах
Эхнэр нөхөр хоёр бие биеэ хайрлаж халамжилж буй дүр төрхөө хүүхэддээ харуулах
Эхийн хэвлийд байх үеэс нь хүүхэддээ боловсрол олгох
Бэлгийн амьдралын талаар хүүхэдтэйгээ илэн далангүй байх
Суралцах чадвар
Зөгийн балаар бичдэг цагаан толгойн үсэг, оньсого тааврааар дамжуулан сурдаг үг
Унтахаас нь өмнө хүүхэддээ 15 минут ном уншиж өгөх гайхалтай аргыг хэрэглэх
“Давхар хэлний боловсролоор” хүүхдийнхээ гадаад хэлний чадварыг сайжруулах
Эцэг эх бол хүүхдийнхээ ярилцлагын хамгийн гол хамтрагч
Онигоо ойлгож мэдэрдэг болгох дасгалжуулалт
Өдөр бүр өглөөний хоолоор хүүхдийнхээ тархийг сэргээх
“Талмуд” хэлбэрийн ярилцлагын аргыг ашиглан хүүхдийнхээ асуултанд хариулахаас илүүтэйгээр хүүхэддээ асуулт тавих
Хүүхдийнхээ хийсэн ямар нэгэн зүйлийн үр дүнг хараад магтахаас илүүтэйгээр тэрхүү зүйлийг хийх явцад сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх
Цаг зав гарган хүүхэдтэйгээ хамт тоглон бүтээлч чадварын гол цөм болох баруун тархийг нь хөгжүүлэх
Хичээл ном бол холын зайн гүйлт, эцэг эх бол дасгалжуулагч
Хүүхэддээ итгэл найдвар өгөн чи ийм байх ёстой гэсэн ямар нэгэн шалгуур тавихгүй байх
Бүтээлч чадвар
Тэвчээртэйгээр хүүхэддээ асуулт тавихад анхаарах
Хүүхдээ ямар нэг зүйлийг “бусад хүн шиг сайн хийдэг хүн” биш “бусдаас өөр хийдэг хүн” болоход нь туслаж дэмжин урамшуулах
“Хүүхэд хичээл хийж байгаад нозоорон залхуу нь хүрвэл босоод өөр зүйл хийж” болохыг зөвшөөрөх
Бүтээлч хүүхэд асуудал ихтэй байдаг
Цээжлэх чадварын нууц
Мэдлэг нь “урлаг” хэмээх нэг талын далавчаа зүүж байж нисэж чаддаг

Ирээдүй нь олон талт чадвартай боловсон хүчний эрин үе, хүүхдийнхээ сонирхож буй салбарыг нэмэгдүүлэх
Хүн чанарын боловсрол
“Талмуд” номноос илүү чухал “өөрийн гэр бүлийн байдлыг” тодорхойлох
Хүүхдээ чиг үүргийн загвараа олоход нь туслах
13 насны насанд хүрсний баяр, бага наснаасаа биеэ дааж сурахад нь хүүхэддээ туслах
Өвөг дээдэс болон үндэсний өв уламжлалынхаа үнэ цэнийг мэддэг болгох
Хүүхэддээ эхлээд мэдлэгээс илүү амьдралын ухааныг заах
Хүүхэддээ бусдад хандив тусламж үзүүлж туслаж дэмжихийн үнэ цэнийг ойлгуулан амьдралд нь хэрэгжүүлүүлэх
Хүүхдэд эдийн засгийн боловсролыг эрт заах тусам сайн
Найз нөхдөө зөв таньж сонгон дотно нөхөрлөх талаар зааж ойлгуулах
Хамгийн анхны өрсөлдөгч болох ах, эгч, дүү нарын харилцааны талаар зааж сургах
Үнэнч шударга байдал хамгийн шилдэг зэвсэг болохыг хүүхэддээ ойлгуулах
Байнга талархалтайгаар амьдрах зуршлыг сургах
Цаг хугацааны үнэ цэнийг ойлгодог болгох
Эгэл жирийн даруу амьдрал хамгийн сайхан амьдрал болохыг ойлгуулах
Хүүхдээ бүх зүйлд дасан зохицож чадахуйц амьдралын чиг хандлагатай болгох
Бусдыг хайрлаж халамжлах, буруу зүйл хийсэн бол уучлал гуйхыг мэддэг нийгмийн харилцааны талаар хүүхэддээ зааж сургах
Хүүхдээ алдаа гаргасан үед нь туслаж дэмжин нэг алдаагаа дахин давтсаар байвал загнаж зэмлэх
Хүүхдээ аливаа зүйлийг сайтар сонссоныхоо дараа бодож тунгаан зөв ярьдаг хүн болгон төлөвшүүлэх
Хүүхдээ бусдад хамаагүй амлалт өгдөггүй, хэрвээ амласан бол амлалтаа заавал биелүүлдэг хүн болгон төлөвшүүлэх
Хүүхэддээ эмх цэгцтэй байдал болон ёс зүйн талаар зааж сургах
Ирээдүйн амьдралын зөвлөгөө
Хүүхдээ итгэл найдвараа алдахгүйгээр амьдралд тохиолдож буй хүнд хэцүү зовлон бэрхшээлийг гайхалтай боломжоор хүлээн авч чаддаг болгох
Хүүхдээ бусдын яваагүй замаар явуулах
Янз бүрийн улс үндэстний соёлын олон талт чанарыг эрт зааж сурган эзэмшүүлэх
Хүмүүс хоорондын нөхөрлөлийн чухал чанарыг хүүхэддээ ойлгуулах